

ФАТФ

Эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх гарын авлага

**ВИРТУАЛ ХӨРӨНГӨ БОЛОН ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ
ҮЗҮҮЛЭГЧИД**

2021 ОНЫ 10-Р САР



Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ) нь олон улсын санхүүгийн системийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхээс сэргийлэх бодлого боловсруулж, дэлгэрүүлэх үүрэг бүхий засгийн газар хоорондын, хараат бус байгууллага юм. ФАТФ-ын зөвлөмжийг олон улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стандарт гэж хүлээн зөвшөөрдөг.

ФАТФ-тай холбоотой нэмэлт мэдээллийг www.fatf-gafi.org вэб хуудаснаас авна уу.

Энэхүү баримт бичиг болон ашиглагдсан зураг нь аливаа нутаг дэвсгэрийн талаарх статус, тусгаар тогтнол, олон улсын хил хязгаар, хот, газар нутгийн нэр хаяг зэргийг хөндөөгүй болно.

Иш татах:

ФАТФ (2021), Виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх гарын авлага, ФАТФ, Парис

www.fatf-gafi.org/publications/fatfrecommendations/documents/Updated-Guidance-RBA-VA-VASP.html

© 2021 ФАТФ/ЭЗХАХБ. Бүх эрх хамгаалагдсан.

Урьдчилсан бичгэн зөвшөөрөл аваагүй тохиолдолд хэвлэх, хуулбарлах болон орчуулахыг хориглоно.

Нийтээр нь болон хэсэгчлэн хэвлэхтэй холбоотой зөвшөөрлийг ФАТФ-ын Нарийн бичгийн даргын газарт хүлээн авна:

2 Рью Андре Паскал 75775 Парис хот Цедекс 16, Франц улс
(Факс: +33 1 44 30 61 37 эсхүл имэйл: contact@fatf-gafi.org)

Нүүр хуудасны зургийг © Getty Images

АГУУЛГА

МЭДЭГДЭЛ.....	4
ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ.....	5
ЕРӨНХИЙ ХУРААНГУЙ.....	7
БҮЛЭГ НЭГ: УДИРТГАЛ.....	10
Оршил.....	10
Гарын авлагын зорилго.....	12
Гарын авлагын цар хүрээ.....	13
Бүтэц.....	18
БҮЛЭГ ХОЁР: ФАТФ-ЫН СТАНДАРТЫН ЦАР ХҮРЭЭ.....	19
Анхдагч эрсдэлийн үнэлгээ.....	19
МУТС-тэй тэмцэх арга хэмжээний хүрээнд ВХҮҮ-тэй холбоотой ФАТФ-ын нэр томъёоны тодорхойлолт, онцлох зүйлс.....	26
БҮЛЭГ ГУРАВ: ФАТФ-ЫН СТАНДАРТУУДЫГ УЛС ОРНУУД БОЛОН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГУУДАД ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ.....	44
ВХ болон ВХҮҮ нарын хүрээнд Зөвлөмжүүдийг ашиглах нь.....	44
ВХҮҮ-ийг МУТС эрсдэлд суурилсан аргачлалын дагуу хянах, шалгах.....	81
БҮЛЭГ ДӨРӨВ: ВХҮҮ-ДЭД БОЛОН ВХ-ИЙН ЗАРИМ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛДЭГ, ЭСХҮЛ ОРОЛЦДОГ ЭТГЭЭДҮҮДЭД ФАТФ-ЫН СТАНДАРТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ.....	88
Харилцагчийг таниж мэдэх.....	89
Улс төрд нөлөө бүхий этгээд (УТНБЭ).....	92
Корреспондент банк болон бусад ижил төрлийн харилцаа.....	92
Цахим шилжүүлэг ба шилжүүлэгийн дүрэм.....	92
Дотоод хяналт, гадаад салбар, охин компаниуд.....	97
СГТ мэдээлэх болон мэдээллийн нууцлал.....	97
БҮЛЭГ ТАВ: ВХ БОЛОН ВХҮҮ-ДЭД ЭРСДЭЛД СУУРИЛСАН АРГАЧЛАЛЫГ ХЭРЭГЖҮҮЛСЭН ОЛОН УЛСЫН ЖИШЭЭ.....	100
БҮЛЭГ ЗУРГАА: ВХҮҮ-ИЙН ХЯНАН ШАЛГАГЧ НАРЫН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ, ХАМТРАН АЖИЛЛАХ ЗАРЧИМ.....	114
Зорилтууд.....	114
Мэдээлэл солилцох, хамтран ажиллах зарчим.....	115

МЭДЭГДЭЛ

Энэхүү шинэчилсэн гарын авлагын баримт бичиг нь дор дурдсан Төслийн багийн гишүүдийн ажил болон 200 гаруй улс орнуудаас бүрдсэн ФАТФ-ын Гишүүдийн Олон Улсын Сүлжээ, ФАТФ-ын төрлийн бүс нутгийн байгууллагын өгсөн мэдээлэл зэрэгт үндэслэсэн болно. Мөн тус гарын авлагыг боловсруулахдаа хувийн хэвшил болон виртуал хөрөнгө, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн төлөөлөлтэй зөвшилцсөн болно.

Энэхүү гарын авлагыг боловсруулах ажлыг (Япон улсын Санхүүгийн үйлчилгээний агентлаг) Nabuchi Takahide, (Америкийн Нэгдсэн улсын Сангийн яам) Jon Fishman, Sandra Garcia, ФАТФ-ын Нарийн бичгийн даргын газрын Ken Menz, Tom Neylan нар удирдав. Төслийн багт дор дурдсан этгээдүүд ихээхэн дэмжлэг туслалцаа үзүүлсэн болно: Evan Gallagher (Австралийн AUSTRAC буюу Гүйлгээний тайлан, дүн шинжилгээний төв), Amr Sayed Rashed (Египетийн Мөнгө угаах, Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх нэгж), Mirzosharif Sharipov (Евразийн Группийн Нарийн бичгийн дарга), Gabriel Hugonnot, Jon Isaksen (Европын комисс), David Sabbon (Францын ACPR), Pierre Offret (Францын Эдийн засаг, санхүүгийн сайд), Pierre Subiger (Францын Санхүүгийн Зах зээлийн эрх бүхий байгууллага), Fabian Rieger (Германы Сангийн яам), Elad Wieder (Израилийн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх байгууллага), Francesca Picardi (Италийн Сангийн яам), Kawada Yuji, Matsuzawa Arisa (Японы Санхүүгийн үйлчилгээний агентлаг), Ricardo Sacho (Мексикийн Санхүү болон Төрийн Зээлийн асуудал эрхэлсэн нарийн бичгийн даргын газар), Rachel Huen, Evadne Ong (Сингапурын Мөнгөний бодлогын газар), Annette Fresard, Giulia Mariani (Швейцарын FINMA буюу Санхүүгийн Хяналтын Холбоо), Vincent Cottier, Melanie Friedli (Швейцарын Холбооны Сангийн яам), Caroline Horres (Америкийн Нэгдсэн улсын Сангийн яам), Val Szczepanik (Америкийн Нэгдсэн улсын Үнэт цаас, арилжааны комисс).

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ННКВ	Нууцлалыг нэмэгдүүлсэн крипто валют
МУТ	Мөнгө угаахтай тэмцэх
ХТМ	Харилцагчийг таньж мэдэх
ТСТ	Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
ҮОХЗДСТ	Үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх
DAпп	Төвлөрсөн бус, эсхүл түгээх апплейкшн
ТБС	Төвлөрсөн бус санхүүжилт
СББМҮҮ	Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч
ХТМНҮА	Харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагаа
ICO	Анхдагч зах зээлд койныг санал болгох
СБ	Санхүүгийн байгууллага
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
МУ	Мөнгө угаах
МҮБ	Мөнгөн үйлчилгээний бизнес
МҮБЗШҮ	Мөнгө, үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ
ӨТ	Өвөрмөц токен
ББЗЗ	Биржийн бус зах зээл
P2P	Хэрэглэгч хоорондын дундын зуучлагчгүй арилжаа
УТНБЭ	Улс төрд нөлөө бүхий этгээд
ҮОХЗДС	Үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх
ЭСА	Эрсдэлд суурилсан аргачлал
ӨЗБ	Өөрийгөө зохицуулах байгууллага
СГТ	Сэжигтэй гүйлгээний тайлан

ТС	Терроризмыг санхүүжүүлэх
ХЭТ	Хуулийн этгээдийг тодорхойлогч
ВХ	Виртуал хөрөнгө
ВХҮҮ	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч

ЕРӨНХИЙ ХУРААНГУЙ

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ) нь 2018 оны 10-р сард виртуал хөрөнгөтэй холбоотой санхүүгийн үйл ажиллагаанд хамаарах харилцааг нарийн тодорхойлох зорилгоор Зөвлөмжүүддээ өөрчлөлт оруулсан. Улмаар ФАТФ нь нэр томъёоны тайлбартаа “виртуал хөрөнгө” (ВХ) болон “виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч” (ВХҮҮ) гэсэн хоёр шинэ нэр томъёог нэмсэн. ФАТФ-ын нэмэлт өөрчлөлт орсон Зөвлөмж 15-д мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) зорилгоор ВХҮҮ-ийн үйл ажиллагааг зохицуулах, тусгай зөвшөөрөл олгох, бүртгэлжүүлэх, хяналт шалгалтын үр дүнтэй системийг бий болгох зэрэг шаардлагуудыг тусгасан.

ФАТФ 2019 оны 6-р сард Зөвлөмж 15 (3.15)-ын Нэмэлт тайлбарыг баталсан бөгөөд ингэхдээ ВХ болон ВХҮҮ-тэй холбоотойгоор ФАТФ-ын шаардлагуудыг хэрхэн ашиглах, нэн ялангуяа ВХ-н үйл ажиллагаа, ВХҮҮ-д зориулж эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх, МУТСТ зорилгоор ВХҮҮ-г хянан шалгах, тусгай зөвшөөрөл олгох эсхүл бүртгэлжүүлэх, харилцагчийг таньж мэдэх (ХТМ) , баримт материал хадгалалт, сэжигтэй гүйлгээний тайлан (СГТ) зэрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээ, мөн бусад хариуцлагын арга хэмжээ, олон улсын хамтын ажиллагааны талаар тодорхой заасан байна.

Түүнчлэн ФАТФ-аас 2019 оны 6-р сард ВХ болон ВХҮҮ-д зориулж эрсдэлд суурилсан аргачлал (ЭСА)-ыг хэрэгжүүлэх энэхүү гарын авлагын анхны хувилбарыг¹ баталсан. Тус хувилбар нь 2021 оны 10-р сард шинэчлэгдсэн. Тус гарын авлагын зорилго нь ВХ, ВХҮҮ-тэй холбоотой зохицуулалт, хяналт шалгалтын арга хэмжээний талаар ойлголтоо нэмэгдүүлэх, ийм арга хэмжээг хөгжүүлэх тал дээр үндэсний эрх бүхий байгууллагуудад дэмжлэг үзүүлэх, мөн хувийн хэвшилд МУТСТ үүрэг хариуцлагыг ойлгож, эдгээр шаардлагуудтай нийцүүлэн ВХ-н үйл ажиллагааг хэрхэн явуулах талаар дэмжлэг үзүүлэх юм.

Энэхүү гарын авлага нь улс орнууд, ВХҮҮ болон ВХ-ийн үйл ажиллагаанд оролцогч бусад этгээдүүдэд ВХ-ийн үйл ажиллагаатай холбоотойгоор мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх (МУТС) эрсдэлийн талаар ойлгуулах, эдгээр эрсдэлд чиглэсэн хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай талаар онцолсон болно. Ялангуяа ВХ-тэй холбоотойгоор онцгойлон анхаарвал зохих эрсдэлийн хүчин зүйлсийн жишээг дурдахаас гадна ВХҮҮ-ийн харилцагчаа таньж тодорхойлох чадамжийг нь сулруулж, гүйлгээг нуун дарагдуулж болох хүчин зүйлсийн талаар онцгойлон анхааруулжээ.

Мөн ВХ-ийн үйл ажиллагаа болон ВХҮҮ нь ФАТФ-ын стандартуудын цар хүрээнд хэрхэн хамаарах талаар гарын авлагад заасан болно. ВХҮҮ-н нэр томъёоны тодорхойлолтод хамаарах таван төрлийн үйл ажиллагааны талаар жишээ татан тайлбарлаж, мөн ФАТФ-ын стандартуудын цар хүрээнд үл хамаарах нөхцөлүүдийн талаар заасан. ВХҮҮ-д тавигдах таван гол шалгуур үзүүлэлт, тухайлбал аливаа этгээдэд зориулж эсхүл түүний өмнөөс үйл ажиллагаа эрхэлсэн байх, ВХ-тэй холбоотой үйл ажиллагаанд идэвхтэй оролцох зэрэг талаар тус гарын авлагад заасан болно.

¹ Энэхүү гарын авлагын дагуу 2015 оны ФАТФ-ын Виртуал Валютуудад зориулсан Эрсдэлд суурилсан аргачлалын гарын авлагыг мөн шинэчилсэн.

Энэхүү гарын авлагад ФАТФ-ын Зөвлөмжүүдийг улс орнууд, холбогдох эрх бүхий байгууллагууд, ВХҮҮ болон ВХ-ийн үйл ажиллагаанд оролцож буй бусад зохицуулалттай этгээдүүд (банк, үнэт цаасны брокер-дилерүүд гэх мэт)-д хэрхэн ашиглах талаар дурдсан. ФАТФ-ын бараг бүх зөвлөмж нь ВХ, ВХҮҮ-тэй холбоотой МУТС эрсдэлд шууд чиглэсэн байдаг бол зарим зөвлөмжүүд нь ВХ, ВХҮҮ-тэй шууд бус байдлаар буюу далд хэлбэрээр уялддаг байна. Иймд ВХҮҮ нь санхүүгийн байгууллагууд (СБ) болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч (СББМҮҮ) нартай ижил бүрэн үүрэг хариуцлага хүлээхээр байна.

Тус гарын авлагад ФАТФ-ын Зөвлөмжүүдийн дагуу ВХ болон ВХҮҮ-д хамаарах бүх чиг үүргүүдийг нарийвчлан заасан бөгөөд ингэхдээ Зөвлөмж тус бүрийн дагуу хүлээх үүргийг дэлгэрэнгүй тайлбарласан. ФАТФ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэхийн тулд ВХ-ийг хөрөнгө болон үнэ бүхий зүйл (“хөрөнгө”, “мөнгөн хөрөнгө”, “мөнгөн болон бусад хөрөнгө”, “харгалзах үнэ бүхий” бусад)-ээр тодорхойлно гэж заасан. Улс орнууд ФАТФ-ын Зөвлөмжүүдийн дагуу холбогдох бүх арга хэмжээнд ВХ, түүнд холбогдох үйл ажиллагаа болон ВХҮҮ нарыг хамруулна.

Гарын авлагад тайлбарласнаар ВХҮҮ нарыг бүртгэлтэй, эсхүл тусгай зөвшөөрөлтэй байхыг, хамгийн багадаа ВХҮҮ нарыг үүсгэн байгуулсан улс орондоо бүртгэлтэй, эсхүл тусгай зөвшөөрөлтэй байхыг шаардсан байна. Хэрвээ ВХҮҮ нь хувь хүн бол бизнесийн үйл ажиллагаа явуулж байгаа улс орондоо бүртгэлтэй, эсхүл тусгай зөвшөөрөлтэй байхыг шаардана. Улс орнууд харилцагчид бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлж байгаа болон тухайн улсаас үйл ажиллагаагаа явуулж байгаа ВХХҮ нарыг мөн бүртгэлтэй, эсхүл тусгай зөвшөөрөлтэй байхыг шаардаж болно. Эрх бүхий байгууллага нь дээр дурдсан тусгай зөвшөөрөлгүй, эсхүл бүртгэлгүй ВХ-ийн үйл ажиллагаа эрхэлж буй хувь хүн, хуулийн этгээдүүдийг илрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Энэ нь үндэсний түвшинд ВХ-ийн үйл ажиллагаа болон ВХҮҮ нарыг хориглохоор шийдвэрлэсэн улс орнуудад ч мөн адил хамааралтай.

Гарын авлагад ВХҮҮ-ийн хяналт шалгалтын хувьд зөвхөн эрх бүхий байгууллагууд (өөрөө зохицуулах байгууллагууд байж болохгүй) нь ВХҮҮ-д хяналт, шалгалт хийж болно гэж тодорхой заасан. Эдгээр эрх бүхий байгууллагууд нь эрсдэлд суурилсан хэлбэрээр хяналт шалгалтыг хэрэгжүүлэхээс гадна хяналт шалгалт хийх, холбогдох баримт бичиг, мэдээллийг гаргуулан авах, хариуцлага хүлээлгэх бүрэн эрхтэй байна. ВХҮҮ нарын үйл ажиллагаа, үйлчилгээний хил дамнасан онцлог шинж чанарыг харгалзан үзэж хянан шалгагч нарын хооронд олон улсын түвшний хамтын ажиллагаа байх шаардлагатай болохыг онцлон дурдсан байна.

ВХҮҮ болон ВХ-ийн үйл ажиллагаанд оролцогч бусад аж ахуйн нэгжүүд нь ФАТФ-ын 3.10-21-д тусгасан бүх урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Ингэхдээ эдгээр үүрэг хариуцлагыг хэрхэн биелүүлэх талаар гарын авлагад тодорхой заасан бөгөөд байнгын бус гүйлгээний босго дүн 1,000 ам.доллар/евро байх шаардлагыг тусгасан байна. Хэрвээ энэ босго дүнгээс давсан бол ВХҮҮ нь (3.10-ын дагуу) харилцагчийг таньж мэдэх ёстой. Мөн (3.16-ын дагуу) ВХ-ийн шилжүүлэгт холбогдох шилжүүлэгч болон хүлээн авагчийн талаар шаардлагатай мэдээллийг бүрэн дүүрэн, үнэн зөв авч, хадгалах, дамжуулах талаар заасан байна. Мөн холбогдох эрх бүхий байгууллагууд нь дотоодын

мэдээлэл хамгаалах болон нууцлалын хууль тогтоомж, дүрэм журмуудтайгаа нийцүүлсэн байдлаар дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлж, зохицуулах ёстой.

Эцэст нь МУТСТ зорилгоор ВХ-ийн үйл ажиллагаа, ВХҮҮ болон бусад зохицуулалттай этгээдийг зохицуулах, хянаж шалгах, хуулийн хэрэгжилтийг хангуулах арга замуудын талаар жишээгээр хангаж өгсөн байна.

2021 оны 10-р сард төр болон хувийн хэвшил аль алинд чиглэсэн байдлаар энэхүү гарын авлагыг шинэчлэн боловсруулсан. Ийнхүү шинэчлэхдээ зургаан гол асуудалд төвлөрсөн байна. Үүнд: (1) ВХ болон ВХҮҮ-ийн тодорхойлолтыг гаргахдаа илүү өргөн цар хүрээг хамарсан байдлаар тодорхойлж, ФАТФ-ын стандартуудад хамаарахгүй санхүүгийн хөрөнгөтэй байж болохгүйг онцолсон (энэ нь ВХ юм уу өөр бусад санхүүгийн хөрөнгөд ч хамааралтай), (2) ФАТФ-ын стандартуудыг тогтвортой койн (стэйблкойн)-д хэрхэн ашиглах, ФАТФ-ын стандартын дагуу тогтвортой койны үйл ажиллагаанд оролцож буй аж ахуйн нэгжүүдийг ВХҮҮ гэж үзэх эсэх талаар тайлбарласан, (3) зохицуулалттай этгээдүүдийг оролцуулаагүй P2P гүйлгээтэй холбоотой МУТС эрсдэлүүд, эдгээр эрсдэлээс сэргийлэхийн тулд улс орнуудын авч хэрэгжүүлэх боломжтой арга хэрэгслүүдийн талаар нэмэлтээр тусгасан, (4) ВХҮҮ-д тусгай зөвшөөрөлд олгох, бүртгэх талаар шинэчлэн заасан, (5) “шилжүүлгийн дүрэм”-ийг хэрэгжүүлэх тал дээр төр болон хувийн хэвшилд нэмэлт удирдамж өгсөн, (6) ВХҮҮ нарын хянан шалгагчдын дунд мэдээлэл хуваалцах, хамтран ажиллах зарчмуудыг тусгасан. Энэхүү баримт нь 2019 оны гарын авлагыг орлоно.

БҮЛЭГ НЭГ: УДИРТГАЛ

Оршил

1. Шинэ технологи, холбогдох бүтээгдэхүүн, үйлчилгээ нь санхүүгийн инноваци болон үр ашгийг нэмэгдүүлж, санхүүгийн хүртээмжийг сайжруулах боломжтой ч нөгөө талаас гэмт хэрэгтнүүд, террористуудын хувьд хууль бусаар олсон хөрөнгө орлогоо угаах, хууль бус үйл ажиллагааг санхүүжүүлэх шинэ боломжийг бий болгож байна. ЭСА нь 2012 онд ФАТФ-ын гишүүн орнуудын баталсан ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандартыг хэрэгжүүлэхэд нэн чухал. ФАТФ нь шинэ технологитой холбоотой эрсдэлийг идэвхтэй хянаж байдаг. Шинэ технологитой уялдан гарч ирж буй эрсдэл буюу шинээр үүсэх эрсдэлүүдийг хянаснаар улс орнууд болон зохицуулалттай этгээдүүд ЭСА-ын дагуу эрсдэлийн үнэлгээг хийх мэдээллээр хангагдаж, улмаар эдгээр эрсдэлийг арилгахад шаардлагатай нөөцийн зохистой хуваарилалтыг хийхэд дэмжлэг болдог.
2. Виртуал валютууд болон тэдгээртэй холбоотойгоор цахим орчинд үнэ бүхий зүйл шилжүүлэх шинэ аргачлал бүхий төлбөр тооцооны механизмууд хөгжиж байгаатай холбогдуулан 2014 оны 6-р сард ФАТФ нь *Виртуал валютууд: Нэр томъёоны тодорхойлолтууд болон МУТС-д тулгарч болзошгүй эрсдэлүүд* нэртэй бичиг баримтыг гаргасан. 2015 оны 6-р сард ФАТФ нь виртуал валютын төлбөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний МУТС эрсдэлийг бууруулахад чиглэсэн үе шаттай авч хэрэгжүүлж буй арга хэмжээний хүрээнд *Виртуал валютад эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх тухай гарын авлага* (2015 оны Виртуал валютын гарын авлага)-ыг гаргасан.
3. 2015 оны Виртуал валютын гарын авлага нь виртуал валютын үйл ажиллагааны уламжлалт санхүүгийн системтэй огтлолцож буй цэг, шилжилтүүд, нэн ялангуяа виртуал валютын арилжааны онцлог шинж чанарт чиглэсэн. Сүүлийн жилүүдэд ВХ-ийн зах зээл хувьсан өөрчлөгдөж ВХ-ийн гүйлгээ зэрэг олон шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загвар, үйл ажиллагааг хамрах болсон.
4. Ялангуяа ВХ-ийн экосистемийн хувьд нууцлалыг нэмэгдүүлсэн крипто валютууд (ННКВ), холих болон хөрвүүлэх үйлчилгээ, төвлөрсөн бус платформууд болон биржүүд, хувийн хэтэвч² зэрэг ил тод байдлыг бууруулж, санхүүгийн урсгалыг нуун дарагдуулах боломжтой олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ хүчтэй түрэн гарч ирж байна. Цаашлаад койнын анхдагч зах зээлийн арилжаа (ICO) зэрэг ВХ-ийн бусад бизнесийн загварууд, үйл ажиллагаа хөгжиж байгаа нь МУТС эрсдэл, залилан, луйвар, зах зээлийн манипуляцийн эрсдэлүүдийг үүсгэж байна. Бусад бүтээгдэхүүн үйлчилгээтэй харьцуулахад илүү хялбар, хямд, аюулгүй байдлаар гүйлгээг нуун халхлах виртуал давхаргын схемүүдийг ихээр хэрэглэж, шинэ хууль бус санхүүжилтийн хэлбэрүүд үүсэн хөгжсөөр байна.
5. Энэ чиглэлээр нэмэлт бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж, шинэ үйлчилгээний төрөл нэвтрүүлж байгаатай холбоотойгоор ФАТФ нь шинэ технологи, үйлчилгээ үзүүлэгчдэд

² Хувийн хэтэвчийг мөн холимог хэтэвч гэж нэрлэж байгаа бөгөөд энэ нь олон хүмүүсийн гүйлгээг нэг шилжүүлэгт нэгтгэн шилжүүлэх боломж олгодог.

зориулж өөрийн стандартуудыг хэрхэн хэрэглэх хүрээнд илүү нарийвчлан тодорхойлох шаардлага үүссэн. Иймд 2018 оны 10-р сард ФАТФ нь нэр томъёоны тодорхойлолтдоо “виртуал хөрөнгө” (ВХ) болон “виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч” (ВХҮҮ) гэсэн хоёр шинэ нэр томъёог нэмэлтээр тусгаж, 3.15-ыг шинэчилсэн (Хавсралт А-г үз). Эдгээр өөрчлөлт, шинэчлэлтийн зорилтууд нь дэлхийн санхүүгийн системийн найдвартай байдлыг хамгаалах, ВХ-тэй холбоотой МУТС эрсдэлүүдийг арилгахад улс орнуудад туслалцаа үзүүлэх, ВХҮҮ нарын салбарт зохицуулалтыг бий болгохын тулд ВХ-ийн үйл ажиллагаа, ВХҮҮ нарт ФАТФ-ын стандартуудыг хэрхэн ашиглах талаар илүү тодорхой болгоход оршино. Түүнчлэн ФАТФ нь өөрийн стандартуудыг ВХ хоорондын, виртуал болон албан ёсны мөнгөн тэмдэгт хоорондын гүйлгээ болон бусад ВХ-ийг оролцуулсан үйл ажиллагаанд ч хамааралтай болохыг зааж өгсөн.

6. 2019 оны 6-р сард ФАТФ нь ЗТ.15-ыг баталсан бөгөөд ингэхдээ ВХ болон ВХҮҮ-тэй холбоотойгоор ФАТФ-ын шаардлагуудыг хэрхэн ашиглах, нэн ялангуяа ВХ-ийн үйл ажиллагаа, ВХҮҮ-д зориулж ЭСА-ыг хэрэгжүүлэх, МУТСТ зорилгоор ВХҮҮ-г хянах шалгах, тусгай зөвшөөрөл олгох ба бүртгэлжүүлэх, ХТМ, баримт материал хадгалах, сэжигтэй гүйлгээг мэдээлэх зэрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээ, мөн бусад хариуцлагын арга хэмжээ, олон улсын хамтын ажиллагааны талаар тодорхой тусгасан байна (Хавсралт А-г үз).
7. ФАТФ нь 2019 оны 6-р сарын чуулганаар энэхүү гарын авлагыг баталсан. Энэхүү гарын авлагыг баталж, ФАТФ-ын Стандартуудад өөрчлөлт оруулсны дараа ФАТФ нь ВХ-ийн салбарын хяналтыг сайжруулж, нэмэлт өөрчлөлт оруулсан стандартуудыг улс орнуудад хэрэгжүүлэх үүрэг өгсөн. 2020 оны 3-р сард ФАТФ нь дижитал нөхцөлд ХТМ-д дэмжлэг үзүүлэх зорилгоор Дижитал бичиг баримтын гарын авлагыг гаргасан. Энэ гарын авлага нь ерөнхийдөө дижитал бичиг баримтад чиглэсэн бөгөөд ВХҮҮ нарт зориулсан чухал мэдээллийг агуулжээ. 2020 оны 6-р сард ФАТФ нь нэмэлт өөрчлөлт оруулсан ФАТФ-ын стандартуудын хэрэгжилтийн 12 сарын хугацааны ажиглалтын тайланг дуусгасан ба улмаар ФАТФ-ын стандартуудыг хэрэгжүүлэхэд тодотгох шаардлагатай зүйлсийг олж тодорхойлсон. Энэхүү тайлантай зэрэгцэн ФАТФ нь тогтвортой койнын талаарх Их 20-д зориулсан тайланг мөн гаргасан. Уг тайланд ФАТФ-ын нэмэлт өөрчлөлт оруулсан стандартуудыг тогтвортой койнд хэрхэн ашиглах, МУТСТ асуудлуудыг хэрхэн авч үзэх талаар дурджээ.
8. ФАТФ нь 2020 оны 9-р сард төр болон хувийн хэвшилд зориулан ВХ-ийн МУТС сэжигтэй гүйлгээний шинж тэмдгүүд тайланг гаргасан. Цаашлаад 2021 оны 3-р сард МУТСТ Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын гарын авлагыг гаргасан. Энэхүү тайланд ерөнхийдөө МУТСТ хяналт шалгалтын талаар тусгаснаас гадна ВХҮҮ нарт зориулсан МУТСТ хяналт шалгалтын мэдээллийг тусгайлан нэмсэн. 2021 оны 7-р сард ВХ болон ВХҮҮ нартай холбоотойгоор нэмэлт өөрчлөлт оруулсан ФАТФ-ын стандартуудын хэрэгжилтийн 12 сарын хугацааны ажиглалтын хоёр дахь шатны тайланг гаргасан. Тус тайланд улс орнууд нэмэлт өөрчлөлт оруулсан ФАТФ-ын стандартуудыг нэвтрүүлэх хүрээнд ахиц гарсан байгаа ч түүнийг хэрэгжүүлэх тал дээр сул тал байсныг онцлон дурдсан нь МУТС зорилгоор ВХ, ВХҮҮ нарыг урвуулан ашиглахаас сэргийлсэн олон улсын тогтолцоо хараахан бүрэлдэн тогтоогүй байгааг илэрхийлэн анхааруулжээ. Мөн тус тайланд зохицуулалттай этгээдийг оролцуулаагүй Р2Р гүйлгээний зах зээлийн хэмжүүр үзүүлэлтүүдийг багтаасан ба улс орнууд “шилжүүлгийн дүрэм”-ийг

хэрэгжүүлэх тал дээр хангалтгүй байгаа нь энэ дүрмийг хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулах хувийн хэвшлийн сонирхлыг бууруулж байгааг онцлон тэмдэглэсэн. Тус тайланд дурдсанаар ВХ болон ВХҮҮ нарт зориулж шинэчилсэн гарын авлага нь ФАТФ-ын нэмэлт өөрчлөлт орсон стандартуудын ашиглалттай холбоотой асуудалд шаардлагатай тодруулгын мэдээллээр хангаж, эдгээр стандартын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлсэн байна.

9. 12 сарын ажиглалтын тайлан, Их 20-д зориулсан тайлан болон 2 дахь шатны 12 сарын ажиглалтын тайлангийн үр дүнд үндэслэж ФАТФ нь төр болон хувийн хэвшилд зориулан нэмэлт өөрчлөлт оруулсан стандартууд, эдгээрийг ВХ болон ВХҮҮ нарт хэрхэн ашиглах тухай шинэчилсэн гарын авлагыг гаргасан. Эдгээр тайлангуудад зургаан үндсэн асуудлыг олж тогтоосон бөгөөд эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд энэхүү гарын авлагыг 2021 оны 11-р сард дахин шинэчилсэн. Ингэхдээ 1) ВХ болон ВХҮҮ-ийг илүү өргөн цар хүрээнд тодорхойлж, ФАТФ-ын стандартуудад хамаарахгүй санхүүгийн хөрөнгөтэй байж болохгүй талаар онцолсон (энэ нь ВХ юм уу өөр бусад санхүүгийн хөрөнгөд ч хамааралтай), (2) ФАТФ-ын стандартуудыг тогтвортой койн (стэйблкойн)³-д хэрхэн ашиглах, ФАТФ-ын стандартуудын дагуу тогтвортой койнын үйл ажиллагаанд оролцож буй аж ахуйн нэгжүүдийг ВХҮҮ гэж үзэх эсэх талаар тайлбарласан, (3) зохицуулалттай этгээдүүдийг оролцуулаагүй P2P гүйлгээтэй холбоотой МУТС эрсдэлүүд, эдгээр эрсдэлээс сэргийлэхийн тулд улс орнуудын авч хэрэгжүүлэх боломжтой арга хэрэгслүүдийн талаар нэмэлтээр тусгасан, (4) ВХҮҮ-д тусгай зөвшөөрөл олгох, бүртгэх талаар шинэчлэн заасан, (5) “шилжүүлгийн дүрэм”-ийг хэрэгжүүлэх тал дээр төр болон хувийн хэвшилд нэмэлт удирдамж өгсөн, (6) ВХҮҮ нарын хянан шалгагчдын дунд мэдээлэл хуваалцах, хамтран ажиллах зарчмуудыг тусгасан. Дээр дурдсан тайлангууд болон ФАТФ-ын бусад тайлангууд, цаг үеийн нөхцөл байдлыг харгалзан тус гарын авлагыг мөн шинэчилсэн. Энэхүү гарын авлагад оруулсан өөрчлөлт, шинэчлэлтүүдийг Хавсралт В-д хураангуйлан үзүүлэв.

Гарын авлагын зорилго

10. Энэхүү шинэчлэгдсэн гарын авлага нь 2015 оны виртуал валютын гарын авлагыг өргөжүүлж, ВХ-д зориулсан МУТСТ арга хэмжээнд ЭСА-ыг хэрхэн хэрэгжүүлэх талаар дэлгэрэнгүй тайлбарласан. ВХҮҮ нарын тодорхойлолтыг гаргаж, ВХ болон ВХҮҮ-ийн салбарт ФАТФ-ын зөвлөмжүүдийг хэрхэн хэрэглэх талаар тодотгосон. Тус гарын авлагын зорилго нь ВХ-ийн үйл ажиллагаа болон ВХҮҮ нарт зориулсан зохицуулалтын арга хэмжээний ойлголтыг өгөх, түүнийг боловсруулах, шаардлагатай бол ВХ-ийн үйл ажиллагаа болон ВХҮҮ-тэй холбоотой МУТС эрсдэлүүдийг удирдахын тулд үндэсний хууль тогтоомждоо нэмэлт өөрчлөлт оруулах тал дээр эрх бүхий байгууллагуудад дэмжлэг үзүүлэхэд оршино.
11. Мөн энэхүү гарын авлага нь ФАТФ-ын нэр томъёоны тайлбарт тодорхойлсон ВХ-н үйл ажиллагааг эрхлэхийг зорьж буй хувийн хэвшлийн байгууллагуудад МУТСТ үүрэг

³ Нэр томъёоны тайлбар: ФАТФ-ын зүгээс “тогтвортой койн” гэдэг нэр томъёог хуулийн болон техникийн хүрээнд тодорхойгүй үг хэллэг гэж үзсэн ч энэ нь ерөнхийдөө энэ төрлийн койн дэмжигчдийн ашигладаг маркетингийн үг хэллэг юм. Иймд ФАТФ-ын зүгээс Их 20-д зориулсан тайландаа “тогтвортой койн” гэдэг нэр томъёог ашиглажээ. Нэр томъёоны нийтлэг хэрэглээг ашиглахын тулд энэхүү гарын авлагад “тогтвортой койн” гэж цаашид нэрлэнэ. Гэхдээ энэ нь ямар нэг утга санаа, баталгааг илэрхийлэхгүй болно.

хариуцлагын талаар илүү сайтар ойлгуулах, ФАТФ-ын шаардлагуудыг хэрхэн үр дүнтэй биелүүлэх тал дээр дэмжлэг үзүүлэх зорилготой. Тус гарын авлага нь улс орнууд, эрх бүхий байгууллагууд, салбарынханд ХТМ, баримт материал хадгалах, сэжигтэй гүйлгээг тайлагнах зэрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх, ВХ-ийн үйл ажиллагаа болон ВХҮҮ нарт зориулсан эрсдэлд суурилсан МУТСТ зохицуулалтын болон хяналт, шалгалтын тогтолцоог боловсруулах, хэрэгжүүлэх талын чиглэлийг өгнө.

12. Тус гарын авлагад 2018 оны 10-р сард ФАТФ-ын баталсан нэр томъёог оруулсан бөгөөд ФАТФ-ын нэр томъёоны тайлбараас “виртуал хөрөнгө” болон “виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч” гэсэн тодорхойлолтуудыг үзнэ үү (Хавсралт А).
13. Энэхүү гарын авлага нь ВХ-ийн үйл ажиллагаа болон ВХҮҮ нарт зориулж ФАТФ-ын зөвлөмжүүдийг хэрхэн хэрэгжүүлэх талаар тайлбарлахыг зорьсон бөгөөд ингэхдээ хамаарал, хэрэгцээ бүхий жишээг ашиглаж, эрсдэлийг арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд үүсч болох болзошгүй саад бэрхшээлүүдийг тодорхойлсон. Энэ нь мөн 3.15 болон ЗТ.15-д нэмэлт тодруулга болж өгсөн бөгөөд өөрөөр хэлбэл ФАТФ-ын Зөвлөмжүүдийн дагуу ВХ болон ВХҮҮ нарт хамаарах чиг үүргүүдийг тодорхойлсон. Үүнээс гадна Зөвлөмжийг хэрэгжүүлэхийн тулд ВХ-ийг “хөрөнгө”, “мөнгөн хөрөнгө”, “мөнгөн болон бусад хөрөнгө”, “харгалзах үнэ бүхий” бусад гэж тодорхойлсон. Улмаар ВХҮҮ (болон бусад зохицуулалттай этгээдүүд) нар болон ВХ-ийн үйл ажиллагааны зохицуулалт, хяналт шалгалтад зориулж үндэсний МУТСТ арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх, түүнчлэн МУТСТ хүрээнд ЭСА-ын талаарх нийтлэг ойлголтыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
14. ФАТФ-аас зарим улс орнууд ВХ, ВХҮҮ-ийн салбарын зохицуулалтын тогтолцоог хэрэгжүүлж байгаа ч олон улс орнууд ВХ-ийн үйл ажиллагаатай холбоотой МУТС эрсдэлийг арилгахад чиглэсэн үр дүнтэй тогтолцоог бий болгож чадаагүй хэвээр байгааг цохон тэмдэглэжээ. Нөгөөтээгүүр ВХ-ийн үйл ажиллагаа нь олон улсыг дамнан хөгжиж, ВХҮҮ нар олон орныг хамруулан үйл ажиллагаа явуулах нь нэмэгдэж байна. Иймд ВХ-ийн энэхүү хурдацтай хөгжил, үйл ажиллагааны тэлэлт, олон улсыг хамарсан шинж чанарыг нь харгалзан улс орнууд ВХ-ийн үйл ажиллагаа болон ВХҮҮ нараас үүдэлтэй МУТС эрсдэлийг арилгах яаралтай арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Энэ нь мөн ФАТФ-ын тэргүүлэх ач холбогдол бүхий чухал зорилт юм. Түүнчлэн рэнсомвэйрийн сүлжээ нь ВХ-ийг ашиглаж байгаа нь ихээхэн асуудал үүсгэж байгаа бөгөөд рэнсомвэйрийн дайралт нь нэмэгдсээр байгаа тул дэлхийн хэмжээнд МУТСТ үр дүнтэй тогтолцоог бий болгох шаардлага үүсч байна. Энэхүү гарын авлага нь МУТСТ зорилгоор ВХ-ийн үйл ажиллагаа болон ВХҮҮ нарт зориулж ЭСА-ыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой ч нөгөө талаас ФАТФ-ын зүгээс бусад бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь ВХҮҮ нарыг зохицуулахад чухал ач холбогдолтой байх боломжтой гэж үзэж байна.

Гарын авлагын цар хүрээ

15. ФАТФ-ын стандартаар улс орнуудыг СБ, СББМҮҮ, ВХҮҮ нарт тавигдах тусгайлсан, үйл ажиллагаанд суурилсан МУТСТ чиг үүргийг тодорхойлж, эдгээр чиг үүргийг дагаж мөрдөж байгаа эсэхийг баталгаажуулахыг шаарддаг. ФАТФ-ын зүгээс Зөвлөмжүүд дэх

хөрөнгө, эсхүл үнэ бүхий зүйлтэй холбоотой нэр томъёонууд (“хөрөнгө”, “мөнгөн хөрөнгө”, “мөнгөн болон бусад хөрөнгө”, “харгалзах үнэ бүхий” бусад гм)-д ВХ-ийг хамруулсан бөгөөд улс орнууд ВХ, ВХ-ийн үйл ажиллагаа болон ВХҮҮ-д Зөвлөмжид заасан бүх холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Энэхүү гарын авлага нь нэн тэргүүнд ФАТФ-ын стандартууд ВХ, ВХ-ийн үйл ажиллагаа, ВХҮҮ нарт хэрхэн хамаарч байгааг тодорхойлж, улмаар улс орнуудад ФАТФ-ын стандартыг үр дүнтэй хэрэгжүүлэх ойлголтыг нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэхэд оршино.

16. Түүнчлэн тус гарын авлага нь өөр ВХ-д, мөн албан ёсны мөнгөн тэмдэгтэд хөрвөх боломжтой, бодит санхүүгийн системтэй огтлолцдог ВХ-үүд гэх мэт өөр бусад хөрөнгө, үнэ бүхий зүйл рүү хөрвөх боломжтой ВХ-үүдэд төвлөрсөн. Гэхдээ ВХ болон ВХҮҮ нарт хамааралтай байж болзошгүй бусад зохицуулалтын асуудлууд (хэрэглэгчийн болон хөрөнгө оруулагчийн хамгаалалт, аюулгүй ба найдвартай байдал, татвар, залилан болон зах зээлийн манипуляцитай тэмцэх асуудлууд, сүлжээний мэдээллийн технологийн аюулгүй байдлын стандартууд, санхүүгийн тогтвортой байдлын асуудал гэх мэт)-д хамаарахгүй.
17. Энэхүү гарын авлага нь мөн төв банкнаас гаргасан дижитал мөнгөн тэмдэгтэд хамаарахгүй. ФАТФ-ын хүрээнд эдгээр мөнгөн тэмдэгт нь албан ёсны мөнгөн тэмдэгтийн дижитал илэрхийлэл тул ВХ гэж тооцогдохгүй. Гэхдээ төв банкны дижитал мөнгөн тэмдэгт нь төв банкнаас гаргадаг бусад албан ёсны мөнгөн тэмдэгтийн нэгэн адил ФАТФ-ын стандартад хамаардаг⁴. Төв банкны дижитал мөнгөн тэмдэгт нь өөрийн онцлогоос хамаарч биет албан ёсны мөнгөн тэмдэгттэй харьцуулахад МУТС өөрийн гэсэн онцлог эрсдэлтэй байж болно. Иймд төв банкны дижитал мөнгийг гаргахаас өмнө ирээдүйд үүсч болзошгүй МУТС эрсдэлүүдийг авч үзэх ёстой. Энэхүү гарын авлагад эдгээр валютыг хамруулаагүй нь ФАТФ-ын зүгээс тэднийг ач холбогдолгүй гэж үзэж байна гэсэн үг биш. Өөрөөр хэлбэл, эдгээр мөнгөн тэмдэгтийг энэхүү гарын авлагад хамаарах ВХ бус, харин албан ёсны мөнгөн тэмдэгт гэсэн ангилалд хамаарна гэж үзэж байгаатай холбоотой юм.
18. Үр дүнтэй ЭСА нь тухайн улсын ВХҮҮ-н салбарын онцлог, олон төрөл байдал, уг салбарын хөгжил, холбогдох эрсдэлийн нөхцөл байдал, ВХҮҮ тус бүрийн эрсдэл, тухайн улсад ашиглаж буй хууль, эрх зүйн болон зохицуулалтын арга барил зэргийг харгалзан үздэг. Ингэхдээ ВХ-ийн үйл ажиллагааны хил дамнасан, цахим орчинд суурилсан онцлог шинж зэргийг анхаарч үзнэ. Тус гарын авлагад ЭСА-ыг боловсруулж, хэрэгжүүлж байхдаа улс орнууд болон ВХҮҮ нарын анхаарч үзэх ёстой олон хүчин зүйлсийг тусгасан болно. Үндэсний эрх бүхий байгууллагууд нь тус гарын авлагад заасан ерөнхий зарчмуудыг харгалзан үзэхдээ улс орны хяналт шалгалтын арга барил, хууль эрх зүйн тогтолцоо, тулгарч буй эрсдэлүүд зэрэг тухайн улсын нөхцөл байдлыг авч үзнэ. Ингэхдээ мөн дээр дурдсанчлан ВХ-ийн үйл ажиллагааны хил дамнасан шинж чанарыг харгалзан үзэх ёстой.
19. Хууль бус үйл ажиллагаанд оролцогч гэмт этгээдүүд санхүүгийн салбарын аливаа этгээдийн үйл ажиллагааг урвуулан ашигладгийн нэгэн адил ВХ-ийн үйл ажиллагаанд

⁴ Төв банкны дижитал валютын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг ФАТФ-ын Тогтвортой койнын талаарх Их 20-д зориулсан тайлангийн Хавсралт Б-ээс үзнэ үү.

оролцогч ВХҮҮ нарыг ч мөн МУТС, хориг арга хэмжээнээс зайлсхийх, залилан, рэнсомвэйр төлбөр тооцоо болон бусад сөрөг зорилгоор ашиглаж болох тухай гарын авлагад авч үзсэн. Тухайлбал, 2015 оны виртуал валютын гарын авлага, 2018 оны ФАТФ-ын Эрсдэл, Чиг Хандлага болон Аргачлалын Бүлгээс гаргасан баримт бичгүүд, мөн ВХ, ВХ-ийн үйл ажиллагаа, ВХҮҮ нартай холбоотой МУТС эрсдэлийн талаар бичсэн ФАТФ-ын тайлангууд, мэдэгдлүүдэд ВХ-ийн үйл ажиллагаатай холбоотой МУТС эрсдэлийн талаарх нэмэлт нөхцөлүүдийн талаар дурдсан болно⁵. ВХ нь МУТС-эд ашиглагдах үнэ цэнийн нэг хэлбэр болж, ВХ-ийн үйл ажиллагаа нь уг хөрөнгө, үнэ цэнийг хууль бусаар шилжүүлэх тогтолцоо байх магадлалтай хэдий ч улс орнууд ВХ-ийн үйл ажиллагаа, ВХҮҮ нарыг заавал МУТС өндөр эрсдэлтэй гэж үзэх албагүй. Гэсэн хэдий ч ВХ-ийн үйл ажиллагааны хил дамнасан байдал, нэрээ нууцлах боломж, зайнаас бизнесийн харилцаа үүсгэж, гүйлгээ хийх, зохицуулалттай этгээдийн дундын зуучлалгүй байдал зэрэг нь улс орны эрсдэлийн үнэлгээнд багтсан байх шаардлагатай. Улс орны зохицуулалтын, хяналт шалгалтын тогтолцоо, түүнчлэн эрсдэлд суурилсан хяналт, эрсдэлийн удирдлага нь ВХ-ийн үйл ажиллагаатай уялдсан нийт эрсдэл, аюул заналд мөн нөлөөлнө. Дээр дурдсан арга хэмжээнээс гадна орхигдсон эрсдэл байж болох тул эрх бүхий байгууллагууд болон ВХҮҮ нар нь зохих оновчтой шийдлийг гаргаж ирэх талаар авч үзэх хэрэгтэй. Улс орнууд өөрийн санхүүгийн салбар, зохицуулалт болон хяналт шалгалтын тогтолцооны хүрээнд ВХ, ВХҮҮ нарын үйл ажиллагааг шалгаж, холбогдох эрсдэлийн үнэлгээг хийнэ.

20. ФАТФ нь 2019 оны 6-р сард стандартдаа өөрчлөлт оруулсны дараа ч МУТС зорилгоор ВХ-ийг ашиглах чиг хандлагыг үргэлжлүүлэн хянасан. Улмаар ФАТФ нь МУТС-тэй холбоотойгоор Виртуал хөрөнгийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх сэжигтэй гүйлгээний шинж тэмдгийн 2020 оны 9-р сарын тайландаа ВХ нь гэмт хэргийн үйл ажиллагаанд өргөн цар хүрээгээр өртөх нь нэмэгдсээр байна гэж дүгнэжээ. Тус тайланд дурдсан ВХ-тэй холбоотой гэмт хэргүүдийн дийлэнх нь МУ гэмт хэрэгтэй хамааралтай байсан ба цаашлаад гэмт хэрэгтнүүд ТС, санхүүгийн хориг арга хэмжээнээс зайлсхийх зорилгоор ВХ-ийг ашигладаг байна. Улс орнуудаас ирсэн тайлангуудад дурдсанаар гол гэмт хэргүүд нь МУ, хяналтад байх бодисын болон бусад хууль бус эд зүйл (галт зэвсэг гм)-ийн худалдаа, залилан, татвар болон хориг арга хэмжээнээс зайлсхийх үйлдэл, компьютерын гэмт хэрэг (хулгай болон рэнсомвэйр зэрэг кибер дайралтууд гэх мэт), хүүхдийн мөлжлөг, хүний наймаа, ТС зэрэг байсан байна. Эдгээрээс хоёр төрлийн гэмт хэрэг хамгийн нийтлэг байсан ба эдгээр нь ВХ-өөр шууд гүйлгээ хийсэн эсхүл ВХ-ийг ашиглан хөрөнгөө нуун дарагдуулах замаар хяналтад байх бодисын худалдаа наймааг хийсэн, мөн залилан, луйвар, рансомвэйр халдлага, мөнгө луйвардах үйлдлүүд хамаарсан байна. Сүүлийн үед МУ мэргэжлийн сүлжээ нь өөрсдийн хөрөнгийг

⁵ Тухайлбал Их 20-н Сангийн Сайдууд болон Төв Банкны Захирагч нарт зориулсан 2018 оны 7-р сарын ФАТФ-ын тайлан, Виртуал хөрөнгийн эрсдэлийг арилгах тухай 2019 оны 2-р сарын ФАТФ-ын нийтэд хандсан мэдэгдэл, Их 20-ын Сангийн Сайдууд болон Төв Банкны Захирагч нарт зориулсан 2019 оны 4-р сарын ФАТФ-ын тайлан, “тогтвортой койн” болон бусад шинээр гарч буй хөрөнгөтэй холбоотой МУ эрсдэлийн талаарх 2019 оны 10-р сарын ФАТФ-ын мэдэгдэл, ВХ/ВХҮҮ нартай холбоотой нэмэлт өөрчлөлт оруулсан ФАТФ-ын стандартуудын хэрэгжилтийн 12 сарын хяналтын тайлан (2020 оны 6-р сар), Тогтвортой койнын талаар Их 20-н Сангийн Сайдууд болон Төв Банкны Захирагч нарт зориулсан 2020 оны 6-р сарын ФАТФ-ын тайлан, ВХ-тэй холбоотой МУТС анхаарах ёстой үзүүлэлтүүдийн талаарх 2020 оны 9-р сарын ФАТФ-ын тайлан, ВХ/ВХҮҮ нартай холбоотой нэмэлт өөрчлөлт оруулсан ФАТФ-ын стандартуудын хэрэгжилтийн хоёр дахь удаагийн 12 сарын хяналтын тайлан (2021 оны 7-р сар).

дамжуулах, цуглуулах, нуун дарагдуулах зорилгоор ВХ-ийг ашиглаж байгааг ФАТФ-аас илрүүлсэн байна.

21. ВХ болон ВХҮҮ нартай холбоотойгоор нэмэлт өөрчлөлт оруулсан ФАТФ-ын стандартуудын хэрэгжилтийн 12 сарын хугацааны ажиглалтын тайланд онцлон тэмдэглэснээр залилан хийх, залилангийн мөнгийг угаах, рэнсомвэйр төлбөрийг хүлээн авах зорилгоор ВХ-үүдийг ихээр ашиглаж байна. Улмаар рэнсомвэйрийн халдлагуудын хурд, нарийн төвөгтэй байдал болон зардлууд нэмэгдэх төлөвтэй байна. ВХ нь рэнсомвэйрт оролцогч талуудын чухал хэрэгсэл болж байгаа бөгөөд тэдний хувьд ВХ-гүйгээр үндсэн гэмт хэргээ санхүүжүүлэхэд илүү төвөгтэй болно. Иймд энэ тал дээр ФАТФ-ын стандартуудыг үр дүнтэй, тохиромжтой байдлаар хэрэгжүүлэх нь маш чухал. МУТС эрсдэлийн хувьд улс орнуудын хоорондох арбитрын үйл ажиллагааны боломж, мөн ВХҮҮ нар, хэрэгслүүд, аргачлалууд нь зохицуулалтын шаардлагуудтай нийцээгүй юм уу сул нийцсэн байдал зэрэг нь голлох нөлөөг үзүүлж байна. Хууль бус оролцогч талууд нь МУТС зорилгоор дээрх ВХҮҮ нарын хангалтгүй ХТМ, хянах процессыг ашиглаж байгаа нь ФАТФ-ын стандартуудыг үр дүнтэй, бодитой хэрэгжүүлэхэд саад учруулж, ВХ-ийг нэргүй нууцлан шилжүүлэх арга, хэрэгслүүдийг ашиглаж, хөгжүүлсээр байна. Тус тайланд төвлөрсөн бус байдал, ВХ болон ВХҮҮ-н тодорхойлолт, P2P, шилжүүлгийн дүрмийн хэрэгжилт зэрэг олон тулгамдсан асуудлуудыг онцолсон байна.
22. Энэхүү гарын авлагад санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж буй, эсхүл ийм үйл ажиллагаанд холбогдсон шинэ, шинэлэг технологи, механизмыг автоматаар бусад аргаас илүү сайн гэж үзэж болохгүйг дурдсан. Мөн улс орнууд төлбөрийн үйлчилгээ, эсхүл үнэт цаасны үйл ажиллагаанд ВХ-г ашиглах зэрэг уламжлалт буюу аль хэдийнээ зохицуулалт хийсэн санхүүгийн үйл ажиллагааг гүйцэтгэх шинэ арга хэрэгсэлтэй холбоотой эрсдэлүүдийг үнэлж, эдгээр эрсдэлийг зохих ёсоор бууруулах ёстой.
23. ВХҮҮ, СБ болон бусад санхүүгийн үйлчилгээ үзүүлж буй зохицуулалттай байгууллагууд, эсхүл ВХ-ийн үйл ажиллагаанд оролцогч талууд нь дээр дурдсан хүчин зүйлсийг харгалзан үзнэ. СБ-ууд нь ВХҮҮ, эсхүл ВХ-ийн үйл ажиллагаанд оролцож буй харилцагч нартай харилцаа холбоо тогтоох, эсхүл харилцаа холбоогоо үргэлжлүүлэхдээ ЭСА-г ашиглаж, бизнесийн харилцаан дахь МУТС эрсдэлийг үнэлж, мөн эдгээр эрсдэлийг зохих ёсоор удирдаж, бууруулах боломжтой эсэхийг үнэлэх шаардлагатай (Бүлэг 4-ийг үз). СБ-ууд нь ЭСА-г зохих байдлаар хэрэгжүүлж, зорилтот эрсдэлийн үнэлгээ хийлгүйгээр ВХҮҮ-тэй бизнесийн харилцааг бүр мөсөн дуусгавар болгох, цуцалж болохгүй.
24. ВХҮҮ нарт зориулж МУТСТ тогтолцоог хэрэгжүүлэхдээ ФАТФ болон улс орнууд нь мэдээллийн хамгаалалт ба нууцлал, санхүүгийн хүртээмж, эрсдэлийн удирдлага, хэрэглэгчийн болон хөрөнгө оруулагчийн хамгаалалт, санхүүгийн инноваци зэрэг асуудалтай холбоотой бусад зохицуулалтын шаардлагууд, бодлогын чиглэлдээ МУТСТ шаардлагуудыг хэрхэн тусгах, ямар нөлөө үзүүлж болох талаар ойлгож мэдэх ёстой.
25. Улс орнууд, ВХҮҮ болон ВХ-ийн үйл ажиллагаа эрхлэгч, эсхүл ийм үйл ажиллагаанд оролцдог бусад зохицуулалттай этгээд энэхүү гарын авлагыг хэрэглэхдээ ВХ-ийн үйл

ажиллагаа, ФАТФ-ын Зөвлөмжүүдийн загвар, нэвтрүүлэлттэй холбоотой үндсэн зарчмуудыг анхаарах ёстой. Үүнд:

а. *Функцийн нийцэмжтэй байдал болон зорилтуудад суурилсан аргачлал.* ФАТФ-ын шаардлагууд (ВХ-ийн үйл ажиллагаатай холбоотой шаардлагууд орно) нь эрх зүй, захиргааны өөр өөр төрлийн тогтолцоотой нийцэмжтэй байна. Ингэхдээ өргөн цар хүрээнд юу хийх ёстойг тайлбарлах ёстой ч ялгаатай хувилбаруудыг авч үзэхийн тулд хэрхэн хэрэгжилтийг хангах ёстой талаар нарийвчлан заасан байх шаардлагагүй. Улс орнууд өөрсдийн хууль тогтоомж, дүрэм журмын хэлбэр, агуулгыг өөрчлөх замаар ФАТФ-ын Зөвлөмжүүдийн зорилтуудыг хангахуйц арга хэмжээг баталж, хэрэгжүүлэх шаардлагагүй. Тус гарын авлага нь бүгдэд тохирсон нийтлэг хэм хэмжээний зохицуулалтыг бүх улс оронд хэрэгжүүлэхийг зориогүй бөгөөд харин ФАТФ-ын холбогдох зөвлөмжүүдийг үр дүн юм уу зорилтуудад суурилсан байдлаар хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой юм.

б. *Технологийн хувьд төвийг сахисан зарчим, ирээдүйн баталгаа.* Технологийн платформын оролцоог үл харгалзан ВХҮҮ, ВХ болон ВХ-ийн үйл ажиллагаанд хамаарах хөрөнгө, үнэ бүхий зүйл зэрэгт тавигдах шаардлагуудыг ашиглах ёстой. Үүнтэй нэгэн адил шаардлагууд нь тодорхой бүтээгдэхүүн, үйлчилгээ, эсхүл бизнес эрхлэгчдийн санал болгож буй шийдэл (МУТСТ үүрэг хариуцлагаа биелүүлэхэд туслах зорилготой технологийн хэрэгжилтийн шийдлүүд орно) зэрэгт тусгайлан чиглээгүй байх ёстой. Харин эдгээр шаардлагууд нь хангалттай хэмжээнд уян хатан байх ёстой бөгөөд ингэснээр улс орнууд болон холбогдох байгууллагууд нь шаардлагуудад нэмэлт өөрчлөлт оруулахгүйгээр одоогийн болон шинээр хөгжиж буй технологиудад хэрэглэх боломжтой байна.

в. *Түвшний тоглолтын талбар (функцийн зарчим).* ВХҮҮ нар зарчмын хувьд ижил түвшний үйлчилгээ үзүүлж, ижил түвшний эрсдэл учруулж байгаа бол улс орнууд болон эрх бүхий байгууллагууд нь тэдгээрийн бизнесийн загварыг үл харгалзан зохицуулалт болон хяналт шалгалтын талаасаа эдгээр ВХҮҮ-үүдэд эрх тэгш хандах ёстой. Харин эрсдэлийн түвшин нь харилцан адилгүй бол ЭСА-аар дамжуулж харилцан адилгүй зохицуулалт хийж болно. Өөрөөр хэлбэл нэг ижил үйлчилгээ үзүүлж, нэг ижил МУТС эрсдэл учруулж болзошгүй СБ-уудад ашигладагтай адил зохицуулалт, хяналтыг ВХҮҮ-д ашиглах ёстой гэсэн үг. Энэ нь санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээний шинж чанарт үндэслэж (нэр томьёо, технологи болон бизнесийн загварт үндэслэхгүй) зохицуулалт, хяналт шалгалтыг ашиглах эрсдэлийн үнэлгээ байна. Түүнчлэн улс орнуудын тус тусын эрсдэл, бодлого зэрэгт нөлөөлсөн нэмэлт шаардлагуудыг ФАТФ-ын стандартуудад тусгаагүй ч улс орны болон хяналт шалгалтын харилцан адилгүй байдлаас аль болох зайлсхийхийн тулд олон улсын хэмжээнд үр дүнтэй хэрэгжилтийг хангахуйц байдлаар дотоодын горимуудаа төлөвлөж, хэрэгжүүлэх нь чухал юм.

26. Энэхүү гарын авлага нь заавал дагаж мөрдөх баримт бичиг биш бөгөөд одоогийн стандартуудын талаар тодруулж, тайлбарласан болно (гэхдээ эдгээр стандартыг өөрчлөөгүй). Тус гарын авлага нь МУТС эрсдэл болон бусад нөхцөл байдал, хүчин зүйлстэй холбоотойгоор ВХҮҮ, ВХ болон ВХ-ийн үйл ажиллагааг үнэлж дүгнэх, ангилах зэрэг эрх бүхий байгууллагуудын эрх мэдэл, хэм хэмжээнд нөлөөлөх зорилгогүй, харин улс орнууд болон хувийн хэвшлийн туршлагад үндэслэн, ЭСА-ыг ашиглаж ФАТФ-ын Зөвлөмжүүдийг үр дүнтэй байдлаар хэрэгжүүлэхэд эрх бүхий байгууллагууд, ВХҮҮ болон холбогдох СБ-ууд (ВХ-ийн үйл ажиллагаанд оролцож буй банкууд гэх мэт)-д дэмжлэг тусалцаа үзүүлэх зорилготой юм.

Бүтэц

27. Энэхүү гарын авлага дараах бүтцээс бүрдэнэ. Үүнд: Бүлэг 2-т ВХ-ийн үйл ажиллагаа болон ВХҮҮ нар нь ФАТФ-ын Зөвлөмжүүдийн цар хүрээнд хэрхэн хамаарч байгааг; Бүлэг 3-т ФАТФ-ын Зөвлөмжүүдийг улс орнууд болон эрх бүхий байгууллагуудад хэрхэн ашиглах талаар; Бүлэг 4-т ФАТФ-ын Зөвлөмжүүдийг ВХҮҮ болон банк, үнэт цаасны брокер-дилер зэрэг СБ-ууд буюу ВХ-ийн үйл ажиллагаанд оролцдог, эсхүл ийм үйл ажиллагаа эрхэлдэг бусад зохицуулалттай байгууллагуудад хэрхэн ашиглах талаар; Бүлэг 5-т МУТСТ зорилгын хүрээнд ВХ-ийн үйл ажиллагаа болон ВХҮҮ (болон бусад зохицуулалттай байгууллагууд) нарыг зохицуулах, хянах, хууль тогтоомж, дүрэм журмын шаардлагыг хэрэгжүүлэх арга замуудын талаарх жишээг; Бүлэг 6-т ВХҮҮ нарын хянан шалгагчдын дунд байвал зохих олон улсын хамтын ажиллагаа, мэдээлэл хуваалцах зарчмуудын талаар дурдсан.
28. Хавсралт А-д Зөвлөмж 15-ын шинэчлэгдсэн бичвэр болон Тайлбарыг, мөн ФАТФ-ын нэр томъёоны тайлбарт оруулсан “виртуал хөрөнгө” болон “виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч” гэсэн нэр томъёоны тодорхойлолтуудыг үзүүлсэн. Хавсралт Б-д 2021 оны 11-р сард энэхүү гарын авлагад оруулсан өөрчлөлт, шинэчлэлтийг харуулав.

БҮЛЭГ ХОЁР: ФАТФ-ЫН СТАНДАРТЫН ЦАР ХҮРЭЭ

29. ЭСА-г ВХҮҮ болон ВХ-ийн үйл ажиллагаанд хэрхэн ашиглах боломжтой талаар зааж, эдгээр үйл ажиллагаа, үйлчилгээ үзүүлэгчид нь олон улсын стандартуудын дагуу хэрхэн МУТСТ шаардлагуудыг биелүүлэх ёстой талаар Бүлэг 2-т тайлбарласан болно. ЗТ.15-н 2-р зүйлд зааснаар ВХҮҮ нар нь эрхэлж буй үйл ажиллагааны төрлөөс хамаарч ФАТФ-ын Зөвлөмжүүдийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Мөн хөрөнгө эсхүл үнэ бүхий зүйлтэй холбоотой, эсхүл түүнд суурилсан нөхцөлтэй тусгайлан холбоотой ФАТФ-ын Зөвлөмжүүдэд заасан холбогдох арга хэмжээг ВХ-д авч хэрэгжүүлнэ.
30. ВХҮҮ нар нь зөвхөн албан ёсны мөнгөн хөрөнгөтэй холбоотой уламжлалт үйл ажиллагаа эрхлэх, эсхүл албан ёсны мөнгөн тэмдэгт хоорондын гүйлгээ хийх тохиолдолд эдгээр нь ВХҮҮ-ийн тодорхойлолтын дагуу ВХ хоорондын, виртуал болон албан ёсны мөнгөн тэмдэгт хоорондын үйл ажиллагааны цар хүрээнд хамаарахгүй тул ФАТФ-ын стандартуудад хамаарах бусад ижил төстэй байгууллага, аж ахуйн нэгжүүдэд мөрдөгддөг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Анхдагч эрсдэлийн үнэлгээ

31. ФАТФ-ын Зөвлөмж нь хангалттай баталгаа нотолгоогүйгээр аль ч салбарыг өндөр эрсдэлтэй гэж урьдчилж үздэггүй. ФАТФ-ын стандартуудад МУТС-д өртөж болох салбаруудыг тодорхойлсон байдаг ч үндэсний түвшин дэх нийт эрсдэлийг улс орнууд өөрсдөө салбар (ВХҮҮ)-ын үнэлгээ хийх замаар тодорхойлох ёстой. Нэг салбарын харилцан адилгүй байгууллагууд нь бүтээгдэхүүн, үйлчилгээ, харилцагчид, газарзүйн байршил, бизнесийн загвар болон байгууллагын комплаенсын хөтөлбөрийн чанар зэргээс хамаарч ялгаатай эрсдэлтэй байж болно. З.1-д ЭСА-г ашиглах цар хүрээг дараах байдлаар заасан байна. Үүнд: тухайн улсын МУТСТ тогтолцоонд ямар этгээдүүдийг хамруулах ёстой, эдгээр этгээдийг тухайн тогтолцоотой нийцүүлэн ажиллаж байгаа эсэхийг хэрхэн хянаж, шалгах ёстой, эдгээр этгээдүүдээр холбогдох тогтолцоог дагаж мөрдүүлэхэд хэрхэн шаардлага тавих ёстой, ВХҮҮ болон ВХ-ийн үйл ажиллагаанд оролцож буй бусад зөвшөөрөлтэй этгээдүүдтэй бизнесийн харилцаа холбоо тогтоохдоо юуг анхаарч үзэх ёстой талаар заасан байдаг. Түүнчлэн ФАТФ-ын ЭСА-ын дагуу холбогдох эрсдэлийг удирдахын оронд эдгээрээс зайлсхийх зорилгоор тодорхой салбарын бизнесийн харилцааг хязгаарлах, цуцлах зэрэг салбарыг бүхэлд нь хамарсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг зөвлөдөггүй (энд өөр өөр эрсдэлийн нөхцөл байдлыг үл харгалзан СБ-уудын зүгээс бүх ВХҮҮ нартай бизнесийн харилцааг дуусгавар болгох үйлдэл хамаарна).
32. ЭСА-ын дагуу, мөн ЗТ.15-н 2-р хэсэгт заасны дагуу улс орнууд нь ВХ, ВХҮҮ нартай холбоотой МУТС эрсдэлийг тодорхойлж, үнэлж, ойлгох ёстой. Мөн улс орнууд нь МУТС эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эдгээр эрсдэлийг арилгахын тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь тухайн эрсдэлүүдтэй нийцэж, тохирч байгаа эсэхийг нягтлах ёстой. Түүнчлэн улс орнууд нь ВХҮҮ (болон ВХ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлдэг, эсхүл ВХ-ийн санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд оролцдог бусад зохицуулалттай этгээдүүд) нараас МУТС-тэй холбоотой эрсдэлүүдийг тодорхойлж, үнэлж, илэрсэн эрсдэлийг бууруулах үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг шаардана.

33. Бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл, ажил гүйлгээ, харилцагчийн эрсдэл, газарзүйн хүчин зүйлс, солилцох ВХ-үүдийн төрөл болон бусад хүчин зүйлс гэх мэт ВХҮҮ болон эрх бүхий байгууллагуудаас хамааралтай гэж үзсэн бүх эрсдэлийн хүчин зүйлсийг ВХҮҮ нарын эрсдэлийн үнэлгээнд хамруулах ёстой.
34. ВХ-ийн хувьд дундын зуучлагчгүйгээр гүйлгээ хийх, алсын зайнаас бизнесийн харилцаа холбоо тогтоох боломжтой байдаг. Түүнчлэн хөрөнгийг олон улсын хэмжээнд асар шуурхай, эргэж буцалтгүйгээр хөдөлгөөнд оруулах, санхүүгийн өргөн цар хүрээний үйл ажиллагаанд ашиглах, тухайлбал мөнгөн хөрөнгө болон үнэ бүхий зүйлийг шилжүүлэх, үнэт цаас, түүхий эд, үүсмэл хэрэгслүүдтэй холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор ВХ-үүдийг ашиглах боломжтой байна. ВХ-ийн санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд ашиглагдаж буй эдгээр хүчин зүйлс нь МУТС өндөр эрсдэлийг дагуулж болзошгүй тул дигиталаар таньж баталгаажуулах шийдлийг ашиглах зэргээр хууль бус үйл ажиллагааг олж тогтоох, үүнтэй тэмцэх, холбогдох эрсдэлийг арилгах үр дүнтэй арга хэмжээ шаардлагатай болно⁶. Мөн нэргүй нууцалсан юм уу хуурамч нэртэй гүйлгээг дэмждэг ВХ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээ байгаа нь МУТС эрсдэлийг нэмэгдүүлж байна. Энэ нь нэн ялангуяа эцсийн хүлээн авагч этгээдийг олж тодорхойлох ВХҮҮ-ийн боломжийг хязгаарлаж байна. Хил дамнасан шинж чанартай ВХ-үүдийн хувьд харилцагч болон оролцогч талыг таньж тодорхойлох үйл явц хангалтгүй байгаа нь гол асуудал болж байна. Харилцагчийг таньж тодорхойлох, баталгаажуулах арга хэмжээний хүрээнд алсын зайны, мэдээлэлгүй гүйлгээтэй холбоотой эрсдэлийг хангалттай удирдаж чадахгүй бол холбогдох хөрөнгийг шалгах, хэлцэлд оролцогч талуудыг тодорхойлох тал дээр хүндрэл бэрхшээл үүсч, улмаар МУТС эрсдэл нэмэгдэнэ.
35. Улс орнууд эрсдэлийн түвшинг тодорхойлохдоо харгалзан үзэх ёстой өөр нэг чухал хүчин зүйл бол хил дамнасан байдлаар хөрөнгө шилжүүлэх, төлбөр гүйцэтгэхэд хэрэглэгчдийн зүгээс ВХ, ВХҮҮ нарыг ашиглаж буй түвшин, цар хүрээ юм. Тухайлбал, ВХ-ийн хууль бус хэрэглэгчид нь ВХ-ийн хил дамнасан шинж чанар, гүйлгээний хурд зэргээс гадна мөн ВХ-ийн санхүүгийн үйл ажиллагаа, үйлчилгээ үзүүлэгчдийн зохицуулалт, хяналт шалгалт хангалтгүй байдлыг ашигладаг. Өөрөөр хэлбэл ВХ-ийн экосистем дэх хууль, эрх зүйн зохицуулалтын нийцэмжгүй байдлыг давуу тал болгон ашигладаг гэсэн үг. ВХ-ийн хувьд олон тооны оролцогч талуудтай, газарзүйн хувьд өргөн цар хүрээг хамарсан, олон улсын хэмжээнд хөрөнгийг шилжүүлэхэд ашиглаж болох хөдөлгөөнт, эсхүл цахим орчинд суурилсан төлбөрийн үйлчилгээ, механизм ашигладаг тул МУТС зорилготой гэмт этгээдүүдийн хувьд таатай нөхцөл байдлыг бүрдүүлдэг.
36. Түүнчлэн нэг улсад байрлаж буй ВХҮҮ нь бүтээгдэхүүн, үйлчилгээгээ МУТСТ харилцан адилгүй үүрэг хариуцлага, хяналт бүхий өөр улсад байгаа харилцагчдад санал болгож болно. Энэ нь ялангуяа МУТСТ хяналт сул, эсхүл ийм хяналтгүй улс оронд, эсхүл өргөн цар хүрээнд олон улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх боломжгүй улс оронд ВХҮҮ нар байрлаж байгаа тохиолдолд асуудал болох юм. Мөн хэдэн хэдэн улс орнуудын хүрээнд ВХ-ийн орон зай тэлж, үйлчилгээ үзүүлэгчид үйл ажиллагаа явуулж

⁶ Дигиталаар таньж баталгаажуулахтай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг ФАТФ-ын Дигитал таних тэмдгийн гарын авлагаас үзэх боломжтой.

байгаа нь эдгээр улс орнуудын хоорондох харилцагчийн болон гүйлгээний мэдээллийн зөрүүтэй байдлаас шалтгаалж ВХ, ВХ-ийн санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой МУТС эрсдэлийг нэмэгдүүлж болох юм. Энэ нь ялангуяа хил дамнасан гүйлгээний хувьд том асуудал болох бөгөөд тухайн гүйлгээнд оролцсон ямар байгууллага, (хувь хүн болон хуулийн) этгээдийг МУТСТ арга хэмжээнд хамруулах, ямар улс орон нь эдгээр этгээдүүдийг МУТСТ үүрэг хариуцлагаа биелүүлэх тал дээр зохицуулалт (тусгай зөвшөөрөл олгох, эсхүл бүртгэлжүүлэх гм), хяналт шалгалт хийх ёстой гэх мэт олон тодорхойгүй байдлыг үүсгэдэг.

Шигтгээ 1. Тогтвортой койн ба МУТС эрсдэл

Тогтвортой койнын үүрэг нь зарим хөрөнгийн үнэ цэнэтэй холбоотойгоор тогтвортой үнэ цэнээр хангах явдал юм. ФАТФ-ын Их 20-д зориулсан тайланд дурдсанаар эдгээр койн нь зарим төрлийн ВХ-тэй адил МУТС эрсдэл учруулдаг. Учир нь эдгээр койн нь тодорхой нэр, мэдээлэлгүй, хил дамнасан шинж чанартайгаас гадна хууль бус хөрөнгийг ашиглах боломжтой байдаг. Үүнээс тодорхой зарим тогтвортой койнын төслүүд нь олон нийтийн хэрэгцээнд ихээхэн хөгжиж, улмаар МУТС эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүй байна. Олон нийтэд хэрэглэгдэх боломж нь бүх ВХ-д хамааралтай хүчин зүйл мөн боловч энэ нь ялангуяа тогтвортой койнын МУТС эрсдэлийг үнэлэхдээ харгалзан үзвэл зохих чухал хүчин зүйл юм.

Нийтэд хэрэглэгдэх боломжтой байдал нь зайлшгүй харгалзан үзэх ёстой МУТС эрсдэлийн чухал хүчин зүйл юм. Учир нь нийтэд хэрэглэгдэх боломж нэмэгдэх тусам хууль бус хөрөнгийг чөлөөтэй солилцох, хөрвөх чадвар өндөр болдог тул гэмт этгээдүүд ВХ-ийг арилжааны нэг арга хэрэгсэл болгон ашиглах магадлалтай байдаг. Түүнчлэн ВХ нь ВХҮҮ юм уу бусад зохицуулалттай этгээдүүдийг оролцуулахгүйгээр үнэ бүхий зүйлийг хадгалах, арилжих хэрэгсэл болдог тул олон нийтийг өргөн цар хүрээнд хамарч, давхар МУТСТ хяналт, комплаенс хангалтгүй, сул тохиолдолд МУТС эрсдэлийг нэмэгдүүлэх боломжтой⁷.

Тогтвортой койн нь ВХ-ийг төлбөрийн хэрэгсэл болгон нийтээр ашиглахад дэмжлэг үзүүлсэн хүчин зүйлс бүхий онцлог шинж чанаруудтай байж болно. Тодруулбал, тогтвортой койн нь тогтвортой үнэ цэнийг бий болгосноор ихэнх ВХ-үүдэд байдаг үнийн хэлбэлзлийн асуудлыг шийдвэрлэх зорилготой. Ийнхүү үнийн хэлбэлзлийг бууруулснаар тогтвортой койныг хөрөнгө шилжүүлгийн, эсхүл төлбөрийн арга хэрэгсэл болгон нийтээр ашиглах боломжтой юм. Ялангуяа олон улсын төлбөр, зохицуулалтын үйлчилгээг санал болгодог технологийн, теле харилцаа холбооны, эсхүл санхүүгийн томоохон байгууллагуудаас тогтвортой койныг санхүүжүүлж, ивээн тэтгэх боломжтой.

ВХ-үүдтэй нэгэн адил тогтвортой койнын шинж чанарууд нь МУТС эрсдэлийг бодитой болгоход нөлөөлж болно. Тогтвортой койн нь засаглал, нэвтрэх эрх (зохицуулалтгүй хэтэвчийг ашиглах боломжтой болон боломжгүй, мөн систем нь зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй хэлбэртэй байдаг) болон холбогдох үйлчилгээ

⁷ Хэрэглэгч хоорондын дундын зуучлагчгүй арилжаатай холбоотой МУТС эрсдлүүдийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 37-41 дүгээр зүйл, заалтнаас үзнэ үү.

үзүүлэх этгээдүүдийн хувьд нэг талаар төвлөрсөн, нөгөө талаар төвлөрсөн бус шинж чанартай байдаг. Энэхүү дизайны сонголтууд нь МУТС эрсдэлүүдтэй холбоотой бөгөөд тогтвортой койнын зохицуулалт хувьсан өөрчлөгдөх тусам үүнийг даган загварын шинж чанар нь ч өөрчлөгдөх боломжтой. Тухайлбал, тогтвортой койнын төв засаглалын байгууллагууд нь ерөнхийдөө ФАТФ-ын стандартуудад ВХҮҮ юм уу СБ-ын аль нэгээр хамрагдана. Төвлөрсөн бус байдлаар ижил чиг үүргийг гүйцэтгэхэд улс орнууд зохицуулалттай этгээдийг тодорхойлох бүтцийн аргачлал ашиглаж, институцийн загвар болон нэрнээс үл хамаарч ЭСА-д суурилан холбогдох эрсдэлийг бууруулна⁸.

ВХҮҮ болон бусад зохицуулалттай этгээдүүд нь ФАТФ-ын шинэ технологиудтай холбоотой Стандартад заасан ерөнхий үүрэг хариуцлагаа биелүүлэхдээ тогтвортой койнттой холбоотой МУТС эрсдэлийг урьдчилж, одоогийн нөхцөлд болон ирээдүйд чиглэсэн байдлаар тодорхойлж, үнэлэх бөгөөд холбогдох эрсдэлийг удирдах, арилгахад шаардлагатай арга хэмжээг тогтвортой койныг нэвтрүүлэхээс өмнө авч хэрэгжүүлнэ⁹. Тогтвортой койныг нэвтрүүлсний дараа ч эдгээр эрсдэлийг үргэлжлүүлэн бууруулж, тогтвортой койныг нийтээр хэрэглэх болсон тохиолдолд хувьсан өөрчлөгдөж буй эрсдэлийг мөн харгалзан үзэх ёстой.

P2P

37. ФАТФ-ын зүгээс хэрэглэгч хоорондын дундын зуучлалгүй арилжаа (цаашид P2P гэх)-г ВХҮҮ юм уу өөр бусад зохицуулалттай этгээдийг ашиглаж, татан оролцуулаагүй хийж гүйцэтгэсэн ВХ-ийн шилжүүлэг гэж тодорхойлсон (жишээлбэл, хоёр зохицуулалтгүй хэтэвчүүд хооронд хэрэглэгчид нь өөрсдийн өмнөөс ВХ шилжүүлэх ажиллагааг дурдаж болно)¹⁰. ФАТФ-ын стандартад P2P-тай холбоотой МУТСТ хяналтын талаар тусгайлан заагаагүй. Учир нь ФАТФ-ын стандартад ерөнхийдөө хувь хүмүүс бус харин зуучлагч нарын үүрэг хариуцлагыг дурдсан байдаг (үүнд зорилтот санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой шаардлагууд зэрэг зарим үл хамаарах нөхцөл бий).
38. ФАТФ-ын стандартад заасан МУТСТ хяналтаас зайлсхийхийн тулд P2P-г ашиглах боломжтой тул эдгээр гүйлгээ нь МУТС онцгой эрсдэлийг учруулж болно. ВХ-ийн шилжүүлэг нь P2P-аар дамжиж хийгддэг тул МУТС эрсдэлээс сэргийлэх, ийм эрсдэлийг бууруулахад зохицуулалттай байгууллагууд оролцдоггүй. P2P нь хууль бус үйл ажиллагаанд дэм болдог бол хууль бус оролцогч талууд нь гэмт хэргээс олсон орлогоо нуун далдлахын тулд зохицуулалттай зуучлагчгүй байдлыг давуу тал болгон ашигладаг. Учир нь ФАТФ-ын стандартуудад заасан ХТМ, СГТ илгээх зэрэг гол гол функцуудыг гүйцэтгэх зохицуулалттай этгээдүүд P2P-д оролцдоггүй. Иймд төрийн бүртгэлд P2P-ны

⁸ тогтвортой койны хувьд ямар байгууллагууд МУТСТ үүрэг хариуцлагатай болох талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 80-90 дүгээр зүйл, заалтнаас үзнэ үү. тогтвортой койн, түүний шинж чанар болон зохицуулалт, хяналт шалгалтын өргөн цар хүрээний асуудлуудыг хамарсан илүү дэлгэрэнгүй мэдээллийг Санхүүгийн Тогтвортой Байдлын Зөвлөлийн 2020 оны “Дэлхийн тогтвортой койн”-ын зохицуулалт, хяналт шалгалт: Эцсийн тайлан болон Дээд Түвшний Зөвлөмжүүдэд оруулсан болно.

⁹ Шинэ технологиудтай холбоотой ВХҮҮ нарын хүлээх үүрэг хариуцлагын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг III-р хэсэгт заасан Зөвлөмж 15-аас харна уу.

¹⁰ Зарим ВХҮҮ нар нь өөрсдийгөө ХХДЗА-ны платформ гэж сурталчилж болно. Энэ нь энд дурдсан ХХДЗА-аас тусдаа бөгөөд 93-р заалттай хамааралтай. Түүнчлэн хувь хүмүүс ч ВХҮҮ байж болно (58-р заалтыг үз). Хувь хүн нь гүйлгээнд ВХҮҮ-ээр оролцсон тохиолдолд үүнийг ХХДЗА гэж үзэхгүй.

ил тод байдлыг сайжруулбал санхүүгийн шинжилгээ болон хууль сахиулах мөрдөн шалгах ажиллагаанд тустай. Ялангуяа ВХ-тэй холбоотой нэргүй протоколууд, технологиуд байхгүй тохиолдолд бусад мэдээллийн эх үүсвэртэй хослуульж ашиглавал үр дүнтэй юм.

39. ФАТФ-ын хоёр дахь удаагийн 12 сарын хугацааны хяналтын тайланд 7 блокчэйн шинжилгээний компаниас өгсөн мэдээлэлд үндэслэж P2P-н хүрээнд ВХ-үүдийг хэрхэн ашиглаж байгаа талаар дурдсан¹¹. Тус тайланд дурдсанаар тодорхой ВХ-үүдийн ихээхэн хэмжээний дүнг P2P-аар дамжин шилжүүлж байгаа бөгөөд хууль бус гүйлгээний эзлэх хувь нь ВХҮҮ-тэй шууд хийсэн гүйлгээнүүдтэй харьцуулахад P2P-д өндөр байжээ. Гэхдээ блокчэйн шинжилгээний компаниудын өгсөн мэдээлэлд зөрүүтэй байдал их байсан тул P2P болон холбогдох МУТС эрсдэлийн хэмжээний тал дээр нэгдсэн дүгнэлтэд хүрээгүй. Мөн P2P-г төрийн бүртгэлд бүртгэсэн ч гэсэн блокчэйн шинжилгээтэй холбоотой энэ төрлийн судалгаанд хамрах хүрээ, цаг хугацаа, үнэн зөв ба найдвартай байдал зэрэг олон сул тал, сорилтууд байдаг.
40. Иймд улс орнууд P2P-тай холбоотой МУТС эрсдэлийн талаар болон P2P-г динамик байдлаар хэрхэн ашиглаж байгаа талаар сайтар ойлгох шаардлагатай байна. Ялангуяа энэ нь шинэ төрлийн ВХ зах зээлд нэвтрэх үед юм уу өмнөх ВХ-үүдийг нийтээр хэрэглэх болсон үед нэн чухал. Одоогийн байдлаар P2P-ийн ашиглалт нэмэгдэж байгаа онцгой чиг хандлага ФАТФ-д ажиглагдаагүй ч ФАТФ-ын стандартыг хэрэгжүүлж, ВХҮҮ нарыг хянаж буй улс орнуудын тоо нэмэгдэж байгаа тул зохицуулалт, хяналт шалгалтаас зайлсхийхийн тулд цаашид ВХ-ийн гүйлгээнүүд P2P руу шилжих эрсдэл үүсч болзошгүй. ВХҮҮ нарыг оролцуулахгүйгээр P2P-аар дамжуулж хууль бус үйл ажиллагаа ВХ-ийн экосистемд эрс нэмэгдсэн, эсхүл уламжлалт бодит эдийн засагт албан ёсны мөнгөн тэмдэгт болон крипто валютын хооронд ийм гүйлгээ их хийгдэх болсон тохиолдолд энэ нь ФАТФ-ын стандартуудыг хэрэгжүүлсний үр дүнг бууруулах магадлалтай. Иймд P2P-тай холбоотой МУТС эрсдэлийг цаашид тасралтгүй байдлаар хянаж байх ёстой. Улс орнуудын зүгээс P2P-г МУТС өндөр эрсдэл учруулж болзошгүй тул нэмэлт арга хэмжээ шаардлагатай гэж үзвэл эрсдэлийн үнэлгээнд үндэслэж энэхүү гарын авлагын 105-106 дугаар зүйлд заасан нэмэлт арга хэмжээнүүдийг авч үзэж болно.
41. Улс орнууд болон ВХҮҮ нар нь ямар төрлийн P2P өндөр, эсхүл бага эрсдэл учруулж болох талаар, мөн P2P-г тодорхойлогч хүчин зүйлс болон тэдгээрийн харилцан адилгүй эрсдэлийн түвшингийн талаар илүү сайн ойлголт авах ёстой. ВХ-ийн загвараас шалтгаалж холбогдох хүчин зүйлс нь ВХ-ийг ашиглах боломжтой байдал, ВХ-ийн нууцлал, ил тод ба найдвартай байдлыг хянадаг протоколууд, гүйлгээний хураамж зэрэг хэрэглэгчдийн зүгээс P2P-г ашиглаж буй нөхцөл байдалд нөлөө үзүүлж болзошгүй. Улс орнууд эдгээр төрөл бүрийн хүчин зүйлсийг харгалзан үзэж, эрсдэлийг үнэлж, ЭСА-тай нийцэмжтэй хяналтыг хэрэгжүүлэхийн тулд хэрхэн эдгээр хүчин зүйлсийг тодорхойлж байгаагаа үнэлж дүгнэх шаардлагатай. Энэ салбарын хурдацтай хувьсал өөрчлөлт нь эрсдэлийн түвшин, шинж чанар хурдан өөрчлөгдөж, хяналт шалгалтыг илүү цогц байдлаар хийх шаардлагыг үүсгэж болзошгүй юм.

ВХ болон ВХҮҮ нартай холбоотой эрсдэлийн хүчин зүйлс

¹¹ ФАТФ-ын хоёр дахь удаагийн 12 сарын хяналтын тайлангийн 76-102 дугаар заалтуудыг үз.

42. ВХ, ВХ-ийн санхүүгийн үйл ажиллагаа болон ВХҮҮ нартай холбоотойгоор МУТС эрсдэл бодитоор оршин тогтнож байна. Иймд улс орнууд болон ВХҮҮ нар нь энэ чиглэлээр гаргасан ФАТФ-ын өмнөх бичиг баримтууд¹² болон эрсдэлийн үнэлгээний талаарх ерөнхий гарын авлагыг¹³ авч үзэхийн зэрэгцээ ВХ-н үйл ажиллагаа болон ВХҮҮ нарын үйлчилгээ, бүтээгдэхүүнтэй холбоотой эрсдэлүүдийг хэрхэн бууруулж байгааг үнэлж, тодорхойлохдоо дор дурдсан жагсаалтуудыг анхаарч үзэх ёстой. Үүнд:

ВХ-тэй холбоотой элементүүд

а. ВХ-ийн шилжүүлгийн тоо, үнийн дүн; гаргасан ВХ-ийн үнэ болон үнийн хэлбэлзэл; ВХ-ийн зах зээлийн үнэлгээ; эргэлтэд байгаа үнэлгээ; хэрэглэгч улс орнуудын тоо болон улс орон бүр дэх хэрэглэгчдийн тоо; улс орон бүр дэх ВХ-ийн төлбөрийн зах зээлд эзлэх хувь хэмжээ, хил дамнасан төлбөр тооцоо, гуйвуулгад ВХ-ийг ашиглаж буй түвшин;

б. Албан ёсны мөнгөн тэмдэгт болон бусад ВХ-үүдтэй арилжиж буй ВХ-үүдтэй холбоотой МУТС эрсдэл, ВХ-д суурилсан гүйлгээний сувгууд/платформууд нь албан ёсны суурьтай гүйлгээний сувгууд/платформууд болон дижитал үйлчилгээ/платформуудтай уялдаж, холбогдсон байдал;

в. ВХ-ийн төлбөрийн суваг, эсхүл системийн шинж чанар, цар хүрээ (нээлттэй юм уу хаалттай хэлхээт систем, эсхүл бичил төлбөр юм уу засгийн газраас аливаа этгээд рүү чиглэсэн/аливаа этгээдээс засгийн газар руу чиглэсэн төлбөрийг хөнгөвчлөх зорилготой систем гэх мэт);

г. Дараах ангилалд хамаарах ВХ-ийн шилжүүлэг болон хууль бус үйл ажиллагаа (хар сүлжээний зах зээл, рэнсомвэйр болон хакер гэх мэт)-тай холбоотой шилжүүлгийн тоо, үнийн дүн: (1) ВХҮҮ/бусад зохицуулалттай этгээдүүдийн хоорондох, (2) ВХҮҮ/бусад зохицуулалттай болон зохицуулалтгүй этгээдүүдийн хоорондох, (3) зохицуулалтгүй этгээдүүдийн хоорондох (P2P гэх мэт);

д. ВХ-ийн шилжүүлгэнд нэр болон мэдээлэлгүй техник (ННКВ, холих, хөрвүүлэх үйлчилгээ, хэтэвчний хаягуудын кластерчлал, хувийн хэтэвчнүүд гэх мэт) болон нэр, мэдээлэлтэй техник (блокчэйн шинжилгээний хэрэгслүүд ашигласан хэтэвчний хаягийн эрсдэлийн үнэлгээ г.м.)-ийн ашиглалт;

е. Гүйлгээ, үйл ажиллагааг нуун дарагдуулж болохуйц, эсхүл ХТМ, МУТСТ үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэхэд ВХҮҮ нарт саад болохуйц Онион рутер (Tor), Үл харагдах интернет төсөл (I2P) болон бусад нэр, мэдээлэлгүй болгодог програм хангамж, сайжруулалт зэрэг Интернет Протокол (ИП)-ын нэр, мэдээллийн арилгагчид өртөж буй байдал;

¹² Тухайлбал, 2015 оны Виртуал валютын гарын авлага, 2018 оны ФАТФ-ын Эрсдэл, Чиг хандлага болон Аргачлалын бүлгээс гаргасан баримт бичгүүд, ВХ, ВХ-ийн үйл ажиллагаа болон ВХҮҮ нартай холбоотой МУТС эрсдэлүүдийн талаарх ФАТФ-ын тайлангууд болон мэдэгдлүүд. Мөн ВХ-ийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг ФАТФ-ын 2020 оны Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой Виртуал хөрөнгийн хувьд анхаарвал зохих үзүүлэлтүүдээс авах боломжтой.

¹³ Тухайлбал, 2013 оны Үндэсний МУТС эрсдлийн үнэлгээний гарын авлага болон 2019 оны ТС Эрсдлийн үнэлгээний гарын авлага.

ё. Бизнесийн хэмжээ, одоогийн харилцагчийн бааз, оролцогч талууд, гаргагч этгээдийн болон харилцааг удирдаж буй төв байгууллагын хил дамнасан үйл ажиллагааны ач холбогдол (хэрэв байгаа бол).

ВХҮҮ нартай холбоотой элементүүд

а. Аль нэг улсад байрлаж буй ВХҮҮ, эсхүл аль нэг улсад байрлаж буй этгээдүүдэд санал болгож буй үйлчилгээний тоо, төрөл, мөн үйлчилгээ бүртэй холбоотой гүйлгээний тоо ба үнийн дүн;

б. ВХҮҮ нарын МУТСТ хөтөлбөрийн уян хатан байдал, ВХ болон ВХҮҮ нарын үйл ажиллагааг хянах тохиромжтой хэрэгслүүд байгаа эсэх, ВХ-тэй холбоотой МУТСТ хөтөлбөрийн нийцэмжтэй байдлыг хариуцсан этгээдүүдийн мэдлэг, туршлага;

в. ВХҮҮ-ийн хэрэглэгчдийн баазын хэмжээ, төрөл, хэрэглэгчдийн болон тэдгээрийн үйл ажиллагааны талаарх мэдээлэлд ВХҮҮ нар нэвтрэх боломжтой байдал, платформуудын хоорондох нэгтгэл гэх мэт;

г. ВХҮҮ нарын санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээ (үндсэндээ хязгаарлагдмал үнэ бүхий зүйлийг хадгалах санхүүгийн хувьд хязгаарлагдсан этгээдүүдэд чиглэсэн жижиг үнийн дүн бүхий хадгаламж, хадгаламжийн данснууд гэх мэт) болон ВХ-ийн дансны шинж чанар, цар хүрээ;

д. Үйлчилгээ үзүүлэгч (ВХҮҮ, ВХ-ийн үйл ажиллагаанд оролцдог, эсхүл ВХ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлдэг бусад зохицуулалттай этгээд)-ийн эрсдэлд өртөх боломж (гүйлгээ, эсхүл дансны үлдэгдлийн хязгаарлалт гэх мэт)-ийг бууруулж болох аливаа арга хэмжээ, үзүүлэлтүүд;

е. ВХҮҮ нар нь бүхэлдээ онлайнаар (платформд суурилсан арилжаа гэх мэт), эсхүл бодитоор (хувь хэрэглэгчид болон киоскт суурилсан биржүүдийн хоорондох гүйлгээг хөнгөвчлөх арилжааны платформууд гэх мэт) ажиллаж байгаа эсэх;

ё. ВХҮҮ нарын тухайн улс оронтой холбоо хамааралтай байдлаас үүсэх МУТС боломж, хориг арга хэмжээний эрсдэл;

ж. ВХҮҮ нар нь шилжүүлгийн дүрмийг хэрэгжүүлж байгаа эсэх, энэ нь “нар мандах магадлалын асуудал”-ыг үр дүнтэй шийдвэрлэж байгаа эсэх (Бүлэг 3 болон 4-ийн 3.16-г үз);

з. Зохицуулалтгүй этгээдүүдийн хоорондох гүйлгээ (зохицуулалттай этгээдийн оролцоогүй зохицуулалтгүй хэтэвчнүүд, зохицуулалт болон хяналт шалгалт байхгүй улс орон дахь ВХҮҮ гэх мэт) болон эхэн үе шатны P2P (ийм өгөгдөл цуглуулах ажиллагаа нь үндэсний нууцлалын тухай хууль тогтоомжтой нийцсэн байдал);

и. ВХҮҮ нарын зүгээс санал болгож буй, эсхүл санал болгохоор төлөвлөж буй онцгой ВХ, мөн ВХ бүрийн онцгой шинж чанарууд (ННКВ, холимог үйлчилгээ, эсхүл үр дүнтэй ХТМ болон МУТСТ бусад арга хэмжээг хэрэгжүүлэх, ХТМ тал дээр ВХҮҮ

нарын боломжийг хязгаарласан, эсхүл гүйлгээг нуун дарагдуулсан өндөр эрсдэл учруулж болох бусад бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ орно);

й. Гүйлгээг хийхэд ашиглаж болох аливаа ухаалаг гэрээнүүдийн¹⁴ удирдлага, эсхүл үүнтэй холбоотой ВХҮҮ нарын үйл ажиллагаа.

ВХ/ВХҮҮ-ийн хориглолт, хязгаарлалт

43. Зарим улс орнууд энэхүү гарын авлагад дурдаагүй бусад бодлогын зорилгоо (хэрэглэгч болон хөрөнгө оруулагч, зах зээлийг хамгаалах, аюулгүй ба найдвартай байдлыг хангах, мөнгөний бодлогоо хэрэгжүүлэх гэх мэт) хэрэгжүүлэхийн тулд, эсхүл үндэсний зохицуулалтын онцлог, эрсдэлийн үнэлгээ зэрэгт үндэслэж ВХ-ийн үйл ажиллагаа, ВХҮҮ, зохицуулалтгүй этгээдүүдийн явуулж буй ВХ-ийн үйл ажиллагаа зэргийг хориглох, хязгаарлах шийдвэр гаргаж болно. Энэ тохиолдолд 3.15-н зарим шаардлагууд хамаарахгүй ч улс орнууд ВХ-ийн үйл ажиллагаа, ВХҮҮ нартай холбоотой эрсдэлийг үнэлэх, хориглолт ба хязгаарлалтуудтай нийцэмжгүй байдалд арга хэмжээ авах хэрэгслүүд, холбогдох асуудал эрхэлсэн эрх бүхий байгууллагуудтай байх шаардлагатай. Улс орнууд ВХҮҮ нарын ВХ-ийн үйл ажиллагааг хориглох, эсхүл хязгаарлах эсэх тал дээр шийдвэр гаргахдаа ВХ-тэй холбоотой МУТС эрсдэлийг ойлгох ёстой. Аливаа улс орон нь ийм хориглолт, хязгаарлалтыг дагаж мөрдүүлэх техникийн чадавх, нөөцтэй байх ёстой.

МУТС-тэй тэмцэх арга хэмжээний хүрээнд ВХҮҮ-тэй холбоотой ФАТФ-ын нэр томъёоны тодорхойлолт, онцлох зүйлс

ФАТФ-ын Зөвлөмжүүдэд СБ, СББМҮҮ болон ВХҮҮ нарт МУТСТ тусгайлсан шаардлагуудыг тавих, мөн эдгээр шаардлага, үүргийг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавихыг бүх улс орнуудаас шаарддаг.

а. “Санхүүгийн байгууллага” гэж харилцагчид зориулан эсхүл харилцагчийн өмнөөс нэг буюу түүнээс дээш бизнесийн үйл ажиллагааг эрхэлдэг хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ;

б. “Виртуал хөрөнгө” гэж цахимаар арилжаалах, шилжүүлэх, төлбөрийн болон хөрөнгө оруулалтын зориулалтаар ашиглаж болох дижитал үнэ цэнийн илэрхийлэл юм. Виртуал хөрөнгөнд ФАТФ-ын Зөвлөмжийн бусад хэсэгт хамруулсан албан ёсны мөнгөн тэмдэгтийн, үнэт цаас, бусад санхүүгийн хөрөнгийн цахим илэрхийллийг хамруулахгүй;

в. “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч” гэж Зөвлөмжийн өөр хэсэгт хамрагдаагүй дараах бизнесийн үйл ажиллагааг хувь хүн, хуулийн этгээдийн өмнөөс эрхэлж байгаа хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ. Үүнд:

- i. Виртуал хөрөнгө болон албан ёсны мөнгөн тэмдэгт хооронд арилжаа хийх;

¹⁴ ВХ-ийн хувьд “ухаалаг гэрээ” (smart contract) гэдэг нь тодорхой нөхцөл хангагдсан үед гуравдагч талыг шууд оролцуулахгүйгээр оролцогч талуудын дунд ВХ шилжүүлэх зэрэг тусгай үйлдлийг автоматаар гүйцэтгэх зориулалттай компьютерийн програм, эсхүл протокол юм.

- ii. Виртуал хөрөнгө хооронд арилжаа хийх;
- iii. Виртуал хөрөнгө шилжүүлэх¹⁵;
- iv. Виртуал хөрөнгө, хэрэгслийг хадгалах, виртуал хөрөнгийн хяналтыг хэрэгжүүлэх;
- v. Виртуал хөрөнгө гаргагч, борлуулагчид санхүүгийн үйлчилгээ үзүүлэх, оролцох.

ВХ, ВХҮҮ-ийн тодорхойлолттой холбоотой ерөнхий анхаарах зүйлс, мэдээлэл

44. ФАТФ-ын Нэр томьёоны тайлбарт ВХ, ВХҮҮ гэсэн шинэ нэр томьёоны тодорхойлолтыг нэмэх болсон шалтгаан нь шинэ төрлийн дижитал хөрөнгө болон эдгээр хөрөнгөтэй холбоотой тодорхой үйлчилгээ үзүүлэгчдийг хамруулж ФАТФ-ын стандартын хэрэглээг өргөжүүлэн тэлэх явдал байсан. Харин ФАТФ-ын стандартад заасан “санхүүгийн байгууллага” гэсэн нэр томьёоны тодорхойлолтод оруулсан төрөл бүрийн санхүүгийн үйлчилгээний цар хүрээнээс, эсхүл “мөнгөн хөрөнгө”, “мөнгөн болон бусад хөрөнгө” гэсэн одоогийн нэр томьёоны тодорхойлолтуудаас хасах зорилго агуулаагүй.

45. Хэлбэрээс нь шалтгаалан санхүүгийн хөрөнгийг ФАТФ-ын Зөвлөмжүүдэд тусгаагүй гэж үзэж болохгүй бөгөөд ямар ч санхүүгийн хөрөнгө ФАТФ-ын стандартад хамааралгүй үлдэж болохгүй. Тухайлбал, аливаа улс орон нь дижитал хөрөнгийг ВХ-ийн нэр томьёоны тодорхойлолтод хамруулаагүй ч энэ нь санхүүгийн хөрөнгө бол ФАТФ-ын зөвлөмжүүдэд хамруулсан гэж үзнэ. Иймд тухайн хөрөнгөтэй холбоотойгоор үйлчилгээ үзүүлэгч этгээдийг СБ гэж үзэж болно. Улс орон бүр ийм хөрөнгө болон холбогдох үйл ажиллагааг ВХ-ийн нэр томьёоны тодорхойлолтод оруулах, эсхүл бусад санхүүгийн хөрөнгө, ВХҮҮ, СБ гэж тодорхойлох ёстой. Аль ч тохиолдолд ФАТФ-ын Зөвлөмжүүд нь өчүүхэн төдий зөрүүтэйгээр нэгэн ижил мөрдөгдөнө¹⁶.

Виртуал хөрөнгө гэж юу вэ?

46. ВХ-ийн нэр томьёоны тодорхойлолт нь илүү өргөн цар хүрээнд тайлбарлагдаж байгаа тул улс орнууд нь технологийн дэвшил болон шинэлэг бизнесийн загваруудтай холбоотой функцийн аргачлалыг ашиглахдаа үүнд илэрхийлэгдсэн үндсэн агуулгыг ашиглавал зохино. ФАТФ-ын Зөвлөмжүүдийн ерөнхий зарчмын хувьд эдгээр нэр томьёоны тодорхойлолт нь технологийн талаар төвийг сахисан болно. Өөрөөр хэлбэл, эдгээр нэр томьёог ашиглаж буй технологи бус, харин үйлчилгээ, хөрөнгийн үндсэн шинж чанарт нь үндэслэж ашиглах ёстой. Иймд нарийвчлан тайлбарлах ёстой цөөн хэдэн зүйл бий.

¹⁵ Виртуал хөрөнгийн хувьд виртуал хөрөнгө шилжүүлэх гэж хувь хүн, этгээдийн нэрийн өмнөөс виртуал хөрөнгийг нэг данс, хаягаас нөгөө данс, хаяг руу шилжүүлэх гүйлгээ хийхийг хэлнэ.

¹⁶ Эдгээр нь ХТМ (3.10) болон цахим шилжүүлгийн дүрмүүд (3.16) (Шилжүүлгийн дүрэм)-тэй хамааралтай. Эдгээр үүрэг хариуцлагын талаарх дэлгэрэнгүй тайлбарыг Бүлэг 3 болон 4-өөс үзнэ үү.

47. Юун түрүүнд ВХ-үүд нь дижитал байх ёстой бөгөөд ВХ-ийг дижитал байдлаар арилжиж, эсхүл шилжүүлдэг байх ёстой. Мөн төлбөр, хөрөнгө оруулалтын зорилгоор ашиглах боломжтой байх ёстой. “Арилжих”, “шилжүүлэх” зэрэг нэр томъёог сонгохдоо ФАТФ нь санаатайгаар ВХ-ийг ерөнхий, өргөн хүрээнд тодорхойлж өгсөн бөгөөд өргөн цар хүрээний үйл ажиллагааг хамруулсан. Тухайлбал, өөр этгээдэд зориулж хөрөнгө гаргаж, тус хөрөнгийг өөр зүйлээр арилжиж, өөр этгээдэд, эсхүл өөр этгээдийн өмнөөс шилжүүлж, эзэмшлийг нь өөрчилж, устгаж буй үйлдлийг ч энд хамруулж үзнэ.
48. ВХ нь ФАТФ-ын Зөвлөмжийн бусад хэсэгт хамруулсан албан ёсны мөнгөн тэмдэгтийн, үнэт цаасны, бусад санхүүгийн хөрөнгийн цахим илэрхийлэл байж болохгүй тул тус хөрөнгө нь өөрөө төлбөр, хөрөнгө оруулалтын зорилгоор ашиглагдах боломжгүй, мөн дижитал байдлаар арилжих, шилжүүлэх үндсэн шинж чанаргүй байна.
49. Дээр дурдсан шалтгаанаар аливаа этгээдийн бодит валютын эзэмшлийг илэрхийлэх дижитал хэлбэрээр хадгалагдаж буй банкны бүртгэл нь ВХ биш юм. Энэ нь ФАТФ-ын стандартад заасан санхүүгийн хөрөнгө дэх байр суурь, эсхүл эзэмшлийг илэрхийлэх бүртгэл ч мөн биш юм. Гэхдээ албан ёсны мөнгөн тэмдэгт, эсхүл ВХ рүү тогтвортой хувь хэмжээгээр арилжих боломжтой тогтвортой койн зэрэг өөр бусад хөрөнгөөр арилжих дижитал хөрөнгийг ВХ гэж үзэж болно. Энэ нөхцөлд гол асуулт нь ВХ нь төлбөр, эсхүл хөрөнгө оруулалтын зорилгоор арилжиж, шилжүүлэх үндсэн үнэ цэнэтэй юу, эсхүл энэ нь ямар нэг зүйлийн эзэмшлийг бүртгэж, илэрхийлсэн зүйл үү? Гэхдээ ВХ-д тооцогдохгүй хөрөнгүүд нь ФАТФ-ын стандартын цар хүрээнд хамаарахгүй гэж үзэж болохгүй. Харин эдгээр хөрөнгийг үнэт цаас, түүхий эд, үүсмэл хэрэгслүүд, бодит валют зэрэг бусад төрлийн санхүүгийн хөрөнгүүдийн ангилалд хамруулж болно.
50. ФАТФ нь аливаа ижил хөрөнгийг ВХ болон санхүүгийн хөрөнгө гэж аль алинаар үзэх зорилгогүй. Гэхдээ улс орнуудын өөр өөр тогтолцооны хүрээнд нэг ижил хөрөнгийг өөр өөрөөр ангилсан байх, эсхүл нэг ижил хөрөнгийг өөр өөр ангиллын дагуу зохицуулсан байх тохиолдлууд гарч болно. Шинэ дижитал хөрөнгийг санхүүгийн хөрөнгө, эсхүл ВХ-ийн аль нэгээр нь тодорхойлохдоо эрх бүхий байгууллагууд нь тухайн шинж дижитал хөрөнгөд санхүүгийн хөрөнгийн зохицуулсан одоогийн тогтолцоо илүү тохиромжтой юу, эсхүл ВХ-д зориулсан тогтолцоо нь илүү тохиромжтой юу гэдгийг анхаарч үзэх ёстой. Тухайлбал, тухайн хөрөнгө нь мөнгөний дижитал илэрхийлэл, эзэмшигчийн гүйлгээний баримт бичиг, эсхүл эзэмшигчийн хувийн илэрхийлэл бол эрх бүхий байгууллагууд нь холбогдох тогтолцоон дахь эрсдэл арилгах арга хэмжээг хэрхэн хэрэглэх талаар анхаарч үзэх ёстой.
51. Шинж чанарыг нь баталгаажуулахад бэрхшээлтэй тохиолдолд улс орнууд өөрсдийн зохицуулалтын системүүдийг үнэлж, аль нь бүтээгдэхүүн, үйлчилгээний эрсдэлийг арилгаж, удирдахад хамгийн тохиромжтой болохыг шийдвэрлэнэ. Мөн улс орнууд хөрөнгийн нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн хэрэглээ (энэ нь төлбөрийн, эсхүл хөрөнгө оруулалтын зорилгоор ашиглагдах эсэх)-г харгалзан үзэж, ямар төрлийн зохицуулалтын тогтолцоо хамгийн тохиромжтой болохыг тодорхойлох ёстой. Аливаа улс орон нь хөрөнгийг ВХ биш санхүүгийн хөрөнгө гэж тодорхойлсон бол санхүүгийн хөрөнгөтэй холбоотой гарын авлага, МУТСТ стандартуудыг ашиглах ёстой. Технологийн хувьд төвийг сахисан зарчимтай нийцсэн байдлаар санхүүгийн хөрөнгө гэж тодорхойлсон блокчэйнд суурилсан хөрөнгө нь энэхүү ВХ-д чиглэсэн гарын авлагад хамааралгүй байж

болно. Учир нь ашиглагдаж буй технологи бол ФАТФ-ын Зөвлөмжүүдийг ашиглах эсэхийг тодорхойлоход шийдвэрлэх хүчин зүйл биш болно. Гэхдээ энэхүү гарын авлагын элементүүд нь ЭСА-ын хувьд улс орнууд, хувийн хэвшлийнхэнд ач холбогдолтой байж болох бөгөөд бусад гарын авлагад дэмжлэг үзүүлэх ёстой. Аль ч тохиолдолд төлбөрийн, эсхүл хөрөнгө оруулалтын зорилготой хөрөнгө нь ВХ, эсхүл санхүүгийн хөрөнгө эсэхээс үл хамаарч үүрэг хариуцлага хүлээнэ.

52. Дижитал хөрөнгүүд нь харилцан солилцох боломжтой гэхээсээ илүү өвөрмөц, практикт төлбөр, хөрөнгө оруулалтын хэрэгсэл гэхээсээ илүү цуглуулгын шинж чанартай ашиглагддаг бол өвөрмөц токен (NFT), эсхүл крипто цуглуулгын зүйл гэгдэж болно. Ийм хөрөнгүүдийг онцлогоос нь шалтгаалан ФАТФ-ын нэр томъёоны тодорхойлолтын дагуу ВХ гэж үздэггүй. Гэхдээ NFT-ийн шинж чанар болон практик дахь үүрэг функцийг нь харгалзан үзэж, ямар нэр томъёо, эсхүл маркетингийн үг хэллэг хэрэглэх эсэхээ шийдэх нь чухал. Учир нь ФАТФ-ын стандартууд нэр томъёог үл харгалзан тэдгээрийг хамарч болно. Зарим NFT нь ВХ-д тооцогдохгүй мэт харагдаж болох ч практикт төлбөр, эсхүл хөрөнгө оруулалтын зорилгоор ашиглагдаж байгаа бол ВХ-ийн нэр томъёонд хамаарч болно. Иймд эдгээр хөрөнгийг ФАТФ-ын нэр томъёоны тодорхойлолтод оруулсан ВХ-д хамруулахгүй ч санхүүгийн хөрөнгө гэдэг утгаараа ФАТФ-ын стандартуудад хамруулж болно¹⁷. ВХ-ийн орон зай хурдацтай хувьсан өөрчлөгдөж байгаа тул NFT болон бусад ижил төстэй дижитал хөрөнгүүдийн хувьд чиг үүргийн аргачлал нь илүү хамааралтай юм. Иймд улс орнууд тухайн нөхцөл, кейс бүрт үндэслэж ФАТФ-ын стандартуудыг NFT-д ашиглах талаар анхаарч үзэх ёстой.
53. ФАТФ нь Их 20-ийн тайландаа өөр бусад төрлийн дижитал хөрөнгөд ашигладаг нэг ижил шалгуурын дагуу, мөн улс орны зохицуулалтын горим болон тогтвортой койнын шинж чанараас нь хамааруулж тогтвортой койныг ВХ, эсхүл санхүүгийн хөрөнгө (үнэт цаас гм)-ийн аль нэгээр стандартуудад хамруулах талаар дурдсан байдаг.

ВХҮҮ гэж хэн бэ?

54. ФАТФ-ын нэр томъёоны тайлбарт дурдсанаар “виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч” гэж Зөвлөмжийн өөр хэсэгт хамрагдаагүй дараах бизнесийн үйл ажиллагааг хувь хүн, хуулийн этгээдийн өмнөөс ажиллагаа эрхэлж байгаа хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ. Үүнд:
- (i) Виртуал хөрөнгө болон албан ёсны мөнгөн тэмдэгт хооронд арилжаа хийх;
 - (ii) Виртуал хөрөнгө хооронд арилжаа хийх;
 - (iii) Виртуал хөрөнгө шилжүүлэх¹⁸;
 - (iv) Виртуал хөрөнгө, хэрэгслийг хадгалах, виртуал хөрөнгийн хяналтыг хэрэгжүүлэх;

¹⁷ 50 дугаар хэсгийг үз.

¹⁸ Виртуал хөрөнгийн хувьд виртуал хөрөнгө шилжүүлэх гэж хувь хүн, этгээдийн нэрийн өмнөөс виртуал хөрөнгийг нэг данс, хаягнаас нөгөө данс, хаяг руу шилжүүлэх гүйлгээ хийхийг хэлнэ.

(v) Виртуал хөрөнгө гаргагч, борлуулагчид санхүүгийн үйлчилгээ үзүүлэх, оролцох.

55. ВХ-ийн нэр томьёоны тодорхойлолтын хүрээнд ВХҮҮ-ийг өргөн цар хүрээнд тодорхойлж, ойлгох ёстой. Улс орнууд нь аливаа аж ахуйн нэгж байгууллагыг ВХҮҮ үзүүлж байгаа эсэхийг тодорхойлохын тулд чиг үүргийн аргачлал болон нэр томьёоны тодорхойлолттой хамааралтай дараах агуулгыг ашиглах ёстой. Улс орнууд нь байгууллагууд өөрсдийгөө тодорхойлоход ашиглаж буй нэр томьёо, нэршил, эсхүл үйл ажиллагаандаа зориулж ашиглаж буй технологид үндэслэж нэр томьёоны тодорхойлолтыг ашиглах ёсгүй. Дээр дурдсанчлан нэр томьёоны тодорхойлолт нь үйлчилгээ үзүүлэгчийн ашиглаж буй технологиос хамаарахгүй. ФАТФ-ын стандартуудад заасан үүрэг хариуцлага нь байгууллагын үйл ажиллагааны загвар, технологийн хэрэгсэл, бүртгэлийн дизайн, эсхүл үйл ажиллагааны өөр бусад онцлогийг харгалзан үзэлгүйгээр санал болгож буй санхүүгийн үйлчилгээнээс үүдэлтэй байна. Нэр томьёоны тодорхойлолтын агуулгыг харуулахад туслах зорилгоор доорх хэсэгт нийтлэг бизнесийн загваруудыг тодорхойлсон ерөнхий нэр томьёог ашиглах жишээг оруулав. Гэхдээ тухайн байгууллага шаардлага хангасан үйлчилгээ үзүүлж байгаа эсэх талаарх үнэлгээнд суурилж нэр томьёоны тодорхойлолтыг ашиглах ёстой бөгөөд зөвхөн нэр томьёонд үндэслэж жишээг ашиглаж болохгүй.
56. Чиг үүргүүдийг тус тусад нь авч үзэхийн өмнө ойлговол зохих цөөн хэдэн нийтлэг элементүүд байна. ВХ-ийн нэр томьёоны тодорхойлолтод заасанчлан давхардах эрсдэлээс сэргийлэхийн тулд ВХҮҮ-ийн нэр томьёо нь зөвхөн “*Зөвлөмжийн өөр хэсэгт хамрагдаагүй*” байгууллагуудад л зөвхөн хамаарна. Үүнд ФАТФ-ын стандартуудад заасан СБ, эсхүл СББМҮҮ хамаарахгүй. Улс орнууд нь нэр томьёоны тодорхойлолт бүрийн агуулгын суурь ойлголтод үндэслэж хамгийн тохиромжтой гэж үзсэн нэр томьёог ашиглах ёстой. Энэхүү гарын авлагын зорилгын үүднээс уламжлалт СБ болон ВХҮҮ нарын хоорондох үндсэн ялгаатай байдал нь 3.10 болон 3.16-ын ашиглалт бөгөөд улс орнууд зохицуулалт болон хяналт шалгалтын илүү сайн хамгаалалт болж чадах нэр томьёоны тодорхойлолтыг ашиглаж болно¹⁹.
57. Нэр томьёоны тодорхойлолтод “*этгээд*” гэдэг үгийг анх хэрэглэхдээ нэр томьёоны тодорхойлолтын (i)-(v)-р хэсэгт заасан холбогдох үйл ажиллагааг явуулдаг этгээд гэж үзсэн. Тус этгээд нь компани, эсхүл хувь хүн байж болно.
58. “*Эрхлэх, явуулах*” гэдэг нэр томьёонд үйлчилгээ үзүүлэх, эсхүл үйлчилгээнд идэвхтэй байдлаар дэмжлэг үзүүлэх зэргийг хамруулж үзэх бөгөөд ВХҮҮ-ийн нэр томьёоны тодорхойлолтын (i)-(v) дугаар хэсэгт заасан үйл ажиллагааг эрхлэхэд идэвхтэй оролцож буй байдлыг илэрхийлнэ. Иймд эдгээр үйл ажиллагааг явуулдаггүй, эсхүл эдгээр үйл ажиллагаанд идэвхтэй дэмжлэг үзүүлдэггүй, туслах шинж чанарын оролцогч талууд (интернет, эсхүл клауд үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгж байгууллагууд)-д хамааралгүй юм.

¹⁹ Эдгээр зөрүү нь давтамжтай гүйлгээний хязгаарыг бууруулахтай холбоотой ХТМ (3.10) болон ВХ-ийн шилжүүлэгтэй хамааралтай цахим шилжүүлгийн дүрэм (3.16) (Шилжүүлгийн дүрэм)-тэй хамааралтай.

59. “*Бизнесийн үйл ажиллагаа*” гэх нэр томъёонд бизнесийн бус зорилгоор маш ховор тохиолдолд үйл ажиллагаа эрхэлж буй этгээдүүдийг ВХҮҮ-д хамруулж үзэхгүй. Энэхүү нэр томъёоны тодорхойлолтын шаардлагыг хангахын тулд аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийнхөө өмнөөс бус харин арилжааны зорилгоор өөр бусад хувь хүн, хуулийн этгээдийн өмнөөс энэхүү үйл ажиллагааг эрхэлдэг байх ёстой. Ингэхдээ тогтмол бус байдлаар биш, хангалттай хэмжээнд тогтмол байдлаар үйл ажиллагаа эрхэлдэг байх ёстой.
60. “*Өөр бусад хувь хүн, хуулийн этгээдийн өмнөөс*” гэх нэр томъёо нь өөр бусад этгээдэд үйлчилгээ үзүүлэх явцад холбогдох чиг үүргийг гүйцэтгэх тохиолдлыг хамруулж үзнэ. Санхүүгийн үйлчилгээг авч буй этгээдийг мөн “хэрэглэгч”, эсхүл “харилцагч” гэж нэрлэж болно. Тодруулбал, нэг хуулийн этгээд нь ВХ-ийн дотоод (тухайлбал, хуулийн этгээд дотроо аль нэг нэгж руу) шилжүүлэг хийж байгаа бол түүнийг ВХҮҮ гэж үзэхгүй. Энэ тохиолдолд тухайн шилжүүлэг нь ВХҮҮ-д хамаарахгүй байх буюу өөр бусад этгээдийн өмнөөс биш байх ёстой.
61. Дээрх шаардлагуудыг хангаж буй этгээд нь ВХҮҮ-ийн нэр томъёоны тодорхойлолтод заасан нэг буюу түүнээс дээш ангиллын үйл ажиллагаа (“виртуал хөрөнгө/албан ёсны мөнгөн тэмдэгтэд арилжих”, “виртуал хөрөнгө хооронд хөвүүлэх, арилжаа хийх”, “виртуал хөрөнгө хадгалах, хяналт тавих”, “виртуал хөрөнгө гаргагч, борлуулагчид санхүүгийн үйлчилгээ үзүүлэх, оролцох”)–г эрхэлж байгаа бол ВХҮҮ-д тооцогдоно. Эдгээр нэр томъёоны хамрах цар хүрээ, агуулгыг дор дэлгэрэнгүй тайлбарлав.

Хөрвүүлэх, шилжүүлэх, арилжаа хийх

62. ВХҮҮ-ийн нэр томъёоны тодорхойлолтын (i)-р хэсэг нь ВХ болон албан ёсны мөнгөн тэмдэгт хооронд арилжих үйлчилгээтэй холбоотой. Талууд албан ёсны мөнгөн тэмдэгт ашиглаж ВХ-д төлбөр төлж байгаа, эсхүл ВХ ашиглаж албан ёсны мөнгөн тэмдэгтэд төлбөр төлж байгаа бол энэхүү үйлчилгээг санал болгогч, эсхүл үзүүлэгч этгээд нь бизнесийн хэлбэрээр ажиллаж байгаа тохиолдолд ВХҮҮ гэж үзнэ. Үүнтэй нэгэн адилаар (ii)-р хэсгийн хувьд талууд нэг төрлийн ВХ-ийг өөр зүйлийн төлбөрийн хэрэгсэл, арилжаа болгон ашиглаж байвал энэхүү үйлчилгээг санал болгогч, эсхүл үзүүлэгч этгээд нь бизнесийн хэлбэрээр ажиллаж байгаа тохиолдолд ВХҮҮ гэж үзнэ. Тухайн үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчдийг төлөөлж үндсэн этгээдээр, клиринг болон төлбөр тооцооны гүйлгээний үндсэн хариуцагч тал, гүйцэтгэгч тал эсхүл гүйлгээнд тусалж буй зуучлагч байдлаар үүрэг гүйцэтгэж байгаа эсэхээс үл хамаарч дээрх үйл ажиллагаанд (i) болон (ii)-р хэсгийг хамруулж үзнэ. ВХҮҮ нь өөр хувь хүн, хуулийн этгээдийн өмнөөс бизнес байдлаар арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаа тохиолдолд энэ тодорхойлолтын шалгуурыг хангахын тулд арилжаа, эсхүл шилжүүлгийн бүх шинж чанарыг заавал хангасан байх шаардлагагүй.
63. ВХҮҮ-ийн нэр томъёоны тодорхойлолтын (iii)-р хэсэг нь хэрэглэгчдэд ВХ-ийн эзэмшил, хяналтыг өөр хэрэглэгч рүү шилжүүлэх, эсхүл нэг хэрэглэгчийн эзэмшиж буй ВХ-ийн данс, хаягийн хооронд ВХ шилжүүлэх аливаа үйлчилгээнд хамааралтай. ФАТФ-ын стандартуудад (iii)-р хэсгийг тодорхойлохдоо “өөр хувь хүн, хуулийн этгээдийн өмнөөс нэг виртуал хөрөнгийн данс, хаягаас өөр нэг виртуал хөрөнгийн данс, хаяг руу ВХ шилжүүлэх” гэжээ. Энэ хэсэг нь практикт юуг хамарч болохыг ойлгохын

тулд шилжүүлгийн дараах ВХ-ийн одоогийн шинж чанарыг анхаарч үзэх нь чухал юм. Шинэ этгээд нь ВХ-ийг хадгалах, эзэмших эрхтэй, мөн ВХ-ийн хяналтыг өөр бусад этгээдэд шилжүүлэх боломжтой, ВХ-ийг ашигласнаас өгөөж хүртэх боломжтой бол шилжүүлэг хийх боломжтой. ВХҮҮ нь өөр бусад хувь хүн, хуулийн этгээдийн өмнөөс бизнесийн үйл ажиллагаа явуулж байгаа бол хяналтын хувьд нэг болон олон гарын үсгийн процессоос²⁰ заавал чөлөөлөгдөх албагүй (доорх (iv)-р хэсгийг үз). Мөн нэг этгээд хөрөнгийг үргэлж ганцаараа хянаж байвал үйлчилгээ үзүүлэгч нь (iii)-р хэсэгт заасан шаардлага хангасан үйлчилгээг үзүүлэхгүй байгааг илтгэж болно. Гэсэн хэдий ч шилжүүлэгт идэвхтэй дэмжлэг үзүүлж байгаа гэсэн утгаараа (iii)-р хэсэгт хамааруулж болно (59-р хэсгийг үз). Мөн үүнд нэг ижил ВХҮҮ-ийн хэрэглэгчдийн хоорондох шилжүүлэг хамаарах бөгөөд ВХҮҮ нарын ашиглаж буй сүлжээний бус дотоод баримт материал хадгалах системийг ч энд хамруулна. Энэ тохиолдолд ВХ нь нэг ижил сүлжээний омнибус хэтэвч, эсхүл дансандаа хэвээр байна.

64. (iii)-р хэсэг нь санхүүгийн хөрөнгөтэй холбоотой мөнгө, үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ (МҮБЗШҮ)-ний талаарх 3.14-тэй агуулгын хувьд төстэй²¹. (iii)-р хэсэгт заасан үйлчилгээний талаар жишээ гэвэл ВХ-ийг өөр бусад этгээдүүд рүү илгээх боломжийг хэрэглэгчдэд олгож, идэвхтэй дэмжлэг үзүүлсэн функц юм. Энэ нь хувийн шилжүүлгийн төлбөр, санхүүгийн бус бараа, үйлчилгээний төлбөр, эсхүл цалингийн төлбөр байж болно. Ийм үйлчилгээ үзүүлж буй этгээд нь ВХҮҮ байж болно.
65. Төвлөрсөн бус бирж, эсхүл платформ гэж ерөнхийдөө танигдсан технологиор дамжиж мөн арилжаа, шилжүүлгийн үйлчилгээ хийгдэх боломжтой. Тухайлбал, “төвлөрсөн бус эсхүл тархмал апплейкшн (ТБАпп) нь блокчэйн, эсхүл үүнтэй ижил төстэй технологи дээр ажилладаг програм хангамжийг илэрхийлсэн нэр томьёо юм. Заримдаа ийм апплейкшн нь бусад протокол, апплейкшнүүд, эсхүл дижитал хөрөнгө болон тэдгээрийн шилжүүлэгт дэмжлэг үзүүлдэг. Эдгээр апплейкшн нь ихэвчлэн төвлөрсөн бус бүртгэл дээр ажилладаг боловч ВХ-ийг бүтээх, эхлүүлэх, ТБАпп-ын функцууд болон захиргааны “түлхүүр”-ийг хадгалж буй дансад зориулсан хэрэглэгчийн интерфэйсүүдийг хөгжүүлэх, төлбөр хураамж цуглуулах зэрэг зарим төрлийн оролцоо, хяналт бүхий төвлөрсөн этгээдтэй байна. Эзэмшигч/оператор/хөгжүүлэгч/олон нийтийн ашиг тусын төлөө ерөнхийдөө ВХ-д төлөгддөг төлбөр, хураамжийг ТБАпп-г ашиглахын тулд төлөхийг хэрэглэгчээс шаарддаг байдлаар ТБАпп-ыг програмчилж болно. ТБАпп нь ВХ-үүдийн арилжаа, шилжүүлгийг дэмжиж, эсхүл арилжаа, шилжүүлгийг гүйцэтгэж болно. Эдгээр ТБАпп нь санхүүгийн үйлчилгээ (ВХҮҮ нарын санал болгодог үйлчилгээ г.м.)-г санал болгож байгаа бол “төвлөрсөн бус санхүү” (ТБС) гэдэг нэр томьёог ерөнхийдөө ашигладаг.
66. ФАТФ-ын стандартууд нь үндсэн програм хангамж, эсхүл технологид хамааралгүй тул ТБС-ийн апплейкшн (програм хангамж г.м.) нь эдгээр стандартын дагуу ВХҮҮ биш юм (доорх 82-р хэсгийг үз). Гэхдээ үүсгэн байгуулагчид, эзэмшигчид, операторууд, эсхүл ТБС-ийн зохицуулалтад хяналт тавьж, хангалттай хэмжээнд нөлөөлж буй бусад

²⁰ Олон гарын үсэгтэй процесс, эсхүл загварын хувьд тухайн этгээд нь түрийвчээс гүйлгээ хийхийн тулд хэд хэдэн дижитал гарын үсэгтэй байх (иймд хэд хэдэн хувийн түлхүүртэй байх) шаардлагатай.

²¹ ВХҮҮ-тэй холбоотойгоор МҮБЗШҮ-ний үүрэг хариуцлага (МҮБЗШҮ үзүүлэгч нарыг МУТСТ хөтөлбөрт агентаар оруулахад тавигдах шаардлага, эдгээр хөтөлбөртэй нийцэмжтэй байгаа эсэхийг хянах гэх мэт)-ын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Бүлэг 3-ын 3.14-с үз.

этгээдүүд нь ВХҮҮ-ийг үзүүлж, эсхүл идэвхтэй дэмжлэг үзүүлж байгаа бол эдгээр зохицуулалт нь төвлөрсөн бус байсан ч гэсэн ФАТФ-ын ВХҮҮ гэсэн нэр томъёоны тодорхойлолтод хамаарч болно. Тухайлбал, өөр бусад талууд үйлчилгээнд үүрэг гүйцэтгэж байгаа, эсхүл процессын зарим хэсэг нь автоматажсан бол дээрх тохиолдолд хамаарна. Эзэмшигчид/операторуудыг гүйцэтгэж буй үйл ажиллагаатай нь харилцан хамааралтай байдлаар нь ялган ангилж болно. Жишээлбэл, ухаалаг гэрээ, эсхүл зарим тохиолдолд санал авах протоколоор дамжин хэрэгжиж байгаа ч хэрэглэгчид болон эзэмшигчид/операторуудын хоорондох бизнесийн харилцаа, үйлчилгээний протоколын функцууд, хөрөнгө зэрэгт хяналт тавьж, эсхүл хангалттай нөлөөлж болно. Мөн үйлчилгээнээс ямарваа этгээд үр өгөөж хүртэж байгаа эсэх, ТБС-ийн зохицуулалтын эзэмшигч/операторыг тодорхойлох үзүүлэлтүүдийг тохируулах, өөрчлөх боломжтой эсэх зэрэг бусад хүчин зүйлсийг улс орнууд харгалзан үзэж болно. Эдгээр нь тухайн эзэмшигч/операторыг ВХҮҮ болгож буй гагцхүү хэдэн шинж чанарууд биш боловч эдгээрийг тусгасан байвал зохино. Мөн үйл ажиллагаанаас шалтгаалж ТБС-ийн зохицуулалттай харилцдаг нэмэлт ВХҮҮ нар байж болно.

67. Энэхүү орон зайд олон улсын хэмжээнд нээлттэй эх үүсвэртэй төслүүд болон хөгжүүлэлтийн оролцогч талууд гарч ирж байгаатай холбоотойгоор ТБС-ийн төслүүд нь тоо, чадамжийн хувьд хурдацтай өргөжин тэлж байна. Энэхүү гарын авлага нь чиглэл өгөх зорилготой бөгөөд улс орнууд хувь хүн, эсхүл хуулийн этгээд үйлчилгээ үзүүлж байгаа эсэхийг тодорхойлохын тулд нөхцөл байдал тус бүрийг үнэлж дүгнэх шаардлагатай. Эзэмшигч, эсхүл оператор нь ВХҮҮ эсэхийг тодорхойлоход ТБС гэж өөрийгөө тодорхойлсон байдал, эсхүл ийм маркетингийн үг хэллэг нь ач холбогдолгүй бөгөөд мөн тусгай технологи ч үүнд хамааралгүй болно. Улс орнууд нь стандартуудад заасан зарчмуудыг өргөн хүрээнд нэр томъёог тайлбарласан байдлаар ашиглах ёстой бөгөөд ингэхдээ чиг үүргийн аргачлалын практик зорилгыг харгалзан үзнэ. ТБС-ийн зохицуулалтууд нь хяналт, эсхүл хангалттай нөлөө бүхий этгээдийг бодитоор оролцуулсан бол өөрсдийгөө төвлөрсөн бус гэж нэрлэх нь маш түгээмэл байдаг бөгөөд улс орнууд энэхүү өөрийгөө тодорхойлсон байдлыг харгалзан үзэлгүйгээр ВХҮҮ-ийн нэр томъёоны тодорхойлолтыг ашиглах ёстой. ФАТФ нь бизнес байдлаар санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг хувь хүн, хуулийн этгээдийг хамруулж авч үзэх зорилготой гэсэн зарчмыг улс орнуудад баримтлах ёстой. Эзэмшигчид/операторууд нь ВХҮҮ-ийн нэр томъёоны тодорхойлолтод хамаарч байвал програм хангамж, платформ гаргах, ашиглахын өмнө МУТС эрсдэлийн үнэлгээг гүйцэтгэж, эдгээр эрсдэлийг одоо болон ирээдүйд чиглэсэн байдлаар удирдах, бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой²². Аливаа этгээд нь ВХҮҮ-ийн засаглалын токеныг худалдан авах боломжтой бол тухайн ВХҮҮ нь МУТСТ үүрэг хариуцлагыг биелүүлэх ёстой. Ийм нөхцөлд токен эзэмшигч хувь хүн нь бусдын өмнөөс бизнес хэлбэрээр явуулж буй ВХҮҮ-ийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хангалттай нөлөөлж чадахгүй бол дээр дурдсан үүрэг хариуцлагыг хүлээхгүй.
68. ТБС-ийн зохицуулалтад хяналт тавих, эсхүл хангалттай нөлөөлөх хувь хүн, хуулийн этгээд мөн эсэхийг тодорхойлох боломжгүй бол ВХҮҮ-ийн тодорхойлолтод нийцэх үндсэн эзэмшигч/оператор байхгүй байж болно. Ийм нөхцөлд улс орнууд нь ТБС-ийн

²² Шинэ технологитой холбоотой ВХҮҮ нарын үүрэг хариуцлагын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахын тулд Бүлэг 3-ын 3.15-ыг үз.

үйлчилгээ, зохицуулалтын учруулж буй эрсдэлийг хянаж, ТБС-ийн төлөөлөгч нартай хамтран ажиллах ёстой. Ийм байдлаар ажиллаж буй ТБС-ийн үйлчилгээ нь мэдэгдэж байвал улс орнууд эрсдэл бууруулах арга хэмжээг анхаарч үзэх ёстой. Үйлчилгээг эхлүүлэхийн өмнө, эсхүл ТБС-ийн үйлчилгээг санал болгох явцад дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлж болно. Жишээлбэл, энд дурдсан этгээдүүдийг ВХҮҮ гэж тодорхойлоогүй бол улс орнууд нь өөрсдийн ЭСА, эсхүл бусад эрсдэлийг бууруулах аргачлалд нийцүүлсэн байдлаар ТБС-ийн зохицуулалттай холбоотой үйл ажиллагаанд зохицуулалттай ВХҮҮ-ийг оролцуулахыг шаардаж болно. Мөн улс орнууд нь энэхүү гарын авлагад дурдсанчлан P2P-тай холбоотойгоор МУТС эрсдэлүүд болон эрсдэл бууруулах арга хэмжээний талаар авч үзэх ёстой²³.

69. Мөн өөр бусад түгээмэл ВХ-ийн үйлчилгээ, эсхүл бизнес загварууд нь ВХҮҮ-ийн нэр томъёоны тодорхойлолтын (i), (ii) болон (iii)-р хэсэгт заасан арилжаа, эсхүл шилжүүлэгт хамаарч болно. Ийм үйлчилгээ, эсхүл загваруудын цаана байгаа хувь хүн, хуулийн этгээд нь өөр бусад этгээдийн өмнөөс бизнес хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаа бол тэдгээрийг ВХҮҮ гэж үзнэ. Эдгээрт оруулж болох нь:

а. Үйлчилгээ үзүүлж буй аж ахуйн нэгж нь хөрөнгийг хадгалж байхад албан ёсны мөнгөн тэмдэгтийг ВХ-өөр арилжихаар илгээх, хүлээн авах, шилжүүлэхийн тулд ВХ-ийн худалдан авагчдын ашиглаж буй ухаалаг гэрээний технологи бүхий үйлчилгээ гэх мэт ВХ-ийн эскроу данс;

б. Хувь хүн, хуулийн этгээдийн өмнөөс ВХ-ийг гаргах, арилжихад туслалцаа үзүүлэх брокерийн үйлчилгээ;

в. Хэрэглэгчдэд нөгөө талаа олох, үнэ мэдрэх боломж олгох замаар худалдагч, худалдан авагч нарыг хооронд нь учруулах, мөн хэрэглэгчдийн худалдах, худалдан авах захиалгыг тааруулсан төхөөрөмж ашиглах замаар арилжаа хийх захиалга-бүртгэлийн арилжааны үйлчилгээ. Гэхдээ зөвхөн ВХ-ийн худалдагч, худалдан авагч нарыг хооронд нь учруулах боломж олгож, ВХҮҮ-ийн нэр томъёоны тодорхойлолтын дагуу аливаа үйлчилгээ үзүүлдэггүй платформыг ВХҮҮ гэж үзэхгүй,

г. Маржин арилжаа, эсхүл алгоритмд суурилсан арилжаа зэрэг илүү уян хатан арилжааны техник ашиглах боломжийг хэрэглэгчдэд бүрдүүлж өгсөн арилжааны дэвшилтэт үйлчилгээ.

70. Арилжаа болон/эсхүл шилжүүлгийн бизнесийн загваруудад ВХ-ийг албан ёсны мөнгөн тэмдэгтээр, эсхүл цалин хөлс (төлбөр хураамж, шимтгэл, ханшийн зөрүү юм уу бусад ашиг)-нд зориулсан өөр бусад ВХ-өөр арилжихад дэмжлэг үзүүлсэн ВХ-ийн арилжаа, шилжүүлгийн үйлчилгээг хамруулж болно. Эдгээр загвар нь бэлэн мөнгө, шилжүүлэг, кредит карт, ВХ зэрэг төлбөрийн олон аргачлалыг хүлээн зөвшөөрдөг. Уламжлалт ВХ-ийн арилжаа, эсхүл шилжүүлгийн үйлчилгээ нь администратороос хамаарсан, хамаараагүй, эсхүл гуравдагч талын үйлчилгээ үзүүлэгч байж болно. “АТМ”, “биткойн теллер машин”, “биткойн АТМ”, эсхүл “худалдааны машин” зэрэг киоскийн үйлчилгээ үзүүлэгчид нь эзэмшигч/оператор нар ВХ, албан ёсны мөнгөн тэмдэгт, бусад ВХ-ийн

²³ Энэхүү гарын авлагын 37-41 болон 104-106 дугаар хэсгийг үз.

хоорондох арилжаа, эсхүл албан ёсны мөнгөн тэмдэгт болон ВХ-ийн хоорондох арилжаа хийхэд дэмжлэг үзүүлсэн биет электрон машин (киоск)-аар дамжуулж ВХ-ийн үйл ажиллагаа явуулж, эсхүл ийм үйл ажиллагаанд идэвхтэй дэмжлэг үзүүлдэг тул дээрх нэр томьёоны тодорхойлолтод багтан орж болно.

*Хадгалах, хяналтыг хэрэгжүүлэх*²⁴

71. ВХҮҮ-ийн нэр томьёоны тодорхойлолтын (iv)-р хэсгийг мөн өргөн цар хүрээнд ойлгох ёстой. ВХ-д хяналтыг хэрэгжүүлэх боломжтой аливаа хуулийн этгээдийг (iv)-р хэсэгт хамруулж ойлгож болно. Учир нь энэ нь “хадгалах”, “хяналтыг хэрэгжүүлэх” гэсэн үгсийн агуулга, утга санааг илэрхийлж байна. “Хадгалах” гэдэг үгийг хамгийн энгийн байдлаар тайлбарлавал өөр бусад этгээдийн өмнөөс ВХ-ийн хувийн түлхүүр, эсхүл ВХ-ийг хадгалах үйлчилгээ юм. “Хяналтыг хэрэгжүүлэх” гэдэг үг нь өөр бусад этгээдийн өмнөөс ВХ-ийг удирдах гэсэн агуулгыг мөн илэрхийлж болно.
72. “Хяналт” гэдэг үг нь ВХ-ийг хадгалах, арилжих, шилжүүлэх, зарцуулах боломжтой байдлыг илэрхийлнэ. ВХ-ийг ашиглах, эсхүл ВХ-ийн шинж чанарыг өөрчлөх боломжтой этгээдүүд нь хянах эрхтэй байна. “Шилжүүлэх” гэдэг нэр томьёоны хувьд хяналт нэг талын байх ёстой гэсэн утга санааг илэрхийлэхгүй. “Хяналт” гэдэгт бусдын эзэмшиж буй түлхүүр, эсхүл эрхүүд нь олон гарын үсэг зурах хөрөнгийн шинж чанарыг өөрчлөхөд шаардлагатай нөхцөл байдлыг хамруулж ойлгоно. Олон талууд гүйлгээнд зориулсан түлхүүр ашиглах ёстой олон гарын үсгийн загвар, загварууд байгаа бол энэ нь ВХ-д нөлөөлөх нөлөөллөөс хамаарч тодорхой байгууллага хяналт хэрэгжүүлэхгүй гэсэн үг. Хяналтын талаарх энэхүү тайлбар нь мөн (iv)-р хэсэгт заасан “хяналтыг боломжтой болгох” гэсэн утга санааг илэрхийлнэ.
73. Тухайлбал, нэр томьёоны тодорхойлолтын энэхүү хэсэгт хадгалах хэтэвчний үйлчилгээ үзүүлэгчийг хамруулж үзэх бөгөөд учир нь эдгээр үйлчилгээ үзүүлэгчид өөр бусад этгээдийн өмнөөс ВХ-ийг хадгалж байгаатай холбоотой. Хуульч зэрэг эксроу үйлчилгээ санал болгох боломжтой этгээдүүд нь энэхүү үйлчилгээг бизнес хэлбэрээр тогтмол үзүүлдэг эсэх, өөрсдөө, эсхүл хадгалах хэтэвчний үйлчилгээ үзүүлэгч зэрэг хяналтыг аутсорсингоор гүйцэтгүүлдэг этгээд хяналтыг хэрэгжүүлж байгаа эсэхийг харгалзан үзнэ. Нэр томьёоны тодорхойлолтод заасан функцийг үзүүлж байгаа эсэх нь ВХҮҮ-ийг тодорхойлох чухал хүчин зүйл болох бөгөөд харин хуульч гэх мэтийн ангилал нь хамааралгүй болно. Эргэлзээтэй байвал бусад этгээдийн өмнөөс ВХ-ийн хяналтыг хэрэгжүүлэх аливаа хуулийн этгээдийг хамруулсан байдлаар нэр томьёоны тодорхойлолтыг уян хатан, ойлгомжтой байдлаар тайлбарлах ёстой.
74. ВХҮҮ-ийн нэр томьёоны тодорхойлолтын (iv)-р хэсгийн хувьд улс орнууд нь аливаа этгээдийн ВХ-ийг хамгаалах функцийг хэрэгжүүлдэг үйлчилгээ, эсхүл бизнесийн загваруудыг харгалзан үзэх ёстой. Эсхүл улс орнууд нь эзэмшигч/хэрэглэгчийн зааврын дагуу л зөвхөн удирдлага, шилжүүлгийг хийнэ гэсэн таамаглалын дагуу ВХ-ийг удирдах, шилжүүлэх эрх мэдэлтэй эсэхийг харгалзан үзнэ. Хадгалах, хянах үйлчилгээнд

²⁴ Энэ хэсэгт ашигласан (“хадгалах”, “хяналтыг хэрэгжүүлэх”, “нэмэлт үйлчилгээ” эх мэт) нэр томьёог ВХ/ВХҮҮ-ийн хүрээнд ашиглаж, тайлбарлана. Эдгээр үг хэллэгийг өөр бусад нөхцөлд (банкны болон бусад уламжлалт санхүүгийн хэрэгслүүд, үйлчилгээ зэрэгтэй холбоотойгоор гэх мэт) хэрэглэх агуулгатай нь хольж, төөрөлдөх хэрэггүй.

өөр бусад этгээдэд хамаарах ВХ-тэй холбоотой хувийн түлхүүрийг нь хянах эрхтэй, эсхүл өөр бусад этгээдэд хамаарах ВХ-тэй холбоотой ухаалаг гэрээний нэг тал бус ч тус гэрээг хянах эрхтэй аливаа этгээдийг хамруулж болно.

75. Энэхүү үйлчилгээг санал болгохыг өөр бусад этгээдэд зөвшөөрсөн туслах дэд бүтцийн үйлчилгээ үзүүлдэг компаниуд, тухайлбал, клауд үйлчилгээ үзүүлэгч, эсхүл гарын үсгийн үнэн зөв байдлыг баталгаажуулах үүрэг бүхий үйлчилгээ үзүүлэгч зэрэг нь энэхүү нэр томъёоны тодорхойлолтод хамаарахгүй. Энэхүү хэсэг нь зөвхөн програм/техник хангамжийг хөгжүүлэх, борлуулах үүрэг бүхий зохицуулалтгүй хэтэвчний үйлчилгээ үзүүлэгчид, эсхүл програм хангамж хөгжүүлэгч нарт хамааралгүй²⁵. Гэхдээ улс орнууд нэр томъёоны тодорхойлолтыг онцгой тохиолдлуудад хэрэглэхдээ тухайн нөхцөл байдлыг анхаарч үзэх ёстой.

ВХ гаргагчийн санал, эсхүл арилжаатай холбоотой санхүүгийн үйлчилгээ үзүүлэх, энэ төрлийн үйлчилгээнд оролцох

76. ФАТФ-ын ВХҮҮ-ийн тодорхойлолт нь ИСО-тай холбоотой үйл ажиллагааг хамрах зорилготой. ИСО нь ерөнхийдөө шинэ төсөлд зориулж санхүүжилт босгох арга хэрэгсэл юм. Ялангуяа (v)-р хэсэг нь ИСО зэрэг үйл ажиллагаагаар дамжуулж ВХ-ийг борлуулахад, эсхүл ВХ гаргагчийн саналд зориулж холбогдох санхүүгийн үйлчилгээ үзүүлж, оролцдог этгээдүүдэд хамааралтай. Ийм этгээдүүд нь ВХ-ийг гаргах, санал болгох, худалдах, түгээх, зах зээлийн эргэлтэд оруулах, арилжих хүрээнд ИСО-г гаргагч этгээдтэй хамааралтай, эсхүл хамааралгүй байж болно. Тухайлбал, үүнд хөрөнгийг дахин борлуулах, хуваарилахын тулд ВХ гаргагч этгээдээс ВХ-ийг худалдан авах захиалгыг авч, санхүүжилт олгож, худалдан авч буй этгээдүүдийг, мөн захиалга, андеррайтеринг, зах зээлийг тодорхойлох, байршуулах агентын үйл ажиллагаа зэргийг ч хамруулж үзнэ. Мөн ВХҮҮ-ийн нэр томъёоны тодорхойлолтын бусад хэсгүүд нь ИСО-д оролцдог бизнесүүдэд хамааралтай байж болно. Түүнчлэн ВХ-ийг гаргахад оролцож буй хувь хүн болон хуулийн этгээд нь ВХҮҮ-ийн нэр томъёоны тодорхойлолтын (i)-(iv) дүгээр хэсэгт заасан арилжаа, шилжүүлэг, хадгалах үйл ажиллагаатай холбоотой үйлчилгээг үзүүлж болно. Ялангуяа энэ нь ИСО зэрэг үйл ажиллагаагаар дамжуулж ВХ-ийг гаргаж, санал болгож, худалдаж буй ВХ гаргагч этгээдтэй хамааралтай.

77. Тодруулбал, ВХ-ийг дангаараа гаргаж буй үйлдэл нь ВХҮҮ-ийн нэр томъёоны тодорхойлолтын (v)-р хэсэгт заасан үйлчилгээ биш юм²⁶. Гэхдээ өөр бусад этгээдийн өмнөөс гаргасан ВХ-ийг арилжих, шилжүүлэх бизнесийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээдүүд нь ИСО-тай холбоотой санхүүгийн үйлчилгээ үзүүлж, оролцож байгаа тул үйлчилгээ үзүүлсэнд тооцогдоно. ВХ-ийн програм хангамж бүтээгч нь өөр бусад этгээдийн өмнөөс нэр томъёоны тодорхойлолтод заасан функцийг бизнес байдлаар гүйцэтгээгүй л бол ВХ-ийг гаргахын тулд ВХ-ийн програм хангамжийг бүтээх үйлдэл нь тухайн бүтээгчийг ВХҮҮ болгохгүй.

78. ИСО-ийн хүрээнд ВХ гаргах, санал болгох, борлуулах, түгээхтэй холбоотойгоор ВХ гаргагчид санхүүгийн үйлчилгээ үзүүлж, оролцож буй этгээдүүдийг зохицуулахын тулд

²⁵ 82-р хэсгийг үз.

²⁶ Энд дурдсан ВХ гаргах гэдэг нь ВХ-ийг бүтээхийг хэлэх бөгөөд энэ нь тухайн ВХ-ийг санал болгох, арилжих процессоос ялгаатай.

аливаа улс орны хүлээх МУТСТ үүрэг хариуцлага нь нэг буюу түүнээс дээш улс орны МУТСТ, эсхүл өөр бусад хууль тогтоомж (мөнгө шилжүүлэх, үнэт цаас, түүхий эд, үүсмэл үнэт цаасны үйл ажиллагаа гэх мэт)-той холбогдож болно.

Нэр томъёоны тодорхойлолтын цар хүрээ

Шигтгээ 2. Анхдагч зах зээлд койн санал болгох (ICO)-той холбоотой онцлог шинж чанарын жишээ

Блокчэйн технологи, эсхүл тархмал бүртгэл ашиглаж ВХ-ийг гаргаж, эсхүл шилжүүлж болно. Ийм хөрөнгийг арга хэмжээгээр дамжуулж хуваарилах механизмыг ICO гэдэг. ICO-н хувьд гаргагч тал буюу сурталчилгаа хийж буй этгээд нь ВХ-ийг албан ёсны мөнгөн тэмдэгт, эсхүл өөр бусад ВХ-өөр сольж арилжаалахын тулд санал болгодог. ICO-г ихэвчлэн төрөл бүрийн маркетингаар дамжуулж онлайнаар зарлаж, идэвхжүүлдэг. Гаргагч этгээд, эсхүл идэвхжүүлэгч нь ICO-г сурталчилж, төслийн талаар бичсэн “бизнесийн танилцуулга”-ыг гаргадаг. Гаргагч буюу идэвхжүүлэгч нь борлуулалтаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг дижитал платформ, програм хангамж, эсхүл бусад төслүүдэд ашиглахаа, мөн ВХ-ийг авснаар платформд нэвтрэх, програм хангамж ашиглах, эсхүл бусад байдлаар төсөлд оролцоход ашиглаж болох талаар худалдан авагч нарт мэдээлж болно. Ийнхүү санал болгох үеэр гаргагч буюу идэвхжүүлэгч этгээд нь ВХ худалдан авагчдад хөрөнгө оруулалтын өгөөжийн хүлээлт, эсхүл төслөөс хүртэх үр өгөөжийн хувь хэмжээний талаар ярьж болно. ВХ-ийг гаргасны дараа тэдгээрийг хоёрдогч зах зээл дээр (дижитал хөрөнгийн арилжааны платформоор юм уу ВХҮҮ-ээр дамжуулж) бусдад дахин борлуулж болно.

ICO-ны хувьд ВХҮҮ-ийн нэр томъёоны тодорхойлолтыг аж ахуйн нэгжүүдэд хэрхэн ашиглахыг тодорхойлохдоо зах зээлд оролцогчдын ашиглаж буй нэр томъёо, нэр шошгыг бус харин ангиллыг тодорхойлох хөрөнгө, үйл ажиллагаа, үйлчилгээг илэрхийлсэн нөхцөл байдалд үндэслэх ёстой. Жишээлбэл, ВХ-ийн тодорхойлолтод хамаарах дижитал хөрөнгийг ямар нэг этгээд бүтээсэн гэж үзье. ВХ нь өөрөө дараа худалдан авагчид хүргэгдэж очих хэдий ч дээрх бүтээгч тал нь ВХ-ийг худалдан авагчдад борлуулж, ийнхүү борлуулснаас олох орлогыг ВХ-ийг ашиглах платформ, экосистемийг хөгжүүлэхэд ашиглана. Энэ тохиолдолд ВХ-ийг худалдаж буй этгээд нь өөрөө ВХ гаргахын зэрэгцээ ВХҮҮ болж байгаа бөгөөд ВХҮҮ-ийн тодорхойлолтын аль нэг хэсэгт хамаарах өөр бусад үйл ажиллагаа явуулж болно (тухайлбал (i) болон (ii)-р хэсэгт заасанчлан ВХ-ийг бодит валют юм уу өөр бусад ВХ-өөр арилжиж, эсхүл (v)-р хэсэгт заасанчлан ICO-г гаргасны дараа зах зээлийг тодорхойлогч болох замаар ВХ-н хөрвөх чадварыг хангаж болно). Тухайн этгээд ВХ-ийг худалдахад санхүүгийн үйлчилгээ үзүүлж буй (брокер, эсхүл дилерээр ажиллаж буй) аж ахуйн нэгжүүд нь тухайн этгээдтэй албан ёсоор хамааралтай эсэхээс үл шалтгаалж ВХҮҮ-ийн нэр томъёоны тодорхойлолтын дагуу (v)-р хэсэгт заасны дагуу ВХҮҮ болно. Тухайн харилцагч нь ВХ-ийг хөрөнгө оруулалт, эсхүл төлбөрийн хэрэгслээр ашиглах зорилготой эсэх нь үүнд хамааралгүй юм.

Мөн дээрх жишээний хувьд ВХ нь тухайн улсын хууль тогтоомжийн дагуу үнэт цаасанд тооцогдож болно. Энэ тохиолдолд тухайн нөхцөл байдлаас шалтгаалж тухайн

улсын хууль тогтоомжийг ашиглаж болно. Иймд ВХ гаргагч этгээдийг ВХҮҮ, эсхүл үнэт цаас гаргагч гэж үзэх эсэх нь тухайн улсын хууль тогтоомж, ИСО-н нөхцөл байдлаас шалтгаална. Өөр өөр улс орнууд төлбөрийн токен зэргийг багтаасан харилцан адилгүй аргачлалтай байж болно. Нэг этгээд нь нэгээс илүү тооны зохицуулалтын орчинд үйл ажиллагаа явуулах шаардлага үүсч болох бөгөөд ийм этгээдийн ашиглаж буй дижитал хөрөнгө нь нэгээс илүү зохицуулалтанд хамаарч болно.

Нэр томъёоны тодорхойлолтын цар хүрээ

79. Энэхүү салбарт хөгжүүлсэн маркетингийн нэр томъёо болон шинэлэг бизнесийн загварууд хурдацтай хувьсан өөрчлөгдөж байгаагаас үл хамааран улс орнууд нэр томъёоны тодорхойлолтыг зөв хэрэглэж байгаа тохиолдолд зарим үе шатанд ВХҮҮ-ийг татан оролцуулахгүй ВХ-ийн цөөн хэдэн зохицуулалтыг хийж болно гэж ФАТФ үздэг. Улс орнууд нь төвлөрсөн бус загварууд, эсхүл тархмал үйлчилгээний бизнес эрхэлж буй байдлыг үнэлж дүгнэхдээ онцгойлон анхаарч, эрсдэл болон эрсдэлийг бууруулах боломжтой нийцүүлэн бизнесийн загвараа өөрсдөө үнэлэх ёстой.
80. Өмнө дурдсанчлан ФАТФ-ын стандартууд нь технологийн хувьд төвийг сахисан байр суурьтай байдаг. Иймд ФАТФ нь ВХ, эсхүл ВХҮҮ-ийн үйл ажиллагааны технологийг зохицуулах зорилгогүй. Харин ФАТФ нь өөр бусад хувь хүн, хуулийн этгээдийн өмнөөс дээр дурдсан ВХҮҮ-ийн үйл ажиллагааг бизнес хэлбэрээр явуулж буй, технологиудын цаана байгаа хувь хүн, хуулийн этгээдийг зохицуулах зорилготой.
81. Иймд ВХ-ийн платформ, эсхүл програм хангамжийн апплейкшнийг бүтээж, худалдан борлуулж буй этгээд нь зөвхөн тухайн апплейкшн, платформыг бүтээж, борлуулж байгаа бол ВХҮҮ гэж тооцогдохгүй. Харин бусад этгээдийн өмнөөс ВХҮҮ-ийн үйл ажиллагааг бизнес хэлбэрээр явуулахын тулд апплейкшн, платформыг ашиглаж байгаа бол ВХҮҮ-д тооцогдож болно. Түүнчлэн програм хангамж, эсхүл платформыг бүтээх, хөгжүүлэх заавар өгч буй этгээд нь өөр бусад этгээдийн өмнөөс ВХҮҮ-ийн үйл ажиллагааг бизнес хэлбэрээр явуулах зорилготой байгаа бол ВХҮҮ-д тооцогдож болно. Ялангуяа тухайн хөрөнгө, програм хангамж, протокол, платформ зэрэгт хяналт тавьж, хангалттай нөлөөлдөг бол, эсхүл ухаалаг гэрээгээр дамжин хэрэгжиж байгаа ч програм хангамжийн хэрэглэгчидтэй бизнесийн харилцаатай бол ВХҮҮ-д тооцогдоно. Ийм ВХҮҮ нь МУТСТ холбогдох чиг үүргийг дагаж мөрдөх үүрэгтэй. Энэ тохиолдолд ВХҮҮ нар нь програм хангамж, эсхүл платформыг ашиглах, ашиглалтад оруулахын өмнө МУТС эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийг одоо болон ирээдүйг харсан байдлаар арилгах арга хэмжээ авах ёстой.
82. Мөн ФАТФ нь ВХ-ийн сүлжээнд туслах үйлчилгээ, бүтээгдэхүүн нийлүүлж буй аливаа ВХҮҮ (хувь хүн болон хуулийн этгээд)-г зохицуулах зорилгогүй болно. Үүнд техник хангамжийн хэтэвч үйлдвэрлэгч, зохицуулалтгүй хэтэвчний үйлчилгээ үзүүлэгч зэрэг туслах шинж чанарын үйлчилгээг хамруулж үзэх бөгөөд ингэхдээ өөр бусад этгээдийн өмнөөс дээр дурдсан ВХ-ийн үйл ажиллагааг бизнес хэлбэрээр явуулдаггүй, эсхүл идэвхтэй дэмжлэг үзүүлдэггүй байх ёстой. Мөн харилцагчдын өмнөөс ВХҮҮ-ийн үйл ажиллагаа эрхэлдэггүй, ийм үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэггүй, зөвхөн ВХ-ийн сүлжээний үйл ажиллагаанд оролцдог (интернет сүлжээний үйлчилгээ, дэд бүтцийг

санал болгодог, клауд үйлчилгээ зэрэг компьютерын үйлчилгээ санал болгодог, бүлэг гүйлгээг үүсгэж, баталгаажуулж, дамжуулдаг) аливаа хувь хүн, хуулийн этгээд нь эдгээр үйл ажиллагааг бизнес хэлбэрээр явуулж байгаа ч гэсэн ФАТФ-ын стандартын дагуу ВХҮҮ гэж тооцогдохгүй.

83. ФАТФ нь ВХ-ийн хувьд (бизнесийн этгээд биш) хэрэглэгчдийг ВХҮҮ гэж үзэж зохицуулахыг зорьдоггүй ч ийм хэрэглэгч нь тухайн улс орны хориг арга хэмжээ, үйл ажиллагааны тогтолцооны дагуу үүрэг хүлээж болно. Мөн ФАТФ нь үл шилжүүлэх, үл арилжих, төлбөр юм уу хөрөнгө оруулалтын зорилгоор ашиглах боломжгүй хаалттай хэлхээний зүйлсийг зохицуулах зорилгогүй. Ийм зүйлст хувь хүн хаалттай хэлхээний системээс гадна хоёрдогч зах зээл дээр худалдан борлуулж болохгүй нисэх онгоцны миль, кредит картны шагнал, эсхүл үүнтэй төстэй роялти хөтөлбөрийн шагнал, оноог оруулж болно. Харин ВХ болон ВХҮҮ-ийн нэр томъёоны тодорхойлолтууд нь виртуал хөрөнгийн хооронд, эсхүл виртуал хөрөнгө болон албан ёсны мөнгөн тэмдэгт хооронд зах зээлийн үнээр хөрвөх, солилцох боломжтой хөрөнгө, санхүүгийн үйл ажиллагаанууд (шилжүүлэг, арилжаа, хадгалалт, хяналтыг хэрэгжүүлэх, ВХ гаргахтай холбоотой санхүүгийн үйлчилгээ үзүүлэх гэх мэт)-ыг хамрах зорилготой. ВХ-ийг бараа, үйлчилгээний төлбөрөөр хүлээн зөвшөөрсөн нь, тухайлбал, барааг худалдан авахдаа үйлчилгээ үзүүлэгч нь ВХ-ийг хүлээн зөвшөөрсөн нь ВХҮҮ-ийн үйл ажиллагаанд тооцогдохгүй. Гэхдээ ВХ-ийг төлбөр гэж хүлээн зөвшөөрч буй компаниудад дэмжлэг үзүүлэх үйлчилгээ нь ВХҮҮ-д хамаарна.
84. Санхүүгийн үйл ажиллагаанд оролцож буй ВХ-ийн төрөл (төрөл бүрийн санхүүгийн гүйлгээний зорилгоор өөр этгээдэд НКВ-г санал болгож, ашигладаг ВХҮҮ гэх мэт), тухайн технологи (эмбеддэд давхарга юм уу, эсхүл бусад тэлэлтийн шийдлийг ашиглах, үндсэн сүлжээг ашиглах гэх мэт), эсхүл платформд оруулсан нэмэлт үйлчилгээ (холих, хөрвүүлэх болон бусад онцлог шинж чанар) зэргээс үл хамаарч МУТСТ дүрэм журмууд нь ВХ-ийн үйл ажиллагаа, ВХҮҮ-д ашиглагдана.
85. Тогтвортой койнын хувьд тогтвортой койнын зохицуулалтад оролцуулсан олон төрлийн аж ахуйн нэгж, байгууллагууд байдаг. Тогтвортой койнууд нь үндсэн хөгжүүлэгчтэй, эсхүл засаглалын байгууллагатай байж болно. Засаглалын байгууллага нь тогтвортой койныг зохицуулсан дүрэм журмуудыг тогтоодог, эсхүл тогтооход оролцдог (тухайлбал тогтвортой койнын функцуудыг тодорхойлох, хэн тогтвортой койнын зохицуулалтад оролцож болох, МУТСТ урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрхэн тус зохицуулалтад тусгах гэх мэт) нэг буюу түүнээс дээш хувь хүн, хуулийн этгээдээс бүрдэнэ. Мөн засаглалын байгууллага нь тогтвортой койнын зохицуулалтын үндсэн функцууд (тогтворжуулалтын функцийг удирдах гэх мэт)-ыг хэрэгжүүлж болно, эсхүл үүнийг өөр бусад этгээдүүдэд төлөөлүүлж болно. Түүнчлэн засаглалын байгууллагууд нь тогтвортой койныг теле харилцаа холбооны платформд нэгтгэх ажлыг удирдаж, тогтвортой койнын зохицуулалтын хүрээнд нийтлэг дүрэм журмуудыг дагаж мөрдөхөд дэмжлэг үзүүлнэ.
86. Ийм төв засаглалын байгууллага нь тогтвортой койнын зохицуулалтад оршин тогтнодог бол эдгээрийг ФАТФ-ын стандартуудын дагуу СБ, эсхүл ВХҮҮ гэж ерөнхийд нь үзнэ. Ялангуяа засаглалын байгууллага нь тогтвортой койнын зохицуулалтад өөр функцийг хэрэгжүүлдэг бол дээрх тохиолдол хамааралтай. Иймд зохицуулалтын байгууллага нь

тогтвортой койныг эхлүүлэх, ашиглахын өмнө МУТС эрсдэлийн үнэлгээг хийж, тус зохицуулалтын хүрээнд эрсдэлийг удирдах, бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх ёстой²⁷.

87. Бүх тогтвортой койнд ВХҮҮ, эсхүл СБ гэж шууд ялгагдаж, тодорхойлогдох боломжтой төв байгууллага байхгүй байж болно. Гэхдээ тогтвортой койныг гаргахаас өмнө ийм зохицуулалтыг хөгжүүлэх, эхлүүлэх үүрэг бүхий этгээд байх шаардлагатай байж болно. Энэхүү этгээд нь бизнесийн аж ахуйн нэгж бөгөөд ВХҮҮ-ийн функцуудыг хэрэгжүүлсэн бол энэ нь тогтвортой койныг гаргахаас өмнөх үе шатанд зохицуулалтын, хяналтын үйл ажиллагааны цар хүрээг бүрэлдүүлнэ. Шууд тодорхойлох боломжтой ВХҮҮ, эсхүл СБ байхгүй бол тухайн улс орон нь тогтвортой койнтой холбоотой эрсдэл болон эдгээр эрсдэлийг арилгах арга хэмжээний шаардлага зэргийг харгалзан үзэх ёстой (тухайлбал, 105-106 дугаар хэсэгт заасан Р2Р-д зориулсан эрсдэл бууруулах арга хэмжээний талаарх мэдээллийг үз). Түүнчлэн энэ нь програм хангамжийн код хөгжүүлж буй этгээдүүдийг хамруулах зорилгогүй, харин ВХҮҮ-ийн нэр томъёоны тодорхойлолтын холбогдох хэсгүүдэд заасан санхүүгийн үйлчилгээг үзүүлэх тогтвортой койнын зохицуулалтад хамаарах этгээдүүдэд чиглэсэн болно.
88. Биржүүд, хадгаламжийн хэтэвчний үйлчилгээ зэрэг тогтвортой койнын зохицуулалтад хамаарах өөр бусад аж ахуйн нэгж, байгууллагууд нь МУТСТ үүрэгтэй байж болно. Үүнийг харуулахын тулд Шигтгээ 3-т кейс судалгааг оруулав. Аливаа зохицуулалтын нарийн мэдээллийг хараат бус байдлаар шалгаж, эдгээр үүрэг хариуцлагыг тодорхой болгох ёстой²⁸.

Шигтгээ 3. Тогтвортой койнын зохицуулалт болон ФАТФ-ын Стандартуудын хэрэглээтэй холбоотой кейс судалгаа

*Жишээ*²⁹

А компани (“Компани” гэх) нь тогтвортой койн (“койн” гэх)-оор ашиглах зорилготой ВХ-ийг гаргахын тулд тархмал бүртгэлийн технологид үндэслэсэн платформыг боловсруулж байгаа.

Тус койн нь олон улсын СБ-уудын данснуудад Компанийн эзэмшиж буй хөрөнгө (хамтад нь “Нөөцийн сан” гэх)-өөр баталгаажна. Койнын зах зээлийн үнийг Зөвшөөрөгдсөн оролцогчийн механизмаар дамжуулж Нөөцийн санд эзэмшиж байгаа

²⁷ Шинэ технологитой холбоотойгоор ВХҮҮ нарын хүлээх үүрэг хариуцлагын талаар дэлгэрэнгүй мэдээллийг Бүлэг 3-т заасан 3.15-аас үз. Мөн энэ нь урьдчилсан төлбөрт карт, гар утасны төлбөр болон интернетэд суурилсан төлбөрийн үйлчилгээний талаарх ФАТФ-ын тайланд дурдсан “Шинэ төлбөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээ (ШТБҮ)”-тэй нийцэмжтэй болно. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээллийг дараах холбоосоос авна уу: www.fatf-gafi.org/media/fatf/documents/recommendations/Guidance-RBA-NPPS.pdf.

²⁸ Тогтвортой койнын зохицуулалтын хувьд ФАТФ-ын Стандартуудыг өөр өөр аж ахуйн нэгж байгууллагуудад ашиглахтай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг тогтвортой койнын талаарх Их 20-д зориулсан ФАТФ-ын Тайланд дурдсан болно.

²⁹ Энэхүү кейс судалгаанд оруулсан жишээг *Глобал тогтвортой койнын Санаачлагын* талаарх IOSCO-н 2020 оны 3-р сарын тайланд тусгасан кейс судалгаанаас авч ашиглав. Ингэхдээ МУТСТ нөхцөлд тохируулж нэмэлт өөрчлөлт оруулж, засварласан болно. Энэхүү жишээнд тогтвортой койнын зохицуулалтад аливаа этгээдийн хүлээх үүрэг хариуцлагыг тодруулах зорилгоор оруулсан бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй болно.

хөрөнгийн үнэ цэнэтэй уялдуулна. Зөвхөн зөвшөөрөгдсөн оролцогч талууд нь Компаниар дамжуулж Нөөцийн сангаас Койн худалдан авч, чөлөөлөх боломжтой байна. Компанийн санал болгож буй экосистемийн дагуу Компани болон гуравдагч талууд (хамтад нь “Баталгаажуулагчид” гэх) нь өөр бусад гуравдагч талын клауд дэд бүтцийг ашиглаж зөвшөөрөгдсөн блокчэйн сүлжээг ажиллуулна. Тус компани нь ISO-р дамжуулж койнд зориулж хөрөнгө татах гэж байгаа.

Компани, гуравдагч талууд болон хэрэглэгчид нь Койн руу нэвтрэх, ашиглах, гүйлгээ хийх боломжтой байна. Арилжааны платформууд, хадгаламжийн хэтэвчний үйлчилгээ үзүүлэгч зэрэг гуравдагч талууд нь сүлжээнд холбогдохын тулд Компаниас зөвшөөрөл олж авах шаардлагатай. Койны хэтэвчнүүд нь хэрэглэгчдэд койныг илгээх, хүлээн авах, хадгалах боломж олгож, мөн хөгжүүлэгчид/гуравдагч талууд нь өөрсдийн онцлогт тохируулсан хэтэвчийг санал болгох боломжтой. Компанийн тогтоосон дүрэм журмын дагуу койнуудыг шилжүүлэх бөгөөд үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө зохицуулах байгууллагуудаар үнэлүүлнэ. Мөн худалдаачид нь Койныг бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлбөр болгон ашиглах боломжтой.

Зохицуулалттай этгээдүүд болон тэдгээрийн ФАТФ-ын Стандартуудын дагуу хүлээх МУТСТ үүрэг хариуцлага.

Энэхүү жишээнд Компанийн функц нь ISO-р дамжуулж санхүүжилт татан төвлөрүүлэх зэрэг Зөвшөөрөлтэй Оролцогч талуудтай койн арилжих гэж байгаа тул тус компанийг ФАТФ-ын стандартын дагуу ВХҮҮ, эсхүл СБ гэж үзнэ. Тус компани нь МУТСТ чиг үүргийг хэрэгжүүлэх шаардлагатайгаас гадна экосистем дэх МУТСТ үүрэг хариуцлагыг бусад гуравдагч талууд биелүүлж байгаа эсэхийг хянах үүрэгтэй. ФАТФ-ын стандартуудын дагуу Компани нь экосистемийн хэмжээнд МУТСТ эрсдэлүүдийг арилгахад тохиромжтой арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой (Койнын дизайн, Зөвшөөрөлтэй оролцогч талуудыг батлах шалгуур болон процесс гэх мэт).

Мөн зөвшөөрөгдсөн оролцогч талуудын функцэд ВХ-ийг гаргах, түгээх, арилжихад дэмжлэг үзүүлэх ажиллагаа орох тул эдгээр оролцогч тал нь ВХҮҮ болно. Арилжааны платформуудын функц нь Койн, албан ёсны мөнгөн тэмдэгт болон бусад ВХ-ийн хооронд арилжаа хийх, койныг шилжүүлэх, хадгалах, хянах зэрэг тул тус арилжааны платформ нь ВХҮҮ болно. Хадгаламжийн хэтэвчний үйлчилгээ үзүүлэгчдийн функц нь койныг шилжүүлэх, хадгалах, хянах ажиллагаа тул ийм хадгаламжийн хэтэвчний үйлчилгээ үзүүлэгч нь ВХҮҮ болно.

ФАТФ-ын стандартын дагуу ВХҮҮ-ийн нэр томъёоны тодорхойлолтод үл хамаарах экосистемийн оролцогч талуудад дараах этгээдүүдийг оруулна. Үүнд: (ФАТФ-ын стандартуудад СБ гэж тодорхойлж, хамруулсан ч гэсэн) зөвхөн Нөөцийн санг удирдах функцтэй олон улсын СБ-ууд, гүйлгээг зөвхөн баталгаажуулах үүрэгтэй Баталгаажуулагчид (Компани орохгүй), зөвхөн дэд бүтцийн ашиглалтыг санал болгож буй клауд үйлчилгээ үзүүлэгч, зөвхөн төхөөрөмжийг үйлдвэрлэж, худалдах үүрэг бүхий техник хангамжийн хэтэвчний үйлдвэрлэгчид, зөвхөн програм/техник хангамжийг хөгжүүлж, борлуулах үүрэг бүхий зохицуулалтгүй хэтэвчний үйлчилгээ үзүүлэгчид, Койнын арилжаанд зориулж зөвхөн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ

үзүүлж буй худалдаачид, ВХҮҮ-ийн функцийг хэрэгжүүлдэггүй програм хангамж хөгжүүлэгчид болон хэрэглэгчид зэргийг оруулна.

Аливаа зохицуулалтын нарийвчилсан мэдээллийг тодорхойлж шийдвэрлэхдээ юуны түрүүнд хангалттай хэмжээнд, хараат бус байдлаар үнэлэлт, дүгнэлт өгөх ёстойг онцлон дурдах нь зүйтэй. МУТСТ арга хэмжээг хэрхэн ашиглах нь тухайн улс орноос хамаарна. Энэ нь зөвхөн жишээ төдий бөгөөд бүх тогтвортой койныг ийм байдлаар зохион байгуулахгүй байж болно. Тухайн улс орноос шалтгаалж үнэт цаас, түүхий эд болон үүсмэл хэрэгслүүд зэрэг санхүүгийн хөрөнгөтэй холбоотой хууль тогтоомжийг энэхүү жишээнд оруулж болно. Мөн улс орнууд МУТС эрсдэлийг (тухайлбал P2P-тай холбоотойгоор) хүлээн зөвшөөршгүй өндөр гэж үзвэл өөр бусад арга хэмжээг авч хэрэгжүүлж болно (улс орнууд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж болох талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 105-106 дугаар хэсгээс үзнэ үү).

89. Зарим платформ, үйлчилгээ үзүүлэгч нь хувь хэрэглэгчдийн хооронд ВХ-ийн шилжүүлгийг шууд хийх боломжтой. Ийм платформуудын хувьд дээрх нэр томьёоны тодорхойлолтуудыг өргөн цар хүрээнд ойлгосноор ашиглаж буй технологи, эсхүл өөрийгөө тодорхойлсон байдал дээр үндэслэж биш харин функц дээр үндэслэж ийм үйлчилгээ үзүүлэгч этгээдийг ВХҮҮ гэж тодорхойлох эсэхийг шийдвэрлэнэ. ВХ-ийг гаргахтай холбоотойгоор санхүүгийн үйлчилгээ үзүүлэх, мөн арилжих, шилжүүлэх, хадгалах, хянах тал дээр маш хязгаарлагдмал үүрэг функц үзүүлж буй этгээдүүд л зөвхөн ВХҮҮ-д тооцогдохгүй. Жишээлбэл, үүнд ВХҮҮ-ийн нэр томьёоны тодорхойлолтод тусгасан үйлчилгээг санал болгохгүйгээр худалдагч, худалдан авагчийн бие биенээ тодорхойлох, хоорондоо харилцах форумыг санал болгож буй вебсайтуудыг оруулж болно.
90. Өөрийгөө тодорхойлсон P2P платформын хувьд улс орнууд нь нэр хаяг, эсхүл бизнес загвар бус харин үндсэн үйл ажиллагаанд нь анхаарах ёстой. Зарим төрлийн “тааруулах”, эсхүл “олох” үйлчилгээг гүйлгээнд оролцоогүй ч гэсэн ВХҮҮ гэж үзэж болно. ФАТФ-ын зүгээс ВХ болон ВХҮҮ гэсэн нэр томьёоны тодорхойлолтыг өргөн цар хүрээнд авч үздэг бөгөөд одоогоор хамгийн их ашиглагдаж байгаа зохицуулалтыг анхаарч үздэг. Эдгээр нь өөрсдийгөө P2P гэж ангилсан байлаа ч гэсэн ВХҮҮ-д хамааралтай бүтээгдэхүүний хөгжүүлэлт хийх, ашиглалтад гаргах тодорхой үе шатанд зарим талууд оролцсон байж болно. Бизнес ториулж үйлчилгээ үзүүлэх зорилготой процессыг автоматжуулах нь хяналт тавьж буй талыг үүрэг хариуцлагаас чөлөөлөхгүй.
91. Үйлчилгээ үзүүлэгч нь ВХҮҮ гэсэн нэр томьёоны тодорхойлолтыг хангаж байгаа эсэхийг тодорхойлохдоо бүтээгдэхүүн, үйлчилгээний амьдралын мөчлөгийг анхаарч үзэх ёстой. Тухайлбал, ВХҮҮ-ийн үзүүлэх үйлчилгээг эхлүүлсэн бөгөөд эдгээр функц нь цаашид автоматаар явагдах байсан ч гэсэн ВХҮҮ-д үүрэг хариуцлага оногдуулна. Ялангуяа үйлчилгээ үзүүлэгч нь удирдлагын түлхүүрийг эзэмшиж, платформд нэвтэрч, төлбөр хураамж цуглуулж, ашиг олох замаар зарим төрлийн хяналт тавьж, эсхүл хангалттай хэмжээний нөлөөлөлтэй бол ВХҮҮ-д үүрэг хариуцлага оногдуулна. ВХҮҮ-ийн функцуудыг хэрэгжүүлэхийн тулд ухаалаг гэрээ мэтийн автомат процессыг ашиглах нь тухайн талуудыг ВХҮҮ-ийн үүрэг хариуцлагаас чөлөөлөхгүй. Энэ тохиолдолд ВХҮҮ-ийн шаардлага хангасан хяналт тавьж буй талууд нь платформуыг ашиглах, эсхүл ашиглалтад оруулахын өмнө МУТС эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэлийг

арилгах тохиромжтой арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Тухайлбал, үүнд МУТСТ үүрэг хариуцлагын хэрэгжилтийг платформд оролцсон өөр бусад хувь хүн, хуулийн этгээдэд төлөөлүүлэх ажиллагаа ч хамаарна.

92. Гэхдээ өргөн цар хүрээг хамарсан аргачлал нь аль байгууллагыг ВХҮҮ гэж тодорхойлох, тэдгээрийн зохицуулалтын цар хүрээг тодорхойлоход эрх бүхий байгууллагуудад практик сорилтуудыг авчрах боломжтой гэж ФАТФ үздэг. Тодорхой аж ахуйн нэгжийг ВХҮҮ мөн эсэхийг тодорхойлохын тулд үнэлэх, эсхүл ВХҮҮ-ийн статус нь тодорхойгүй бизнес загварыг үнэлэх шаардлагатай болсон тохиолдолд цөөн хэдэн ерөнхий асуулт нь хариултыг чиглүүлэхэд тусалж болно. Тухайлбал үйлчилгээ, хөрөнгийг ашигласнаас хэн ашиг хүртэх вэ, хэн дүрмийг тогтоосон бэ, хэн дүрмийг өөрчилж чадах бэ, хэн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц шийдвэр гаргаж чадах бэ, хэн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож, ашиглалтад оруулсан бэ, хэн гэрээлэгч тал, эсхүл үйл ажиллагаатай холбоотой өгөгдлийг эзэмшиж, хянаж буй өөр бусад этгээдтэй бизнесийн харилцаа тогтоосон бэ, хэн бүтээгдэхүүн, үйлчилгээг хааж чадах бэ? Нөхцөл байдал нь харилцан адилгүй байх тул дээрх асуултууд нь зөвхөн жишээ төдий болно.
93. ФАТФ-ын стандарт, ВХҮҮ болон ВХ-ийн нэр томъёоны тодорхойлолт зэрэг нь улс орнуудын хувьд нэвтрүүлбэл зохих наад захын стандарт болно. Улс орнууд нь ЭСА-тай уялдуулж ВХ болон ВХҮҮ гэсэн ФАТФ-ын нэр томъёоны тодорхойлолтоос давсан өөр бусад дижитал хөрөнгө, аж ахуйн нэгжүүдийг оруулж МУТСТ тогтолцоогоо тэлж болно. Ингэхдээ зохицуулалтын харилцан адилгүй байдалтай холбоотой сорилтуудыг харгалзан үзэхийн зэрэгцээ МУТС эрсдэлийн үнэлгээнд үндэслэх ёстой.

БҮЛЭГ ГУРАВ: ФАТФ-ЫН СТАНДАРТУУДЫГ УЛС ОРНУУД БОЛОН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГУУДАД ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

94. Бүлэг 3-т ВХ, ВХҮҮ-тэй холбоотой ФАТФ-ын Зөвлөмжүүдийг улс орнууд, эрх бүхий байгууллагуудад хэрхэн ашиглах талаар тайлбарлаж, ВХ-ийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийг тодорхойлох, бууруулах, урьдчилсан сэргийлэх арга хэмжээ авах, тусгай зөвшөөрөл болон бүртгэлийн шаардлагуудыг хэрэглэх, СБ-уудын санхүүгийн үйл ажиллагааг хянахтай холбоотой үр дүнтэй хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, үр дүнтэй хариуцлагын арга хэмжээ авах, үндэсний болон олон улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх зэрэг асуудалд анхаарна. Улс орнууд ВХ, ВХҮҮ нартай холбоотой МУТС эрсдэлийг удирдахын тулд засгийн газрын эрх бүхий байгууллагууд болон олон улсын хамтын ажиллагааг хэрхэн ашиглах ёстой талаар ойлгуулахад ФАТФ-ын бараг бүх зөвлөмжүүд чиглэсэн байдаг бол бусад зөвлөмжүүд нь хэдий хамааралтай ч ВХ, ВХҮҮ нартай шууд бус байдлаар уялдаа холбоотой байдаг.
95. ВХ болон ВХҮҮ нар нь ЗТ.15-д заасны дагуу ФАТФ-ын Зөвлөмжүүдийн хүрээнд өргөн цар хүрээний үүрэг хариуцлага хүлээнэ. Тухайлбал, ВХ-ийн үйл ажиллагаатай холбоотой МУТС эрсдэлийг харгалзан үзэхийн зэрэгцээ ВХҮҮ нарын эрхэлж буй санхүүгийн үйл ажиллагаанд үндэслэж МУТСТ дүрэм журмуудын дагуу өөр бусад аж ахуйн нэгжүүдэд хамааралтай үүрэг хариуцлагыг үүнд оруулна.
96. ВХҮҮ нарын хянан шалгагч нар ЭСА-ыг хэрхэн ашиглахтай холбоотой асуудлыг энэхүү хэсэгт мөн авч үзнэ.

ВХ болон ВХҮҮ нарын хүрээнд Зөвлөмжүүдийг ашиглах нь

Эрсдэлд суурилсан аргачлал болон үндэсний уялдаа холбоо

97. **Зөвлөмж 1.** ФАТФ-ын Зөвлөмжүүдэд улс орнууд нь өөрсдийн тодорхойлсон МУТС эрсдэлээс сэргийлэх, уг эрсдэлийг бууруулах арга хэмжээ нь нийцсэн эсэхийг баталгаажуулахын тулд ЭСА-ыг ашиглах ёстой гэж тодорхой заасан байдаг. Улс орнууд нь ЭСА-ын дагуу өндөр эрсдэлтэй нөхцөл байдал, эсхүл ВХ-ийг оролцуулсан үйл ажиллагаанд тавигдах шаардлагуудыг бэхжүүлэх ёстой. ВХ-үүдтэй холбоотой МУТС эрсдэлийг үнэлэхдээ улс орнуудын харгалзан үзэх ёстой гол асуудал нь P2P зэрэг тодорхой төрлийн ВХ-ийн санхүүгийн үйл ажиллагаа, ВХҮҮ нарын үйл ажиллагаа, төвлөрсөн ба төвлөрсөн бус ВХ-ийн ялгаа, ВХ-үүд нь зохицуулалттай ВХҮҮ нарын хяналтад байгаа эсэх зэрэг асуудлууд хэвээр байх төлөвтэй байна. ВХ-ийн санхүүгийн урсгалын нууцлагдмал, нэргүй, мэдээлэлгүй байдал нэмэгдэж, мөн үр дүнтэй хяналт тавих болон ХТМ (харилцагчийг таних, баталгаажуулах г.м.)-тэй холбоотой сорилтууд тулгарч байгаа учир ерөнхийдөө ВХ болон ВХҮҮ нар нь МУТС өндөр эрсдэлтэйд тооцогдож болно. Иймд тухайн улсын нөхцөл байдлаас шалтгаалж шаардлагатай бол хяналт болон харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагаа (ХТМНҮА)-г хэрэгжүүлэх шаардлагатай байж болно.
98. Зөвлөмж 1 нь МУТС эрсдэлийг тодорхойлох, ойлгох, үнэлэх, улмаар эдгээр эрсдэлийг үр дүнтэй бууруулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг улс орнуудаас шаарддаг. Тус шаардлага нь 3.15-д заасны дагуу шинэ технологитой холбоотой эрсдэл

(ВХ болон ВХ-ийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлдэг ВХҮҮ нартай холбоотой эрсдэл)-тэй хамааралтай. ВХ-ийн үйл ажиллагаа (ВХ-ийн төлбөр, шилжүүлэг, ВХ гаргах гэх мэт), ВХ-ийн технологийн инноваци болон шинээр гарч ирж буй бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой МУТСТ бодлогуудыг боловсруулахад төрхувийн хэвшлийн хамтын ажиллагаа нь эрх бүхий байгууллагуудад тусалж болно. Мөн эрх бүхий байгууллагуудын зүгээс МУТСТ нөөцийг хуваарилах, эрэмбэлэхэд хамтын ажиллагаа нь тустай байж болно.

99. ФАТФ-ын нэмэлт өөрчлөлт оруулсан 3.1 болон 2020 оны Тайлбарт стандартад тодорхойлсны дагуу үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх (ҮОХЗДС) эрсдэлийг үнэлэхийн тулд улс орнууд, СБ болон СББМҮҮ нарт тавигдах шаардлагуудыг тусгасан болно. 2021 оны 6-р сард ФАТФ нь ҮОХЗДС-тай холбоотой шаардлагуудыг мөн ВХҮҮ нарт ашиглах байдлыг тодруулахын тулд 3.15-д Тайлбараар нэмэлт өөрчлөлт оруулсан. Эдгээр шаардлагыг тодруулахын тулд ФАТФ нь 2021 оны 6-р сард ҮОХЗДС эрсдэлийн үнэлгээ, эрсдэл бууруулах арга хэмжээний гарын авлагыг гаргасан. Улс орнууд нь ВХ-тэй холбоотой МУТС/ҮОХЗДС эрсдэлийг тодорхойлж, үнэлж, мөн эдгээр эрсдэлийг бууруулах үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай.
100. Үндэсний эрх бүхий байгууллагууд нь ВХ-ийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээ, ВХҮҮ болон түүнд хамаарах нийт салбарын эрсдэлийг үнэлэх ажлыг зохион байгуулалттай хийж гүйцэтгэх шаардлагатай. Уг эрсдэлийн үнэлгээ нь (i) ВХ-ийн тусгай бүтээгдэхүүн, үйлчилгээний функц нь МУТСТ зорилготой хэрхэн нийцсэн, бүх холбогдох зохицуулалтын орчинд хэрхэн нөлөөлж байгааг ойлгох боломжоор холбогдох эрх бүхий байгууллагуудыг хангах ёстой (ВХҮҮ-ийн нэр томъёоны тодорхойлолтод заасанчлан мөнгө шилжүүлэх, төлбөрийн механизм, ВХ-ийн киоск, түүхий эд, үнэт цаас, эсхүл ВХ-ийг гаргахтай үйл ажиллагаа гэх мэт), (ii) ижил эрсдэл бүхий ижил төстэй бүтээгдэхүүн, үйлчилгээнд МУТСТ ижил төстэй аргачлалыг хэрэгжүүлэх боломж бүрдүүлнэ. Эрсдэлийн үнэлгээг хийхэд ВХ, ВХҮҮ болон тэдгээрийн үндсэн технологийн талаарх мэдлэгтэй этгээдүүдийг хамруулах нь чухал юм.
101. ВХҮҮ-ийн салбар хувьсан өөрчлөгдөж байгаа тул улс орнууд ВХ-ийн үйл ажиллагааны болон бусад зохицуулалтын, хяналт шалгалтын арга хэмжээнүүд (харилцагчийн болон хөрөнгө оруулагчийн хамгаалалт, аюулгүй ба найдвартай байдал, сүлжээний мэдээллийн технологийн хамгаалалт, татвар гэх мэт)-д зориулсан МУТСТ арга хэмжээний хоорондох харилцан хамаарлыг шалгаж үзэх ёстой. Учир нь бусад чиглэлийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь МУТС эрсдэлд нөлөөлж болно. ВХ-ийг олон нийтээр өргөн хүрээнд ашиглах үйлдэл нь өргөжин тэлсээр байгаа тул ВХ-ийн үйл ажиллагаа болон ВХҮҮ (мөн ВХ-ийн салбарт үйл ажиллагаа явуулж буй бусад зохицуулалттай этгээдүүд)-д зориулсан зохицуулалт, хяналт шалгалтын цогц тогтолцоог хөгжүүлэх богино болон урт хугацааны бодлогыг хэрэгжүүлэх талаар анхаарч үзэх ёстой.
102. Мөн улс орнууд ВХ-ийн үйл ажиллагааг эрхлэх, эсхүл тодорхой ВХ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгохтой холбоотой МУТС эрсдэлийг тодорхойлж, үнэлж, эдгээр эрсдэлийг арилгах үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг ВХҮҮ нар

(болон бусад үүрэг бүхий этгээдүүд)-аас шаардах ёстой. ВХҮҮ нарыг үндэсний хууль тогтоомжийн дагуу зөвшөөрсөн бол ВХ-ийн үйл ажиллагаа эрхэлдэг, эсхүл ВХ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлдэг СБ, СББМҮҮ болон ВХҮҮ нар нь холбогдох МУТС эрсдэлээ үнэлж, эдгээр эрсдлээс урьдчилан сэргийлэх, бууруулахад тохиромжтой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн эсэхийг нягтлах зорилгоор ЭСА-ыг ашиглана.

103. ВХ-ийн хувьд тогтвортой койн, ялангуяа олон нийтээр ашиглаж болох, P2P-д ашиглаж болох хөрөнгүүдтэй холбоотой МУТС эрсдэлийн өнөөгийн нөхцөл байдлыг харгалзсан болон ирээдүйд чиглэсэн байдлаар шинжлэх ёстой. Шинэ бүтээгдэхүүнийг хөгжүүлж байхдаа ВХҮҮ болон бусад зохицуулалттай этгээдүүд нь эдгээр бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэхийн өмнө МУТС эрсдэлээ үнэлж, түүнийг бууруулах арга хэмжээг бий болгох ёстой. Тухайлбал ийм эрсдэлийг бууруулах арга хэмжээнд нэргүй, мэдээлэлгүй гүйлгээ хийх хэрэглэгчийн боломжийг хязгаарлах, зохицуулалтад нэвтрэх эрх бүхий этгээдийг хянах, тус зохицуулалтад МУТС-тэй холбоотой урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусгасан эсэх, эсхүл хэрхэн тусгасан болохыг хянах, тус зохицуулалтын хүрээнд зохицуулалттай этгээдүүдийн МУТС үүрэг хариуцлага биелсэн эсэхийг баталгаажуулах зэргийг хамруулж болно. Ингэхдээ гүйлгээг хянах, сэжигтэй үйл ажиллагааг илрүүлэх програм хангамж ашиглаж болно. Хянан шалгагч нар нь бүртгэлд хамруулах, тусгай зөвшөөрөл олгохын өмнө эдгээр эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхийг зорих ёстой. Эдгээр бүтээгдэхүүнийг ашиглалтад оруулсны дараа эрсдэлийг нь бууруулахад илүү бэрхшээлтэй болно.

P2P

Гарын авлагын Бүлэг 2-т заасанчлан улс орнуудын P2P-тай холбоотой МУТС эрсдэлийг ойлгох, өөрсдийн улс оронд хэрхэн ашиглагдаж байгаа талаар ойлгох нь чухал юм. P2P-н эрсдэлийг ойлгохын тулд улс орнуудын анхаарч үзэх ёстой арга хэмжээнүүдээс дурдвал:

а. P2P салбарын төлөөлөгчид, ВХҮҮ гэх мэт хувийн хэвшилд соён гэгээрүүлэх ажиллагааг хэрэгжүүлэх (P2P-тай холбоотой МУТС шаардлагуудын талаар зөвлөх гэх мэт);

б. Хяналт шалгалтын, санхүүгийн мэдээллийн алба (СМА)-ны болон хууль сахиулах албан хаагчдын сургалт;

в. Сэжигтэй гүйлгээ/үйлдлийг тодорхойлох, зохицуулалттай, эсхүл зохицуулалтгүй хэтэвч эсэхийг тодорхойлох³⁰ эрсдэлийн аргачлал, түүнийг бууруулах шийдэл, P2P-н зах зээлийн үзүүлэлтүүдийг цуглуулах, үнэлэхийн тулд блокчэйн шинжилгээ зэрэг арга, хэрэгслүүдийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, энэ талаар програмчид/хөгжүүлэгч нартай хамтран ажиллах.

³⁰ ФАТФ нь өнөөдрийг хүртэл зөвхөн ВХ-ийн хаягаас болон бүх нөхцөл байдалд үр шим хүртэгчийн түрийвчийг үнэн зөв, цогц байдлаар удирддаг ВХҮҮ-ийг тодорхойлох техникийн хувьд баттай арга хэрэгслийн талаар олж мэдээгүй болно.

104. Тодорхой төрлийн P2P, эсхүл P2P-тай холбоотой эрсдэлийн үнэлгээнээс хамаарч улс орнууд эдгээр эрсдэлийг үндэсний түвшинд бууруулахад тохиромжтой арга хэрэгслүүдийг авч үзэн, хэрэгжүүлж болно. Эдгээр арга хэрэгсэл, арга хэмжээнүүдэд хамруулж болох нь:

а. Зохицуулалттай болон зохицуулалтгүй аж ахуйн нэгжүүдийн хоорондох ВХ-ийн үйл ажиллагаа, P2P-н үйл ажиллагааны ил тод байдлыг дэмжих хяналт (эдгээр хяналтад ВХ-ийн шилжүүлэгтэй холбоотой баримт материал хадгалах дүрэм, эсхүл валютын гүйлгээний тайлангуудыг оруулах ёстой)³¹;

б. Зохицуулалтгүй хэтэвчний гүйлгээнд онцгойлон анхаарсан ВХ-ийн орон зайд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд болон ВХҮҮ нарт зориулсан эрсдэлд суурилсан нарийвчилсан хяналт шалгалт (ВХҮҮ нь эдгээр гүйлгээтэй холбоотой хууль тогтоомжуудыг дагаж мөрдсөн эсэхийг баталгаажуулах газар дээрх болон зайны хяналт шалгалт гэх мэт);

в. Зөвхөн ЭСА-тай уялдуулан хүлээн зөвшөөрөгдөхүйц гэж үзсэн хаяг, эх үүсвэрийн хооронд гүйлгээ хийхийг ВХҮҮ нарт үүрэг болгох;

г. Зөвхөн ВХҮҮ нар болон бусад зохицуулалттай аж ахуйн нэгжүүдийн хоорондох гүйлгээг дэмжихийг ВХҮҮ нарт үүрэг болгох;

д. Зохицуулалтгүй этгээдүүдийн хоорондын гүйлгээнд зориулж ВХҮҮ нарт МУТСТ нэмэлт шаардлагуудыг тавих (баримт материал хадгалах нэмэлт шаардлага, ХТМНҮА-ны шаардлага гэх мэт);

е. P2P-д оролцдог харилцагч нарт зориулж ЭСА хэрэглэх, эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийн үзүүлэлт болон ангилал зэргийг ашиглахын ач холбогдлыг онцолсон гарын авлагаар ВХҮҮ нарыг хангах;

ё. P2P-тай холбоотой эрсдэлийн талаар олон нийтэд зориулсан гарын авлага гаргах, энэ эрсдэлийн талаар зөвлөгөө өгөх, ойлголтыг нэмэгдүүлэх кампанит ажлууд зохион байгуулах (тодорхой хэрэглэгчид, үйлдэл, орон нутгийн болон бүс нутгийн эрсдэл, зохицуулах болон хууль сахиулах байгууллагуудын мэдээлэл зэргийг үнэлэх замаар P2P-тай холбоотой тодорхой эрсдэлийг харгалзан үзэх гэх мэт).

105. P2P-тай холбоотой эрсдэлээс гадна ФАТФ-ын зүгээс нэмэлт арга хэмжээ шаардагдаж болох бусад эрсдэлийг тодорхойлсон байдаг. Үүнд МУТСТ тогтолцоо байхгүй, эсхүл сул тогтолцоотой (МУТСТ урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохих ёсоор хэрэгжүүлээгүй) улс орнуудад байрладаг ВХҮҮ болон төвлөрсөн бус засаглалын бүтэц (МУТСТ арга хэмжээг ашиглаж болох зуучлагчийг оролцуулаагүй)-тэй холбоотой эрсдэлийг оруулна³². Үүний улмаас улс орнууд, эсхүл ВХҮҮ нар нь ВХҮҮ-тэй, эсхүл өөрийн улстай холбоотой эрсдэлийг тодорхойлох, эдгээр эрсдэлд чиглэсэн зохих хяналт, шалгалт, дүрэм журмууд хангалтгүй улс орнууд, ВХҮҮ нартай холбоотой

³¹ Ийм тайлагналын шаардлагууд нь хил дамнасан их хэмжээний бодит мөнгөний шилжүүлэгтэй холбоотой МУТС эрсдэлүүдийн талаар ФАТФ-ын зүгээс тайлагнахыг шаарддаг шаардлагуудтай ижил төстэй (3.32-г үз).

³² Илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл тогтвортой койнын талаарх Их 20-д зориулсан ФАТФ-ын тайланг үз.

гүйлгээнүүдэд зориулсан тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэх шаардлагатай байж болно. Ялангуяа олон нийтээр ашиглах боломжтой бол дээрх эрсдэлүүд нь өндөр байна³³.

ВХ/ВХҮҮ-ийн хориглолт, эсхүл хязгаарлалт

106. Аливаа улс орон нь энэхүү гарын авлагад тусгаагүй бусад бодлогын зорилтууд (харилцагчийн болон хөрөнгө оруулагчийн хамгаалалт, аюулгүй болон найдвартай байдал, мөнгөний бодлого гэх мэт)-д дэмжлэг үзүүлэх зорилгоор, эсхүл өөрсдийн эрсдэлийн үнэлгээ болон зохицуулалтын орчинд үндэслэж зохицуулалтгүй этгээдүүдийн явуулах ВХ-ийн үйл ажиллагаа, ВХҮҮ нарыг хориглож, хязгаарлах эрхтэй болно. Үүнд МУТСТ-д хүлээн зөвшөөрөгдөхгүй түвшний эрсдэл учруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний тусгай хориг, хязгаарлалт, эсхүл үйл ажиллагаанд тавигдах ерөнхий хориг, хязгаарлалтыг оруулж болно. Ийм хориг, хязгаарлалт нь хуулийн, эсхүл хууль сахиулах арга хэрэгсэл байх ёстой.
107. ВХ-ийн үйл ажиллагаа, эсхүл ВХҮҮ нарыг хориглох, хязгаарлах эсэх талаар шийдвэрлэхдээ улс орнууд нь ВХ болон ВХҮҮ нартай холбоотой МУТС эрсдэлийг ойлгох ёстой. Мөн улс орнууд нь МУТС эрсдэлтэй холбоотой ийм хоригийн нөлөөллийг харгалзан үзэх ёстой. Тухайн улс орон нь ийм үйл ажиллагааг хориглох, хязгаарлах, эсхүл зохицуулахаар болсон эсэхээс үл хамаарч МУТСТ эрсдэлийг арилгахад нэмэлт арга хэмжээ чухал ач холбогдолтой байж болно. Жишээлбэл, тухайн улс орон нь ВХ-ийн үйл ажиллагаа болон ВХҮҮ нарыг хориглосон бол эрсдэлийг бууруулах арга хэмжээнд хууль бусаар үйл ажиллагаа явуулдаг ВХҮҮ (эсхүл ВХ-ийн үйл ажиллагаанд оролцож болох бусад зохицуулалттай этгээдүүд) нарыг тодорхойлох, ийм ВХҮҮ нарт зохих хариуцлагын арга хэмжээ авах, гадаад улсад байрлалтай ВХҮҮ-ийн санал болгож буй үйлчилгээтэй холбоотой эрсдэлийг үнэлэх зэргийг оруулж болно. Тухайн улсын эрсдэлийн түвшинд үндэслэж хориг, хязгаарлалтыг албадан хэрэгжүүлэх арга хэмжээ авах шаардлага үүсч болох бөгөөд мөн ВХ-ийн хил дамнасан үйл ажиллагаа (хил дамнасан ВХ-ийн төлбөр, шилжүүлэг гэх мэт), ВХҮҮ нарын үйл ажиллагаа зэрэг эрсдэлийг арилгах стратегиудыг хэрэгжүүлж болно. МУТС эрсдэл болон хориг, хязгаарлалтыг албадан хэрэгжүүлэх бололцоо зэрэг нь хурдацтай хувьсан өөрчлөгдөж байгаа тул улс орнууд нь эрсдэлийн үнэлгээний үндэс суурийг тогтмол хэлэлцэж, эргэн харж байх шаардлагатай.
108. **Зөвлөмж 2** нь ВХҮҮ-ийн салбарт МУТСТ, ҮОХЗДСТ бодлогуудын хүрээнд хамтын ажиллагаа, уялдаа холбоотой байхыг шаарддаг. Ийм хамтын ажиллагаа, уялдаа холбоо нь ВХ-ийн үйл ажиллагааг зохицуулж, хянахад улс орнуудад шууд бус байдлаар хамаардаг. Улс орнууд нь ВХ-ийн үйл ажиллагаа болон ВХҮҮ нартай холбоотой МУТСТ, ҮОХЗДСТ эрсдэлд чиглэсэн үр дүнтэй бодлого, дүрэм журмууд болон бусад арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэхийн тулд бодлого боловсруулагчид, зохицуулагч байгууллагууд, хянан шалгагчид, СМА, хууль сахиулах эрх бүхий байгууллагуудыг хоорондын болон өөр бусад холбогдох эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах боломжийг бүрдүүлсэн агентлаг хоорондын ажлын хэсэг, эсхүл ажлын бүлэг зэрэг механизмуудыг бий болгох ёстой. Үүнд мэдээллийн хамгаалалт, нууцлалын

³³ ХХДЗА болон нийтээр ашиглахтай холбоотой МУТС эрсдлүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг 40-р хэсгээс үзнэ үү.

дүрмүүд болон бусад ижил төстэй (мэдээллийн нууцлал/нутагшуулалт гэх мэт) дүрэм журмуудтай МУТСТ шаардлагууд нийцэмжтэй байгаа эсэхийг баталгаажуулахын тулд холбогдох эрх бүхий байгууллагуудын хоорондох хамтын ажиллагаа, уялдаа холбоог хамруулж ойлгоно. Ялангуяа ВХ-үүд нь хөдөлгөөн ихтэй, хил дамнасан шинж чанартай байдаг төдийгүй зохицуулалттай ВХ-ийн үйл ажиллагаанд зохицуулалтын олон байгууллагууд (мөнгөний шилжүүлэг, үнэт цаас, түүхий эд болон үүсмэл үнэт цаасны үйл ажиллагааг зохицуулах эрх бүхий байгууллагууд гэх мэт)-ыг татан оролцуулах шаардлагатай байж болох тул үндэсний хамтын ажиллагаа, уялдаа холбоо нь чухал юм. Түүнчлэн кибер болон ВХ-ийн экосистемтэй холбоотой агентлаг хоорондын төрөл бүрийн арга хэрэгслийг хөшүүргэ болгон ашиглах, мөрдөн шалгах ажиллагааг гүнзгийрүүлж хийх зэрэгт ВХ-ийн асуудалтай холбоотой үндэсний хамтын ажиллагаа чухал юм.

ВХ-ийн харилцаа: Хөрөнгө болон үнэ бүхий зүйлд суурилсан гэх нэр томьёо, нөхцөлийг тайлбарлах нь

109. ФАТФ-ын Зөвлөмжүүдийг ашиглах зорилгоор улс орнууд нь “хөрөнгө”, “мөнгөн хөрөнгө”, “мөнгөн болон бусад хөрөнгө” болон “харгалзах үнэ бүхий” зэрэг бусад хөрөнгө болон үнэ бүхий зүйлд суурилсан бүх нэр томьёог харгалзан үзэх ёстой. Ялангуяа улс орнууд нь МУТС, ҮОХЗДСТ хүрээнд ВХ-ийг урвуулан ашиглахаас сэргийлэхийн тулд Зөвлөмж 3-8, 30, 33, 35 болон 38-д заасан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой бөгөөд эдгээрт ВХ-тэй холбоотой дээр дурдсан хөрөнгө, эсхүл үнэ бүхий зүйлд суурилсан нэр томьёо, үүнтэй ижил төстэй нэр томьёог оруулсан байдаг. Мөн улс орнууд нь ВХ-ийг оролцуулсан гэмт хэргээс олсон бүх мөнгөн хөрөнгөтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх ёстой. Дээр дурдсан зөвлөмжүүдийн зарим нь өнгөц харахад ВХҮҮ болон үүнтэй ижил төстэй зохицуулалттай байгууллагуудтай шууд хамааралгүй мэт боловч бодит байдал дээр хамааралтай юм. Эдгээр зөвлөмж нь МУ гэмт хэрэг, хөрөнгө хураах, түр зуурын арга хэмжээ, ТС гэмт хэрэг, санхүүгийн зорилгот хориг арга хэмжээ, ашгийн бус байгууллагууд, хууль сахиулах эрх мэдэл, хориг арга хэмжээ болон олон улсын хамтын ажиллагаатай холбоотой.
110. **Зөвлөмж 3.** Зөвлөмж 3-ыг хэрэгжүүлэх зорилгын хувьд үнийн дүнг үл харгалзан мөнгө угаах гэмт хэргийг ВХ-тэй холбоотойгоор гэмт хэргээс шууд олсон бүх төрлийн хөрөнгөд хамааруулж үздэг. Тухайн хөрөнгө нь гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө (ВХ-тэй холбоотой мөнгөн орлого) болох нь тогтоогдсон бол гэмт этгээд нь заавал суурь гэмт хэрэгт яллагдсан байх шаардлагагүй. Иймд улс орнууд нь мөнгө угаах гэмт хэргийн арга хэмжээг ВХ-тэй холбоотой гэмт хэргийн мөнгөн хөрөнгийг хамруулсан байдлаар өргөн цар хүрээнд авч үзэх ёстой.
111. **Зөвлөмж 4.** Дээрхийн нэгэн адил (a) мөнгө угааж олсон хөрөнгө, (b) мөнгө угаах, эсхүл гэмт хэрэг үйлдэх зорилгоор ашигласан, эсхүл ашиглахад зориулсан мөнгөн орлого, (c) террорист үйл ажиллагаа, террорист үйлдэл, эсхүл террорист байгууллагыг санхүүжүүлэхэд ашигласан, ашиглах зорилготой, хуваарилсан мөнгөн орлого, хөрөнгө, (d) харгалзах үнэ бүхий хөрөнгөтэй холбоотой хөрөнгө хураах, түр зуурын арга хэмжээг мөн ВХ-д хэрэглэнэ.

112. Албан ёсны мөнгөн тэмдэгт болон бараа бүтээгдэхүүнд хамаарах түр зуурын арга хэмжээ, эсхүл хөрөнгө хураах үйл ажиллагааны хувьд хууль сахиулах байгууллагууд нь гэмт хэргийн үйл ажиллагаанаас гаралтай гэж үзэх үндэслэл байхгүй бол хөрөнгийг түр царцаах хүсэлт гаргах боломжтой байх ёстой. Хөрөнгийг хураах хүсэлт гаргах, эсхүл хөрөнгийг царцаах хугацааг сунгахын тулд хууль сахиулах байгууллагууд нь шүүхийн шийдвэр авах ёстой.
113. **Зөвлөмж 5.** Мөн Зөвлөмж 5-д заасан терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг хууль, эсхүл хууль бус эх үүсвэрээс гаралтай ВХ зэрэг “аливаа мөнгөн болон бусад хөрөнгө”-д хамааруулж болно (ЗТ.5-г үзнэ үү).
114. **Зөвлөмж 6.** Мөн улс орнууд нь хориг арга хэмжээний жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдийн ВХ зэрэг мөнгөн болон бусад хөрөнгийг цаг алдахгүйгээр царцаах ёстой. Түүнчлэн улс орнууд нь ВХ зэрэг мөнгөн болон бусад хөрөнгийг терроризмтой холбоотой санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ, ТС зорилгоор хоригийн жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдийн төлөө ашиглаагүй эсэхийг хянаж, баталгаажуулах ёстой.
115. **Зөвлөмж 7.** ҮОХЗД-тэй холбоотой санхүүгийн зорилтот хориг арга хэмжээний хүрээнд улс орнууд нь хоригийн жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдийн ВХ зэрэг мөнгөн болон бусад хөрөнгийг цаг алдахгүйгээр царцаах ёстой. Мөн улс орнууд нь ВХ зэрэг мөнгөн болон бусад хөрөнгийг хоригийн жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдийн төлөө ашиглаагүй эсэхийг хянаж, баталгаажуулах ёстой.
116. **Зөвлөмж 8.** Мөн улс орнууд нь 3.8-д заасанчлан ТС гэмт хэргээс ашгийн төлөө бус байгууллагуудыг хамгаалахын тулд ЭСА-тай уялдуулан арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой. Үүнд ВХ-ийг оролцуулсан мөнгөн хөрөнгийг террорист байгууллагууд руу нууцаар шилжүүлэх ажиллагаа хамаарна (3.8(с)-г үзнэ үү).
117. **Зөвлөмж 30** нь энэхүү гарын авлагын 111-р хэсэгт заасан бүх хөрөнгө, эсхүл үнэ бүхий зүйлд суурилсан нэр томьёоны хэрэглээний хүрээнд ВХ-ийн үйл ажиллагаа болон ВХҮҮ нарт хамааралтай. Бусад төрлийн гэмт хэргийн шинж чанартай хөрөнгө, мөнгөний хувьд холбогдох эрх бүхий байгууллагууд нь гэмт хэргээс олсон хөрөнгө гэж сэжиглэж буй, эсхүл хураасан юм уу хурааж болох ВХ-ийг царцаах, хураах зэрэг арга хэмжээг нэн даруй тодорхойлж, авч хэрэгжүүлж байх ёстой. Улс орнууд нь ВХ-ийг үндэсний хууль тогтоомжид хэрхэн ангилснаас үл хамааран (тухайн улсын хөрөнгийн тухай хууль тогтоомжтой холбоотойгоор ВХ-ийг хууль ёсны дагуу хэрхэн ангилснаас үл хамааран) 3.30-ыг хэрэгжүүлэх ёстой.
118. **Зөвлөмж 33.** Улс орнуудын хөтлөх ёстой статистикийн хувьд эрх бүхий байгууллагуудын хүлээн авч, тараах СГТ болон эрх бүхий байгууллагуудын царцаах, хураах хөрөнгийн талаарх мэдээлэл хамаарна. Иймд улс орнууд нь ВХҮҮ болон ВХ-ийн үйл ажиллагаатай холбоотойгоор 3.33-ыг хэрэгжүүлж, ВХҮҮ, ВХ, эсхүл ВХ-ийн үйл ажиллагаатай холбоотой СГТ-уудыг илгээдэг ВХҮҮ болон банк зэрэг бусад зохицуулалттай этгээдүүдээс илгээж, холбогдох эрх бүхий байгууллагуудын зүгээс хүлээн авдаг СГТ-ын талаарх статистик мэдээллийг хадгалах ёстой. Мөн хөрөнгө, эсхүл үнэ бүхий зүйлд суурилсан нэр томьёог агуулсан бусад Зөвлөмжүүд (Зөвлөмж 3-8, 30,

35 болон 38)-ийн хувьд улс орнууд нь үндэсний хууль тогтоомжид заасан өмч, хөрөнгийн тухай хууль тогтоомжтой холбоотойгоор ВХ-ийг хэрхэн ангилснаас үл шалтгаалж холбогдох эрх бүхий байгууллагуудын царцааж, хураан авсан аливаа ВХ-ийн талаарх статистик мэдээллийг хадгалах ёстой. Түүнчлэн улс орнууд нь мөрдөн шалгах ажиллагаа ыболон санхүүгийн шинжилгээнд тустай ВХ-тэй холбоотой үзүүлэлтүүдийг хамруулсан байдлаар СГТ болон холбогдох статистик мэдээллийг шинэчлэх талаар анхаарч үзэх ёстой.

119. **Зөвлөмж 35**-д МУТСТ-тэй холбоотой шаардлагуудыг дагаж мөрдөөгүй Зөвлөмжийн 6, 8-23-д заасан хувь хүн, хуулийн этгээдийн эсрэг хийсэн гэмт үйлдэлд нь тохирсон, дахин үйлдэгдэхээс сэргийлэхүйц (гэмт хэргийн, иргэний болон захиргааны) хариуцлагын арга хэмжээтэй авахыг улс орнуудаас шаарддаг. ЗТ.15-ын 6-р хэсэгт шаардсанчлан улс орнууд нь МУТСТ шаардлагуудыг дагаж мөрдөөгүй ВХҮҮ (болон ВХ-ийн үйл ажиллагаанд оролцдог бусад зохицуулалттай этгээдүүд) нарын эсрэг авч хэрэгжүүлэх хориг арга хэмжээтэй байх ёстой. СБ, СББМҮҮ болон бусад хувь хүн, хуулийн этгээдийн хувьд ийм хориг арга хэмжээ нь зөвхөн ВХҮҮ-д хамааралтай байх ёстой ч шаардлагатай бол мөн ВХҮҮ нарын захирал болон дээд шатны удирдлагад ч хамааралтай байх ёстой.
120. **Зөвлөмж 38** нь мөн хөрөнгө болон үнэ бүхий зүйлд суурилсан нэр томьёог агуулсан байдаг бөгөөд эдгээр нь ВХ-д хамааралтай ч ЗТ.15-ын 8-р хэсэгт тодорхойлсончлон Зөвлөмж 37-40-г хэрэгжүүлэхэд, Олон улсын хамтын ажиллагааны талаарх 3.1.8-р дэд хэсэгт заасан нөхцөлд хамааралтай.

Тусгай зөвшөөрөл олгох, эсхүл бүртгэлжүүлэх

121. Улс орнууд нь ВХҮҮ нарт тусгай зөвшөөрөл олгох, тэдгээрийг бүртгэлжүүлэх үүрэг бүхий нэг буюу түүнээс дээш эрх бүхий байгууллагуудыг томилох ёстой.
122. ФАТФ-ын стандартууд нь ВХҮҮ нарт тусгай зөвшөөрөл олгох, тэдгээрийг бүртгэлжүүлэхэд уян хатан байдлыг бий болгох боломжоор улс орнуудыг хангана. Олон улс орнууд ВХҮҮ нарыг одоо хэрэгжиж буй тусгай зөвшөөрөл, бүртгэлтэй холбоотой горимд хамруулах уу, эсхүл шинэ горим бий болгох уу гэсэн асуудал дээр шийдвэр гаргах шаардлагатай. Одоогийн мөрдөгдөж буй горимыг ашиглах нь улс орнуудын хувьд хэрэгжүүлэхэд хурдан байхын зэрэгцээ холбогдох процессыг хэрхэн ашиглах талаарх комплаенсын одоогийн мэдлэгийн давуу талыг эдлэх боломжийг олгодог. Улс орнуудад одоо мөрдөгдөж буй горимууд нь ВХҮҮ нарт тохирсон бол МҮБЗШҮ-д зориулсан горимууд зэрэг одоогийн тусгай зөвшөөрөл/бүртгэлийн системийг ашиглахад илүү хялбар байж болно. Гэхдээ ВХҮҮ нарт зориулсан шинэ горимыг гаргаж болох бөгөөд үүнд ВХҮҮ нартай хамааралгүй асуудлуудыг хамруулж болохгүй. Тухайлбал, ийм тогтолцоонд МУТСТ шинжилгээний технологийн чадавхад илүү анхаарч, уламжлалт санхүүгийн үйлчилгээний салбараас ялгарах ВХ-ийн салбарын эрсдэл, эрсдэл арилгах арга хэмжээний талаар заасан байна. Одоогийн систем нь ВХҮҮ-ийн эрсдэлд хангалттай чиглэсэн эсэхийг урьдчилж баталгаажуулах шаардлагатай. Улс орнууд ВХ болон ВХҮҮ нарт тусгайлан зориулсан шинэ хууль тогтоомж, дүрэм журмыг гаргасан бол тухайн шинэ тусгай зөвшөөрөл, бүртгэлийн систем нь илүү ач холбогдолтой байж болно. Улс орнууд нь өөр өөр төрлийн ВХ, ВХҮҮ нарын үйл

ажиллагаа, холбогдох МУТС эрсдэлийг үнэлсний үндсэн дээр тухайн горимын төрөл, шаардлага, шинж чанар зэргийг харгалзан үзэх ёстой.

Ямар ВХҮҮ нарт тусгай зөвшөөрөл олгож, эсхүл бүртгэлжүүлэх ёстой вэ?

123. ЗТ.15-н 3-р хэсэгт заасны дагуу дор хаяж ВХҮҮ нарыг үүсгэн байгуулагдсан улс оронд нь тусгай зөвшөөрөлд хамруулж, эсхүл бүртгэлжүүлэх ёстой. Хуулийн этгээдийг үүсгэн байгуулахад³⁴ улсын, бизнесийн болон өөр ижил төстэй бүртгэлд бүртгүүлэх, эсхүл нотариат болон өөр бусад албан хаагчаар баталгаажуулах, компанийн дүрэм болон дотоод журмыг гаргах, компанийн татвар төлөгчийн дугаар авсан байх зэрэг хуулийн этгээдийг албажуулахад хэрэглэдэг механизм байх ёстой.

124. ВХҮҮ нь хувь хүн бол бизнес нь байрлаж буй газарт тусгай зөвшөөрөл авч, эсхүл бүртгүүлсэн байх шаардлагатай. Ингэхдээ улс орнуудын харгалзан үзэх ёстой хэд хэдэн хүчин зүйлс бий. Хувь хүний бизнесийн байршлыг бизнесийн үйл ажиллагааг гүйцэтгэж байгаа, эсхүл бизнесийн бүртгэл, баримт бичиг хадгалагдаж буй, тухайн этгээд оршин сууж байгаа (хувь хүний үндсэн оршин суух газар гэдгийг тухайн бизнес оршин байгаа хаягаар тооцож болно) үндсэн байршлаар тодорхойлж болно. Мөн нэг анхаарч үзэж болох хүчин зүйл гэвэл бизнесийн хаяг нь бизнесийн серверийн байрлал байж болно.

125. Мөн улс орнууд нь харилцагчдад зориулж бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлдэг ВХҮҮ нараас тусгай зөвшөөрөл авсан байх, эсхүл бүртгүүлсэн байхыг шаардаж болно. Иймд хост улс орнууд нь өөрсдийн нутагт оршин сууж, эсхүл амьдарч буй хүмүүст үйлчилгээ үзүүлж буй ВХҮҮ нарыг тусгай зөвшөөрөл авсан байх, эсхүл бүртгүүлсэн байхыг шаардаж болно. Эсхүл эдгээр хост улс орнууд нь өөрсдийн нутагтаа ВХҮҮ нарыг ажилчид, эсхүл удирдлагатай байхыг шаардаж болно. Эдгээр аж ахуйн нэгжүүдийг ФАТФ-ын стандартад хамруулахыг шаарддаггүй ч улс орнууд нь ВХ-ийн хил дамнасан шинж чанартай холбоотой эрсдэлийг бууралахад дээрх хамгаалалт чухал байж болно. ВХ нь аж ахуйн нэгжүүд хаана бүртгэлтэй, үүсгэн байгуулагдснаас үл хамаарч ямар ч улс оронд нэвтрэх боломжтой тул энэхүү эрсдэлийг харгалзан үзэж өргөн цар хүрээний хамгаалалттай байх нь илүү чухал байж болно.

126. Үүсгэн байгуулагдснаасаа өөр улс оронд бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлж буй ВХҮҮ нарыг тодорхойлохын тулд хянан шалгагч нар нь холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг ашиглаж болно. Үүнд оффис болон серверийн байршил (дуудлагын төв зэрэг харилцагчтай нүүр тулгарах үйл ажиллагаа орно), тодорхой улс орон/зах зээлийг чиглэсэн идэвхижүүлэлтийн харилцаа холбоо, ВХҮҮ-ийн вэбсайт болон хөдөлгөөнт апплейкшний хэл, ВХҮҮ-ийн аливаа улс оронд түгээлтийн сүлжээтэй байдал (аливаа улс орны оршин суугч нартай биечлэн уулзах, эсхүл туслалцаа үзүүлэх зуучлагчийг томилсон эсэх гэх мэт), зорилтот улс орнуудыг мэдэхийн тулд харилцагчаас асуух тусгай мэдээлэл зэргийг хамруулна.

ВХҮҮ нарыг тусгай зөвшөөрөлд хамруулах, эсхүл бүртгүүлэх эсэхийг хэрхэн тодорхойлох

127. Улс орнууд нь тусгай зөвшөөрөл, эсхүл бүртгэлгүй ВХ-ийн үйл ажиллагаа явуулдаг хувь хүн, хуулийн этгээдийг тодорхойлох арга хэмжээг авч хэрэгжүүлж, мөн ВХ-ийн

³⁴ ЗТ.24-ийн 40-р тайлбарыг үзнэ үү.

үйл ажиллагаанд оролцож болох уламжлалт зохицуулалттай этгээдүүд (харилцагчиддаа ВХ-ийн үйлчилгээ үзүүлдэг банк гэх мэт)-ийн хүрээнд зохих хариуцлагын арга хэмжээг авдаг байх ёстой. Үндэсний эрх бүхий байгууллагууд нь ВХ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлдэг, эсхүл ВХ-ийн үйл ажиллагаанд оролцож болох бусад зохицуулалттай этгээдүүд болон ВХҮҮ-ийн салбарыг хянах механизмтай байх ёстой ба бүртгүүлэх, эсхүл тусгай зөвшөөрөл авах чиг үүрэгтэй эсэх талаар ВХҮҮ болон бусад зохицуулалттай этгээдүүдэд мэдээлэл дамжуулах сувгуудтай байна. Мөн улс орнууд нь бүртгэлтэй болон бүртгэлгүй ВХҮҮ нарыг тодорхойлох, хариуцлагын арга хэмжээ авах эрх бүхий этгээд (мөн ВХ-ийн үйл ажиллагаанд оролцдог бусад зохицуулалттай этгээдүүд)-ийг томилох ёстой. 108-109 дүгээр хэсэгт заасанчлан ВХҮҮ, эсхүл ВХ-ийн үйл ажиллагааг хориглосон улс орнууд нь 3.15-д шаардсаны дагуу хууль ёсны үүрэг хариуцлагаа биелүүлээгүй хувь хүн, хуулийн этгээдийг тодорхойлох, хариу арга хэмжээ авах эрх мэдэл, хэрэгслүүдтэй байх ёстой.

128. Тусгай зөвшөөрөл, эсхүл бүртгэлгүй үйл ажиллагаа явуулж байгаа этгээдүүдийг тодорхойлохын тулд улс орнууд нь холбогдох шалгалтыг хийхэд хангалттай нөөц, арга хэрэгслүүдтэй эсэхийг харгалзан үзнэ. Тухайлбал, улс орнууд нь дараах зүйлсийг харгалзан үзэж болно. Үүнд:

а. Блокчэйн, эсхүл тархмал бүртгэлийн шинжилгээний хэрэгслүүд болон бусад мөрдөн шалгах ажиллагааны арга хэрэгслүүд, чадавх;

б. Бүртгэлгүй, эсхүл тусгай зөвшөөрөлгүй этгээдийн сурталчилгаа, идэвхжүүлэлтийн харилцаа холбоо, хөтөлбөрүүд, эсхүл бусад зүйлсийг тодорхойлох нээлттэй эх сурвалжийн мэдээлэл, вэб дээрх мэдээлэл;

в. Бүртгэлгүй, эсхүл тусгай зөвшөөрөлгүй байж болох тодорхой бизнесүүдийн талаарх салбарын мэдээлэл, олон нийт болон зохицуулалттай этгээдүүдийн мэдээлэл (нийтийн санал хүсэлтийг хүлээн авах сувгуудыг бий болгох гэх мэт);

г. Бүртгэлгүй, эсхүл тусгай зөвшөөрөлгүй хувь хүн, хуулийн этгээд (ВХҮҮ)-ийг олж тодорхойлох мөрдөн шалгах ажиллагаа, СГТ зэрэг мэдээлэх үүрэгтэй этгээдүүдээс болон СМА-наас хүлээн авсан бусад мэдээлэл;

д. Тухайн байгууллага урьд өмнө нь тусгай зөвшөөрөл, бүртгэлд өргөдөл гаргаж байсан эсэх, бүртгэл юм уу тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн эсэх талаарх олон нийтэд нээлттэй бус мэдээлэл;

е. Олон улсын хамтын ажиллагааны мэдээлэл гэх мэт хууль сахиулах байгууллагын болон хяналт шалгалтын тайлангууд (олон улсын ижил төстэй байгууллагуудын зөвлөмж гэх мэт).

ВХҮҮ нарт тусгай зөвшөөрөл олгох, бүртгэлжүүлэхэд анхаарах зүйлс

129. Тусгай зөвшөөрөлтэй, эсхүл бүртгэлтэй ВХҮҮ нар нь холбогдох эрх бүхий байгууллагуудын тавьсан тусгай зөвшөөрөл, бүртгэлийн шалгуур үзүүлэлтийг хангах шаардлагатай. Эдгээр шалгуур нь ВХҮҮ нарыг МУТСТ үүрэг хариуцлагыг дагаж мөрдөх боломжтой эсэх тал дээр үндэсний хянан шалгагч нарт итгэл үнэмшил өгөх

ёстой. Иймд ВХҮҮ нарын үйл ажиллагааны шинж чанар (ВХ болон гүйлгээний төрлүүд, зорилтот хэрэглэгчид, хуваарилалтын суваг гэх мэт)-ыг харгалзан үзэж МУТСТ хөтөлбөрүүд, бодлого, дүрэм журмууд, тэдгээрийн зохион байгуулалтыг хэрэгжүүлж, эсхүл хэрэгжүүлэх боломжтой гэдгээ батлан харуулах үүрэгтэй байхыг дээрх шалгуурт тусгаж өгнө. Мөн комплаенс хариуцсан ажилчдын ур чадвар, итгэлтэй байдлын талаар ч анхаарч үзэх ёстой. Эдгээр шалгуурын үнэлгээг тусгай зөвшөөрөлд хамруулах, бүртгэлжүүлэх үед хийвэл, эсхүл ВХ-ийг ашиглалтад оруулахын өмнө эрсдэлийн хяналт байгаа эсэхийг баталгаажуулах зорилгоор хийвэл илүү үр дүнтэй байдаг.

130. ВХҮҮ нарын тусгай зөвшөөрөл, бүртгэлжүүлэлтийн схемийг улс орнууд гаргасан даруйд олон тооны ВХҮҮ нар тусгай зөвшөөрөл, бүртгэлд хамрагдах хүсэлтийг нэгэн зэрэг гаргаж болно. Процессыг илүү энгийн, хялбар байлгах үүднээс холбогдох эрх бүхий байгууллагууд нь нөөц хөрөнгө хангалттай байгаа эсэх, мөн ирж буй хүсэлтүүдийг эрэмбэлэх хангалттай уян хатан байдлыг аргачлалдаа тусгасан эсэхийг хэрхэн баталгаажуулах талаар анхаарч үзвэл зохино. Улс орнууд нь өргөдөл, хүсэлтүүдийг эрэмбэлэхэд олон хүчин зүйлсийг анхаарч үзэж болох ч хянан шалгагчийн санал дүгнэлт, чадавх зэрэгт үндэслэж эрэмбэлэлт хийх ёстой.
131. Тусгай зөвшөөрөл, бүртгэлжүүлэлтэд хамруулахад эрх бүхий байгууллагууд нь гэмт хэрэгтнүүд болон тэдгээртэй хамаарал бүхий этгээдүүд ВХҮҮ-ийн эцсийн өмчлөгч болох, эсхүл ихээхэн хэмжээний юм уу хяналтын багцыг нь эзэмших, удирдлагыг нь авахаас сэргийлсэн хууль эрх зүй, зохицуулалтын шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой. Ийм арга хэмжээний хүрээнд ВХҮҮ нараас хувьцаа эзэмшигчид, бизнесийн үйл ажиллагаа, бүтэц зэрэгт нь томоохон өөрчлөлт орохоор бол эрх бүхий байгууллагуудаар урьдчилж батлуулж байхыг шаардаж болно.
132. Эрсдэлд үндэслэн эрх бүхий байгууллагууд нь ВХҮҮ нарыг үр дүнтэй хянах зорилгоор тусгай зөвшөөрөл, эсхүл бүртгэлд хамрагдахыг хүсч буй ВХҮҮ нарт нөхцөл, шаардлага тавьж болно. Иймд нөхцөл, шаардлагад ВХҮҮ нарын үйл ажиллагааны хэмжээ, шинж чанар зэргээс хамаарч дараах зүйлсийг хамруулж болно. Үүнд: байнгын оршин суугч бүхий гүйцэтгэх захиралтай байх, менежментийн дийлэнх оролцоотой байх, санхүүгийн тусгай шаардлагууд болон маркетингийн материал, вебсайт, гар утасны апплейкшн зэрэгтэй холбоотой бүртгэл, тусгай зөвшөөрлөө мэдээлж байх шаардлагууд, мөн эрх бүхий байгууллагууд нь аутсорсингийн функцууд болон туслан гүйцэтгэгчдийн холбогдох бизнесийн орчинтой холбоотой мэдээ, мэдээлэлд нэвтрэх эрхтэй байх шаардлагууд зэргийг дурдаж болно.
133. ФАТФ-ын стандартуудад хамаарах бусад аж ахуйн нэгжүүдийн нэгэн адил ВХҮҮ нар нь шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний загварыг гаргаж, бүтээж байхдаа буюу эдгээр бүтээгдэхүүн, үйлчилгээг гаргахын өмнө МУТСТ комплаенсийг бий болгосон байх ёстой. Эс бөгөөс дараа нь комплаенсын хэрэгжилтийг хангахад илүү бэрхшээлтэй болно. Иймд нэн ялангуяа тусгай зөвшөөрөл, бүртгэлд хамруулах үе шатанд эрсдэлийг сайтар үнэлж, мөн эрсдэлийг бууруулах арга хэмжээг ч сайтар үнэлэх нь чухал юм. Тусгай зөвшөөрөл, бүртгэлд хамруулж дуусмагц бүтээгдэхүүн, үйлчилгээнд тусгасан МУТСТ арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, хянаж байх ёстой.

134. Улс орнууд нь олон нийтийн харилцаа холбооны хэрэгсэл, арга хэмжээ (боловсролын кампанит ажил, форум, эсхүл ВХ-ийн экосистем дэх “ажлын цаг”)-гээр дамжуулж ВХҮҮ нарт тавигдах МУТСТ шаардлагуудыг онцлон дурдаж байвал зохино. Компаенсын соёлыг дэмжих өөр нэг чухал үзүүлэлт нь зөвлөгөө, гарын авлага чиглэл өгөх замаар хууль, эрх зүйн тогтолцоог тодорхой болгох явдал юм. Мөн улс орнууд нь бүртгэлтэй, эсхүл бүртгэлгүй ВХҮҮ нарын эсрэг албадан арга хэмжээ авахдаа ил тод байх талаар анхаарч үзвэл зохино.
135. Түүнчлэн зарим улс орнуудын хувьд тусгай зөвшөөрөл, бүртгэлжүүлэлтийн шаардлагыг өндөр эрсдэлтэйд тооцож хэрэгжүүлэхгүй байж болох бөгөөд энэ тохиолдолд ийм тусгай зөвшөөрөл/бүртгэлийн үр дүнтэй тогтолцоогүй улс орнуудын ВХҮҮ нартай харилцах, хамтран ажиллахыг өндөр эрсдэлтэй гэж хянан шалгагчийн зүгээс үзсэн бол нэмэлт тайлагналын шаардлагуудыг гаргаж болно (мөн Бүлэг 3 болон 4-ийн 3.16 дахь ВХҮҮ нарын ХТМ, Бүлэг 3-ын 3.10 дээрх ХТМНҮА-ны мэдээллийг үзнэ үү).
136. Бүх улс орнууд нь бүх холбогдох хууль эрх зүйн болон зохицуулалтын шаардлагуудтай нийцэмжтэй ажиллах соёлыг дэмжих ёстой. Ингэхдээ МУТСТ арга хэмжээнээс гадна хөрөнгө оруулагч болон хэрэглэгчийн хамгаалалт, зах зээлийн найдвартай байдал, үндэсний болон эдийн засгийн ашиг сонирхол зэрэг өргөн цар хүрээний бодлогын зорилтуудыг харгалзан үзэж болно. Иймд зарим улс орнууд нь МУТСТ эрх үүргийг хэрэгжүүлдэггүй бусад эрх бүхий байгууллагуудаас тусгай зөвшөөрөл авахгүй байхыг зааж өгсөн байдаг. Мөн ВХҮҮ болон эрх бүхий байгууллагууд нь хэрэглэгчийн болон гүйлгээний хэмжээний төсөөлөлтэй уялдуулж МУТСТ компаенсын функцэд хангалттай хэмжээний нөөцийг зарцуулж байгаа эсэхийг улс орнууд хянаж баталгаажуулах ёстой.
137. Өмнө дурдсанчлан ялангуяа нийтээр ашиглах боломжтой болон Р2Р-д ашиглах боломжтой тогтвортой койнын МУТС эрсдэлийг одоогийн нөхцөл байдалд тохируулж, мөн ирээдүйг харсан байдлаар шинжилж, тогтвортой койнуудыг нэвтрүүлэхээс өмнө эдгээр эрсдэлийг бууруулна. ВХҮҮ, эсхүл бусад зохицуулалттай этгээд нь тогтвортой койныг бүтээж, ашиглахыг зорьж байгаа бол тусгай зөвшөөрөлд хамруулах, бүртгүүлэх процессын хүрээнд МУТС эрсдэлийг үнэлэх, арилгах ажиллагааг хамруулах ёстой. Ялангуяа тогтвортой койнд ВХҮҮ, эсхүл бусад зохицуулалттай этгээд оролцдоггүй байдлыг харгалзан үзэж, хянан шалгагч нар нь анхаарал болгоомжтой байх ёстой. Аливаа хөрөнгийг ашиглалтад гаргахаар бүтээж, хөгжүүлэх процессыг автоматжуулах боломжгүй тул эхлэлийн үе шатанд дээрх хүчин зүйлийг харгалзан үзэх нь ач холбогдолтой. Бүх ВХҮҮ нарын эрсдэлийн үнэлгээ, тусгай зөвшөөрөл болон бүртгэлд хамруулах журам зэрэгт харгалзан үзэх ёстой нэг чухал үзүүлэлт бол нийтээр ашиглах боломжтой байдал юм. Ерөнхийдөө тогтвортой койныг ашиглалтад оруулж, эсхүл тогтвортой койнд оролцож буй ВХҮҮ болон зохицуулалттай этгээдүүдэд зориулсан тусгай зөвшөөрөл, бүртгэлийн журам нь ВХ-ийн журамтай ижил төстэй байх ёстой.

Дотоодын болон олон улсын түншүүдийн хамтын ажиллагаа

138. Зөвлөмж 2-ын хүрээнд өмнө дурдсанчлан зохицуулалт, тусгай зөвшөөрөл, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрөл бүрийн эрх бүхий байгууллагууд нь зөвшөөрөлгүй

үйлчилгээ үзүүлэгчид, үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл эзэмшиж байж болох тул эдгээр байгууллагын хоорондох хамтын ажиллагаа нь чухал юм. Энэ нь нэн ялангуяа нэг төвлөрсөн тогтолцоогүй, харин ВХҮҮ нарт зориулсан олон өөр төрлийн тусгай зөвшөөрөл, бүртгэлжүүлэлтийн тогтолцоотой тохиолдолд чухал ач холбогдолтой.

139. Мөн бүртгэлжүүлэлт, тусгай зөвшөөрөлд хамруулах процессын хувьд олон улсын хамтын ажиллагаа нь чухал юм. Өөр өөр улс орон дахь эрх бүхий байгууллагууд нь хоорондоо тусгай зөвшөөрөл, бүртгэлд хамрагдсан, мөн үйл ажиллагаа явуулж байгаа ВХҮҮ нарын талаар хоорондоо мэдээлэл солилцож байх нь зүйтэй. Улс орнууд нь тусгай зөвшөөрөлгүй, бүртгэлгүй ВХҮҮ нарыг тодорхойлох, хориг арга хэмжээ авахад дэмжлэг үзүүлэхийн тулд хоорондоо мэдээлэл хуваалцах сувгуудтай байх ёстой. Мөн улс орнуудын эрх бүхий байгууллагууд нь тусгай зөвшөөрөл, бүртгэлд хамруулах процесст хоорондоо хэрхэн хамтран ажиллах тал дээр ВХҮҮ нарын хянан шалгагчдын дундах мэдээлэл хуваалцах, хамтран ажиллах зарчмуудыг анхаарч үзэх ёстой (Бүлэг 4-ийг үзнэ үү).

Хяналт шалгалт

140. **Зөвлөмж 26 болон 27.** Дор дурдсанчлан 3.15-ын дагуу улс орнууд нь ВХҮҮ нартай холбоотойгоор МУТСТ хяналт шалгалтын үр дүнтэй системтэй байх шаардлагатай. 3.26 , 27-д дурдсанчлан 3Т.15-ын 5-р хэсгийн дагуу улс орнууд нь МУТСТ дүрэм журмууд, хяналт шалгалтыг ФАТФ-ын Зөвлөмжид заасны дагуу МУТС эрсдэлтэй уялдуулан үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэхийг хянан баталгаажуулах шаардлагатай. ВХҮҮ нар нь хяналтын үр дүнтэй тогтолцоотой байх ёстой бөгөөд үндэсний МУТСТ шаардлагуудтай нийцэмжтэй байдлаар ажиллах ёстой. Өөрийгөө зохицуулах байгууллага (ӨЗБ) биш харин эрх бүхий байгууллага нь эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийж, ВХҮҮ нарыг хянаж шалгах ёстой. ӨЗБ нь хянан шалгагч биш байх бөгөөд ӨЗБ болон салбарын бүлэглэлүүд нь хянан шалгагч нарт мэдээлэл хуваалцах, ВХҮҮ нар хүрэхэд туслалцаа үзүүлж болно. МУТС-тэй тэмцэх шаардлагын хүрээнд хянан шалгагч нар нь ВХҮҮ (болон ВХ-ийн үйл ажиллагаа явуулдаг бусад зохицуулалттай байгууллагууд) нарыг хянаж шалгах, комплаенсыг хангуулахад хангалттай эрх мэдэлтэй байх ёстой (үүнд хяналт шалгалт хийх, баримт бичгүүдтэй танилцах, мэдээлэл гаргуулж авах, ВХҮҮ нарын тусгай зөвшөөрөл, бүртгэлийг цуцлах, хязгаарлах, түдгэлзүүлэх зэрэг төрөл бүрийн санхүүгийн болон сахилгын хориг арга хэмжээ авах гэх мэт эрхүүд орно). Улс орнууд нь олон улсын хамтын ажиллагааны өргөн цар хүрээнд ВХҮҮ нарын хянан шалгагч нар нь хэн болох талаар илүү тодорхой мэдэж байх ёстой.

141. 3Т.15-ын 8-р хэсэгт заасанчлан ВХҮҮ нарын үйл ажиллагаа, үйлчилгээний хил дамнасан шинж чанар, тодорхой ВХҮҮ-ийг нэг улсын хүрээнд авч үзэхтэй холбоотой сорилт, бэрхшээлүүд, мөн холбогдох хянан шалгагч нарын хоорондох олон улсын хамтын ажиллагаа нь чухал ач холбогдолтой болно (мөн 257-260-р хэсгийг үзнэ үү). Мөн улс орнууд нь Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага, Олон улсын банкны хяналт шалгалтын Базелийн хороо зэрэг олон улсын стандарт тогтоогч байгууллагуудын холбогдох гарын авлага, зөвлөмжүүдтэй танилцах нь зүйтэй³⁵.

³⁵ Жишээлбэл, банкны үр дүнтэй хяналт шалгалтын үндсэн зарчмууд гэсэн Базелын хорооноос гаргасан баримт бичгийн 3 (хамтын ажиллагаа) болон 13 (үндсэн болон хост улсуудын харилцаа холбоо)-р зарчмыг үзнэ үү. www.bias.org/publ/bcns230.pdf

142. Энэхүү гарын авлагын 227-228-р хэсэгт дэлгэрэнгүй заасанчлан СББМҮҮ нь ВХҮҮ-ийн үйл ажиллагаа эрхэлдэг бол улс орнууд нь ФАТФ-ын Зөвлөмжүүдэд заасан ВХҮҮ нарт зориулсан бүх холбогдох (хяналт шалгалт гэх мэт) арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой³⁶.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ

143. Зөвлөмж 10-21-д заасан урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь ВХ болон ВХ-ийн санхүүгийн үйл ажиллагааны хүрээнд улс орнууд болон зохицуулалттай этгээдүүдийн аль алинд хамааралтай болохыг ЗТ.15-н 7-р хэсэгт тодорхой заасан. Гэхдээ Зөвлөмж 9, 22 болон 23 нь мөн энэхүү асуудалтай шууд бус байдлаар хамааралтай бөгөөд энэ талаар дор дурдсан болно. ВХ-ийн хүрээнд урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх талаар улс орнуудад туслалцаа үзүүлэхийн тулд дор дурдсан хэсэгт Зөвлөмж тус бүрийг тайлбарласан болно. Бүлэг 4 нь ВХ-ийн үйл ажиллагаа эрхэлдэг ВХҮҮ болон бусад зохицуулалттай этгээдүүдэд зориулсан гарын авлагаар хангах бөгөөд энд ФАТФ-ын Зөвлөмжүүдийн дагуу дор дурдсан урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон МУТСТ бусад арга хэмжээг хэрхэн авч хэрэгжүүлэх талаар заасан болно.

144. Ерөнхийдөө Зөвлөмж 10-21-т заасан урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь хоёр тусгайлсан асуудлын хувьд СБ-уудтай нэгэн адил байдлаар ВХҮҮ нарт хамаарна. Нэгдүгээрт, ВХҮҮ-ийн ХТМ-д хэрэгжүүлэх байнгын бус гүйлгээний босго дүн (15,000 ам.доллар/евро биш) 1,000 ам.доллар/евроогоос дээш байх, хоёрдугаарт, 3.16-д заасан шилжүүлгийн дүрэм нь ВХҮҮ болон ВХ-ийн шинжүүлэгт шинэчлэгдсэн байдлаар (“Шилжүүлгийн дүрэм”) мөрдөгдөнө. Энэ талаар дор илүү дэлгэрүүлж тайлбарласан болно.

Санхүүгийн байгууллагын нууцлалын тухай хууль тогтоомж

145. **Зөвлөмж 9** нь СБ-ын нууцлалын тухай хууль тогтоомж нь ФАТФ-ын Зөвлөмжүүдийн хэрэгжилтэд саад болохгүй эсэхийг баталгаажуулах зорилготой. Хэдийгээр 3.9 нь ВХҮҮ нарын талаар тусгайлан дурдаж, эдгээрийг хамраагүй ч гэсэн СБ-ын нууцлалын тухай хууль тогтоомж нь ВХҮҮ-тэй холбоотойгоор ФАТФ-ын Зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд саад болохгүй байх ёстой.

Харилцагчийг таньж мэдэх

146. **Зөвлөмж 10.** Улс орнууд болон зохицуулалттай байгууллагууд нь ФАТФ-ын стандартууд болон үндэсний хууль эрх зүйн шаардлагуудыг хангахуйц ХТМ процессыг гаргах ёстой. ХТМ процесс нь дээр дурдсан босго дүнгээс давсан байнгын бус гүйлгээ, эсхүл бизнесийн харилцаа холбоо, ВХ-ийн үйл ажиллагаатай холбоотой МУТС эрсдэлийг үнэлэхэд ВХҮҮ (болон ВХ-ийн үйл ажиллагаанд оролцож буй бусад зохицуулалттай байгууллагууд) нарт туслах ёстой. Анхан шатны ХТМ-д харилцагчийг, шаардлагатай бол харилцагчийн эцсийн өмчлөгчийг тодорхойлох, эрсдэл, найдвартай

³⁶ Улс орнууд нь ВХҮҮ-ийг “СБ” эсхүл “СББМҮҮ” гэж нэрлэж болно. Гэхдээ улс орнууд ВХҮҮ-ийг хэрхэн нэрлэхээс үл шалтгаалж ВХҮҮ нарын явуулж буй санхүүгийн үйл ажиллагаа, тэдгээрийн үзүүлж буй санхүүгийн үйлчилгээтэй уялдуулан СБ-уудтай ижил түвшинд хяналт шалгалт, зохицуулалтыг авч ашиглах ёстой.

болон хараат бус мэдээ, мэдээлэл, баримт бичигт үндэслэж харилцагчийн мэдээллийг холбогдох хууль эрх зүйн, эсхүл зохицуулалтын тогтолцоонд шаардсан хэм хэмжээнд баталгаажуулах ажлууд орно. Мөн ХТМ процесст бизнесийн харилцааны зорилго, шинж чанарыг ойлгох, шаардлагатай бол өндөр эрсдэлтэй нөхцөлд нэмэлт мэдээллийг олж авах ажлууд багтана.

147. Практикт ВХҮҮ нар нь дансыг нээж, хадгалж (харилцагчтай холбоо тогтоож) болох бөгөөд өөрсдийн харилцагчдын өмнөөс ВХ-ийн үйл ажиллагаа эрхэлж, үйлчилгээ үзүүлж байгаа бол ХТМ үйл ажиллагааны мэдээллийг цуглуулж авах ёстой. Гэхдээ ВХҮҮ нь байнгын бус гүйлгээ хийж байгаа бол ВХҮҮ-ийн зүгээс ХТМ хийхэд шаардлагатай босго дүн нь ЗТ.15-н 7(а)-р зүйлд заасны дагуу 1,000 ам.доллар/евро байна³⁷.
148. Гүйлгээ, эсхүл харилцаа холбооны шинж чанарыг үл харгалзан ВХҮҮ нар нь харилцагчтай бизнесийн харилцаа холбоо тогтооход, босго дүнгээс чөлөөлөгдсөн байдлыг үл харгалзан МУТС сэжигтэй тохиолдлууд гарсан үед, мөн өмнө олж авсан мэдээллийн хангалттай бөгөөд үнэн зөв байдлын талаар эргэлзэж байвал эрсдэлд суурилсан харилцагчийг таньж мэдэх, шалгаж баталгаажуулах үр дүнтэй дүрэм журмуудтай байх ёстой.
149. Зарим улс орнууд нь ВХ-ийн киоск (ВХ-ийн үйлчилгээ, бизнес загваруудтай холбоотой 71-р хэсэгт заасанчлан үүнийг зарим тохиолдолд ВХ-ийн АТМ гэж нэрлэж болно)-ийг байнгын гүйлгээ мэтээр үзэж болно. Энэ тохиолдолд киоскийн эзэмшигч/оператор, үйлчилгээ үзүүлэгч болон киоскийг ашиглаж буй харилцагч нар нь зөвхөн нэг удаа гүйлгээ хийж байх ёстой. Бусад улс орнууд нь ийм гүйлгээг байнгын гэж үзэхгүй бол ХТМ үүрэг үүсч болно.
150. Өмнө өгүүлсэнчлэн ВХ-үүд нь хил дамнасан шинж чанартай, түргэн төлбөр тооцоо хийгддэг, Р2Р-г хийх боломжтой, нэрийн нууцлал ба мэдээлэлгүй байдал нэмэгдэж байгаа, гүйлгээний шилжүүлэг болон оролцогч талуудын нууцлагдмал байдал зэрэгтэй холбоотойгоор МУТС эрсдэлтэй байж болно. Иймд улс орнууд нь дээрх шинж чанаруудыг харгалзан үзэж 3.10-д шаардсанаас илүү түвшинд буюу ВХҮҮ (болон ВХ-ийн үйл ажиллагаанд оролцдог банк зэрэг бусад зохицуулалттай этгээдүүд) нарын гүйцэтгэж буй гүйлгээ, эсхүл ВХ-ийн шилжүүлэгт зориулсан ХТМ шаардлагатай байж болно. Үүнд үндэсний эрхзүйн тогтолцоотой уялдуулсан 1,000 ам.доллар/еврогаос бага босго дүнтэй “байнгын гүйлгээ” ч хамааралтай. Ийм арга хэмжээ нь тухайн улсын эрсдэлийн үнэлгээнд суурилсан байх учир 3.1-д заасан ЭСА-тай нийцэмжтэй байх ёстой. Түүнчлэн улс орнууд нь өөрсдийн зохицуулалтын болон хяналт шалгалтын горимуудыг тогтоож байхдаа ВХҮҮ-ийг хэрхэн тодорхойлох тал дээр анхаарч үзэж, мөн гүйлгээг (ховор тохиолдолд биш) зөвхөн нэг удаа, эсхүл байнга хийж байгаа эсэхийг анхаарч үзэх ёстой. Байнгын гүйлгээний хувьд авч хэрэгжүүлэх ямар арга хэмжээтэй байхыг тодорхойлохдоо улс орнууд нь ВХҮҮ нарын үзүүлж буй үйлчилгээ, бүтээгдэхүүнийг харгалзан үзэх ёстой. ВХҮҮ нар нь ВХ-ийн орон зайд байнгын гүйлгээтэй холбоотой тухайн улсын баримталж буй аргачлалын дагуу үлдэгдэл эрсдэлийг хүлээн зөвшөөрөх

³⁷ ФАТФ нь ВХ-ийн үйл ажиллагааны хил дамнасан шинж чанар, эдгээртэй холбоотой МУТС эрсдлүүд зэргийг харгалзан үзэж ВХ-тэй холбоотой гүйлгээний босго дүнг 1,000 ам.доллар/евро болгон бууруулахыг зөвшөөрсөн.

боломжтой тохиолдолд бага эрсдэлтэй, нэг удаагийн шинж чанартай ВХ-ийн шилжүүлгийг тодорхойлж байхыг ВХҮҮ нараас шаардаж болно.

151. 3.10 (ЗТ.10)-ын Тайлбарт дурдсанчлан МУТС эрсдэл өндөр байх нөхцөлд ХТМНҮА-г авч хэрэгжүүлэх ёстой. Тухайлбал, ВХ-тэй холбоотой үйл ажиллагаа болон ВХҮҮ нарын хувьд улс орнууд нь үндэсний, эсхүл газарзүйн бүс нутгийн эрсдэлийн хүчин зүйлсийг харгалзан үзэх ёстой. Тодорхой улс оронд байрлаж байгаа ВХҮҮ нар, эсхүл эдгээр улсаас хийгдэж буй ВХ-ийн шилжүүлэг нь МУТС өндөр эрсдэлтэй байж болно (ЗТ.10-ын 15(b) хэсэг).

Харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан болон хялбаршуулсан үйл ажиллагаа

152. ВХҮҮ-ийн үйл ажиллагаа явуулж байгаа, эсхүл ВХ-ийн гүйлгээ хийгдэж буй улс орон нь МУТС өндөр эрсдэлтэй эсэхийг тодорхойлох нэгдсэн нэг аргачлал, нэр томъёоны тодорхойлолт байхгүй бол бусад эрсдэлийн хүчин зүйлсийн хамт тухайн улсын эрсдэлийг харгалзан үзэх ёстой. Ингэснээр МУТС эрсдэлийг тодорхойлох чухал мэдээлэл болно. Өндөр эрсдэлийн хүчин зүйлст оруулж болох зүйлс нь:

а. Найдвартай эх сурвалжуудын үүднээс террорист үйл ажиллагаанд санхүүжилт олгодог, дэмжлэг үзүүлдэг гэж тодорхойлсон, эсхүл террорист байгууллага гэж тодорхойлогдсон улс орнууд, эсхүл газарзүйн байршлууд³⁸;

б. Найдвартай эх сурвалжуудын зүгээс зохион байгуулалттай гэмт хэрэг, авилга, бусад гэмт хэргийн үйл ажиллагаа ихтэй (хууль бус мансууруулах бодис, хүний наймаа, контрабанд, хууль бус мөрийтэй тоглоомын эх үүсвэр, эсхүл дамжин өнгөрөх цэг болсон улсууд орно) гэж тодорхойлсон улс орнууд;

в. Нэгдсэн Үндэстний Байгууллага зэрэг олон улсын байгууллагуудаас гаргасан хориг арга хэмжээ, эсхүл үүнтэй төстэй арга хэмжээнд орсон улсууд;

г. Найдвартай эх сурвалжуудын үүднээс сул засаглал, хууль сахиулах болон зохицуулалтын тогтолцоо гэж тодорхойлогдсон улсууд (ФАТФ-ын зүгээс ВХҮҮ-тэй холбоотойгоор МУТСТ стратегийн дутагдалтай гэж тодорхойлогдсон улсууд, мөн бизнес харилцаа болон гүйлгээний хувьд ВХҮҮ болон бусад зохицуулалттай этгээдүүдийн зүгээс тусгайлан анхаарах ёстой гэж үзсэн улсууд орно).

153. Мөн улс орнууд нь ВХ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, гүйлгээ, хүргэлтийн сувагтай холбоотой эрсдэлийн хүчин зүйлсийг анхаарч үзэх ёстой. Тухайлбал, үйл ажиллагаа нь нууц, эсхүл “нэргүй гүйлгээ”, “нүүр тулсан бус алсын зайны бизнесийн харилцаа, гүйлгээ” болон/эсхүл “үл мэдэгдэх, холбоо хамааралгүй гуравдагч талаас хүлээн авсан төлбөр” зэрэгтэй холбоотой эсэхийг нягталж үзнэ (ЗТ.10-ын 15(c) болон энэхүү гарын авлагын 31-р хэсэгт заасан өндөр ба бага эрсдэлийн хүчин зүйлсийг жишээг үз). Бараг

³⁸ “Найдвартай эх сурвалжууд” гэж нэр хүндтэй, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын байгууллагуудын гаргадаг мэдээлэл болон ийм мэдээллийг олон нийтэд түгээдэг бусад байгууллагуудыг хамруулж ойлгоно. Ийм эх сурвалжуудад ФАТФ болон ФАТФ-ын төрлийн бүс нутгийн байгууллагуудаас гадна Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Санхүүгийн мэдээллийн албадын Эгмонт Групп зэрэг үндэсний болон олон улсын байгууллагуудыг хамруулж үзэж болно.

бүх ВХ-д дурдсан нэг буюу түүнээс дээш шинж чанар агуулагдсан байдаг тул улс орнуудын зүгээс ВХ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, гүйлгээ, эсхүл хүргэлтийн механизмын шинж чанарт үндэслэж ийм төрлийн үйл ажиллагааг өндөр эрсдэлтэй гэж тодорхойлж болно.

154. Дээр дурдсан болон бусад тохиолдлуудад өмнө өгүүлсэн хүчин зүйлстэй холбоотой өндөр эрсдэлийг бууруулах ХТМНҮА-д дараах зүйлсийг хамруулна. Үүнд:

а. Харилцагчаас хүлээн авсан иргэний үнэмлэхний дугаар зэрэг тусгай мэдээллийг гуравдагч талын өгөгдлийн сан, эсхүл бусад найдвартай эх үүсвэрийн мэдээлэлтэй харьцуулж батлах нотлох;

б. Харилцагчийн IP хаягийг шалгах боломж;

в. Блокчэйн шинжилгээ зэрэг шинжилгээ бүтээгдэхүүний ашиглалт³⁹;

г. Үндэсний нууцлалын хууль тогтоомжтой нийцүүлж өгөгдөл цуглуулсны үндсэн дээр харилцагчийн гүйлгээний мэдээлэлтэй нийцүүлэн үйл ажиллагааны мэдээллийг шалгаж баталгаажуулах зорилгоор интернетээр хайлт хийх⁴⁰.

155. Мөн улс орнууд нь ЗТ.10-ын 20-р хэсэгт заасан ХТМНҮА-г анхаарч үзэх ёстой. Үүнд харилцагчийн талаарх нэмэлт мэдээлэл авах, бизнесийн харилцааны шинж чанар болон харилцагчийн санхүүжилтийн эх үүсвэрийн мэдээлэл олж авах, хийхээр төлөвлөж буй болон хийж гүйцэтгэсэн гүйлгээний үндэслэл шалтгааны талаарх мэдээлэл олж авах, харилцаа болон гүйлгээнд нэмэлт хяналт хийх зэрэг ажиллагааг багтаана. Түүнчлэн улс орнууд нь нүүр тулаагүй алсын зайны албан ёсны мөнгөн тэмдэгтээр илэрхийлэгдсэн үйл ажиллагаанд оролцож буй СБ-уудаас шаарддаг арга хэмжээ, эсхүл эрсдэлийг үнэлэх, түүнийг бууруулах хяналтыг хөгжүүлэхэд ВХ-ийн гүйлгээтэй харьцуулагдахуйц арга хэмжээг анхаарч үзэх ёстой.

156. Улс орнууд нь мөн хориглосон үйл ажиллагаанд оролцсон, ийм үйл ажиллагааг эрхэлж буй эсэхийг олж тодорхойлох, дараагийн арга хэмжээг ЭСА-ын дагуу авч хэрэгжүүлэх боломжтой болгохын тулд өндөр эрсдэлтэй харилцагчид, гүйлгээний талаар нэмэлт мэдээлэл цуглуулахыг ВХҮҮ нараас шаардаж болно. Ийм нэмэлт мэдээлэлд оруулж болох нь:

а. Төлбөр, гүйлгээний зориулалт;

б. Тухайн зүйлийн шинж чанар, эцсийн хэрэглээ, эсхүл эцсийн хэрэглэгчийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

в. Хөрөнгийн эзэмшлийн баталгаа, нотолгоо;

³⁹ Өнөөдрийг хүртэл ФАТФ нь бүх нөхцөлд зохицуулалтгүй хэтэвчийг үнэн зөв, нарийн удирдаж, эзэмшдэг этгээдийг тодорхойлох техникийн хувьд найдвартай арга хэрэгслийн талаар олж мэдээгүй байна. Мөн улс орнууд ч энэ талаар анхаарч, ийм арга хэрэгслийг ашигласан шинжилгээний үр дүнг зөвхөн жишээ төдий мэдээлэл гэж үзэх ёстой.

⁴⁰ 2013 оны 6-р сард гаргасан Шинэ төлбөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд зориулсан эрсдэлд суурилсан аргачлалын гарын авлагын 66-р хэсэг, мөн 2015 оны ВХ-ийн гарын авлагын 44-р хэсгийг үз.

г. Гүйлгээнд оролцогч талууд болон тэдгээрийн хоорондох харилцаа холбоо;

д. Хөрөнгө болон мөнгөний эх үүсвэр;

е. Нөгөө талын эцсийн өмчлөл, таних мэдээлэл;

ё. Үндэсний экспортын хяналтын эрх бүхий байгууллагуудын гаргасан экспортын хяналтын юм уу бусад тусгай зөвшөөрлүүд, эцсийн хэрэглэгчийн гэрчилгээний хуулбарууд зэрэг экспортын хяналтын мэдээлэл.

157. Улс орнууд нь мэдээлэл солилцох замаар хориглосон үйл ажиллагааны талаар ВХҮҮ нарт мэдээлж, ийм хориглосон үйл ажиллагааг мөрдөн шалгах, таслан зогсооход дэмжлэг үзүүлж, ингэхдээ тухайн тохиолдол тус бүрт үндэслэж одоо явагдаж байгаа мөрдлөг шалгалтад нөлөөлөхгүй байна. Харилцагч нь санамсаргүйгээр хориглосон үйл ажиллагаанд оролцсон байж болзошгүй гэж ВХҮҮ-ийн зүгээс сэжиглэвэл тухайн харилцагчид мэдэгдэлгүйгээр ХТМНҮА-г явуулж, тухайн эрсдэлийг арилгахыг зорьж, хориглосон үйл ажиллагаанд хамааралтай гүйлгээг олж тодорхойлсон даруйд гүйлгээг зогсоох, царцаах зэрэг арга хэмжээг авч, шаардлагатай бол СГТ-г илгээх ёстой.

ХТМ үйл ажиллагааны хүрээнд цуглуулсан мэдээлэл нь шинэчлэгдсэн эсэхийг нягтлах

158. Түүнчлэн улс орнууд нь ВХ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээний ангилал, ялангуяа өндөр эрсдэлтэй харилцагчидтай холбоотойгоор одоогийн бүртгэл, баримт бичгийг шалгах, мөн таньж мэдэх замаар ХТМ үйл ажиллагааны дагуу цуглуулсан мэдээ, мэдээлэл, баримт бичиг зэргийг шинэчилж байхыг ВХ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлж байгаа ВХҮҮ болон бусад зохицуулалттай этгээдүүдээс шаардах ёстой (ВХҮҮ болон бусад зохицуулалттай этгээдүүдэд зориулсан таньж мэдэх, тэдгээрт хяналт тавих үүргийн талаар Бүлэг 4-өөс дэлгэрүүлж харна уу). Үр дүнтэй хяналтад ийм гүйлгээний болон бүртгэлийн хяналт нь чухал бөгөөд энэ нь шилжүүлгийн дүрэмтэй нийцүүлж харилцагчийн шаардлагатай мэдээллийг дамжуулахад чухал мэдээллийн эх үүсвэр болно (3.16-г үзнэ үү).

Баримт материал хадгалах

159. **Зөвлөмж 11**-т шаардсаны дагуу ВХҮҮ нар нь гүйлгээний болон ХТМ бүх бүртгэл, мэдээллийг дор хаяж таван жилийн хугацаанд хадгалах ёстой бөгөөд ингэхдээ холбогдох эрх бүхий байгууллагуудын шаардсаны дагуу ажил гүйлгээний мэдээллийг гарган өгч байна. Улс орнууд нь ВХҮҮ болон ВХ-ийн үйл ажиллагаанд оролцож буй бусад зохицуулалттай этгээдүүдээс ХТМ хүрээнд олж авсан мэдээлэл, гүйлгээний баримт зэргийг хадгалахыг шаардах ёстой. Эдгээр мэдээлэл, баримт бичгүүдэд холбогдох талуудыг тодорхойлох холбоотой мэдээлэл, нийтийн түлхүүр (эсхүл үүнтэй адилтгахуйц таних тэмдэг), хаяг ба данс (эсхүл үүнтэй төстэй мэдээлэл), гүйлгээний хийсэн огноо ба гүйлгээний шинж чанар, шилжүүлсэн дүн зэргийг оруулна. Тодорхой ВХ-ийн блокчэйн юм уу бусад тархмал бүртгэл дээрх нийтийн мэдээлэл нь бүртгэл, мэдээлэл хөтлөхөд эхлэлийн шат болж өгөх бөгөөд ингэснээр байгууллагууд нь өөрсдийн харилцагчдыг хангалттай хэмжээнд тодорхойлох боломжтой. Гэхдээ баримт материал хадгалахын тулд ВХ-тэй холбоотой блокчэйн юм уу бусад төрлийн тархмал

бүртгэлд зөвхөн найдаж, тулгуурлах нь Зөвлөмж 11-тэй нийцэмжтэй байхад хангалтгүй болно.

160. Тухайлбал, блокчэйн юм уу бусад төрлийн тархмал бүртгэл дээрх мэдээлэл нь хэтэвчний хаягийг хувь хүний нэртэй шууд холбодоггүй ч хэтэвчний хаягийг ашиглаж гүйлгээг шалгах боломжийг холбогдох эрх бүхий байгууллагуудад бий болгож өгнө. Хэтэвчний хаяг нь тархмал бүртгэл дээр тоо, үсгийн онцгой хослол бүхий дижитал гарын үсэг болж үйлчилдэг хэрэглэгчийн код (нийтийн түлхүүр гэх мэт) агуулсан байдаг. Гэхдээ хаягийг бодит этгээдтэй хамаатуулахад нэмэлт мэдээлэл шаардлагатай болно.

Улс төрд нөлөө бүхий этгээд

161. **Зөвлөмж 12**-т шаардсаны дагуу улс орнууд нь ВХҮҮ зэрэг зохицуулалттай этгээдүүдээс харилцагчид, эсхүл эцсийн өмчлөгч нь гадаадын улс төрд нөлөө бүхий этгээд (УТНБЭ)⁴¹ мөн эсэх, эсхүл гадаадын УТНБЭ-тэй хамааралтай этгээд мөн эсэхийг тодорхойлох эрсдэлийн удирдлагын тогтолцоотой байхыг шаардах ёстой. Хэрвээ УТНБЭ, эсхүл УТНБЭ-тэй холбоотой бол эдгээр этгээдтэй бизнесийн харилцаа холбоотой байгаа эсэхийг тодорхойлох (шаардлагатай бол хөрөнгийн эх үүсвэрийг тодорхойлох)-ын тулд (3.10-д тодорхойлсончлон) ердийн ХТМ үйл ажиллагаанаас илүү нэмэлт арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой.

Корреспондент банк болон бусад ижил төстэй харилцаа холбоо

162. **Зөвлөмж 13**-д зааснаар СБ-ууд хил дамнасан корреспондент харилцаанд оролцож байгаа бол ердийн ХТМ арга хэмжээг гүйцэтгэхээс гадна тусгай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг шаардах ёстой. ЗТ.13-д дурдсанаар корреспондент банкны болон бусад ижил төстэй харилцааны хувьд СБ-ууд нь ердийн ХТМ ажиллагааг гүйцэтгэхийн зэрэгцээ Зөвлөмж 13-ын (а)-(е) дэх шалгуурыг ашиглах ёстой. “Бусад ижил төстэй харилцаа” гэдэгт МҮБЗШҮ үзүүлэгчид нь бусад ижил төстэй үйлчилгээ үзүүлэгчдэд зориулж зуучлагч болох үед, эсхүл банкны өөр МҮБЗШҮ харилцагчийн дансаар дамжуулж банкны юм уу үүнтэй ижил төстэй үйлчилгээнд нэвтрэх үеийн МҮБЗШҮ-г хамруулж ойлгоно (2016 оны ФАТФ-ын Корреспондент банкны харилцааны талаарх гарын авлагыг үзнэ үү).

163. Зөвлөмж 13 нь ВХҮҮ-д хамааралтай. Энэхүү гарын авлагад “корреспондент харилцаа” гэж нэг ВХҮҮ-ийн зүгээс нөгөө ВХҮҮ, эсхүл СБ-д ВХ-ийн үйлчилгээ үзүүлэхийг хэлнэ. Ийм корреспондент харилцаа нь банкны салбартай адил давтагдах шинж чанараар тодорхойлогдоно⁴². Мөн ийм харилцаанд өөрийн платформыг өөр ВХҮҮ-ээр хаяглаж буй ВХҮҮ, мөн нэстед үйлчилгээ үзүүлж буй ВХҮҮ-г хамруулж

⁴¹ “Гадаадын УТНБЭ” гэж гадаад улсын төрийн томоохон албан тушаалд ажилладаг, эсхүл ажиллаж байсан этгээдүүдийг хэлнэ. Тухайлбал, төр юмуу засгийн газрын тэргүүн, нөлөө бүхий улс төрч, засгийн газрын, шүүхийн болон зэвсэгт хүчний өндөр албан тушаалтан, төрийн өмчит компаниудын дээд удирдлага, голлох улс төрийн намын албан хаагчид зэргийг хамруулж ойлгоно (ФАТФ-ын Нэр томъёоны тайлбар бичиг).

⁴² Харилцагчийн бус харилцааны хувьд нэг удаагийн гүйлгээ, эсхүл цэвэр мессежний харилцаа нь корреспондент харилцаа биш (Корреспондент банкны талаарх ФАТФ-ын гарын авлагын 13-р хэсгийг үзнэ үү).

болно (үүнд хөрвөх чадвар болон арилжааны зориулалтаар ашиглуулахаар жижиг ВХҮҮ-д данс өгөх үйлчилгээ орно).

164. Корреспондент харилцаа нь ижил түвшний МУТС эрсдэл агуулаагүй өргөн цар хүрээний үйлчилгээтэй холбоотой байж болно. ВХҮҮ-ийн салбар дахь харилцаа холбоо нь хил дамнасан корреспондент банкны харилцаатай ижил төстэй шинж чанартай (эсхүл цаашид ийм ижил төстэй шинж чанартай болж болох) тул (нэн ялангуяа ВХҮҮ нь өөр ВХҮҮ-д данс эзэмшиж буй нэстед харилцааны хувьд) улс орнууд нь 3.13-д заасан урьдчилан сэргийлэх арга хэмжээг ВХҮҮ (болон ВХ-ийн салбарт үйл ажиллагаа явуулж буй бусад зохицуулалттай этгээдүүд)-д зориулж хэрэгжүүлэх ёстой. 3.13-д хил дамнасан корреспондент харилцааны МУТС эрсдэлийг бууруулах арга хэмжээг дурдсан байдаг. Өөр ВХҮҮ, эсхүл санхүүгийн байгууллагад үйлчилгээ үзүүлж буй ВХҮҮ нараас хил дамнасан корреспондент харилцааны хүрээнд дараах зүйлсийг шаардах ёстой. Үүнд:

- a. Бусад ВХҮҮ, эсхүл СБ-ын бизнес, МУТС эрсдэлийн хяналтын тогтолцооны шинж чанарыг бүрэн ойлгохын тулд хил дамнасан корреспондент харилцаа тогтоохыг зорьж буй ВХҮҮ, эсхүл СБ-ын талаарх хангалттай мэдээллийг олж цуглуулах. Бусад ВХҮҮ, эсхүл СБ нь хил дамнасан корреспондент харилцаагаар дамжуулж ямар төрлийн харилцагчдад үйлчилгээ үзүүлэхийг зорьж байгаа талаарх асуудал ч энд хамааралтай.
- b. Бусад ВХҮҮ, СБ-ын нэр хүнд, хяналт шалгалтад хамрагдсан байдал, МУТС-ийг мөрдөн шалгах ажиллагаа, зохицуулалтын арга хэмжээ авагдсан эсэх талаарх мэдээлэл цуглуулах, олон нийтэд нээлттэй мэдээллийн эх сурвалжийг ашиглах;
- c. Бусад ВХҮҮ, эсхүл СБ-ын МУТСТ хяналтыг үнэлэх;
- d. Хил дамнасан шинэ корреспондент харилцааг тогтоохын өмнө дээд шатны удирдлагаас зөвшөөрөл авах;
- e. Бусад ВХҮҮ, СБ-ын харилцагчдын өөрсдөө шууд ашиглах боломжтой данс, хадгаламжийн хэтэвчтэй холбоотойгоор эдгээр харилцагчдад ХТМ үйл ажиллагаа хийгдсэн эсэх, шаардсан даруйд юм уу нууцлал, мэдээлэл хамгаалах хууль тогтоомжид зөвшөөрсөн хэм хэмжээнд ХТМ үйл ажиллагааны мэдээллийг гаргаж өгдөг эсэх.

165. ВХҮҮ нь дээр дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлснээр хил дамнасан корреспондент харилцааны хувьд МУТС эрсдэлийг ойлгож, эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлэх боломжтой болно. МУТСТ дүрэм журам сул, эсхүл ийм дүрэм байхгүй, ВХҮҮ-ийн хяналт шалгалт сул эсхүл байхгүй улс орнуудын хувьд хил дамнасан корреспондент харилцаа нь МУТС өндөр эрсдэл учруулж болзошгүй. Харилцагчдын мэдээлэл, харилцагчдын гүйлгээний шинж чанарын мэдээллийг нууцалсан, эсхүл гуравдагч этгээдээр төлбөр гүйцэтгүүлсэн, гүйлгээний урсгалын хэмжээ ихтэй үйлчилгээ үзүүлж буй корреспондент харилцааны хувьд мөн адил МУТС өндөр эрсдэлтэй байж болно. Ийм нөхцөлд хариуцагч ВХҮҮ-ийн зүгээс дээр дурдсан харилцагчдын шинж чанарыг сайтар ойлгож, гүйлгээг нь хянаж байх нь эрсдэл арилгах тохиромжтой жишээ болно.

166. Зөвлөмж 13 нь дотоодын ижил төстэй корреспондент харилцаанд хамаарахгүй ч ВХҮҮ нь дотоодын ВХҮҮ нарын өмнөөс ВХ-ийн үйл ажиллагаа явуулахдаа 3.10-д заасны дагуу эрсдэлд суурилсан ХТМ ажиллагааг гүйцэтгэх ёстой. Таньж мэдэх зэрэг бизнесийн харилцааны шинж чанар, зорилгыг эрсдэл суурилсан байдлаар ойлгох гэдэг нь ижил төстэй үйлчилгээ үзүүлдэг этгээдүүдийн МУТСТ хяналтын чанар болон тэдгээртэй байгуулсан харилцааны хүрээнд хэрэглэгчдэд үзүүлж буй үйлчилгээний чанарыг харгалзан үзэх ажиллагааг хамруулна. Дотоодын корреспондент харилцааны хувьд олон улсын корреспондент харилцаанаас ялгарах үндсэн шинж чанар нь нэг ижил улсад байгаа бусад зохицуулалттай ВХҮҮ нь нэг ижил түвшний хяналт шалгалт, зохицуулалттай байдаг явдал юм. ВХ болон ВХҮҮ нарын шинж чанарыг харгалзан үзэж улс орнууд нь ВХҮҮ нар нь бие биенээ дотоодын, эсхүл олон улсын эсэхийг хэрхэн тодорхойлох талаар зөвлөгөө өгч болно. Учир нь ВХҮҮ-ийн хувьд банктай адил корреспондент харилцаанд оролцогч талыг олон улсын, эсхүл дотоодын этгээд эсэхийг олж тодорхойлоход амаргүй байдаг.

167. Тодруулбал, 3.16-д нийцүүлэх зорилгоор ВХҮҮ-ийг таньж мэдэх нь хил дамнасан корреспондент харилцаанд хамаарах үүрэг хариуцлагаас ангид тусдаа юм. Банкны салбараас ялгаатай талыг дурдвал корреспондент, эсхүл бусад харилцаа холбоо байхгүй ч ВХҮҮ нарын хооронд өөр бусад этгээдийн өмнөөс ВХ-ийн шилжүүлэг хийгдэх боломжтой. Ийм нөхцөлд ВХ-ийн шилжүүлэгт оролцож буй ВХҮҮ нь бусад ижил төстэй үйлчилгээ үзүүлэгчдийг шилжүүлгийн дүрэмтэй нийцүүлэн ажиллаж байгаа эсэх, МУТС эрсдэлийг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа эсэх тал дээр таньж мэдэж болно. Гэхдээ ВХ-ийн шилжүүлэгт оролцож буй хоёр ВХҮҮ-ийн хоорондох корреспондент харилцаа нь таньж мэдэх үйл ажиллагааны шаардлагыг хэсэгчлэн, эсхүл бүрэн хангаж болно. Шилжүүлгийн дүрмийн хүрээнд ВХҮҮ-ийн таньж мэдэх ажиллагааг хэрхэн хийх талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 3.16-гаас авах боломжтой.

Мөнгө болон үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ

168. Зөвлөмж 14-т зааснаар улс орнууд МҮБЗШҮ үзүүлж байгаа хувь хүн болон хуулийн этгээдийг тусгай зөвшөөрөл эсхүл бүртгэлд хамруулж МУТСТ холбогдох арга хэмжээг дагаж мөрдөж байгаа эсэхийг баталгаажуулах шаардлагатай. Виртуал хөрөнгийн 2015 оны гарын авлагад дурдсанчлан тухайн улсад үйл ажиллагаа явуулж байгаа МҮБЗШҮ-ний бүртгэл, тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавих, МУТСТ-тэй холбоотой бусад арга хэмжээг авах шаардлагатай гэсэн байдаг. 3.15 нь ВХҮҮ-тэй холбоотой ч МҮБЗШҮ эрхлэгчдийн үйл ажиллагаанд мөн адил хамаарна (жишээ нь, тухайн улс дахь виртуал болон албан ёсны мөнгөн тэмдэгтүүдийн солилцоог хийх дотоодын аж ахуй нэгжүүд).

169. Зөвлөмж 14 нь МҮБЗШҮ үзүүлэгчдэд хамаардаг. Мөн энэ нь тухайн байгууллагатай гэрээ байгуулан эсхүл түүний удирдлаган дор ВХҮҮ-ийн нэрийн өмнөөс МҮБЗШҮ үзүүлж байгаа хувь хүн, хуулийн этгээдэд ч хамаарна. МҮБЗШҮ үзүүлэгч нь үндсэн ВХҮҮ-г үзүүлэхгүй ч гуравдагч этгээдээр оролцдог. Тухай МҮБЗШҮ эрхлэгчийн бизнесийн үйл ажиллагаанаас хамааран ВХ-ийн салбарын хуулийн этгээдийн нэрийн өмнөөс байнга үйл ажиллагаа явуулж болдог байна. Хэрэв ВХҮҮ нь МҮБЗШҮ үзүүлэгчдийг ашигладаг бол МҮБЗШҮ эрхлэгчид нь мөн адил МУТСТ шаардлагуудыг хэрэгжүүлэн, түүнийг хянах шаардлагатай. Тус агентууд нь мөн эрх бүхий

байгууллагаас тусгай зөвшөөрөл авч, бүртгүүлэх ёстой бөгөөд үндсэн ВХҮҮ болон түүний төлөөлөгчийн үйл ажиллагаа явуулдаг улс орнуудын эрх бүхий байгууллагуудад хандах боломжтой.

Шинэ технологи

170. Зөвлөмж 15. ФАТФ-аас 2018 оны 10-р сард ВХ-ийн үйлчилгээний утга агуулгыг тодорхой болгох үүднээс шинэ технологийн хүрээнд улс орнууд болон зохицуулттай этгээдүүдийн ЭСА-ууд, холбогдох үүргийг тусгаж 3.15-ыг шинэчлэн баталсан. 3.15-д улс орнууд шинэ бүтээгдэхүүн, бизнесийн хэрэглээнээс үүдэлтэй (тухайлбал, түгээлтийн шинэ механизм) болон одоогийн байгаа бүтээгдэхүүн, шинээр хөгжүүлж буй технологитой холбоотойгоор үүсч болох МУТС эрсдэлийг тодорхойлж үнэлнэ гэж заадаг. Түүнчлэн улс орнууд өөрийн харьяаллын дагуу тусгай зөвшөөрөл авсан, үйл ажиллагаа явуулж буй СБ-ын шинэ бүтээгдэхүүн, бизнесийн хэрэглээнээс үүдэлтэй шинэ эсхүл хөгжиж буй технологи ашиглахаас өмнө МУТС эрсдэлийг үнэлэх, бууруулах зохих арга хэмжээ авахыг шаарддаг (Хавсралт А-г үзнэ үү).
171. Зөвлөмж 15-ын үзэл баримтлалын дагуу 2018 оны 10-р сарын шинэчилсэн найруулгад улс орнууд ВХ-өөс үүсч болох эрсдэлийг удирдаж, бууруулах, ВХҮҮ-ийг МУТСТ зорилгоор зохицуулж, бүртгэх эсхүл тусгай зөвшөөрөл олгох, ФАТФ-ын зөвлөмжид дурдсан холбогдох арга хэмжээг дагаж мөрдөх, хяналт тавих үр дүнтэй системд хамруулах хэрэгтэй. ФАТФ-аас 2019 оны 6-р сард 3.15-д оруулсан нэмэлт тайлбараар ВХ-тэй холбоотой шаардлагууд, ВХ-ийн үйлчилгээнд ямар үйл ажиллагааг хамруулах талаар оруулсан. Мөн түүний МУТС эрсдэлийг үнэлэх, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох, хяналт шалгалт хийх, ХТМ, баримт материал хадгалах, сэжигтэй гүйлгээг мэдээлэх, хариуцлагын арга хэмжээ, олон улсын хамтын ажиллагааны талаар нэмж тусгасан (Хавсралт А-г үзнэ үү).
172. ВХ болон ВХҮҮ-ийн үйл ажиллагааны хүрээнд улс орнууд өөрийн харьяаллын дагуу тусгай зөвшөөрөл авсан эсхүл үйл ажиллагаа явуулж байгаа ВХҮҮ нь нэрээ нууцлах технологи, механизмыг ашиглахтай холбоотой үйл ажиллагаанд оролцох эрсдэлийг удирдаж, бууруулах боломжтой эсэхийг хянах ёстой. Нэр нууцлах технологи нь ВХ-ийн холигч (mixing and tumbling), нууцлалын хэтэвч, хүлээн авагч, эзэмшигч этгээд, эцсийн өмчлөгчийг хэн болохыг нуун дарагдуулдаг байна. Хэрэв ВХҮҮ нь ийм үйл ажиллагаатай холбоотой учирч болох эрсдэлийг удирдаж, бууруулж чадахгүй бол ВХҮҮ-ийн ийм үйл ажиллагааг явуулахыг зөвшөөрөх ёсгүй.
175. **Зөвлөмж 16 болон Зөвлөмж 16-ын тайлбарыг** террорист этгээдүүд болон бусад гэмт хэрэгтнүүд хөрөнгө, мөнгөө цахим шилжүүлэг ашиглан саадгүй шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх, буруугаар ашиглах байдлыг илрүүлэх зорилгоор боловсруулсан. ФАТФ-аас үүнийг “цахим шилжүүлэг” гэж нэрлэсэн бөгөөд ФАТФ-ын 3.16-ын дагуу цахим шилжүүлэгтэй холбоотой болон холбогдох бусад шаардлагууд нь энэ төрлийн бүх үйлчилгээ үзүүлэгчдэд хамаарна. Тухайлбал, үүнд цахим шилжүүлэгтэй төстэй үйл явц бүхий ВХ шилжүүлэх үйл ажиллагаанд оролцдог эсхүл энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг ВХҮҮ-үүдийг хамруулдаг байна.

Зөвлөмж 16-ын тойм ба ВХ, ВХҮҮ-ийн хэрэглээ

176. 3.16-д "цахим шилжүүлэг"-ийг шилжүүлэгч эсхүл хүлээн авагч нь ижил хүн байхаас үл хамааран шилжүүлэгчийн нэрийн өмнөөс СБ-аар дамжуулан электрон хэлбэрээр хүлээн авагч СБ руу буюу хүлээн авагч руу хийгдэж буй гүйлгээ гэж тодорхойлсон байдаг.
177. 3.16-д дотоодын болон хил дамнасан цахим шилжүүлэгт хоёуланд нь хамаарах цахим шилжүүлэг, холбогдох мессежийн шаардлагуудыг дурдсан. Товчхондоо, улс орнууд нь СБ-д цахим шилжүүлэг хийж байгаа шилжүүлэгч болон хүлээн авагчийн талаар шаардлагатай бөгөөд үнэн зөв мэдээллийг цахим шилжүүлэг болон холбогдох мессежид агуулж байгаад хяналт тавина. СБ-ууд мөн шаардлагатай *цахим шилжүүлэг хийж байгаа шилжүүлэгч болон хүлээн авагчийн талаар мэдээлэл* дутуу шилжүүлгийг илрүүлэхийн тулд цахим шилжүүлгүүдэд хяналт тавьж, гүйлгээг НҮАБЗ-өөс гаргасан холбогдох тогтоолд нийцүүлэн шалгах ёстой. (3.6, 7-г үзнэ үү)
178. ЗТ.15-т заасны дагуу улс, орнууд нь 3.16-ын шаардлагыг ВХ-ийн шилжүүлэг болон ВХҮҮ-дэд тавьдаг. Улс орнууд уламжлалт цахим шилжүүлэг эсхүл ВХ-ийн шилжүүлгийн үнэ цэнэ нь *албан ёсны мөнгөн тэмдэгт* эсхүл ВХ-өөр илэрхийлэгдсэн эсэхээс үл хамааран 3.16-г хэрэгжүүлэх шаардлагатай. Гэсэн хэдий ч ВХ-ийн технологийн өвөрмөц шинж чанарыг хүлээн зөвшөөрч, 3.16-г 3.15-ын тайлбарын 7(b)-д заасан ВХ-д нэмэлт өөрчлөлт оруулсан хэлбэрээр мөрддөг. ВХ-ийн контекстэд ФАТФ-ын цахим гүйлгээний шаардлагын хэрэглээг *шилжүүлгийн дүрэм (travel rule)* гэж нэрлэдэг.
179. 3.16-ын шаардлагуудыг ВХҮҮ-ийн гүйлгээ албан ёсны мөнгөн тэмдэгт эсхүл ВХ-өөр хийгдсэн эсэхээс үл хамааран дараах тохиолдолд мөрдөнө. Үүнд: (а) уламжлалт цахим шилжүүлэг, (б) ВХҮҮ болон бусад зохицуулалттай этгээд хооронд хийгдсэн ВХ-ийн шилжүүлэг (хоёр ВХҮҮ хооронд эсхүл банк, бусад СБ хооронд гэх мэт ВХҮҮ болон өөр зохицуулалттай этгээд хоорондын шилжүүлэг), эсхүл (в) ВХҮҮ болон зохицуулалтгүй этгээд хооронд хийгдсэн ВХ-ийн шилжүүлэг (зохицуулалтгүй хэтэвч гэх мэт). 3.16-ын бүрэн шаардлагыг доор дурдсанчлан (а) ба (б)-д хамаарах боловч (в)-д хамаарахгүй. Улс орнууд бүх ВХ-ийн шилжүүлгийг ЗТ.1-ийн дагуу ВХ-ийн үйл ажиллагаа болон ВХҮҮ-ийн үйл ажиллагааны хил дамнасан шинж чанарт тулгуурлан дотоодын цахим шилжүүлэг гэхээсээ илүү хил дамнасан цахим шилжүүлэг гэж үзэх нь зүйтэй. Зохицуулалтгүй хэтэвчийн тухайд ((в)-д дурдсанчлан), 3.16-ын шаардлагыг доорх байдлаар мөрдөнө.
180. ВХ-ийн шилжүүлэгтэй холбоотой гүйлгээний хураамж⁴³ нь шилжүүлгийн дүрэмд хамаардаггүй бөгөөд хүлээн авагч нь өөрөө ВХ шилжүүлэгч эсхүл хүлээн авагч биш учраас ВХҮҮ-д гүйлгээний хураамжийн хүлээн авагчийг тодорхойлох шаардлагагүй байдаг. Техникийн шалтгааны улмаас ВХҮҮ нь шилжүүлэх ёстой ВХ-ийн бодит хэмжээнээс илүү их хэмжээний ВХ-ийг илгээж, зөрүүг шилжүүлэгч ВХҮҮ-д автоматаар буцаан олгох хувилбарууд мөн байж болдог. Ийм тохиолдолд буцаан олголт нь шилжүүлэгч ВХҮҮ-ийн шилжүүлгийн нэг хэсгийг бүрдүүлдэг тул буцаан олголттой холбоотойгоор шилжүүлгийн дүрэм нь хүлээн авагч ВХҮҮ-д хамаардаггүй.

⁴³ "Гүйлгээний шимтгэл" гэдэг нь гүйлгээг блокт оруулсан майнерын цуглуулж болох ВХ-ийн хэмжээг хэлнэ. Үүнийг урамшуулал гэж нэрлэх бөгөөд ВХ-ийн төрлөөс хамаарч янз бүрээр нэрлэж болох хэдий ч ижил шалтгаанаар эдгээрийг шилжүүлгийн дүрэмд хамруулдаггүй.

Цахим шилжүүлэг хийж байгаа шилжүүлэгч болон хүлээн авагчийн шаардлагатай, үнэн зөв мэдээллийг олж авах, хадгалах, илгээхэд тавигдах шаардлага

181. Улс, орнууд ВХ шилжүүлэгч байгууллага нь цахим шилжүүлэг хийж буй шилжүүлэгч болон хүлээн авагчийн талаар шаардлагатай, үнэн зөв мэдээллийг олж авч, хадгалан, хүлээн авагч байгууллагад (ВХҮҮ эсхүл бусад СБ-д гэх мэт) илгээж байгаад хяналт тавих нь зүйтэй. Цаашлаад, улс орнууд хүлээн авагч байгууллага нь (ВХҮҮ эсхүл бусад СБ-д гэх мэт) ЗТ.16-д заасан цахим шилжүүлэг хийж буй шилжүүлэгчийн (гэхдээ үнэн зөв байх албагүй⁴⁴) болон хүлээн авагчийн шаардлагатай, үнэн зөв мэдээллийг олж авч, хадгалж байгаа эсэхэд мөн хяналт тавих шаардлагатай (Шигтгээ 4-ийг үзнэ үү).

Шигтгээ 4. Тодорхой үг хэллэгийн тайлбар

ЗТ.15-ын 7(б)-д заасан цахим шилжүүлгийн дүрэм

“3.16”: “Улс орнууд шилжүүлэгч ВХҮҮ нь ВХ-ийн шилжүүлгийн үед цахим шилжүүлэг хийж буй шилжүүлэгч болон хүлээн авагчийн талаар шаардлагатай, үнэн зөв мэдээлэл олж авч, хадгалж байгаа эсэхэд хяналт тавих шаардлагатай”.

Тайлбар: “3.16-ын, 6-р хэсэгт заасан эсхүл ВХ-д хамаарах бусад ижил төрлийн мэдээлэл.”

ЗТ.16-д ашигласан нэр томъёоны тайлбар

Үнэн зөв: Үнэн зөв байдлыг нь шалгаж, баталгаажуулсан мэдээллийг хэлнэ.

ЗТ.16

6. Шаардлага хангаж буй цахим шилжүүлэг нь дараах мэдээллүүдийг тогтмол агуулж байх шаардлагатай. Үүнд:

(а) **шилжүүлэгчийн нэр;**

(б) шилжүүлэг хийхэд ашиглаж буй шилжүүлэгчийн **дансны дугаар;**

(в) **шилжүүлэгчийн хаяг**, эсхүл регистрийн дугаар, харилцагчийн дугаар/төрсөн огноо;

(г) **хүлээн авагчийн нэр;**

(д) шилжүүлэг хүлээн авагчийн **дансны дугаар.**

182. Цахим шилжүүлэг хийж буй шилжүүлэгчийн талаар шаардлагатай мэдээлэл гэдэгт дараахыг авч үзнэ. Үүнд:

а. шилжүүлэгчийн нэр (илгээж буй хүний үнэн зөв (баталгаажуулсан) бүтэн нэр);

⁴⁴ Зураг 1-ийн дагуу, хүлээн авагч ВХҮҮ нь шилжүүлэгч ВХҮҮ-ээс илгээсэн цахим шилжүүлэг хийж буй шилжүүлэгчийн мэдээллийг заавал үнэн, зөв байхыг шаарддаггүй бөгөөд тухайн мэдээллийг шилжүүлэгч ВХҮҮ-ээс баталгаажуулсан гэж үзэж болдог.

б. шилжүүлэг хийхэд ашиглагдаж буй шилжүүлэгчийн дансны дугаар. ВХ-ийн тухайд энэ нь ВХ-ийн “хэтэвчний хаяг”.

в. шилжүүлэгчийн (газарзүйн) хаяг эсхүл регистрийн дугаар, харилцагчийн дугаар, эсхүл төрсөн огноо. Шилжүүлэгчийн газарзүйн хаяг гэдэг нь шилжүүлэгч ВХҮҮ-ийн ХТМ үйл ажиллагааны хүрээнд үнэн зөв байдлыг баталгаажуулсан хаягийг хэлнэ (ХТМ талаар 148-160-р хэсгийг үзнэ үү);

г. хүлээн авагчийн нэр (шилжүүлэгч талаас ВХ-ийн шилжүүлгийг хүлээн авагч гэж тодорхойлсон хувь хүний нэр). Энэ мэдээллийн үнэн зөв байдлыг шилжүүлэгч байгууллагаас баталгаажуулах шаардлагагүй хэдий ч СГТ-гийн хяналт болон, хоригийн жагсаалттай тулгах зорилгоор нягтлах нь зүйтэй;

д. шилжүүлэг хүлээн авахад ашиглагдаж буй хүлээн авагчийн дансны дугаар. ВХ-ийн тухайд энэ нь ВХ-ийн “хэтэвчний хаяг”.

183. Цахим шилжүүлэг хүлээн авч буй байгууллагын шилжүүлэгч байгууллагаас олж авах шаардлагатай мэдээлэл гэдэгт дараахыг авч үзнэ. Үүнд:

а. шилжүүлэгчийн нэр (илгээж буй хувь хүний нэр). Хүлээн авагч байгууллага нь шилжүүлэгчийн нэрийг заавал баталгаажуулах шаардлагагүй хэдий ч СГТ-гийн хяналт болон, хоригийн жагсаалттай тулгах зорилгоор нягтлах нь зүйтэй;

б. шилжүүлэг хийхэд ашиглагдаж буй шилжүүлэгчийн дансны дугаар. ВХ-ийн тухайд энэ нь ВХ-ийн “хэтэвчний хаяг”;

в. шилжүүлэгчийн (газарзүйн) хаяг эсхүл регистрийн дугаар/харилцагчийн дугаар, эсхүл төрсөн огноо;

г. хүлээн авагчийн нэр (шилжүүлэгч талаас ВХ-ийн шилжүүлгийг хүлээн авагч гэж тодорхойлсон хувь хүний нэр). Хэрэв харилцагчийн нэрийг өмнө баталгаажуулж байгаагүй бол хүлээн авагч байгууллага нь хүлээн авагчийн нэрний үнэн зөв байдлыг заавал нягтлах шаардлагатай. Мөн хүлээн авагч байгууллага нь тэдний шилжүүлэгч байгууллагаас хүлээн авсан хүлээн авагчийн нэр болон дансны дугаар нь өөрсдийн баталгаажсан харилцагчийн мэдээлэлтэй таарч байгаа эсэхийг баталгаажуулах боломжтой;

д. шилжүүлэг хүлээн авахад ашиглагдаж буй хүлээн авагчийн дансны дугаар. ВХ-ийн тухайд энэ нь ВХ-ийн “хэтэвчний хаяг”.

Хүснэгт 1. Шилжүүлгийн дүрэм дэх шилжүүлэгч болон хүлээн авагч ВХҮҮ-дэд тавигдах мэдээллийн шаарлага

<i>Мэдээллийн төрөл болон шаардлагатай арга хэмжээ</i>	<i>Шилжүүлэгч ВХҮҮ</i>	<i>Хүлээн авагч ВХҮҮ</i>
--	------------------------	--------------------------

<p>Шилжүүлэгчийн мэдээлэл</p>	<p><i>Шаардлагатай: Шаардлагатай мэдээллийг заавал хүлээн авагч байгууллага руу илгээх.</i></p> <p><i>Үнэн зөв: <u>шилжүүлэгч ВХҮҮ нь мэдээллийн үнэн зөв байдлыг ХТМ үйл ажиллагааны хүрээнд баталгаажуулах.</u></i></p>	<p><i>Шаардлагатай: хүлээн авагч ВХҮҮ нь <u>шилжүүлэгч ВХҮҮ-ээс шаардлагатай мэдээллийг олж авах.</u></i></p> <p><i>Мэдээллийн үнэн зөв байдлыг нягтлах шаардлагагүй. Хүлээн авагч ВХҮҮ нь мэдээллийн үнэн зөв эсэхийг шилжүүлэгч ВХҮҮ баталгаажуулсан гэж үзэж болно.</i></p>
<p>Хүлээн авагчийн мэдээлэл</p>	<p><i>Шаардлагатай: <u>Шаардлагатай мэдээллийг заавал хүлээн авагч байгууллага руу илгээх.</u></i></p> <p><i>Мэдээллийн үнэн зөв байдлыг нягтлах шаардлагагүй хэдий ч <u>шилжүүлэгч ВХҮҮ нь заавал сэжигтэй зүйл илрүүгүй эсэхийг нягтлах шаардлагатай.</u></i></p>	<p><i>Шаардлагатай: хүлээн авагч ВХҮҮ нь <u>шилжүүлэгч ВХҮҮ-ээс шаардлагатай мэдээллийг олж авах.</u></i></p> <p><i>Үнэн зөв: хүлээн авагч ВХҮҮ нь шаардлагатай мэдээллийг баталгаажуулж, <u>хүлээн авч буй мэдээлэл нь хэвээрээ эсэхийг нягтлах шаардлагатай.</u></i></p>
<p>Авах шаардлагатай арга хэмжээ</p>	<p><i>Цахим шилжүүлэг хийж буй шилжүүлэгчээс шаардлагатай мэдээллийг олж авч, бүртгэл хөтлөх.</i></p> <p><i>Хүлээн авагчийн нэр хоригийн жагсаалтад байгаа эсэхийг шалгах.</i></p> <p><i>Гүйлгээнүүдийг хянаж, сэжигтэй тохиолдолд мэдээлэх.</i></p>	<p><i>Шилжүүлэгч ВХҮҮ-ээс шаардлагатай мэдээллийг олж авч, бүртгэл хөтлөх.</i></p> <p><i>Шилжүүлэгчийн нэр хоригийн жагсаалтад байгаа эсэхийг шалгах.</i></p> <p><i>Гүйлгээнүүдийг хянаж, сэжигтэй тохиолдолд мэдээлэх.</i></p>

184. ВХҮҮ нь шаардлагатай мэдээллийг хүлээн авагч байгууллагад илгээх шаардлагатай бөгөөд энэ нь улс, орнууд ВХҮҮ нь шилжүүлэгч эсхүл хүлээн авагчийн талаар шаардлагатай мэдээллийг түргэн шуурхай, найдвартай дамжуулж байгаа эсэхэд хяналт тавихад чухал юм. Энэ нь ВХ-ийн шилжүүлгийн түргэн шуурхай/хил дамнасан шинж чанартай холбоотой төдийгүй 3.16-ын шаардлагад (3.16-ын дагуу шилжүүлэгч болон хүлээн авагчийн мэдээлэлд тавигдах албан ёсны мөнгөн тэмдэгттэй холбоотой уламжлалт шаардлага) мөн хамаардаг байна. Хүлээн авагч байгууллага байхгүй ч гэсэн ВХҮҮ нь шаардлагатай мэдээллийг (доор дурдсан) заавал цуглуулна.

185. “Түргэн шуурхай” – ЗТ.15-ын 7(б)-ийн хүрээнд төдийгүй ВХ-ийн хил дамнасан шинж чанар, дэлхийн хэмжээний хүртээмжтэй байдал болон гүйлгээний хурд зэргийн дагуу энэ нь үйлчилгээ үзүүлэгчид шаардлагатай мэдээллийг шилжүүлгийн хамт илгээх нь зүйтэй. Дэлгэрэнгүй мэдээллийг Бүлэг 4-ийн 3.16-аас авна уу.

186. “Найдвартай” гэх ойлголт нь мөн л ЗТ.15-ын 7(б)-ийн хүрээнд үйлчилгээ үзүүлэгчид шаардлагатай мэдээллийг аюулгүйгээр дамжуулах, хадгалах ёстойг илэрхийлэх зорилготой юм. Энэ нь баримт материал хадгалах үйл явцыг хөнгөвчлөх, (бусад шаардлагуудын хамт) шаардлагатай мэдээллийн бүрэн бүтэн байдал,

хүртээмжийг хамгаалах, ВХҮҮ эсхүл бусад зохицуулалттай этгээдээс хүлээн авсан мэдээллийг ашиглах боломжийг хөнгөвчлөх, мэдээллийг зөвшөөрөлгүй задруулахаас хамгаалах зорилготой юм. ВХҮҮ нь нөгөө талын ВХҮҮ-ийг шилжүүлгийн дүрмийн мэдээллийг хангалттай хамгаалж чадахгүй байгааг үнэлэх⁴⁵ боломжтой тохиолдолд өөр арга барил тохиромжтой байж болох хэдий ч үүнийг ашиглах нь 3.16 эсхүл 3.9-ийн шаардлагад харшлах зорилгогүй юм.

187. ФАТФ-ын стандартын дагуу мэдээлэл илгээх явц нь түргэн шуурхай, найдвартай л бол шилжүүлэгч болон хүлээн авагчийн мэдээллийг багц хэлбэрээр илгээхийг зөвшөөрдөг. Харин шаардлагатай мэдээллийг шилжүүлэг хийгдсэний дараа илгээхийг зөвшөөрдөггүй (өөрөөр хэлбэл, ВХ-ийн шилжүүлэг хийхээс өмнө эсхүл хийгдэх үед бол зөвшөөрнө). Улс орнууд ВХҮҮ эсхүл бусад зохицуулалттай этгээдүүд шаардлагатай мэдээллийг багцалсан хэдий ч ВХ-ийн шилжүүлгийн хамт нэгэн зэрэг илгээх ёстой эсэхийг тодруулах ёстой.

188. Мэдээллийг ВХ-ийн шилжүүлэгтэй шууд хавсаргах шаардлагагүй. Мэдээллийг ЗТ.15-д заасны дагуу шууд болон шууд бус хэлбэрээр "түргэн шуурхай, найдвартай" илгээж, зохих эрх бүхий байгууллагын хүсэлтийн дагуу гаргаж өгөхөд бэлэн байлгах шаардлагатай. ФАТФ-ын технологиос хамаарахгүй байх зарчмын дагуу шаардлагатай мэдээллийг заавал блокчэйн эсхүл өөр DLT платформ дээр шилжүүлэхийн нэг хэсэг болгох (эсхүл нэгтгэх) шаардлагагүй. Хүлээн авагч ВХҮҮ-д мэдээлэл илгээх нь блокчэйн эсхүл бусад DLT ВХ-ийн шилжүүлгээс огт өөр үйл явц байж болно. Энэхүү шийдэл нь шилжүүлэгч болон хүлээн авагч байгууллагуудад 3.16-ын шаардлагыг биелүүлэх боломжийг олгосон (мэдээж ФАТФ-ын зөвлөмжийн дагуу МУТСТ бусад үүргээ биелүүлэхэд нь саад болохгүй) тохиолдолд аливаа технологи, програм хангамжийн шийдлийг хүлээн зөвшөөрдөг. Улс орнууд 3.16-ын дагаж мөрдөх боломжит технологийн хэрэглээ эсхүл шийдлүүдийн талаар хувийн хэвшлийнхэнтэй хамтран ажиллах нь зүйтэй (3.16-ын хүрээнд үйлчилгээ үзүүлэгч болон бусад МҮЭ-дийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг Бүлэг 4-өөс үзнэ үү). Зохицуулагч/хянан шалгах чиг үүрэг бүхий байгууллага хоорондын, хувийн хэвшлийн байгууллагууд хоорондын, мөн зохицуулагч/хянан шалгах чиг үүрэг бүхий байгууллагууд болон хувийн хэвшлийн байгууллагууд хоорондын хамтын ажиллагаа, зохицуулалт нь ВХҮҮ-ийн баталсан шилжүүлгийн дүрмийн шийдлүүдийн харилцан уялдаатай байдлыг хангахад маш чухал гэдгийг анхаарах нь чухал.

189. Хуулийн этгээдийн хувьд, Хуулийн этгээдийг тодорхойлогч (ХЭТ)-ийг төлбөрийн мэдээлэлд нэмэлт мэдээлэл болгон ашиглаж болно⁴⁶. ХЭТ-ийг нэмэлтээр ашиглахыг зөвшөөрөхийн тулд улс орнууд холбогдох оролцогч талуудыг (жишээ нь, СБ-ын хувьд

⁴⁵ ВХҮҮ нь эрсдэлд суурилсан шийдвэрийн дагуу хэнтэй гүйлгээ хийхээ сонгох шаардлагатай (199 дэх хэсэг). ВХҮҮ биш зохицуулалттай этгээдтэй шилжүүлэг хийж буй ВХҮҮ нь харилцагчаасаа шилжүүлэгч болон хүлээн авагчийн талаар шаардлагатай мэдээллийг авах нь зүйтэй. (хүлээн авагч ВХҮҮ руу мэдээлэл илгээгээгүй байсан ч гэсэн) (204 дэх хэсэг).

⁴⁶ Төлбөрийн болон зах зээлийн дэд бүтцийн хороо (СРМІ) – Корреспондент банк – 2016, 7-р сар. Базелын хороо (BCBS) – МУТС-тэй холбоотой эрсдлийг оновчтой удирдах гарын авлага 2020, 7-р сар, “СРМІ-аас санал болгосны дагуу, одоогийн холбогдох төлбөрийн мессежүүдэд ХЭТ-ийг нэмэлт мэдээлэл болгон ашиглах сонголтыг боломжтой байлгах нь зүйтэй (МТ 202 COV and МТ 103). ХЭТ-ийн хэрэглээ нь корреспондент банканд мессеж дэх мэдээллээс гүйлгээний шилжүүлэгч болон хүлээн авагчийн талаарх мэдээллийг хангалттай авч чадах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай.”

Төлбөр тооцооны зах зээлийн практик бүлэг, ВХҮҮ-ийн салбарын холбоод, ВХҮҮ-дийн салбар дахь ажлын хэсгүүд) зах зээлийн нийтлэг туршлагыг тодорхойлоход төдийгүй одоогийн мессежийн бүтцийг өөрчлөхгүйгээр холбогдох ВХ-ийн өгөгдөлийг дамжуулах мессежүүдэд ХЭТ-г хэрхэн оруулах талаар дэмжлэг, туслалцаа үзүүлж болно.

190. Улс, орнууд өөрсдийн хяналтан дор байгаа шилжүүлэгч болон хүлээн авагч байгууллагуудыг 3.11-д заасан баримт материал хадгалах шаардлагын дагуу дээр дурдсан мэдээллийг эрх бүхий байгууллагаас шаардсан тохиолдолд нэн даруй гаргаж өгөх боломжтой байлгах шаардлага тавих хэрэгтэй.

191. Улс орнууд янз бүрийн ВХ болон холбогдох ВХ-ийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийг харгалзан ФАТФ-ын стандартын дагуу ВХ-ийн шилжүүлгийн хамгийн доод босгыг 1,000 ам.доллар/евроогоор тогтоож болно. Хэрэв улс орнууд энэхүү босго дүнг хэрэгжүүлэхээр сонгосон бол босго дүнгээс дээш дүнтэй ВХ-ийн шилжүүлэгтэй харьцуулахад босго дүнгээс доогуур дүнтэй ВХ-ийн шилжүүлэгт тавигдах шаардлага харьцангуй бага байна. Босгоос доогуур ВХ-ийн шилжүүлгийн хувьд улс орнууд ВХҮҮ-ээс дараахь мэдээллийг цуглуулахыг шаарддаг. Үүнд:

а. шилжүүлэгч болон хүлээн авагчийн нэр;

б. тус бүрийн ВХ-ийн хэтэвчний хаяг эсхүл дахин давтагдашгүй гүйлгээний дугаар.

192. МУТС-тэй холбоотой сэжигтэй нөхцөл байдал байхгүй тохиолдолд энэхүү мэдээллийг баталгаажуулах шаардлагагүй бөгөөд энэ тохиолдолд харилцагчтай холбоотой мэдээллийг баталгаажуулах⁴⁷ шаардлагатай.

ВХ-ийн шилжүүлэгт хориг арга хэмжээг мөрдөх

193. Улс орнууд шилжүүлэгч болон хүлээн авагч байгууллагуудаас аль альнаас нь царцаах арга хэмжээ авахыг шаардаж, жагсаалтад орсон этгээд, аж ахуйн нэгжтэй хийх гүйлгээг хориглох ёстой. Шилжүүлэгч байгууллага нь 3.10-т заасан ХТМ шаардлагын дагуу харилцагч, цахим шилжүүлэг хийж буй шилжүүлэгч, хүлээн авагчийн талаарх шаардлагатай мэдээлэлтэй байх ёстой. Шилжүүлэгч болон хүлээн авагч байгууллагууд нь тус тус харилцагчтай бизнесийн харилцаа үүсгэх үед (мөн нэрээ өөрчилсөн тохиолдолд) харилцагчийн нэрийг санхүүгийн зорилтот хориг арга хэмжээний жагсаалтад байгаа эсэхийг шалгасан байх шаардлагатай юм. Үүний дараа ВХ-ийн шилжүүлгийг хийхдээ нөгөө талын (цахим шилжүүлэг хийж буй шилжүүлэгч эсхүл хүлээн авагч) нэрийг шалгах ёстой (дээрх Хүснэгт 1-ийг үзнэ үү).

194. Улс орнууд ВХҮҮ болон бусад МҮЭ-ээс зорилтот санхүүгийн хориг арга хэмжээний шаардлагад нийцэх үр дүнтэй хяналтын тогтолцоог хэрэгжүүлэхийг шаардах нь зүйтэй. Энэхүү тогтолцоо нь ВХ-ийн шилжүүлгийн шинж чанарыг харгалзан үзэх ёстой. Цахим шилжүүлэг хийж буй шилжүүлэгч болон хүлээн авагчийг тодорхойлох шаардлагатай мэдээллийг ВХ-ийн шилжүүлгийн системд (жишээ нь, блокчэйн) тусад нь хадгалах боломжтой тул ВХ-ийн шилжүүлгийг ийм мэдээлэл дутуу байсан ч эсхүл

⁴⁷ 3.16, 3Т.16, 5-р хэсэг.

сэжигтэй, хориглосон гүйлгээг илрүүлэхийн тулд шилжүүлгийг шалгахгүйгээр хийж болно. Иймд ВХҮҮ буюу бусад МҮЭ ийм шууд төлбөр тооцоонд шаардлагатай ВХ-ийн шилжүүлгийн мэдээллийг тусад нь шалгах ёстой. Тиймээс, ВХҮҮ-д өөрсдийн бизнесийн үйл явц болон ВХ-ийн техникийн шинж чанарт тохирсон эсрэг арга хэмжээг авч үзэх шаардлагатай байж магадгүй юм. Хэдийгээр блокчэйн технологи нь байнга өөрчлөгдөж байдаг ч ВХҮҮ эсхүл бусад МҮЭ-ийн дараах хяналтын арга хэмжээг хэрэгжүүлж болно. Үүнд:

а. хяналтын үйл явц дуусаж, аливаа асуудал байхгүй болохыг баталгаажуулах хүртэл хэтэвчийг түр саатуулах;

б. ВХ-ийн шилжүүлгийг харилцагчийн хэтэвчтэй холбосон үйлчилгээ үзүүлэгчийн хэтэвчээр хүлээн авахаар зохион байгуулж, шилжүүлсэн ВХ-ийг зөвхөн хяналтын үйл явц дууссаны дараа харилцагийн түрийвч рүү шилжүүлэх.

195. Улс орнууд ВХ-ийн шилжүүлэг нь уламжлалт албан ёсны цахим шилжүүлгээс өөр болохыг ойлгох шаардлагатай. Тиймээс улс орнууд ВХҮҮ болон бусад зохицуулалттай этгээдээс үр дүнтэй хяналт шалгалтыг хөнгөвчлөх үүднээс дутагдлаа арилгах зорилгоор авсан хяналтын арга хэмжээг баримтжуулахыг шаардах хэрэгтэй. Улс орнууд эрх бүхий этгээдүүдээс энэхүү хяналтыг МУТС эрсдэлийн үнэлгээнд тусгахыг хүсэх боломжтой.

ВХҮҮ хоорондын ВХ-ийн шилжүүлэг болон ХТМ арга хэмжээ

196. ФАТФ нь улс орнуудаас ЗТ.15-ын 7(б)-д заасан шаардлагыг ВХ-ийн шилжүүлгийн өвөрмөц шинж чанар болон хувийн хэвшил дэх шилжүүлгийн дүрмийн шийдлүүдийн ирээдүйн хяналтын тогтолцоог харгалзан хэрэгжүүлэхийг шаарддаг. (Бүлэг 4-ийн 3.16-г үзнэ үү). Зуучлагчийн шаардлагагүйгээр хэтэвчний хаяг хооронд блокчэйн дээр тараасан зөвшилцөлд тулгуурлан ВХ-ийн шилжүүлгийг шууд шийдвэрлэх боломжтой. ВХҮҮ нь шаардлагатай мэдээллийг өөр ВХҮҮ руу дамжуулахын тулд тэд нөгөө талын ВХҮҮ-ийг тодорхойлох шаардлагатай. ВХҮҮ нь хууль бус оролцогч талууд эсхүл хоригийн жагсаалтад багтсан этгээдтэй харилцахаас зайлсхийхийн тулд шаардлагатай мэдээллийг дамжуулахаас өмнө нөгөө талын ВХҮҮ-ийг таних зохих арга хэмжээг авах шаардлагатай. Сэжигтэй гүйлгээний түүх болон бусад мэдээлэл (сөрөг мэдээлэл болон захиргааны эсхүл эрүүгийн хариуцлагатай холбоотой нийтлэгдсэн мэдээлэл гэх мэт) байхгүй бол ВХҮҮ-д өмнө нь зохих таних арга хэмжээг авч хэрэгжүүлсэн ВХҮҮ-тэй харилцахдаа ВХ-ийн шилжүүлэг хийх бүртгээ нөгөө талын ВХҮҮ-ийг таних арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагагүй. Таньж мэдэх арга хэмжээний талаар ойлголтыг авч үзвэл улс орнууд өөрсдийн тодорхойлсон ЭСА бүхий хяналтын бүтцийн дагуу харилцаанаас эрсдэл үүсэх үед харилцагч талын зохих таньж мэдэх үйл ажиллагааны мэдээллийг үе үе шинэчилж байх ёстой. Үүний дагуу улс орнууд өөрсдийн МҮЭ болох ВХҮҮ-ээс энэхүү хяналтын механизмыг хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавих нь зүйтэй. Өмнө дурдсанчлан, ВХҮҮ-д тэдгээрийн харилцагч байгууллагууд нь солилцсон мэдээллийн нууцлалыг хамгаалах чадамжтай эсэхийг тодорхойлохын тулд энэхүү зохих таньж мэдэх үйл ажиллагааг ашиглах хэрэгтэй.


197. Хамтрагч байгууллагыг таньж мэдэх арга хэмжээг цаг тухайд нь, найдвартай хэрэгжүүлэх хамгийн шилдэг арга нь сорилт⁴⁸ бөгөөд энэ үйл явц нь 3 үе шатаас бүрдэнэ. Эдгээр нь ВХҮҮ-ийн заавал авах арга хэмжээ биш, харин харилцагч талыг таньж мэдэх зохих арга хэмжээг хэрхэн хийх талаар зааварчилгаа юм. Үүнд:

а. I шат: ВХ-ийн шилжүүлэгт хүлээн авагч ВХҮҮ байгаа эсэхийг тодорхойлох. Хувь хүн ВХ-ийг өөр ВХҮҮ руу (жишээ нь, хүлээн авагч нь зохицуулалттай хэтэвчтэй байх) эсхүл ВХ-ийг зохицуулалтгүй хэтэвч рүү шилжүүлж болно. Тиймээс цахим шилжүүлэг хийж буй ВХҮҮ нь өөр ВХҮҮ-тэй гүйлгээ хийх эсэхээ шийдэх ёстой. Энэхүү үйл явц нь зөвхөн МУТСТ шаардлага бус, харин ВХ-нд үндэслэсэн технологиос үүдэлтэй юм. Өнөөдрийг хүртэл ФАТФ нь дан ганц ВХ-ийн хаягнаас хүлээн авагчийн хэтэвчийг бүрэн, нарийн, үнэн зөв удирддаг ВХҮҮ-ийг тодорхойлох баталгаатай арга хэрэгслийг олж мэдээгүй байна;

б. II шат: ВХҮҮ нь харилцагч талын ВХҮҮ-ийг тодорхойлох. ВХҮҮ нь тухайн улсын холбогдох зохицуулалтын дагуу найдвартай эх сурвалж ашиглан харилцагч талын ВХҮҮ-ийг тодорхойлж болно;

в. III шат: Харилцагч ВХҮҮ нь харилцагчийн мэдээллийг илгээж, түүнтэй бизнесийн харилцаатай байж болох зохицуулалттай этгээд мөн эсэхийг үнэлэх. (харилцагч ВХҮҮ-ийг таньж мэдэх талаар нэмэлт мэдээллийг Бүлэг 4-ийн 3.16 болон харилцагчийн мэдээллийг зохих ёсоор хадгалах, удирдахтай холбоотой мэдээллийг 3.11-ээс үзнэ үү)

Зураг 1. Харилцагч ВХҮҮ-ийг таньж мэдэх үйл ажиллагааны ерөнхий зураглал



⁴⁸ ФАТФ-ын 12-р сарын тоймын 61 дэх хэсэг.

198. Энэхүү гарын авлагын хамрах хүрээг тодорхой болгохын тулд эрх бүхий байгууллагууд нь ВХҮҮ-д эхлээд бизнесийн харилцаатай ВХҮҮ-ийг үнэлэхийн тулд 'III шат'-д урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхийг ВХҮҮ-ээс шаардаж, дараа нь таньж мэдэх үйл ажиллагааны үр дүнг давтамжтай хянаж байх нь зүйтэй. Улс орнууд мөн ВХҮҮ-ийн харилцагч ВХҮҮ-ээ тодорхойлоход туслалцаа үзүүлэхийн тулд "II шат"-ны найдвартай, бие даасан мэдээллийн эх сурвалжийг хадгалдаг байх шаардлагатай. Үүнд зохицуулалттай байгууллагуудын жагсаалт буюу ВХҮҮ-дийн жагсаалт, тэдгээрийн эцсийн өмчлөгчдийн бүртгэл болон Базелын хорооны удирдамжид⁴⁹ дурдсан бусад жишээнүүд багтаж болно. Харилцагч талыг үр дүнтэй, үр ашигтай таньж мэдэхийн тулд зохицуулалттай байгууллагуудын жагсаалтад оруулж болох хэдий ч энэ нь зөвхөн ВХҮҮ-дийн нэр, бүртгэлтэй хаягаар хязгаарлагдах ёсгүй. Санхүүгийн салбарт цахимжсан үйл явцын хэрэглээ нэмэгдэж байгааг харгалзан улс орнууд машинаар унших боломжтой (machine-readable) форматыг ашиглахыг дэмжих нь зүйтэй. Улс, орнууд аль хэдийн СБ-ын тусгай зөвшөөрөл авсан эсхүл бүртгүүлсэн (ФАТФ-ын зөвлөмжөөр тодорхойлсон) хувь хүн эсхүл хуулийн этгээдэд тусад нь ВХҮҮ-ийн тусгай зөвшөөрөл олгох буюу бүртгэх системтэй байх шаардлагагүй. Ийм тогтолцоотой улс орнууд шаардлагагүй эрсдэлийг бууруулах арга хэмжээнээс зайлсхийхийн тулд ийм СБ нь ВХҮҮ-ийн жагсаалтад байхгүй, тэр ч байтугай нэг зохицуулагч байгууллагын хяналтан дор байдаггүй гэдгийг хувийн хэвшилдээ тайлбарлаж болно.

199. Нэмж дурдахад, улс орнууд ВХҮҮ-ийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ нь өөр өөр байх боломжтой гэдгийг хүлээн зөвшөөрч, *хэнтэй* гүйлгээ хийх талаар эрсдэлд суурилсан шийдвэр гаргах ёстой гэдгийг тодотгох ёстой. Ерөнхийдөө эдгээр шийдвэрийг ВХҮҮ бүр өөрийн эрсдэлд суурилсан дүн шинжилгээн дээр үндэслэн МУТСТ хэтийн төлөв, түүнчлэн мэдээллийн хадгалалт, аюулгүй байдал, бизнесийн харилцааны ашигт ажиллагаа зэрэг дагаж мөрдөх бусад асуудлуудыг харгалзан үзсэнээр гаргадаг. Шилжүүлэг хийж буй аж ахуй нэгжүүд нь хүлээн авагч талын харьяалалд зохих зохицуулалт байхгүйгээс үл хамааран хүлээн авагч аж ахуй нэгжээс гэрээгээр шилжүүлгийн дүрмийг дагаж мөрдөхийг шаардаж болно. Өөрсдийн үзэмжээр болон МУТС эрсдэлийн үнэлгээг харгалзан улс, орнууд тусгай зөвшөөрөл олгох эсхүл бүртгэлийн шаардлагыг үр дүнтэй хэрэгжүүлдэггүй улс орнуудын бүх ВХҮҮ-ийг өндөр эрсдэлтэй хэмээн тооцож болно.

200. ФАТФ нь улс орнуудаас ЗТ.15-ын 7(б) хэсгийг аль болох түргэн шуурхай хэрэгжүүлэхийг шаарддаг. Улс орнууд шаардлагатай системийг хэрэгжүүлэхэд ВХҮҮ-д хангалттай хугацаа байгаа эсэхийг баталгаажуулахын тулд шилжүүлгийн дүрэмд тавигдах шаардлагуудыг үе шаттайгаар хэрэгжүүлж болох хэдий ч ВХҮҮ-д нь ВХ-ийн шилжүүлгийн үед бий болох МУТС эрсдэлийг зохих ёсоор бууруулахад чиглэсэн бусад арга хэмжээнүүдтэй байх ёстой. Улс орнууд нь хувийн хэвшилд зориулсан шаардлагатай мэдээллийг найдвартай илгээх шийдлүүдийг боловсруулахдаа ВХ-ийн

⁴⁹ Базелын хороо (2014, шинэчилсэн найруулга. 2020) МУТС-тэй холбоотой эрсдлийг оновчтой удирдах нь: хяналт шалгалтын хамтын ажиллагааны шинэчилсэн найруулга, Хавсралт 2” 21. Банкууд ч мөн олон нийтийн нээлттэй эх сурвалжаас мэдээлэл цуглуулах боломжтой бөгөөд ингэхдээ хянан шалгагчаас ирүүлсэн мэдээллийг шалгах эсхүл харилцагч банканд тавигдсан МУТСТ асуудалтай холбоотой захиргааны хориг арга хэмжээний талаар мэдээллийг шалгахдаа харилцагч банкыг хянан шалгах эрх бүхий байгууллагын цахим хуудсыг ашиглах боломжтой юм. (ФАТФ-ын Гарын авлага, 25-р хэсэг). www.bis.org/bcbs/publ/d505.pdf

шилжүүлгийн өвөрмөц шинж чанар болон хөгжиж буй хяналтын тогтолцоог харгалзан үзэх хэрэгтэй. Гэсэн хэдий ч улс орнууд ВХҮҮ-д зориулсан МУТСТ тогтолцоогоо өөр, өөр байдлаар хэрэгжүүлсээр байна. Энэ нь зарим улс орнууд бусад улс орнын шилжүүлгийн дүрмийг дагаж мөрдөхөөс өмнө өөрсдийн улсын шилжүүлгийн дүрмийг дагаж мөрдөхийг ВХҮҮ-ээс шаардана гэсэн үг юм. Энэ нь шилжүүлгийн дүрэм хараахан хүчин төгөлдөр болоогүй байгаа нутаг дэвсгэрт байрлах ВХҮҮ-тэй харилцахдаа ямар арга барилыг баримтлах талаар ВХҮҮ-ийн хувьд сорилт болж магадгүй юм. Хүлээн авагчийн харьяалалд зохицуулалт байхгүйгээс үл хамааран, шилжүүлэгч байгууллагууд гэрээ эсхүл бизнесийн үйл ажиллагааны дагуу хүлээн авагчдаас шилжүүлгийн дүрмийг дагаж мөрдөхийг шаардаж болно. Ерөнхийдөө эдгээр бизнесийн шийдвэрийг ВХҮҮ бүр эрсдэлд суурилсан дүн шинжилгээн дээр үндэслэн гаргадаг. ВХҮҮ-ийн ЗТ.15-ын 7(б)-д заасан шаардлагад нийцэх түвшин нь эдгээр шийдвэрийн нэг хэсэг байх шаардлагатай. ВХҮҮ болон СБ нь харилцагч хувь хүн/харилцагч ВХҮҮ бүрийн МУТС эрсдэлийн түвшин болон харилцагч ВХҮҮ-ийн хэрэгжүүлсэн эрсдэлийг бууруулах арга хэмжээ зэргийг харгалзан үзэх ёстой.

201. Шилжүүлгийн дүрэмтэй холбоотой "sunrise issue"-ыг харгалзан улс орнууд ВХҮҮ-ийн танилцуулсан бизнесийн загваруудыг үнэлэхдээ эрсдэлд суурилсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зохистой. Холбогдох МУТС эрсдэлийг зохих ёсоор бууруулахын тулд ВХҮҮ-ээс эрсдэлийг бууруулах хангалттай арга хэмжээ авч байгаа эсэхээс хамааран улс орнууд шилжүүлгийн дүрмийг дагаж мөрдөх бүрэн нөхцөл байдлыг харгалзан үзэх ёстой. Тодорхой улс орны зохицуулалтаас үл хамааран ВХҮҮ нь шилжүүлгийн дүрмийн шаардлагыг биелүүлэхийн тулд хяналтын хатуу арга хэмжээ авч болно. Жишээ нь: ВХ-ийн шилжүүлгийг өөрсдийн харилцагчид дунд хийгдэхээр хязгаарлах (жишээ нь, ижил ВХҮҮ хооронд хийгдэх ВХ-ийн дотоод шилжүүлэг) буюу харилцагчдаас гадна (шилжүүлэг болон хүлээн авагч нь нэг ижил хүн байх үед) зөвхөн эхний баталгаажсан шилжүүлгийг болон гүйлгээний нарийвчилсан хяналтыг хүлээн зөвшөөрдөг. Эрсдэлийг бууруулах бусад жишээг Бүлэг 4-ийн “Харилцагч ВХҮҮ-ийг тодорхойлох болон таньж мэдэх”-ийг үзнэ үү. Улс орнуудад холбогдох зохицуулалтыг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх нь өөрөө чухал боловч нэг улсад холбогдох зохицуулалт байхгүй байгаа нь ВХҮҮ-ээс дангаараа хэрэгжүүлж буй арга хэмжээний үр нөлөөнд саад учруулдаггүй байна.

Зуучлагч ВХҮҮ-тэй хийгдэх ВХ-ийн шилжүүлэг

202. СБ-уудын хооронд цахим шилжүүлэг хийхтэй адил, “зуучлагч ВХҮҮ” буюу бусад зуучлагч зохицуулалттай этгээдийг эсхүл ВХ-ийн шилжүүлгийг ВХ-ийн шилжүүлгийн гинжин хэлхээний⁵⁰ завсрын элемент болгон хөнгөвчилдөг СБ-уудыг хамарсан ВХ-ийн шилжүүлгийн хувилбарууд байж болно. Улс орнууд ийм зуучлагч байгууллагууд (ВХҮҮ эсхүл бусад бусад зохицуулалттай эсэх) ЗТ.15-д заасан 3.16-ын шаардлагыг дагаж мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих шаардлагатай. Хил дамнасан албан ёсны цахим шилжүүлгийг хийхдээ уламжлалт зуучлагч СБ-ууд шаардлагатай бүх шилжүүлэгч болон хүлээн авагчийн мэдээллийг хадгалах ёстойгийн адилаар зуучлагч

⁵⁰ ВХҮҮ, СБ болон зуучлагч зохицуулалттай этгээд нь ВХ-ийн шилжүүлгийг ВХ-ийн шилжүүлгийн гинжин хэлхээний завсрын элемент болгон хөнгөвчилдөг эсхүл энэхүү гарын авлагад зарим үйл ажиллагаа/бизнесийг ВХҮҮ гэж тодорхойлсон бол үүнийг “зуучлагч ВХҮҮ” гэж ойлгоно.

ВХҮҮ болон ВХ-ийн шилжүүлэг хийдэг бусад ижил төстэй зуучлагч байгууллага нь мөн л ВХ-ийн шилжүүлгийн үед шилжүүлсэн мэдээллийг хадгалах, эрх бүхий байгууллагыг шаардсан үед гаргаж өгөхөд бэлэн байлгах шаардлагатай. Үүний нэгэн адил, техникийн хязгаарлалт нь шилжүүлэгч эсхүл хүлээн авагчийн мэдээллийг шаардлагатай өгөгдөлийн хамт шилжүүлэхэд саад болж байвал шилжүүлэгч ВХҮҮ эсхүл өөр зуучлагч ВХҮҮ-ээс хүлээн авсан бүх мэдээллийн бүртгэлийг хүлээн авагч эсхүл зуучлагч ВХҮҮ нь дор хаяж таван жилийн турш хадгалах ёстой. ВХ-ийн шилжүүлэгт оролцож буй зуучлагч байгууллагууд нь шилжүүлэгч болон хүлээн авагч ВХҮҮ (эсхүл ВХ-ийн шилжүүлгийг хийх бусад шилжүүлэгч эсхүл хүлээн авагч зохицуулалттай этгээд)-тэй нэгэн адил сэжигтэй гүйлгээг илрүүлэх, царцаах арга хэмжээ авах, хоригийн жагсаалтад орсон хувь хүн, аж ахуйн нэгжтэй хийх гүйлгээ хийхийг хориглох ерөнхий үүрэгтэй.

Зохицуулалтгүй хэтэвчтэй хийх ВХ-ийн шилжүүлэг

203. ФАТФ нь уламжлалт албан ёсны цахим шилжүүлгээс ялгаатайгаар ВХ-ийн шилжүүлэг бүрт ВХҮҮ эсхүл бусад зохицуулалттай этгээд (санхүүгийн байгууллага) гэх мэт хоёр эрх бүхий аж ахуйн нэгж оролцдоггүй (эсхүл захиалсан байж болохгүй) гэдгийг хүлээн зөвшөөрдөг. ВХ-ийн шилжүүлэг нь зөвхөн нэг зохицуулалттай этгээдийг хамарсан тохиолдолд (жишээ нь: шилжүүлэгч ВХҮҮ эсхүл бусад зохицуулалттай этгээд нь цахим шилжүүлэг хийж буй шилжүүлэгчийн нэрийн өмнөөс ВХ-ийг хүлээн авагч байгууллагын харилцагч биш хүлээн авагчид илгээсэн тохиолдолд) улс, орнууд нь зохицуулалттай этгээд харилцагчтайгаа (шилжүүлэгч эсхүл хүлээн авагч) холбоотойгоор 3.16-д дурдсан шаардлагуудыг дагаж мөрдөж байгаад хяналт тавих шаардлагатай.

204. ФАТФ-аас ВХҮҮ болон СБ нь ВХ-ийн шилжүүлгийг хийхдээ эрх бүхий этгээд бус хувь хүмүүст шаардлагатай мэдээллийг өгөхийг шаарддаггүй. ВХҮҮ биш аж ахуйн нэгж болон бусад зохицуулалттай этгээдэд (жишээ нь, ВХ-ийн хувь хэрэглэгчээс зохицуулалтгүй түрийвч рүү) ВХ-ийг шилжүүлж, хүлээн авч байгаа ВХҮҮ нь цахим шилжүүлэг хийж буй шилжүүлэгч болон хүлээн авагчийн мэдээллийг харилцагчаасаа авах ёстой. Улс орнууд нь энэ төрлийн шилжүүлгийг үр дүнтэй шалгах механизмыг хэрэгжүүлэх, тухайлбал сэжигтэй гүйлгээг тайлангнах болон хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үүргээ биелүүлэхийг ВХҮҮ эсхүл бусад зохицуулалттай этгээдээс шаардах ёстой (доор дурдсан 3.20-ын тайлбарыг үзнэ үү) ба дээр дурдсанчлан зохицуулалтгүй хэтэвчтэй хийгдэж буй шилжүүлэг дээр нэмэлт хязгаарлалт эсхүл хяналт тавьж болно.

Гуравдагч этгээдэд тулгуурлах

205. **Зөвлөмж 17** нь улс орнуудад зохицуулалттай этгээдүүдэд бизнесийн харилцаа тогтоох, харилцагчийг тодорхойлох, шалгах болон ХТМ ажиллагааг гуравдагч этгээдээр хийлгэх боломжийг олгодог. Гэсэн хэдий ч гуравдагч этгээд нь ХТМ үйл ажиллагааны хэрэгжилт, баримт материал хадгалах шаардлагуудыг дагаж мөрдөх үүрэгтэй, мөн МУТСТ эрх бүхий байгууллагын хяналт шалгалтад хамрагддаг зохицуулалттай этгээд байх ёстой. Түүнчлэн, гуравдагч этгээдэд тулгуурлах нь зохицуулалттай этгээдийг үүрэг хариуцлагаас чөлөөлөх болон зөрчил гарсан тохиолдолд хариуцлагаас чөлөөлөх нөхцөл болохгүй.

206. Улс орнууд 3.15-д заасаны дагуу ВХҮҮ-дийг гуравдагч этгээдээр ажиллахыг зөвшөөрч болно. МҮЭ нь гуравдагч этгээдийн зохицуулалттай байдлыг шалгахаас гадна эрсдэлийн үндсэн дээр сонголтоо хийх ёстой. Гуравдагч ВХҮҮ-ийн хувьд улс орнууд болон зохицуулалттай этгээдүүд гуравдагч этгээдээс учирч болзошгүй эрсдэл, бизнес болон үйл ажиллагааны мөн чанар, гуравдагч ВХҮҮ-ийн харилцагчийн бүлэг эсхүл зорилтот зах зээл, түүний бизнесийн түншүүд, бусад холбогдох тохиолдлуудыг авч үзэх нь зүйтэй. ВХҮҮ нь бизнесийн харилцааг эхлүүлэх эсхүл ХТМ үйл ажиллагааг явуулахдаа өөр ВХҮҮ-д тулгуурладаг бол ХТМ-д ВХҮҮ-ВХҮҮ байдлаар үйл ажиллагаа нь ялангуяа ВХ-ийн шилжүүлгийн хүрээнд 3.16-ын шаардлагад нийцсэн байх шаардлагатай.

Дотоод хяналт болон гадаад дах салбар, охин компаниуд

207. **Зөвлөмж 18**-д заасны дагуу улс орнууд МУТСТ бодлого, үйл явцын үр нөлөө, үйл ажиллагаа, хэлтэс, салбар, охин компаниуд дахь эрсдэлийн менежментийн чанарыг сайжруулах үүднээс зохицуулалттай этгээдүүдээс дотоод хяналтыг хэрэгжүүлэхийг шаарддаг байх хэрэгтэй. Эдгээр дотоод хяналтууд нь МУТСТ үүргийг тодорхой хуваарилж, удирдлагын түвшинд комплаенсын ажилтан томилсон зохих засаглалын зохицуулалт; орон нутгийн холбогдох хууль тогтоомжийн дагуу ажилтнуудын шударга байдалд тавих хяналт; ажилтнуудын байнгын сургалт; мөн системийг тестлэх (гадаад эсхүл дотоод) хараат бус аудитын функц зэргийг агуулсан байх шаардлагатай.

Өндөр эрсдэлтэй улс, орнууд

208. **Зөвлөмж 19**-т улс орнууд өндөр эрсдэлтэй орнуудын иргэн болон хуулийн этгээдтэй бизнесийн харилцаа үүсгэхдээ ХТМНУА авах шаардлагатай талаар дурдсан байдаг. Энэ нь ВХ-ийн үйл ажиллагаа болон ВХҮҮ-ийн үйл ажиллагааны хил дамнан шинж чанарыг харгалзан үзэхэд онцгой ач холбогдолтой юм.

СГТ болон мэдээллийн нууцлал

209. **Зөвлөмж 20**-д СБ-ыг аливаа хөрөнгийг гэмт хэрэг үйлдэж олсон болон ТС-тэй холбоотой гэж сэжиглэх үндэслэлтэй бол сэжиглэх үндэслэлээ холбогдох СМА-нд яаралтай мэдээлэхийг шаарддаг. Үүний дагуу улс орнууд ВХҮҮ болон ВХ-ийн үйл ажиллагаа эрхэлдэг бусад зохицуулалттай этгээд сэжигтэй гүйлгээг мэдээлж байгаа эсэхэд хяналт тавих ёстой (ВХҮҮ болон бусад зохицуулалттай этгээдүүдэд хамаарах нэмэлт мэдээллийг Бүлэг 4-өөс үзнэ үү).

210. Урьдчилан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой ЗТ.15-ын 7-р хэсэг болон 3.16-ын хүрээнд дээр дурдсанчлан улс орнууд ВХҮҮ-ээс үйл ажиллагаа явуулж буй улсдаа 3.16-д холбогдох бүх шаардлагыг дагаж мөрдөхийг шаардах ёстой.

211. ВХ-тэй холбоотой үйл ажиллагаа эрхэлдэг ВХҮҮ болон бусад зохицуулалттай этгээдийн хувьд МУТСТ үүргийг хэрэгжүүлдэг зарим улс орнуудад ВХ-тэй холбоотой СГТ нь хууль сахиулах байгууллагын мөрдөн шалгах үйл ажиллагааг цаашид ахиулж,

СМА-ны ВХ-ийн экосистем⁵¹ дэх үйлчилгээ үзүүлэгч болон үйл ажиллагааг илүү сайн ойлгож, дүн шинжилгээ хийх чадварыг сайжруулахад үнэлж баршгүй ач холбогдолтой болох нь батлагдсан. Төхөөрөмжийн таниулбар (device identifier), IP хаяг, ВХ-ийн хэтэвчний хаяг зэрэг ВХ-ийн үйл ажиллагаатай холбоотой байж болох тодорхой үзүүлэлтүүдийг мэдээлэх боломжоор үйлчилгээ үзүүлэгчид болон бусад зохицуулалттай этгээдийг хангахын тулд улс орнууд өөрсдийн одоогийн тайлагнах механизм эсхүл маягтыг шинэчлэх шаардлагатай эсэхийг бодолцож үзэх хэрэгтэй.

212. Хэдийгээр ВХҮҮ нь хүлээн авагчийн талаар шаардлагатай баталгаажуулсан мэдээллийг илгээх шаардлагагүй (дээрх 3.16-г үзнэ үү) хэдий ч ВХҮҮ-ийн тэмдэглэсэн аливаа зөрүүгээс болж боловсруулсан өгөгдлийн үнэн зөв эсэхийг сэжиглэж болзошгүй нөхцөл байдал үүсэж болно. Эдгээр зөрүүг блокчейн аналитик хэрэгсэл, харилцагч ВХҮҮ-ээс ирүүлсэн мэдээлэл, эсхүл гүйлгээний түүх зэргийн тусламжтайгаар тодорхойлж болно. Хэрэв харилцагчийн өгсөн буруу эсхүл дутуу мэдээллээс (шилжүүлэгч ВХҮҮ-ийн хувьд) эсхүл шилжүүлэгч ВХҮҮ-ээс (хүлээн авагч ВХҮҮ-ийн хувьд) шалтгаалан ямар нэгэн зөрүүтэй байдал үүссэн бол үүнийг хийгдэх гэж буй болон ижил харилцагчтай холбоотой бусад гүйлгээнүүдийн хамт үнэлнэ. Энэ нь СМА, хууль сахиулах байгууллага болон мөрдөн байцаагчдад маш үнэ цэнэтэй мэдээлэл байж болох тул улс орнууд сэжигтэй гүйлгээг үр дүнтэй шалгах механизмыг болон хориг арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагыг биелүүлэхийг ВХҮҮ-ээс шаардах ёстой.

213. **Зөвлөмж 21** нь СБ-ын мэдээллийг задруулах болон нууцлалыг хадгалах арга хэмжээтэй холбоотой бөгөөд 3Т.15-ын 7-р хэсэгт заасны дагуу урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахтай холбоотойгоор улс орнууд ВХҮҮ-д ийм арга хэмжээ авахыг шаардах хэрэгтэй. 3.21-ийн дагуу ВХҮҮ, тэдгээрийн удирдлага, албан тушаалтнууд, ажилтнууд нь сэжигтэй үйлдлийн талаар мэдээлсэн бол гэрээ, хууль, эрх зүйн болон захиргааны хэм хэмжээгээр тогтоосон мэдээлэл задруулахыг хориглосон заалтыг зөрчсөн гэж эрүүгийн болон иргэний хариуцлагад татахаас хуулиар хамгаалуулж, мэдээллийг задруулахгүй байх үүргийг хуулиар хүлээнэ.

Хуулийн этгээд болон эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн эцсийн өмчлөгч болон ил тод байдал

214. **Зөвлөмж 24 болон 25:** ФАТФ-ын нэр томъёоны тайлбарт ВХҮҮ-ийг ВХҮҮ-ийн тодорхойлолтод заасан бизнесийн үйл ажиллагааг эрхэлдэг аливаа хувь хүн, хуулийн этгээд гэж тодорхойлдог. 3.24, 3.25-д улс орнууд МУТС зорилгоор хуулийн этгээд болон эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийг зүй бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах шаардлагын талаар дурдсан байдаг. Иймээс СБ болон СББМҮҮ-ийн нэгэн адил улс орнууд ВХҮҮ-ийг зүй бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, 3.10, 3.22-г заасан шаардлагуудыг хэрэгжүүлсэн ВХҮҮ-д

⁵¹ Тухайлбал, хадгаламжийн байгууллагууд болон ВХҮҮ-ээс мэдээлсэн СГТ нь 2017 онд АНУ-ын хууль сахиулах байгууллагад албан ёсны мөнгөн тэмдэгт болон ВХ-ийн арилжааг интернетэд суурилсан мөнгөн гуйвуулагч болох ВТС-е-ийн эсрэг арга хэмжээ авах боломжийг олгосон. Үүний тусламжтайгаар рэнсомвэйр, компьютерийг хакердах, хувийн мэдээллийг хулгайлах, татварын луйврын схемүүд, авлига, хар тамхины наймаа зэрэг нь ВТС-е-ийн ашигласан гүйлгээний ВХ-ийн хэтэвчний хаягийг илрүүлж, биржээр дамжиж буй янз бүрийн хууль бус үйл ажиллагааны урсгалыг илрүүлсэн.

эцсийн өмчлөгч болон хяналтын мэдээлэлд нэвтрэх боломжийг хялбарчлах арга хэмжээг авч үзэх ёстой.

Хууль сахиулах байгууллага болон үйл ажиллагаа

215. **Зөвлөмж 25.** 3.20-ийн дагуу ВХҮҮ нь СГТ-г СМА-нд мэдээлэх шаардлагатай. СМА нь өөрийн харьяаллын зохицуулалттай этгээдээс нэмэлт мэдээлэл авах боломжтой байх ёстой бөгөөд үүнд ВХҮҮ-ийг хамруулж, СМА нь үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн, захиргааны болон хууль сахиулах мэдээллийг цаг тухайд нь авах боломжтой байх ёстой.
216. **Зөвлөмж 30**-ийг хөрөнгө эсхүл хэмжээ дээр суурилсан нэр томъёоны хэсэгт дээр дурдсан болно.
217. **Зөвлөмж 31.** Улс орнууд эрх бүхий байгууллагуудад СБ, СББМҮҮ-дийн нэгэн адил ВХҮҮ-ийн хадгалсан бүх шаардлагатай бичиг баримт, мэдээлэл, бүртгэлд нэвтрэх боломжтой байхад анхаарах шаардлагатай. Эдгээр нь хувь хүн эсхүл хуулийн этгээд болох ВХҮҮ нь ВХ-ийн данс, эсхүл хэтэвчийг эзэмшиж, хянадаг эсэхийг тодорхойлох үр дүнтэй механизмтай байх ёстой бөгөөд зохицуулалттай этгээд нь өмчлөгчид урьдчилан мэдэгдэлгүйгээр ВХ-ийг тодорхойлох үйл явцтай байхыг баталгаажуулах механизмтай байх ёстой. 3.31-ийг хэрэгжүүлэх нь ВХ-ийн болон ВХҮҮ-ийн үйл ажиллагаатай холбоотой МУТС эрсдэлийг багасгахад улс орон болон тэдгээрийн эрх бүхий байгууллагуудад онцгой ач холбогдолтой юм.
218. **Зөвлөмж 32.** Улс орнууд нь 3.32-ыг ВХ-тэй холбоотой үйл ажиллагаа болон ВХҮҮ-д хамруулах эсэхийг авч үзэхдээ ЭСА-ыг авч үзэх хэрэгтэй. Улс орнууд ЭСА-даа (а) ВХҮҮ-ийн болон ВХ-тэй холбоотой үйл ажиллагаа нь мөнгөний хэрэгслийг тээвэрлэх параметр хүчин зүйлсэд хамаарч байгаа эсэх, (б) тухайн хөрөнгийн хил дамнан хөдөлгөөнийг илрүүлэх болон мэдүүлэх систем нь тавигдсан шаардлагыг хэрхэн хангаж байгаа зэргийг харгалзан үзэх шаардлагатай.
219. 3.30-тай адил **Зөвлөмж 33**-ын талаар хөрөнгө эсхүл хэмжээ дээр суурилсан нэр томъёоны хэсэгт дээр дурдсан болно.
220. **Зөвлөмж 34** нь ВХ, ВХ-тэй холбоотой үйл ажиллагаа болон ВХҮҮ-тэй холбоотой МУТС эрсдэлийг илрүүлэх, шийдвэрлэхэд чиглэсэн улс орнуудын нэн чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Холбогдох эрх бүхий байгууллагуудаас МУТСТ тогтолцоог хэрэгжүүлэхэд ВХҮҮ-дэд зориулсан үндэсний МУТСТ арга хэмжээг хэрэгжүүлэх, сэжигтэй гүйлгээг (виртуал/албан ёсны мөнгөн тэмдэгт) илрүүлэх, мэдээлэхтэй холбоотой гарын авлагыг боловсруулж, зөвлөмж болон заавраар хангах хэрэгтэй.

Олон улсын хамтын ажиллагаа

221. **Зөвлөмж 36-40.** Улс орнууд болон эрх бүхий байгууллагууд нь ВХ-ийн хил дамнан, хөдөлгөөнт шинж чанартай холбоотойгоор олон улсын хамтын ажиллагааг 3.36-40-д заасны дагуу хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой юм. Түүнчлэн олон улсын хамтын ажиллагаатай холбоотой шаардлагуудыг хэрэгжүүлэх нь ВХ-ийн үйл ажиллагаа

эрхлэгчдийн илүү зохицуулалттай улсын ВХ бусад зохиуцлалт сул улсын ВХ-тэй шударга бус өрсөдлөөнийг бий болгохоос сэргийлэхэд чухал нөлөө үзүүлнэ.

222. ВХҮҮ-ийн салбартай холбоотой үр дүнтэй зохицуулалт, хяналт, хэрэгжилт нь дэлхийн хэмжээнд хандах хандлага, эрх зүйн зохицуулалтын түвшний зохицуулалт шаарддаг гэдгийг хүлээн зөвшөөрч, ЗТ.15-ын 8-р хэсэгт ВХ-тэй холбоотой эрсдэлийг бууруулахын тулд 3.37-40-д заасан шаардлагуудыг хэрэгжүүлэхийн ач холбогдлыг онцолж, ВХ-ийн үйл ажиллагаа, ВХҮҮ-дийг хамруулсан. Улс орнууд бие биетэйгээ хамтран ажиллах, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхэд шаардлагатай арга хэрэгсэлтэй байх (3.37); ВХҮҮ-ийн үйл ажиллагаатай холбоотой бусад уламжлалт эд хөрөнгийг түүнчлэн ВХ-ийн хэлбэрээр байж болох гэмт хэргийн орлого, хэрэгслийг илрүүлэх, царцаах, хураах, хураахад туслах (3.38); бусад олон улсын чадавхийн хамт ВХ-тэй холбоотой гэмт хэрэг эсхүл хууль бус үйл ажиллагаа эрхэлдэг хууль бус этгээдүүдийг шилжүүлэн өгөхөд үр дүнтэй туслалцаа үзүүлэх (3.39) нь зүйтэй.
223. Хөрөнгө болон үнэлгээ дээр суурилсан нөхцөлийг агуулсан бусад Зөвлөмжийн нэгэн адил улс орнууд “мөнгө угаах, суурь гэмт хэрэг эсхүл терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой эд хөрөнгө, олсон орлого, ашигласан хэрэгсэл”-тэй холбоотой хөрөнгө хураах болон түр зуурын арга хэмжээнүүдийг ВХ дээр мөн адил хэрэгжүүлэх шаардлагатай.
224. 3.15-ын 8-р хэсэгт мөн ВХҮҮ-ийг хянан шалгах эрх бүхий этгээдийг ВХҮҮ-ийн байр суурь, нэршлийн ялгаа зэргээс үл хамааран гадаадын түншүүдтэйгээ шуурхай, үр дүнтэй мэдээлэл солилцохыг онцгойлон шаарддаг.
225. Нэг нутаг дэвсгэрт бүртгүүлж, тусгай зөвшөөрөл авахыг эрмэлздэг хэдий ч бусад улс оронд байрлах харилцагчдад "оффшор" бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлдэг ВХҮҮ-дэд олон улсын хамтын ажиллагаа нь мөн хамаарна. СМА-нууд хамтран ажиллагсадтайгаа холбогдох СГТ-ийн талаар ялангуяа хил дамнасан ВХ-ийн үйл ажиллагаа эсхүл ВХҮҮ-ийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг цаг тухайд нь солилцож, хамтран ажиллах нь чухал юм. Өөрсдийн харьяалалд үйл ажиллагаа явуулж буй ВХҮҮ-ийн хангалттай хэмжээний хяналт, зохицуулалттай байх нь улс орнуудад ВХ-ийн тухайд мөрдөн шалгах үйл ажиллагааны туслалцаа болон бусад олон улсын хамтын ажиллагааг илүү сайн хангах боломжийг олгодог. Одоогийн байдлаар олон оронд зохицуулалт болон мөрдөн шалгах үйл ажиллагааны чадвар дутмаг байгаа нь улс орнуудын үр дүнтэй хамтын ажиллагаанд саад учруулж болзошгүй юм. Түүгээр ч зогсохгүй олон улс, оронд ВХ-тэй холбоотой зарим төрлийн МУТС үйл ажиллагааг гэмт хэрэгт тооцох эрх зүйн орчин байдаггүй бөгөөд энэ нь цаашид гэмт үйлдлийн нөхцөл байдалд харилцан үр дүнтэй эрх зүйн туслалцаа үзүүлэх боломжийг хязгаарлаж болзошгүй юм.
226. Эрх бүхий байгууллагууд нь хянан шалгагчдад хэрхэн хамтарч ажиллах талаар заавар, зөвлөмж өгөхдөө “ВХҮҮ-ийг хянан шалгах эрх бүхий этгээд хооронд мэдээлэл солилцон, хамтран ажиллах зарчим”-ыг авч үзэх хэрэгтэй (Бүлэг 4-ийг үзнэ үү).

ВХ-ийн үйл ажиллагаа явуулж буй болон тус үйл ажиллагаанд оролцож буй СББМҮҮ

227. СББМҮҮ нь ВХҮҮ-тэй холбоотой аливаа үйл ажиллагаа явуулах тохиолдолд ФАТФ-ын зөвлөмжид заасан бүх л арга хэмжээг дагаж мөрдөхийг шаардах хэрэгтэй. Жишээлбэл (а) казино, (б) үл хөдлөх хөрөнгө зуучлалын агентлаг (в) үнэт металл болон үнэт чулууны арилжаа эрхлэгчид, (г) хуульч, нотариатч, нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч, (д) траст, компанийн үйлчилгээ үзүүлэгч нар нь 3.22, 3.23-т заасан ХТМ, баримт материал хадгалах болон бусад СББМҮҮ-дэд зориулж тусгайлан заасан шаардлагуудыг биелүүлэх шаардлагатай. 3.22-т 3.10, 11, 12, 15, болон 17 нь СББМҮҮ-дэд хамаарна гэж нарийвчлан зааж өгсөн байдаг. Тиймээс ВХҮҮ-ийн үйл ажиллагаатай холбогдсон аливаа СББМҮҮ нь дээр дурдсан зөвлөмжүүдэд заасны дагуу ХТМ, баримт материалыг хадгалах болон бусад арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай юм.
228. Үүнтэй нэгэн адилаар улс орнууд, эрх бүхий байгууллагууд нь СББМҮҮ-дийг зохицуулах, хянан шалгах арга хэмжээг ФАТФ-ын зөвлөмжүүдэд зааснаар авч хэрэгжүүлэхийг 3.28-ын хүрээнд шаарддаг. Өмнө дурдсанчлан ВХҮҮ-ийн үйл ажиллагаатай холбоотой СББМҮҮ-ийн зохицуулалт, хянан шалгалтын хэмжээг СБ-ыг хянан шалгах түвшинтэй тэнцүү байлгана. Өөрөөр хэлбэл ВХҮҮ-тэй холбоотой СББМҮҮ-дэд бусад СББМҮҮ-ээс илүү өндөр түвшний хяналт шалгалт хийх бөгөөд энэ нь 3.26, 27-д заасанчлан СБ-ын хяналт шалгалтын түвшинтэй ижил байна. Энэхүү хяналтын арга хэлбэрийг ашигласнаар ВХҮҮ-ийн салбарын зохицуулалтыг олон улсын хэмжээнд бататгаж, хяналт шалгалтын түвшинг ВХҮҮ-ийн холбоо харилцаа бүхий үйл ажиллагаанд оновчтойгоор тохируулж хянахад туслана.

ВХҮҮ-ийг МУТС эрсдэлд суурилсан аргачлалын дагуу хянах, шалгах

МУТС эрсдэлийн ойлголт

229. МУТСТ эрсдэлд суурилсан аргачлал нь холбогдох МУТСТ чиг үүрэг бүхий этгээдүүдэд илэрсэн эрсдэлд нь тохирсон, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг багасгах арга хэмжээг хэрэгжүүлэх зорилготой. Энэхүү ЭСА нь хянан шалгах эрх бүхий байгууллагын нөөцийн оновчтой хуваарилалт болон ВХҮҮ-ийн ЭСА-ын хэрэгжилтийг хянах хянан шалгагч нарт мөн хамаарна.
230. ФАТФ-аас 2021 оны 3-р сард “Хянан шалгагчдад зориулсан МУТСТ хяналт шалгалтыг ЭСА-аар хэрэгжүүлэх гарын авлага”-ыг гаргасан. Энэхүү баримт бичигт хянан шалгагч нарт хэрхэн эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг өргөн хүрээнд хэрэгжүүлэх талаар тусгасан болно. Үүнд ВХҮҮ-ийг хянан шалгагчдад зориулсан нэмэлт заавар, практик зөвлөгөө зэрэг багтсан болно.
231. Үр дүнтэй эрсдэлд суурилсан тогтолцоо нь аливаа улсын бодлого, хууль эрх зүйн болон зохицуулалтын арга хэлбэрт тусгагдсан байх нь зохистой. Үндэсний бодлого, хууль эрх зүй болон зохицуулалтын хүрээ нь санхүүгийн салбарын бодлогын зорилт болох санхүүгийн хүртээмж, санхүүгийн тогтвортой байдал, санхүүгийн шударга байдал, мөн санхүүгийн харилцагчдыг хамгаалах зорилт зэрэг өргөн хүрээний агуулгатай байх бөгөөд зах зээлийн өрсөлдөөн зэргийг мөн харгалзан үзэх шаардлагатай. Цаашлаад энэхүү үндэсний бодлого, хууль эрх зүй, зохицуулалтын хүрээ нь ВХҮҮ салбарын мөн чанар, олон талт байдал, нөхцөл байдлын эрсдэлд, түүнчлэн бие

даасан ВХҮҮ, ВХ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагаатай холбоотой МУТС эрсдэлд түүнээс урьдчилан сэргийлж багасгах ЭСА-ыг хэрэгжүүлэх боломжийг олгодог байх хэрэгтэй.

232. Хянан шалгагчид нь өөрсдийн ВХ-ийн салбарын эрсдэлийг сайн үнэлэхийн тулд ВХҮҮ-ийн зах зээл, түүний санхүүгийн системд үзүүлэх нөлөө, зах зээлийн бүтэц болон тухайн улсын эдийн засгийн талаар гүнзгий ойлголттой байх шаардлагатай. Үүний тулд ВХҮҮ-дэд сургалт зохион байгуулж, хяналт шалгалт хийх нөөц бололцоогоор хангаж, тухайн салбарыг зохицуулах, хянах практик ур чадвар эзэмших нөхцөлийг бүрдүүлэх нь чухал юм.
233. Хянан шалгагчид нь ВХҮҮ болон ВХ-ийн бүтээгдэхүүн үйлчилгээ, үйл ажиллагааны МУТС эрсдэлийг үнэлэх, илрүүлэхэд олон төрлийн нөөцийг ашиглах боломжтой байх хэрэгтэй. Тухайлбал тэрхүү шаардлагатай нөөцөд үндэсний болон салбарын эрсдэлийн үнэлгээний талаарх мэдээлэл, дотоодын болон олон улсын типологи, удирдах мэргэжилтэн болон СМА-ны гарын авлага, эргэх холбоо, санал дүгнэлт зэрэг багтана. Хэрэв улс орны эрх бүхий байгууллагууд нь ВХҮҮ-ийн салбарыг эсхүл ВХ-ийн системийг хангалттай түвшинд ойлгоогүй бол тухайн салбарт илүү анхаарал хандуулж салбарын эрсдэлийн үнэлгээг хийх шаардлагатай бөгөөд энэ нь цаашлаад ВХҮҮ-тэй холбоотой үйл ажиллагааг ойлгоход туслахаас гадна ВХҮҮ нь өөрөө эрсдэлээ үнэлэхэд тусална.
234. Хэд хэдэн улс орнууд хяналт шалгалтдаа дэмжлэг үзүүлэх зорилгоор блокчэйн аналитик үйлчилгээг ашиглаж, цаашдын хэрэглээг судалсаар байна. Энэхүү үйлчилгээг хэд хэдэн аргаар ашиглаж болох бөгөөд, хянан шалгагчдад бие даасан ВХҮҮ-ийг үнэлэх явцад анхаарлаа хандуулах шаардлагатай хэсгүүдийг тодорхойлж, үйл ажиллагаанд нь үндэслэн хамгийн өндөр эрсдэлтэй ВХҮҮ-ийг ангилахад туслах болно. Эдгээр хэрэгслүүдийн зардлыг харгалзан үзэх хэрэгтэй бөгөөд бүх ВХҮҮ хамрагдаагүй байдгийг анхаарах хэрэгтэй. ВХҮҮ болон зарим СБ-ууд нь өөрсдийгөө эрсдэлд өртөж буй эсэхээ хянахын тулд блокчэйн аналитикийг өргөнөөр ашигладаг (жишээлбэл, холигч (mixer) үйлчилгээгээр дамжсан эсхүл нууцлалтай хэтэвчнээс шилжүүлсэн ВХ). Хэрэв эдгээр нь ил тод байдлыг (жишээ нь, олон нийтийн блокчэйн) зөвшөөрдөг бол эдгээр хэрэгслийг ашиглахдаа хувийн нууцлал, мэдээллийн хамгаалалтад үзүүлж болзошгүй үр дагаврыг авч үзэх нь чухал юм.
235. МУТС эрсдэлийн талаарх мэдээлэлд нэвтрэх боломж нь үр дүнтэй ЭСА-ын үндэс суурь юм. ФАТФ-ын 3.1-ийн (ЗТ.13-ыг үзнэ үү) хүрээнд аливаа улс орон, хянан шалгагч нь МУТС эрсдэлийг тодорхойлох, үнэлэх алхмуудыг авч хэрэгжүүлж, СБ болон СББМҮҮ (ВХҮҮ) нарыг эрсдэлийн мэдээллээр хангах хэрэгтэй гэж заасан. Улс орнууд нь эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж СБ, СББМҮҮ (ВХҮҮ)-дийг мэдээллээр хангах механизмтай байх шаардлагатай. ВХҮҮ-ийн салбарын зарим хэсэг нь холбогдох бүтээгдэхүүн үйлчилгээ, үйл ажиллагааныхаа эрсдэлийг тодорхойлох хязгаарлагдмал нөөц бололцоотой тохиолдолд хянан шалгагчид нь салбарын байгууллагуудтай хамтран ажиллаж хувийн хэвшлийн салбарын эрсдэлийн ойлголтыг нэмэгдүүлэхэд тусална. ВХҮҮ-ийн салбарын чадамжаас шалтгаалж ерөнхий болоод нарийвчилсан мэдээлэл, дэмжлэг шаардлагатай.

236. Бие даасан ВХҮҮ, эсхүл тодорхой нэг ВХ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагааны хувьд хянан шалгагчид нь ВХҮҮ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес модель, компанийн засаглалын зохицуулалт, санхүүгийн болон нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл, түгээлтийн суваг, харилцагчийн мэдээлэл, газарзүйн байршил, үйл ажиллагаагаа явуулдаг улс орнуудын мэдээлэл, ВХҮҮ-ийн МУТСТ арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлдэг талаарх комплаенсын мэдээлэл зэргийг харгалзан үзэхээс гадна хянан шалгагчийн МУТСТ арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх боломж, чадамжийг бууруулдаг эсхүл гүйлгээний талаар будлиантуулж болзошгүй аливаа ВХ-ийн токен, бүтээгдэхүүнийг анхаарч үзнэ. Түүнчлэн ВХҮҮ-ийн эрсдэлийн менежментийн бодлого, дотоод хяналтын механизмын үйл ажиллагаа зэрэг ВХҮҮ-ийн удирдлагын хяналт нь зохистой эсэхэд хяналт тавина.
237. Дээр дурдсан зарим мэдээллүүдийг ВХҮҮ буюу ВХ-ийн үйл ажиллагаа эрхэлдэг бусад зохицуулалттай этгээд нь зохистой байдлын зохицуулалтад (ВХҮҮ нь банк, даатгалын компани, үнэт цаасны үйлчилгээ үзүүлэгч эсхүл хөрөнгө оруулалтын компаниуд гэх мэт үндсэн зарчмуудад⁵² хамаарах СБ байх үед) хамрагддаг улс орнуудын хянан шалгагчаар дамжуулан авч болно.
238. Шаардлагатай тохиолдолд бусад оролцогч талуудын мэдээлэл, СМА, хууль сахиулах байгууллагын мэдээлэл нь хянан шалгагчдын ВХҮҮ-ийн МУТС эрсдэлийг тодорхойлоход үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж болно. Хууль сахиулах байгууллагууд нь ВХҮҮ-ийн талаар мэдээлэлтэй байж, тэдний бизнесийн сүлжээ, бүтээгдэхүүн үйлчилгээ болон ашиг сонирхлын талаар мэддэг байх нь чухал.
239. Хянан шалгагчид нь ВХҮҮ-ийн салбарын эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж, аливаа нөхцөл байдлын өөрчлөлт, аюул занал нэмэгдсэн тохиолдолд хугацааны хамааралгүй хийх хэрэгтэй.

МУТС эрсдэлийг бууруулах

240. ФАТФ-ын зөвлөмжүүдийн дагуу хянан шалгагчид нь МУТС эрсдэлийг тодорхойлж эрэмбэлэн өндөр эрсдэлтэй хэсгүүдэд нөөцийг хуваарилахыг шаарддаг. Хянан шалгагчид нь энэхүү ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд ВХҮҮ-ийн салбарын болоод бие даасан ВХҮҮ-ийн МУТС эрсдэлийн түвшинд суурилж үнэлгээ хийх давтамж, үнэлгээний хэлбэр зэргийг тодорхойлох ба бие даасан ВХҮҮ эсхүл аливаа салбарт үйл ажиллагаа эрхлэгч ВХҮҮ байхаас үл хамааран эрсдэлийн түвшингээр эрэмбэлнэ. Хэрэв улс орон нь тухайн салбарыг бүхэлд нь өндөр эрсдэлтэй гэж ангилах тохиолдолд мөн адил холбогдох шалтгаан тайлбаруудыг өгөх шаардлагатай.
241. Эрх бүхий байгууллагууд нь эрсдэлд суурилсан зохицуулалтын хүрээнд бүх ВХҮҮ нь адилхан МУТСТ зохицуулалтыг авч хэрэгжүүлэхгүй гэдгийг ойлгох нь чухал ба ганц нэг тохиолдлын шинжтэй хууль бусаар мөнгө шилжүүлсэн, солилцсон тохиолдол нь ВХҮҮ-ийн МУТСТ зохицуулалтыг бүхэлд нь үгүйсгэх үндэслэл болохгүй. Нөгөө талаас

⁵² ФАТФ-ын Зөвлөмжийн дагуу, “үндсэн зарчмууд” гэдэгт Базелын хорооноос гаргасан Банкны хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх үндсэн зарчмууд, Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагаас гаргасан үнэт цаасны зохицуулалтын зорилго, зарчим болон Олон улсын даатгалын хянан шалгагчдын холбооноос гаргасан даатгалын хяналт шалгалтын зарчмуудыг хамруулж ойлгоно.

ВХҮҮ нь уян хатан ЭСА-ыг хэрэгжүүлэх нь тэднийг үр дүнтэй МУТСТ хяналт хийх үүргээс чөлөөлөхгүй гэдгийг ойлгох хэрэгтэй.

242. Хянан шалгагчдын ЭСА-ыг тохируулах арга хэлбэрийн жишээг дараах жагсаалтаар харуулав. Үүнд:

а. МУТСТ хяналт шалгалтын төрлийг тодорхойлох: Хянан шалгагчид нь холбогдох комплаенсын болон эрсдэлийн талаарх мэдээлэлд нэвтрэхдээ газар дээрээс болон зайнаас авах аргын аль алиныг нь авч хэрэгжүүлнэ. Гэсэн хэдий ч хянан шалгагчид нь өөрсдийн горимоор зөвшөөрөгдсөн хэмжээний хүрээнд ВХҮҮ-ийн газар дээрх болон зайнаас хийх хяналт шалгалтын оновчтой хэмжээг тодорхойлохыг анхаарах хэрэгтэй. Өндөр эрсдэл бүхий нөхцөл байдалд зайнаас хяналт шалгалт хийх нь хангалтгүй. Харин өмнөх хянан шалгалтаар МУТС эрсдэл бага гэж үнэлэгдсэн бол нөөцийг бусад өндөр эрсдэл бүхий ВХҮҮ-дэд хуваарилах нь зүйтэй. Тиймээс бага эрсдэлтэй ВХҮҮ нь зайнаас хяналт шалгалтад орох боломжтой.

б. МУТСТ хяналт шалгалтын давтамжийг тодорхойлох: хянан шалгагчид нь илэрсэн эрсдэлийн түвшинтэй уялдуулан МУТСТ хяналт шалгалтын давтамжыг тогтоох бөгөөд түүнийг хяналтын дүгнэлт хийх үйл ажиллагаатай нэгтгэхээс гадна асуудал илэрсэн тохиолдолд МУТСТ хяналтыг тухай бүр хийнэ. Хяналт шалгалтын бусад ЭСА-д газар зүйн байршлын асуудал, бүртгэл эсхүл тусгай зөвшөөрөл, харилцагчийн мэдээлэл, гүйлгээний төрөл, ВХ-ийн төрөл, нийт данс бүртгэлийн тоо, хөрөнгө, санал болгож буй бүтээгдэхүүн үйлчилгээ, комплаенсыг хэрэгжүүлээгүй түүх, бүтэц зохион байгуулалтын чухал өөрчлөлт зэрэг үзүүлэлтүүд хамаардаг.

в. МУТСТ хяналт шалгалтын давтамжийг тодорхойлох: хянан шалгагчид нь илэрсэн эрсдэлийн түвшинтэй уялдуулан үнэлгээний зохих цар хүрээ, түвшинг тодорхойлох бөгөөд энэ нь ВХҮҮ-ийг зүй бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагааны горимын тохиромжит байдлыг үнэлэхэд чиглэнэ. Жишээ нь өндөр түвшний өргөтгөсөн хяналт шалгалтад ВХҮҮ-ийн эрсдэлийн үнэлгээний зохих байдал, мэдээлэх болон баримт бичгийн хадгалалтын бодлого, үйл явцын хэрэгжилтийг баталгаажуулах зорилгоор нарийвчилсан системийн тест хийх, дотоод аудит хийх, түвшин түвшнийн ажилтнуудтай ярилцлага хийх зэрэг багтана.

243. Хянан шалгагчид нь өөрсдийн дүгнэлтэд үндэслэн МУТС эрсдэлийн үнэлгээг хянан шинэчлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд МУТСТ хяналт шалгалтын аргачлал, эсхүл МУТСТ дүрэм, зөвлөмжийг хэвээр үлдээх эсэхийг харгалзан үзнэ. Шаардлагатай тохиолдолд мэдээллийн нууцлалтай холбогдох стандарт шаардлагуудтай нийцүүлэх зорилгоор хянан шалгагчид нь ВХҮҮ-тэй өөрсдийн илрүүлсэн мэдээллийг хуваалцаж ВХҮҮ-дэд ЭСА-ын чанарыг сайжруулах боломжийг нээж өгөх нь зүйтэй.

Ерөнхий чиг хандлага

244. Хянан шалгагчид нь ВХҮҮ-дэд болон ВХҮҮ-ийн салбартай уялдан тулгарч буй МУТС эрсдэлийг ойлгох шаардлагатай бөгөөд бизнесийн чиглэл эсхүл тодорхой нэг ВХ-ийн бүтээгдэхүүн үйлчилгээ, үйл ажиллагааны өндөр болон бага эрсдэлийн талаар,

тэр дундаа өндөр эрсдэлтэй бүтээгдэхүүн үйлчилгээ, үйл ажиллагааны цогц ойлголтыг авсан байх ёстой.

245. Хянан шалгагчид нь өөрсдийн ажилтнуудыг ВХҮҮ-ийн эрсдэлийн үнэлгээ болон менежментийн үйл ажиллагаа нь ВХҮҮ-ийн эрсдэлийн бодлого, процедур, хяналттай нийцэж байгааг үнэлэх үнэлгээ хийхэд шаардлагатай аливаа хэрэгслээр хангасан байх хэрэгтэй. Хянан шалгагчдын ВХҮҮ-ийн салбарын ерөнхий арга хэмжээний давуу талыг ойлгуулахад туслах үүднээс улс орнууд нь бие даасан ВХҮҮ-ийн удирдлагын чанартай байдлын талаарх дүгнэлтийг мэдээлэх зорилгоор ВХҮҮ-ийн МУТСТ хөтөлбөрт харьцуулсан дүн шинжилгээг хийнэ.
246. ЭСА-ын агуулгын хүрээнд хянан шалгагчид нь ВХҮҮ-ийн МУТСТ комплаенс болон эрсдлийг зохицуулах хөтөлбөр нь хангалттай хэмжээнд (i) удирдлагын шаардлагуудыг хангасан (ii) холбогдох эрсдэлийг зохих ёсоор, үр дүнтэйгээр удирдаж бууруулсан байгаа эсэхийг тодорхойлох шаардлагатай. Ингэж тодорхойлохдоо хянан шалгагчид нь ВХҮҮ-ийн өөрсдийн эрсдэлийн үнэлгээг харгалзан үзэх болно. Олон төрлийн бүртгэл, тусгай зөвшөөрөл ашиглаж бусад улс оронд үйл ажиллагаа эрхлэгч ВХҮҮ, хил дамнасан ВХ-ийн үйл ажиллагааны тохиолдолд ВХҮҮ-ийг хувь хүн, хуулийн этгээдээр бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох хянан шалгагч нь ВХҮҮ-ийг МУТС үйл ажиллагаанд өртөх эрсдэл, түүнийг зохих ёсоор бууруулсан байгаа эсэхийг харгалзан үзнэ.
247. Хянан шалгагч нь ВХҮҮ-тэй МУТСТ хяналтын талаарх дүгнэлт, саналыг мэдээлэх бөгөөд холбогдох хууль эрх зүйн хүрээнд хүлээх үүргийг биелүүлэхийн тулд авах арга хэмжээтэй холбогдон үүсэх хүлээлтийн талаар мөн хуваалцах шаардлагатай. ВХ-ийн санхүүгийн үйл ажиллагаа нь зохицуулалттай этгээдэд хамааралтай байдаг тул улс орнуудын хувьд хянан шалгах эрх бүхий талууд нь мөн адил нэг нэгэнтэйгээ хамтран ажиллаж, хэрвээ боломжтой бол ВХҮҮ-ийн талаарх хүлээлтийг нэгтгэх хэрэгтэй. Ялангуяа энэ нь ВХҮҮ нь олон төрлийн ВХ-ийн үйл ажиллагаа эрхэлдэг (жишээ нь: ВХ-ийн МҮБЗШҮ, үнэт цаас, бараа бүтээгдэхүүн эсхүл деривативын үйл ажиллагаа), эсхүл ВХ-ийн санхүүгийн үйл ажиллагаа нь банк, үнэт цаас, төлбөрийн хэрэгслүүдийг татан оролцуулдаг тохиолдлуудад илүү чухалд тооцогдоно.
248. ВХҮҮ-дэд МУТСТ сул талууд илэрсэн тохиолдолд хянан шалгагч нар дутагдлыг арилгах, дахин давтагдахаас урьдчилан сэргийлэхийн тулд авсан арга хэмжээний нийцтэй байдлыг дахин үнэлэх шаардлагатай. Хянан шалгагч нар комплаенсийн дутагдлаас үүдсэн учирч болзошгүй эрсдэлийг арилгахад хэрэглэгдэх өргөн хүрээний хяналтын арга хэмжээ авах боломжтой байх ёстой. Энэ хүрээнд ВХҮҮ-дийн үйл ажиллагаанд сануулга өгөх, албан бичиг явуулах, мэдэгдэл өгөх, гэрээ байгуулах, захиргааны шийтгэл, торгууль ногдуулах болон бусад хязгаарлалт, арга хэмжээ багтаж болно. Гарсан зөрчлийн ноцтой байдлын түвшинд харгалзан иж бүрэн арга хэмжээ авах шаардлагатай. Салбарыг МУТС хамгийн их эрсдэлд оруулж буй дутагдлуудад нэн тэргүүнд тавих хэрэгтэй. Татгалзах, пропорционал, үр дүнтэй хориг арга хэмжээ авах талаар нэмэлт зааварчилгааг авахыг хүсвэл санхүүгийн салбар болон хууль сахиулах байгууллагын МУТСТ хянан шалгагч нарын зөрчилтэй нь дүйцэхүйц, дахин үйлдэгдэхээс сэргийлсэн, үр дүнтэй арга хэмжээний талаарх ФАТФ-ын гарын авлагыг үзнэ үү.

249. Тогтвортой койнтой холбоотой ВХҮҮ болон СБ-ууд ВХ, санхүүгийн хөрөнгийн нэгэн адил хяналт шалгалтад хамрагддаг байх шаардлагатай. Бусад ВХ-ийн нэгэн адил тэдний эрсдэлийн үнэлгээ нь энэ үйл явцын нэг хэсэг байх ёстой бөгөөд хянан шалгагч нарын дүгнэлтээр тогтвортой койн нь МУТС эрсдэл өндөр эсхүл бага байж болох бөгөөд хяналтын төрөл, давтамжид мөн үнэлгээний дүн нөлөөлнө. Хэрэв өгөгдсөн тогтвортой койн нь санхүүгийн хөрөнгөнд хамаарах бол бусад ижил ангилалд хамаарах хөрөнгийн нэгэн адилаар уг тодорхойлолтын дагуу хяналт шалгалт хийнэ. ВХ хил дамнасан шинж чанарыг харгалзан ВХҮҮ-ийн хянан шалгагчдын олон улсын хамтын ажиллагаа энэ хүрээнд маш чухал юм.

Гарын авлага

250. Хянан шалгагчид нь ВХҮҮ-ийн комплаенсын талаарх хүлээлтийг холбогдох хууль эрх зүйн чиг үүргүүдтэй нийцүүлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд холбогдох талуудтай зөвлөлдөх арга хэмжээг авна. Энэхүү гарын авлагад үр дүнд суурилсан чухал шаардлагууд, эрсдэлд суурилсан үүрэг хариуцлага, болон хянан шалгагчид нь хэрхэн холбогдох хууль, журмыг ойлгож байгааг болон ВХҮҮ нь МУТСТ хяналтыг хэрхэн хамгийн сайнаар хэрэгжүүлэх боломжтой талаар мэдээллийг багтаасан байна.

251. Хянан шалгагчид болон бусад эрх бүхий байгууллагууд энэхүү гарын авлага, ВХ-ийн техникийн мэргэжилтнүүдийн тайлбарыг холбогдох ВХҮҮ-ийн бизнес модель, үйл ажиллагааны талаар илүү гүнзгий ойлголттой болох зорилгоор, мөн ВХ-ийн тодорхой нэг төрөл, үйл ажиллагааны МУТС эрсдэлийг ойлгох, эрсдэлийг бууруулахад шаардлагатай арга хэмжээний талаар ойлголттой дүгнэлт хийх зорилгоор танилцдаг.

252. Дээр дурдсанчлан ВХҮҮ-ийн салбарыг гарын авлагаар хангаж, эргэх холбоо үүсгэх нь 3.34-ийн хүрээнд тавигдах шаардлагыг биелүүлэхэд чухал ач холбогдолтой. Гарын авлагад аливаа ВХҮҮ нь хэрхэн эрсдэлийн үнэлгээг хийж, түүнийгээ бууруулан холбогдох хууль эрх зүйн хүрээнд хүлээсэн үүргээ биелүүлж комплаенсын удирдлагын системийг сайжруулж байгаа тухай сайн туршлагыг багтаасан байвал зохино. Хянан шалгагч болон ВХҮҮ-ийн хооронд цаг тухайд нь үр дүнтэй харилцаа холбоо тогтоох нь ЭСА-ыг амжилттай хэрэгжүүлэх суурь болох ач холбогдолтой.

253. ВХҮҮ-ийн хянан шалгагч нар нь бусад дотоодын зохицуулах, хянан шалгах зохицуулалттай этгээдүүдтэй харилцан уялдаатай ажиллаж, ВХҮҮ-ийн хооронд болон ВХҮҮ, бусад зохицуулалттай этгээд болох СБ, СББМҮҮ хоорондын зохицуулах хүрээ хязгаар, ВХҮҮ-ийн хуулийн хүрээнд хүлээсэн үүргийг уялдаа холбоотойгоор тайлбарлах нь чухал юм. Энэ нь нэгээс илүү хянан шалгах байгууллага хяналт шалгалтын ажиллагааг хариуцах тохиолдолд чухал ач холбогдолтой (МУТСТ хянан шалгагч тусдаа байгууллага юм уу нэг байгууллагын өөр нэгж байх гэх мэт). Мөн ВХҮҮ нь олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлдэг бөгөөд тэр нь тухайн улсын хянан шалгах, зохицуулах өөр өөр эрх бүхий байгууллагад харьяалагддаг бол илүү чухал байна. Гарын авлагын олон төрлийн эх үүсвэртэй байх нь аливаа зохицуулалтын арбитр, цоорхой эсхүл ВХҮҮ дунд эргэлзээ үүсгэхгүй байвал зохино. Боломжтой бол холбогдох зохицуулах, удирдах эрх бүхий байгууллага нь хамтарсан удирдамж боловсруулах хэрэгтэй.

Сургалт

254. Хянан шалгалт хийх ажилтан, удирдах албан тушаалтнаас эхлээд менежер, удирдах зөвлөлийн гишүүд хүртэлх бүх түвшинд хянан шалгагч нарын ВХҮҮ-ийн салбарыг ойлгох, ялгаатай бизнес моделиудын мэдээлэл авах сургалтыг хийх нь чухал юм. Ялангуяа хянан шалгах ажилтнууд нь ВХҮҮ-ийн МУТС эрсдэлийн үнэлгээний чанарыг үнэлэх, эрсдэлийн үнэлгээг хийхдээ ВХҮҮ-ийн МУТСТ бодлого, журам, дотоод хяналтын үр ашигтай, үр дүнтэй, тохиромжтой байдлыг үнэлэхэд хангалттай бэлтгэгдсэн эсэхэд анхаарах нь зүйтэй. Блокчэйн болон бусад аналитик зэрэг одоогийн болон шинээр гарч ирж буй технологиудын талаар сургалт явуулах нь бас хэрэгтэй байж болох юм.
255. Сургалт нь хяналт шалгалтын ажилтнуудад ВХҮҮ-ийн эрсдэлийн үнэлгээний чанар, ВХҮҮ-ийн МУТСТ хяналтыг тэнцвэржүүлэх, пропорционал байдлын талаар зөв дүгнэлт гаргах боломжийг олгоно. Түүнчлэн олон эрх бүхий байгууллага эсхүл хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллагын хөгжил сул, тарсан бүтэцтэй үед үндэсний хэмжээний хяналт шалгалтын нэгдмэл байдлыг хангах зорилготой.
256. Үүнтэй адилаар улс орнууд төр, хувийн хэвшлийн сургалтын боломжуудыг авч үзэх хэрэгтэй бөгөөд ВХ болон ВХҮҮ-ийн үйл ажиллагаатай холбогдсон олон төрлийн асуудлуудыг салбарын болон зохицуулалттай этгээдүүдэд таниулж, цаашдын боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр хамтран ажиллах хэрэгтэй.

Мэдээлэл солилцоо

257. Төрийн болон хувийн хэвшлийн хоорондын мэдээлэл солилцоо нь чухал бөгөөд ВХ, ВХҮҮ-ийн үйл ажиллагааны хүрээнд улс орны МУТСТ стратегийн салшгүй хэсэг болно. Төрийн байгууллагууд эрсдэлийн мэдээллийг боломжтой тохиолдолд ВХҮҮ-ийн эрсдэлийн үнэлгээнд тусалцаа болгон хуваалцах хэрэгтэй. Төр, хувийн хэвшлийн хуваалцаж болох ВХ-тэй холбоотой эрсдэлийн мэдээллийн төрөл нь дараах мэдээллүүд байна. Үүнд:
- а) МУТС эрсдэлийн үнэлгээ;
 - б) Мөнгө угаагчид болон террорист этгээдүүд хэрхэн ВХҮҮ-ийг зүй бусаар ашиглаж байгаа, хэрхэн ВХ-ийн зохих механизмыг нөгөөд нь зүй бусаар ашиглаж байгаа эсхүл ВХ-ийг хэрхэн буруугаар ашиглаж байгаа арга зүй, аргачлал, типологи;
 - в) СГТ болон бусад холбогдох тайлангуудын чанар, ашигт байдалд өгсөн ерөнхий санал хүсэлт;
 - г) ВХ-ийн үйл ажиллагаа, ВХҮҮ-ийн гүйлгээтэй холбоотой сэжигтэй шинж тэмдгийн талаарх мэдээлэл;
 - д) Шаардлагатай тохиолдолд нууцлалын гэрээ зэрэг холбогдох хамгаалалтаар хамгаалагдсан зорилтот бус санхүүгийн мэдээлэл;

е) 3.6-д заасны дагуу санхүүгийн зорилтот хориг арга хэмжээнд орсон улс, хувь хүн болон байгууллагын хөрөнгө, гүйлгээг царцаах шаардлагатай.

258. Цаашлаад улс орнууд хувийн хэвшил, тэр дундаа ВХҮҮ-дэд хууль сахиулах байгууллагаас ирүүлсэн мэдээллийн хүсэлт эсхүл бусад засгийн газраас ирүүлсэн хүсэлт зэргийн гол агуулгыг нь ойлгоход нь туслах зорилгоор хувийн хэвшлийн байгууллагуудтай хэрхэн мэдээлэл хуваалцах талаар авч хэлэлцэх нь зүйтэй. Ингэснээр ирүүлсэн хүсэлтийн дагуу ВХҮҮ-д эрх бүхий байгууллагыг илүү нарийвчилсан, тодорхой мэдээллээр хангаж чадна.

259. Банк, үнэт цаас, бараа бүтээгдэхүүн, деривативын салбар мөн ВХҮҮ-ийн хяналтын ажилтнуудын хоорондын дотоод хамтын ажиллагаа болон мэдээлэл солилцоо; хууль сахиулах байгууллага, СМА болон ВХҮҮ-ийн хяналтын ажилтнуудын дотоод хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоо; түүнчлэн СМА болон ВХҮҮ-ийн хянан шалгагчдын хоорондын дотоод хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоо нь ВХҮҮ-ийн хяналт шалгалтыг үр дүнтэй хийхэд чухал үүрэгтэй.

260. Үүнтэй адилаар, 3.40-ийн дагуу, улс орнуудын зохицуулалттай этгээдүүд мөн хувийн хэвшлийн байгууллагууд олон улсын түншүүдтэй хил дамнасан мэдээлэл солилцох нь ВХҮҮ-ийн салбарын хил дамнасан шинж чанар, олон улсын хүртээмжийг харгалзан үзэх чухал ач холбогдолтой юм. ВХҮҮ-ийн хянан шалгагч нарын хамтын ажиллагааны талаар нэмэлт удирдамж авахын тулд эрх бүхий байгууллагууд мэдээлэл хуваалцах, хамтран ажиллах зарчмуудыг сайжруулах хэрэгтэй (Бүлэг 4-ийг үзнэ үү).

БҮЛЭГ ДӨРӨВ: ВХҮҮ-ДЭД БОЛОН ВХ-ИЙН ЗАРИМ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛДЭГ, ЭСХҮЛ ОРОЛЦДОГ ЭТГЭЭДҮҮДЭД ФАТФ-ЫН СТАНДАРТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

261. ФАТФ-ын зөвлөмжүүдийг улс орнууд, ВХҮҮ, ВХ-тэй холбоотой санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч (“бусад зохицуулалттай этгээд”) буюу банкууд, үнэт цаасны брокер дилерүүд, болон бусад СБ-ууд дагаж мөрдөнө. Иймээс Бүлэг 4 нь ВХ-ийн үйл ажиллагааг хамарсан ВХҮҮ, бусад зохицуулалттай этгээдүүдийг тусгайлсан нэмэлт удирдамжаар хангана.

262. 3.1-т заасан ВХҮҮ, бусад зохицуулалттай этгээдүүд МУТС эрсдэлийг илрүүлэх, үнэлэх, үр дүнтэй арга хэмжээ авахаас гадна Бүлэг 3-т тодорхойлсон ХТМ-тэй холбоотой 3.9-3.21-т заасан урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой. Үүний адилаар, ЗТ.15-ын 227-228-д зааснаар СББМҮҮ-д ВХ-ийг хамарсан үйл ажиллагаанд оролцох үедээ МУТСТ үүргээ сайтар ухамсарласан байх шаардлагатай.

263. Энэхүү гарын авлагын уншигчид урьдчилан сэргийлэх арга хэмжээ, ФАТФ-ын зөвлөмжүүдтэй холбоотой дараах хэсгүүд нь ВХҮҮ, бусад зохицуулалттай этгээдүүдийг тодорхой асуудлаар нэмэлт нарийвчилсан зааварчилгаагаар хангах зорилготой гэдгийг санах нь зүйтэй. Жишээлбэл Бүлэг 3-т тодорхойлсон урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд ФАТФ-ын зөвлөмж тус бүрээр гаргасан хэсэг байхгүй байгаа нь тухайн зөвлөмжийг эсхүл тухайн урьдчилан сэргийлэх арга хэмжээг дагаж мөрдөх ёстой ВХҮҮ, болон бусад зохицуулалттай этгээдүүд хэрэгжүүлэхгүй гэсэн үг биш юм.

264. Ерөнхийдөө 3.9-3.21-д заасан урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийн хоёр тусгай шинж чанараас бусад нь ижил нөхцлөөр ВХҮҮ-д хамаарна. Нэгдүгээрт, ВХҮҮ-ээс ХТМ үйл ажиллагаа явуулахад шаардагдах гүйлгээний босго дүн 1,000 ам.доллар/евро (15,000 ам.доллар/евро биш) байна. Хоёрдугаарт, 3.16-д заасан шилжүүлгийн дүрмүүд нь арай өөр хэлбэрээр ВХҮҮ болон ВХ-ийн шилжүүлэгт хамаарна (шилжүүлэгийн дүрэм “travel rule”). Үүнийг доор дэлгэрэнгүй тайлбарласан болно.

Харилцагчийг таниж мэдэх

265. 3.10-т зааснаар СБ нь бүх харилцагчиддаа ХТМ арга хэмжээг авах шаардлагатай бөгөөд үүнд харилцагчийг таних, баталгаатай эх үүсвэртэй бичиг баримтууд, дата мэдээллийг ашиглан харилцагчийг баталгаажуулах; эцсийн өмчлөгчийг илрүүлэх; бизнесийн харилцааны гол зорилгын талаарх мэдээллийг олж авах, хадгалах; бизнесийн харилцааг таньж мэдэх болон гүйлгээний мэдээллийг нягт нарийн судлах арга хэмжээнүүд багтана.

Харилцагчийг таньж мэдэх арга хэмжээг хэзээ авах вэ?

266. 3.10-т заасны дагуу санхүүгийн байгууллагууд ХТМ арга хэмжээг дараах тохиолдлуудад заавал авч хэрэгжүүлнэ. Үүнд: бизнесийн харилцаа тогтоох үед; байнгын бус гүйлгээний дүн нь богсо дүн болох 1,000 ам доллар/евроогоос дээш бол; эсхүл ЗТ.16-д хамаарах нөхцөлөөр хийсэн цахим шилжүүлэг бол; МУТС гэж сэжиглэх үндэслэл байгаа бол; мөн харилцагчийн талаар өмнө нь авсан мэдээлэл бүрэн бус, бодит бус гэх эргэлзээ СБ-д төрсөн бол ХТМ арга хэмжээг заавал авна. Улс орнууд өөрсдийн тогтолцоотой уялдуулан ВХ-ийн шилжүүлэг, байнгын бус ВХ-ийн гүйлгээнд босго дүн болох 1,000 ам.доллар/еврог батлах ба энэ нь 3.16-д заасан хил дамнасан цахим шилжүүлэгт тооцогдох бөгөөд банкууд, брокер дилерүүд болон бусад СБ-ууд ВХ-нд хамаарах үйл ажиллагаа явуулах үедээ ХТМ-тэй холбоотой хүлээсэн үүргээ заавал биелүүлэх шаардлагатай. ВХ-ийн үйл ажиллагаатай холбогдсон казино зэрэг СББМҮҮ-ийн байнгын бус гүйлгээний дүн нь босго дүн болох 1,000 ам.доллар/евроогоос дээш давсан бол, эсхүл Бүлэг 3-т дурдсанчлан байнгын бус гүйлгээ нь цахим шилжүүлгээр хийгдсэн бол мөн адил ХТМ үүрэг хүлээнэ. Бүлэг 3-т тэмдэглэсэнээр улс орнууд, ВХҮҮ-чид харилцагчтай гэрээ хийх, гүйлгээ хийхэд дэмжлэг үзүүлэх зэрэг өөрийн үйл ажиллагааны горим, үйл явцыг тогтоохдоо хэрхэн нэг удаагийн эсхүл байнгын бус гүйлгээг тогтмол хийгддэг гүйлгээнээс ялгаж, баталгаажуулах тал дээр анхаарах хэрэгтэй.

267. Казино болон үнэт металл, үнэт чулуу арилжаалагчийн байнгын бус гүйлгээ нь харилцан 3,000 ам.доллар/евро болон 15,000 ам.доллар/евроогоос давсан тохиолдолд ХТМ арга хэмжээг заавал авах шаардлагатай бөгөөд СББМҮҮ нь ямар нэг ВХ, ВХҮҮ-тэй холбогдсон бол ЗТ.15-д зааснаар ХТМ арга хэмжээний наад захын шаардлагыг биелүүлэх хэрэгтэй.

Харилцагчийг таньж мэдэх арга хэмжээг хэрхэн авах вэ?

268. Харилцаа холбоо, гүйлгээний хэв шинжээс үл хамааран ВХҮҮ болон бусад зохицуулалттай этгээдүүд үр дүнтэйгээр хэрэгждэг ХТМ журамтай байх ба бизнесийн харилцаа тогтоох үед, МУТС байж болзошгүй гэж үзэх сэжиглэх үндэслэлтэй үед, босго хэмжээг давсан гүйлгээ хийгдэх үед, мөн харилцагчаас өмнө нь авсан мэдээлэл бүрэн бус, бодит бус гэх эргэлзээ төрсөн тохиолдолд харилцагчийг танихын тулд эрсдэлд суурилсан тус дүрэм журмыг баримтлан ажиллана.
269. Бусад зохицуулалттай этгээдүүдтэй нэгэн адил, ВХҮҮ нь 3.10-ын дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд ХТМ мэдээлэл, баталгааг хуулийн хүрээнд олж авна. ХТМ шаардлагатай мэдээлэлд ерөнхийдөө харилцагчийн нэр, цаашлаад оршин суугаа хаяг, төрсөн он сар өдөр, регистрийн дугаар, паспортын дугаар зэрэг мэдээллүүд багтдаг. Хууль эрх зүйн хүрээний шаардлагаас хамааран ВХҮҮ-дийг бизнесийн харилцаа тогтоох; харилцагчийн дансанд итгэмжлэлээр нэвтрэх; бизнесийн харилцааг таних болон бизнесийн эрсдэлийн нөхцөл байдлыг тодорхойлоход туслах; мөн харилцагч, түүний санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой МУТС эрсдэлийг тодорхойлох зэрэг үйл ажиллагаа хийгдэх үед харилцагчийг илүү сайн танихын тулд нэмэлт мэдээллүүд цуглуулах хэрэгтэй байдаг. Зарим ВХҮҮ-ийн цуглуулж байгаа нэмэлт мэдээллүүдэд жишээлбэл тухайлсан цаг хугацааны тамгатай IP хаяг, газарзүйн байршлын мэдээлэл, төхөөрөмжийн тодорхойлогч, ВХ-ийн хэтэвчний хаяг болон гүйлгээний бүртгэлийн дугаар зэрэг мэдээллүүд багтаж байна.
270. ВХ-ийг хамарсан үйл ажиллагааны хувьд харилцагчийн болоод эцсийн өмчлөгчийн мэдээллийг ВХҮҮ нь шинэ харилцаа үүсгэхээс өмнө, эсхүл үүсгэж байх явцдаа олж авах хэрэгтэй.
271. ВХҮҮ нь зохих түвшинд ХТМ арга хэмжээг авч чадахгүй тохиолдолд 3.10-ын дагуу ВХҮҮ-ийг бизнесийн харилцаанд оролцохоос татгалзах, тогтмол бус гүйлгээ хийхгүй байх, эсхүл өмнө үүссэн бизнесийн харилцааг зогсоохыг; мөн үйлчлүүлэгчтэй холбоотой СГТ мэдээлэхийг зөвлөдөг.
272. ХТМ арга хэмжээг хэрэгжүүлэх замаар олж авсан цогц мэдээлэлд суурилан ВХҮҮ болон бусад зохицуулалттай этгээд нь зохих тохиолдлуудад харилцагчийн эрсдэлийн мэдээллийг (risk profile) бэлдэхэд бэлэн байх хэрэгтэй. Харилцагчийн эрсдэлийн мэдээллийг ашиглаж хяналтын шаардлагатай түвшин, төрөл зэргийг тодорхойлох бөгөөд цаашид тухайн бизнесийн харилцааг тогтоох, үргэлжлүүлэх, зогсоох эсэхийг шийднэ. Эрсдэлийн төлөв нь харилцагчийн түвшинд болон бүлгийн түвшинд хийгдэж болох бөгөөд бүлгийн түвшинд хамаарах харилцагчид нь нэг төрлийн шинжээрээ нэгдсэн байна. ВХҮҮ нь ХТМ зохих түвшнийг тодорхойлохын тулд бизнесийн харилцаан дахь харилцагчийн эрсдэлийн төлөвийг тогтмол шинэчлэх шаардлагатай.
273. Хэрэв ВХҮҮ нь цаашид бизнесийн харилцаа үргэлжлүүлэхгүй болсон эсхүл МУТС эрсдэлтэй гэж үзсэн ВХ-ийн хаягийг ил болгосон тохиолдолд тухайн улсын ВХҮҮ-ийн хууль эрх зүйн хүрээнд “ВХ-ийн хар жагсаалт”-д тухайн ВХ-ийг оруулах хэрэгтэй. ВХҮҮ нь харилцагч болон харилцагчийн хэтэвчний хаягийг хар жагсаалтад орсон эсэхэд хяналт тавьж байнгын мониторингийн нэг хэсэг болгон ажиллах ёстой. ВХҮҮ нь эрсдэлд суурилсан үнэлгээг хийж, эрсдэл үүссэн тохиолдолд нарийвчилсан үйл

ажиллагаа эсхүл урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай эсэхийг тодорхойлох ёстой.

274. ВХ-ийн үйл ажиллагаанд хамаарах ВХҮҮ-д болон бусад зохицуулалттай этгээдүүд нь ХТМ арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэхийг тохируулах бөгөөд энэ нь тухайн улс орны хууль эрх зүйн хүрээнд заагдсан шаардлагуудтай болон дээр дурдагдсан 3.1-ийн шаардлагуудтай нийцсэн байх хэрэгтэй. ВХҮҮ болон бусад зохицуулалттай этгээдүүд нь Бүлэг 3-т тодорхойлсноор бизнесийн харилцаа, ВХ-ийн үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй бол харилцагчаас авах мэдээллийн цар хүрээг нэмэгдүүлэх шаардлагатай. Нөгөө талаас хэрвээ илэрсэн эрсдэл нь бага бол харилцагчаас авах мэдээллийг хялбаршуулсан байдлаар хийж болно. Гэсэн хэдий ч ВХҮҮ-д болон бусад зохицуулалттай этгээдүүд нь ВХ-ийн үйл ажиллагаа, үйлчилгээ үзүүлдэг хувь хүн, хуулийн этгээд нь хааяа эсхүл маш хязгаарлагдмал байдлаар үйл ажиллагаа явуулдаг гэх үндэслэлээр хялбаршуулсан ХТМ арга хэмжээ буюу бусад урьдчилан сэргийлэх арга хэмжээнээс чөлөөлөхийг хориглоно. Түүнчлэн МУТС эрсдэл байгаа эсхүл өндөр эрсдэл бүхий тохиолдлуудад ХТМ хялбаршуулсан арга хэмжээг хэрэгжүүлж болохгүй.

Тогтмол ХТМ арга хэмжээ ба хяналт

275. Эрсдэлд суурилсан тогтмол хяналт шалгалт гэдэг нь аливаа ВХҮҮ-ийн харилцагчийн бизнесийн харилцааны зорилго, мөн чанар болон харилцагчийн мэдээллийг хийгдэж буй гүйлгээтэй нийцэж байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор тус гүйлгээг нарийвчлан судлахыг хэлнэ. Гүйлгээний хяналтад харилцагчийн төлөвийн мэдээллийн өөрчлөлтийг тодорхойлж шинэчлэх, ХТМНАХ авах шаардлагатай эсэхийг тодорхойлох үйл ажиллагаа хамаарна. ВХ-ийн гүйлгээний хүрээнд хяналт тавьж сэжигтэй гүйлгээг илрүүлэх нь чухал юм.

276. Хяналт шалгалт нь тасралтгүй явагдах бөгөөд тодорхой нэг гүйлгээнээс улбаалан эрчимжиж болно. Өндөр дүнтэй гүйлгээ тогтмол хийгддэг тохиолдолд автоматжуулсан систем нь илүү тохиромжтой бөгөөд сэжигтэй гүйлгээ дээр дүн шинжилгээ хийх хэрэгтэй. ВХҮҮ болон бусад зохицуулалттай этгээдүүд нь өөрсдийн үүргийг ухамсарлан өдөр тутмын үйл ажиллагааг шударгаар явуулах бөгөөд ВХ-ийн бүтээгдэхүүн үйлчилгээ, үйл ажиллагааны МУТС эрсдэлийг тооцдог эсэхийг шалгана.

277. ВХҮҮ, бусад зохицуулалттай этгээдүүд нь салбарын эрсдэлийн үнэлгээ болон бие даасан харилцагчийн эрсдэлийн төлөвт нийцүүлэн хяналтын тогтолцооны цар хүрээ, түвшинг тодорхойлно (жишээ нь: зохицуулалтгүй хэтэвчний гүйлгээ). Нарийвчилсан хяналт шалгалтыг өндөр эрсдэлтэй нөхцөл байдалд хийх шаардлагатай (Бүлэг 2 ба 3-т тайлбарласан болно). ВХҮҮ болон бусад зохицуулалттай этгээдүүд нь өөрсдийн хяналтын тогтолцооны цар хүрээ, түвшинг МУТСТ эрсдэлийн хөтөлбөртэй байнга холбоотой байлгахын тулд тогтмол шалгаж байх хэрэгтэй.

278. ЭСА-ын хүрээнд хяналт шалгалтыг хийх нь ВХҮҮ, бусад зохицуулалттай этгээдүүдэд мөнгөн эсхүл бусад босго дүнг тогтоож ямар үйл ажиллагааг шалгах шаардлагатайг тодорхойлох боломжийг олгодог. ВХҮҮ болон бусад зохицуулалттай этгээдүүд нь хэрэглэгчдийг ангилахад ашиглагддаг шалгуур үзүүлэлт, параметруудийг тодорхойлж, баримтжуулах ба хэрэв боломжтой бол харилцагчийн бүлэг тус бүрт

эрсдэлийн түвшинд хамааруулсан хуваарилалтыг тодорхойлох хэрэгтэй. Ялгаатай харилцагчийн сегмент бүрт хийх хяналт шалгалтын давтамж, эрчим зэргийг тодорхойлох шалгуур үзүүлэлт нь мөн адил ил тод байх хэрэгтэй. Эцэст нь ВХҮҮ болон бусад зохицуулалттай этгээд нь зохих ёсоор баримтжуулж, хадгалж, холбогдох ажилтнууд болон үндэсний эрх бүхий байгууллагатай өөрсдийн хяналтын үр дүнгийн талаар харилцаж байх хэрэгтэй.

Улс төрд нөлөө бүхий этгээд (УТНБЭ)

279. **Зөвлөмж 12.** Дотоодын болон олон улсын байгууллагын УТНБЭ-ийн хувьд ВХҮҮ зэрэг зохицуулалттай этгээдүүд нь харилцагч эсхүл эцсийн өмчлөгч нь дотоодын эсхүл олон улсын байгууллагын УТНБЭ мөн эсэхийг тодорхойлох арга хэмжээг авч, бизнесийн харилцааны эрсдэлийг үнэлэх шаардлагатай. УТНБЭ-ээс үүдсэн өндөр эрсдэлтэй бизнесийн харилцааны хүрээнд ВХҮҮ-д болон бусад зохицуулалттай этгээдүүд нь гадны УТНБЭ-үүдэд авч хэрэгжүүлэх нэмэлт арга хэмжээг мөн адил хэрэгжүүлнэ.

Корреспондент банк болон бусад ижил төрлийн харилцаа

280. **Зөвлөмж 13.** “Корреспондент банк” нь нэг удаагийн гүйлгээг агуулдаггүй (Бүлэг 3-ын 3.13-ыг үзнэ үү), харин байнгын, давтагдах шинж чанартайгаараа онцлог юм. ВХҮҮ-д хил дамнасан корреспондент **харилцаанд** оролцоходоо ХТМ үйл ажиллагааг нарийвчилсан байдлаар хэрэгжүүлэх, өөрийн хяналтын тогтолцоог бүрдүүлэхийг шаарддаг. ЗТ.13-т корреспондент банк болон бусад ижил төстэй хил дамнасан харилцааны хувьд СБ нь 3.13-ын (а)-(е) хүртэлх шалгууруудыг ХТМ нарийвчилсан үйл ажиллагаанд хэрэгжүүлэх хэрэгтэй гэж заасан байна. Мөн 3.16-д ВХҮҮ-дийн харилцагчаа үнэлэх нэмэлт мэдээллийг тусгасан болно.

Цахим шилжүүлэг ба шилжүүлэгийн дүрэм

281. **Зөвлөмж 16.** Бүлэг 3-т тэмдэглэснээр 3.16-д заасан шаардлагуудад нийцүүлэх бөгөөд энэ нь сэжигтэй гүйлгээг илрүүлэх, тайлагнах зорилгоор ВХ-ийн гүйлгээтэй холбоотой хүлээн авагчийн **мэдээллийг** олж авах, хадгалах, дамжуулах, мөн царцаах үйл ажиллагааг явуулах, тухайлсан хувь хүн, хуулийн этгээдийн гүйлгээг түдгэлзүүлэх зэрэг чиг үүргүүдийг биелүүлнэ. Энэхүү шаардлагууд нь харилцагчийн нэрийн өмнөөс ВХ-ийн гүйлгээг шилжүүлэх, хүлээн авах үед ВХҮҮ-дэд болон бусад зохицуулалттай этгээдүүд болох СБ-дад бүгдэд нь хамаарна.

Өгөгдөлийг хянах технологи

282. ФАТФ нь технологийн хувьд төвийг сахисан байр суурьтай байдаг. Өмнө дурдсанчлан МУТСТ чиг үүргүүдтэй нийцэж байгаа тохиолдолд ямар ч технологи, програм хангамжийг ашиглаж болно.

283. Эдгээр технологийн шийдлүүд нь ВХҮҮ-ийн шилжүүлгийн дүрмийг үр дүнтэй, үр ашигтайгаар дагаж мөрдөх, дараах үндсэн үйл ажиллагааг гүйцэтгэх боломжийг олгох ёстой. Үүнд:

а. ВХ-ийн шилжүүлэг хийхийн тулд харилцагч ВХҮҮ-д ВХҮҮ-ийг тодорхойлох боломжийг бүрдүүлж өгөх;

б. DLT (distributed ledger technology) платформ дээр ВХ-ийн шилжүүлэг хийх үед шаардлагатай бөгөөд үнэн зөв эх сурвалжийн буюу хүлээн авагчийн мэдээллийг нэн даруй илгээх боломжийг олгох;

в. ВХҮҮ-д тогтвортой байдлаар олон чиглэлд, их хэмжээний гүйлгээ хийх боломжийг олгох;

г. ВХҮҮ-д өгөгдлийг найдвартай дамжуулах, өөрөөр хэлбэл бүртгэл хөтлөлтийг хөнгөвчлөхийн тулд шаардлагатай мэдээллийн бүрэн бүтэн байдал, хүртээмжийг хамгаалах;

д. Мэдээллийг хамгаалах үүднээс ВХҮҮ эсхүл бусад зохицуулалттай этгээдүүдийг үндэсний аюулгүй байдал, нууцлал, мэдээлэл хамгаалах хууль тогтоомжийн дагуу зөвшөөрөлгүй задруулахаас хамгаалах;

е. Харилцагч ВХҮҮ-д зохих ХТМ арга хэмжээг авах, өндөр эрсдэлтэй гүйлгээ эсхүл хориглосон үйл ажиллагаатай холбоотой эсэхийг тодорхойлохын тулд гүйлгээний талаарх мэдээллийг шаардах гэх мэт зорилгоор харилцагч ВХҮҮ-ийг харилцааны сувгаар хангах.

284. ВХҮҮ-чид эсхүл зохицуулалттай этгээд нь дээрх харилцааны сувгаар дамжуулан олж авсан мэдээлэлд дүн шинжилгээ хийн, гүйлгээг үр дүнтэй шалгах механизмыг хэрэгжүүлж СГТ-д тусгах ёстой. Үүнийг харилцагчийн бусад мэдээлэл, гүйлгээний түүх болон өөрийн эсхүл харилцагч ВХҮҮ-с авсан гүйлгээний нэмэлт мэдээллийг нэгтгэх замаар хийж болно. ВХҮҮ нь хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үүргээ биелүүлэх үүднээс гүйлгээг шалгаж баталгаажуулах ёстой. Дэлгэрэнгүй нэмэлт мэдээллийг энэхүү гарын авлагын 3.16-ын 3-р хэсэгт тусгасан болно. ВХҮҮ эсхүл зохицуулалттай этгээдүүд шилжүүлгийн дүрмийг дагаж мөрдөх технологийн шийдлийг сонгохдоо дээрх хяналтын зохицуулалтыг анхаарч үзэх хэрэгтэй.

285. ВХҮҮ болон ВХ-ийн гүйлгээ хийдэг бусад зохицуулалттай этгээд нь шилжүүлэгч эсхүл хүлээн авагч байгууллага байхаас үл хамааран одоогийн боломжит арилжаанд ашиглаж буй тоног төхөөрөмжүүд нь 3.16-д заасан шаардлагуудыг хэрхэн хангаж байгааг авч үзэх хэрэгтэй. ВХ-ийн гүйлгээний хүлээн авагчийг тодорхойлох, шилжүүлэгч эсхүл хүлээн авагчийн шилжилт зэрэг DLT талбарт ВХ-ийн гүйлгээг хийхээс өмнө бодит цаг хугацаанд хийх боломжийг үйлчилгээ үзүүлэгчдэд нээж өгч байгаа технологүүдын жишээг дараах жагсаалтад харуулав. Үүнд:

а) Нийтийн болон хувийн шифрлэлтийн түлхүүр ашиглах. Энэ нь дамжуулагч талууд нь хоорондын холбоог үүсгэж мэдээлэл дамжуулалтын эхний хэсгийг шифрлэх бөгөөд ингэснээр мэдээлэл илгээгч болон хүлээн авагч нь зөвхөн шифрлэлтийг тайлж мэдээллийг унших боломжтой болно. Нийтийн түлхүүр нь бүх хүмүүст нээлттэй байдаг бол хувийн түлхүүрийг зөвхөн түлхүүр үүсгэгч нь мэддэг.

б) Тээврийн давхаргын аюулгүй байдал/найдвартай залгуурын давхарга (TSL/SSL) холболтууд ашиглах. Энэ нь нийтийн болон хувийн түлхүүрийг талуудын хооронд холболт

үүсгэхэд болон и-мэйл, веб хайлт хийх, нэвтрэх эрх, санхүүгийн гүйлгээ зэрэг интернет дамжуулалт нь веб серверүүдийн хооронд дамжигдах үед аюулгүй байдлаа хадгалж үлдэхэд ашиглана.

в) Х.509 сертификат ашиглах. Х.509 гэрчилгээ нь Х.509 РКІ стандартыг ашигладаг гэрчилгээний түлхүүр, хэрэглэгч, компьютер, эсхүл үйлчилгээний таних тэмдэгтэй бөгөөд дэлхий даяар нийтийн болон хувийн хэвшилд ашиглагддаг болохыг гэрчлэх байгууллагаас удирддаг дижитал гэрчилгээ юм.

г) Х.509 шинж чанарын гэрчилгээ ашиглах. Энэ нь аливаа шинж чанарыг (нэр, төрсөн огноо, хаяг, онцгой таних дугаар зэрэг) кодолж Х.509 гэрчилгээнд криптографиклан хавсаргасан байдаг ба шинж чанарын гэрчилгээ олгох эрх бүхий байгууллага нь удирддаг.

д) АПИ технологи (API technology). Програм хангамжийг хөгжүүлэх зам, протокол, хэрэгсэл зэргийг хангахаас гадна програм хангамжийн бүрэлдэхүүн нь хэрхэн харилцан үйлчлэх зэргийг нарийвчилан тайлбарладаг.

е) Бусад арилжаанд ашиглах боломжтой технологи, чадамжид програм хангамж эсхүл дата мэдээлэл солилцох шийдлүүд.

Харилцагч ВХҮҮ-ийг тодорхойлох, хяналт шалгалт хийх

286. Бүх ВХҮҮ харилцан адилгүй. Тэдгээр нь бие даасан жижиг бизнесээс эхлээд үндэстэн дамнасан томоохон корпорац хүртэл өөр өөр хэмжээтэй байдаг. Үүний нэгэн адил ямар ч улс орны ВХҮҮ-д зориулсан МУТСТ дэглэм яг адилхан байдаггүй бөгөөд улс орнууд өөр өөр хурдаар арга хэмжээгээ нэвтрүүлж байна. Салбарын янз бүрийн аж ахуйн нэгжүүд нь бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйлчлүүлэгчид, газарзүйн байршил, ВХҮҮ-ийн хүрэн дэх МУТСТ дэглэм хуулийн этгээдийн дагаж мөрдөх хөтөлбөр зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан өндөр эсхүл бага эрсдэлтэй байх болно. ВХҮҮ өөрсдийн тодорхойлсон МУТСТ эрсдэлүүд нь тэдэнд хэрхэн нөлөөлж байгааг судалж, ойлгохыг эрэлхийлж, эдгээр эрсдэлийг бууруулах, удирдах зохих арга хэмжээг авах ёстой. Иймд эрсдэлийн үнэлгээ нь МУТСТ арга хэмжээг эрсдэлд тулгуурлан хэрэгжүүлэх үндэс суурь болдог.

287. ФАТФ-ийн ВХҮҮ-дэд тавих стандартын хэрэгжилт хангалтгүй хэвээр байгаа бол эдгээр төрлийн харилцааг зохицуулах нь цаашдын сорилт байх болно. Үүгээр хэрэгжилтийн ач холбогдлыг онцолж байгаа бөгөөд ВХҮҮ-д хэрэгжилт сул байгаа орнуудын хувьд нэмэлт хяналтын арга хэмжээг авч үзэх шаардлагатай бөгөөд тухайлбал, тэдгээр улсуудад суурилсан ВХҮҮ-тэй хийсэн гүйлгээг эрчимтэй хянах, гүйлгээнд үнийн хязгаарлалт тавих, эсхүл эрчимтэй, ойр ойрхон нарийвчлан шалгах арга хэмжээ авах шаардлагатай болно. ВХ-ийн шилжүүлгийг өөрсдийн харилцагчийн бааз доторх (жишээ нь, ижил ВХҮҮ доторх ВХ-ийн дотоод шилжүүлэг) хязгаарлах, харилцагчийн баазаас гадуурх шилжүүлгийг зөвхөн анхдагч тал баталгаажуулснаар шилжүүлэг хийх (өөрөөр хэлбэл, шилжүүлэгч болон хүлээн авагч нь нэг хүн байх) болон нарийвчилсан хяналттай гүйлгээнүүд орно. Бусдаар, ВХҮҮ нь хэрэгжүүлэх үйл явц сул эсхүл огт байхгүй улс оронд суурилсан ВХҮҮ-тэй харилцаа үүсгэх эсэх талаар хүнд шийдвэртэй тулгарч болох юм.

288. ВХҮҮ болон СБ нь энэхүү гарын авлагыг ФАТФ-ын Корреспондент банкны үйлчилгээний заавартай хамт авч үзэх ёстой. Хэдийгээр харилцагч ВХҮҮ-ийн харилцаа нь корреспондент банкны харилцаа биш байж болох ч ВХҮҮ-д дөхөм болох зохих харилцагчийн таньж мэдэх арга барилд ижил төстэй талууд байдаг. Үүний дагуу 3.13-т заасан үйл явцыг энэхүү гарын авлагат иш татсан болно.

289. ВХҮҮ нь шинэ харилцагч ВХҮҮ-тэй харилцаа тогтоохдоо 3.10, 13-т заасан мэдээллийг харилцагч ВХҮҮ-ээс шууд авч болно. Эдгээр зөвлөмжийн шаардлагын дагуу мэдээллийг баталгаажуулах ёстой. Хуулийн этгээдийн хэн болох, эцсийн өмчлөгчийг баталгаажуулах, найдвартай, хараат бус мэдээллийн эх сурвалжуудын жишээнд: аж ахуйн нэгжийн бүртгэл, эрх бүхий байгууллагаас үүсгэн байгуулж буй эсхүл зохицуулалттай байгууллагуудын жагсаалтад хадгалагдаж буй бүртгэлүүд (жишээ нь, хэрэв байгаа бол харьяалал тус бүрээр хөтөлдөг ВХҮҮ-ийн жагсаалтууд) орно.

290. Эрсдэлийн түвшний талаарх мэдээллийн боломжит эх сурвалжуудад дараах жишээнүүд орох боловч зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй: харилцагч байгууллага бизнес эрхэлж байгаа болон тэдгээрийг хэрхэн хэрэгжүүлэх талаарх тухайн улс эсхүл хост улсын МУТСТ хууль тогтоомж, дүрэм журам, олон нийтийн мэдээллийн сан, хууль эрх зүйн шийдвэр болон/эсхүл зохицуулалтын болон хэрэгжилтийн арга хэмжээ, хөрөнгийн биржид ирүүлсэн жилийн тайлан, улс орны үнэлгээний тайлан эсхүл олон улсын байгууллагаас хэвлэгдсэн бусад мэдээлэл (ФАТФ, ФАТФ-ын бүс нутгийн байгууллага, Базелийн хороо гэх мэт), ОУВС болон Дэлхийн банк, ФАТФ-аас гаргасан Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлгийн үйл явцын хүрээнд гаргасан жагсаалт, нэр хүндтэй сонин, сэтгүүл эсхүл бусад нээлттэй эх сурвалжийн цахим мэдээллийн хэрэгсэл, гуравдагч этгээдийн мэдээллийн сан, үндэсний болон үндэстэн дамнасан эрсдэлийн үнэлгээ, харилцагч байгууллагын удирдлагын мэдээлэл, комплаенсын ажилтан(ууд) болон хянан шалгагчаас олон нийтэд мэдээлсэн мэдээлэл.

291. ВХҮҮ нь харилцагчийнхаа мэдээллийг хууль бус оролцогчид эсхүл хориглогдсон байгууллагуудад өгөхөөс зайлсхийхийн тулд харилцагч ВХҮҮ-ийн МУТСТ хяналтыг үнэлэх шаардлагатай бөгөөд ВХҮҮ нь эмзэг мэдээллийг зохих ёсоор хамгаалж чадах эсэхийг авч үзэх шаардлагатай. Энэ нь ФАТФ-ын 3.13-ийн (б)-д заасан үйл явцтай төстэй боловч эрсдэлд тулгуурласан арга юм. Практикт ийм үнэлгээ хийхдээ харилцагч талын МУТСТ систем, хяналтын тогтолцоог хянаж үзэх шаардлагатай. Үнэлгээгээр харилцагч талын МУТСТ хяналт нь хөндлөнгийн аудитад (гадны болон дотоод байж болно) хамрагдаж байгаа эсэхийг баталгаажуулах ёстой. ВХҮҮ нь МУТС эрсдэлтэй гэж үзсэн үед шилжүүлгийг үргэлжлүүлэн гүйцэтгэх явцад харилцагч ВХҮҮ мэдээллийг аюулгүй дамжуулахгүй байх эрсдэлтэй гэж үзвэл харилцагчийн мэдээллийг илгээхгүй байх өөр үйл явцыг хэрэгжүүлэх боломжтой. Ийм нөхцөлд ВХҮҮ нь шаардлагатай тохиолдолд хянан шалгагчдийн зүгээс зохих ёсоор хянаж болох холбогдох үйл ажиллагааны загварыг тодорхойлох ёстой.

292. Ойлгомжтой болгох үүднээс ВХҮҮ нь 3Т.15-ын 7(б)-ын дагуу шаардлагатай мэдээллийг харилцагч талд шилжүүлэхээс өмнө харилцагч талын ВХҮҮ-д зохих шалгалт хийх шаардлагатай. ВХҮҮ нь ВХ шилжүүлэх бүрт харилцагч талын ВХҮҮ-д зохих шалгалтыг хийх шаардлагагүй. Гэсэн хэдий ч ВХҮҮ нь тогтмол давтамжтайгаар

эсхүл харилцагч талдаа мэдээлэл өгөх эсэхээс үүдсэн харилцаанд эрсдэл тулгарсан үед ВХҮҮ-ээс тодорхойлсон ЭСА-ын дагуу харилцагч талын зохих шалгалтын мэдээллийг шинэчилж байх ёстой.

Шаардлагатай мэдээллийг бүрдүүлэх

293. ЗТ.15-ын 7(б)-д заасны дагуу ВХ-ийн шилжүүлгийн үйл ажиллагаа эрхэлдэг бусад зохицуулалттай этгээдүүд шаардлагатай мэдээллийг аюулгүйгээр илгээх нь нэн чухал бөгөөд ингэснээр ВХ-ийн шилжүүлэгтэй холбоотой харилцагчийн мэдээллийг зөвшөөрөлгүй задруулахаас хамгаалж, хүлээн авагч байгууллагын сэжигтэй ВХ-ийн шилжүүлгийг илрүүлэх, царцаах арга хэмжээ авах, хоригийн жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдтэй хийх гүйлгээг хориглох зэрэг МУТСТ үүргээ үр дүнтэй биелүүлэх юм. Цаашилбал, үйлчилгээ үзүүлэгч нар шаардлагатай мэдээллийг нэн даруй, өөрөөр хэлбэл шилжүүлэгтэй нэгэн зэрэг эсхүл дагалдуулан өгөх нь чухал бөгөөд ялангуяа ВХ-ийн үйл ажиллагааны хил дамнасан шинж чанар, дэлхий даяар хамрах хүрээ, гүйлгээний хурд зэргийг харгалзан үзэх шаардлагатай. Дэлгэрэнгүй мэдээллийг Бүлэг 3-аас үзнэ үү.

294. ВХҮҮ нь ЗТ.16-т заасан үүсгэн байгуулагч болон хүлээн авагчийн мэдээллийг дамжуулах ёстой. Улс орнууд ВХ-ийн шилжүүлгийн хувьд *de minimis* босго тогтоож болох ба түүнээс доош дүнтэй гүйлгээнд МУТС байж болзошгүй гэх сэжиглэх үндэслэл байхгүй л бол шилжүүлэгч болон хүлээн авагчийн мэдээллийг баталгаажуулах шаардлагагүй. Өөрөөр хэлбэл, 1,000 ам.доллар/еврог-с доош буюу тухайн улс орнын валюттай тэнцэх хэмжээний мөнгөн дүнгээс доош ВХ-ийн шилжүүлэг хийх тохиолдолд ЗТ.16-ын шаардлагын дагуу шилжүүлэгч болон хүлээн авагчийн нэр, тус бүрийн хэтэвчний хаяг эсхүл гүйлгээний өвөрмөц лавлах дугаарыг шаардах хэрэгтэй. Түүнчлэн, МУТС байж болзошгүй гэх сэжиг үндэслэл байхгүй бол энэхүү мэдээллийг шалгах шаардлагагүй харин харилцагчтай холбоотой мэдээллийг баталгаажуулах шаардлагатай.

Зохицуулалтгүй хэтэвчнээс илгээсэн/хүлээн авсан ВХ-ийн шилжүүлэг

295. Зохицуулалтгүй этгээд (жишээ нь, зохицуулалтгүй хэтэвч) руу ВХҮҮ болон зохицуулалттай этгээд шилжүүлэг хийж болно. Ийм нөхцөлд ВХҮҮ нь өөр ВХҮҮ-ээс холбогдох мэдээллийг авч чадахгүй тул шилжүүлэгч болон хүлээн авагчийн мэдээллийг харилцагчаас авах шаардлагатай. Энэхүү шилжүүлгийг гүйлгээний хяналт, санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг дагаж мөрдөх гэх мэт ВХҮҮ-ийн МУТСТ үүргийн хүрээнд хийж гүйцэтгэнэ.

296. ВХҮҮ-д нь зохицуулалтгүй хэтэвчрүү/хэтэвчнээс ВХ-ийн шилжүүлэг хийх болон холбогдох P2P гүйлгээнээс үүсэх эрсдэлийг мэдэж байх ёстой. Ийм гүйлгээ нь нэрээ нууцлах, хөдөлгөөнт байдал, гүйлгээний хурд зэргээс шалтгаалан хууль бус оролцогчдын сонирхлыг татдаг. Тиймээс ВХҮҮ-д өөрсдийн зохицуулалтгүй хэтэвчний шилжүүлгийн талаарх мэдээллийг цуглуулж, тухайн гүйлгээ нь эрсдэлд хэр зэрэг нийцэж байгааг тодорхойлохын тулд шаардлагатай бол хяналт тавьж, үнэлж, эрсдэлд суурилсан зохих хяналтыг гүйлгээ/харилцагчид хэрэглэж сэжигтэй гүйлгээг тайлагнах үүргээ биелүүлэх ёстой (Бүлэг 3-ын 3.20-ыг үзнэ үү). ВХ/ВХҮҮ нь ФАТФ-ын стандартыг хараахан хэрэгжүүлж амжаагүй улсын харьяалалд суурилж байгаа

тохиолдолд МУТСТ зорилгоор хараахан зөвшөөрөл аваагүй/бүртгүүлээгүй, хяналтад ороогүй ВХҮҮ-ээс учирч болох эрсдэлийг харгалзан үзэхэд ижил логик хэрэгжинэ.

297. ВХҮҮ нь ЭСА-ийн дагуу зохицуулалтгүй хэтэвчтэй гүйлгээнд дараах нэмэлт хязгаарлалт, хяналт, хориг тавих боломжтой. Үүнд:

а. зохицуулалтгүй хэтэвчтэй хийх гүйлгээний улмаас учирч болох тодорхой эрсдэлийг тооцохын тулд одоо байгаа эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог сайжруулах (тухайлбал, тодорхой хэрэглэгчдийн бүртгэл, ажиглагдсан зан үйлийн хэв маяг, орон нутгийн болон бүс нутгийн эрсдэл, зохицуулагчид болон хууль сахиулах байгууллагын мэдээлэл гэх мэт); болон

б. зөвхөн ВХҮҮ, бусад зохицуулалттай этгээд болон/эсхүл ВХҮҮ-ийн найдвартай гэж үнэлэгдсэн зохицуулалтгүй хэтэвчнээс гүйлгээг хүлээн авах боломжийн талаар судлах.

Дотоод хяналт, гадаад салбар, охин компаниуд

298. **Зөвлөмж 18.** МУТСТ эрсдэлд суурилсан аргачлалыг амжилттай хэрэгжүүлж, үр дүнтэй ашиглах нь ВХҮҮ-ийн салбар дахь ЭСА-г боловсруулах, хэрэгжүүлэхэд тавих хяналтыг багтаасан удирдлагын менежментээс шууд хамаарна. 3.18-д мөн шаардлагатай бол, ялангуяа хэвийн бус гүйлгээ, үйл ажиллагааны талаар байгууллага дотроо мэдээллээ хуваалцахыг шаарддаг.

299. ВХҮҮ болон бусад зохицуулалттай этгээдүүд эрсдэлээ удирдаж, бууруулахад хангалттай хэмжээний МУТСТ хөтөлбөр, системтэй байх ёстой. МУТСТ хяналтын шинж чанар, цар хүрээ нь ВХҮҮ-ийн бизнесийн мөн чанар, цар хүрээ, нарийн төвөгтэй байдал, түүний үйл ажиллагаа, газарзүйн олон талт байдал, харилцагчийн бааз, бүтээгдэхүүн, үйл ажиллагааны дүр төрх, түүнчлэн бусад үйл ажиллагааны чиглэл бүрээрх эрсдэлийн зэрэгтэй холбоотой олон хүчин зүйлээс хамаарна.

СГТ мэдээлэх болон мэдээллийн нууцлал

300. **Зөвлөмж 20.** ВХҮҮ ба ВХ-ийн үйл ажиллагаа эрхэлдэг, энэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангадаг бусад зохицуулалттай этгээд нь хөрөнгө, гүйлгээний хэвийн бус эсхүл сэжигтэй хөдөлгөөн, түүний дотор ВХ-тэй холбоотой эсхүл түүнтэй холбоотой гүйлгээг цаашид дүн шинжилгээ хийх анхааруулах зорилгоор таньж мэдэх чадвартай байх ёстой. Гүйлгээ, үйл ажиллагаа нь албан ёсны мөнгөн тэмдэгт хооронд, виртуал хооронд, албан ёсны мөнгөн тэмдэгт болон виртуал хооронд эсхүл виртуал болон албан ёсны мөнгөн тэмдэгт хооронд гэсэн шинж чанартай эсэхээс үл хамааран хууль бус үйл ажиллагаанд оролцож болзошгүйг илтгэх үйл ажиллагаа мөн орно. ВХҮҮ болон бусад зохицуулалттай этгээд нь зохих системтэй байх ёстой бөгөөд ингэснээр эдгээр хөрөнгө, гүйлгээг цаг тухайд нь шалгаж, мөнгө, гүйлгээ нь сэжигтэй эсэхийг тодорхойлох боломжтой болно.

301. ВХҮҮ болон бусад зохицуулалттай этгээд нь СМА-нд сэжигтэй хөрөнгө, гүйлгээ, тэр дундаа ВХ, тэдгээртэй холбоотой гүйлгээний талаар эрх бүхий байгууллагаас тогтоосон журмын дагуу шуурхай мэдээлэх ёстой. ВХҮҮ болон бусад зохицуулалттай этгээдийн сэжиглэлийг нэмэгдүүлж, эцэст нь СМА-нд мэдээлэхийн тулд хэрэгжүүлж

буй үйл явцад үүнийг тусгаж өгөх ёстой. ВХҮҮ болон бусад зохицуулалттай этгээд эрсдэлд үнлэслэсэн сэжиг төрүүлэхэд хүргэдэг бодлого, үйл явцыг хэрэгжүүлэх боломжтой ч тэд гүйлгээний хэмжээ, гүйлгээ дууссан эсэхээс үл хамааран МУТС байж болзошгүй гэх үндэслэлээр сэжиглэж байгаагаа мэдээлэх ёстой. Иймд ВХҮҮ болон бусад зохицуулалттай этгээдийн сэжигтэй гүйлгээг мэдээлэх үүрэг нь эрсдэлд суурилдаггүй бөгөөд тайлагнаж байгаа үйлдэл нь тэднийг МУТС бусад үүргээс чөлөөлөхгүй. Цаашилбал, ВХҮҮ болон бусад зохицуулалттай этгээд өөр өөр харьяалалд үйл ажиллагаа явуулж байсан ч холбогдох СГТ-гийн шаардлагыг дагаж мөрдөх ёстой.

302. ЗТ.15, ЗТ.16-тай холбоотойгоор ВХҮҮ эсхүл бусад зохицуулалттай этгээд нь ВХ, ВХ-ийн шилжүүлэгч болон хүлээн авагч талын аль алиныг нь хянадаг бол ВХҮҮ эсхүл бусад зохицуулалттай этгээд нь бүх мэдээллийг харгалзаж үзэх ёстой. Мэдээлэл нь сэжигтэй эсэхийг тодорхойлохын тулд шилжүүлэгч болон хүлээн авагч талуудын аль алиных нь мэдээллийг авах, шаардлагатай бол холбогдох СМА-нд СГТ мэдүүлэх, холбогдох гүйлгээний мэдээллийг СМА-нд нээлттэй болгох ёстой. Шилжүүлэгч эсхүл хүлээн авагчийн мэдээлэл дутмаг байгаа нь ВХ эсхүл ВХҮҮ-тэй холбоотой шилжүүлэгч сэжигтэй эсэх, иймээс СМА-нд мэдээлэх шаардлагатай эсэхийг үнэлэх хүчин зүйл гэж үзэх ёстой. Энэ нь ВХ эсхүл ВХҮҮ-тэй холбоотой шилжүүлэгч оролцдог уламжлалт СБ, бусад зохицуулалттай этгээдэд мөн адил хамаарна.

303. ВХҮҮ нь ВХҮҮ болон бусад зохицуулалтгүй этгээдээс ВХ-ийн шилжүүлэгч хүлээн авсан үед харилцагчийн талаар нэмэлт мэдээлэл эсхүл харилцагчаасаа мэдээлэл авахыг хүссэн тохиолдолд харилцагчаас цаг тухайд нь шаардлагатай мэдээлэл, бичиг баримт шаардана. Харилцагч нь хариу өгөхгүй бол ВХҮҮ нь гүйлгээнийхээ найдвартай байдлыг үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй байна гэсэн болгоомжлолыг төрүүлж, ВХҮҮ-ийг тухайн харилцагч дээр СГТ мэдүүлэх асуудлыг авч үзэхэд хүргэж болзошгүй юм. Мэдээллийн хүсэлтийн дараа шаардлагатай бол харилцагчийн шинж чанар, эрсдийн профайлыг дахин үнэлж болно.

304. Гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй ВХ-ийн сэжигтэй гүйлгээний шинж тэмдгүүдийн талаарх нэмэлт мэдээллийг ФАТФ-ын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх виртуал хөрөнгийн сэжигтэй гүйлгээний шинж тэмдгүүдэд тусгасан болно. Эдгээр шинж тэмдгүүд нь ВХҮҮ болон бусад зохицуулалттай этгээдэд ВХ-тэй холбоотой сэжигтэй гүйлгээг илрүүлж мэдээлэхэд тусалдаг. Гол шинж тэмдэгт нь:

а. Нууцлалыг нэмэгдүүлдэг технологийн онцлогууд – холих болон хөрвүүлэх гэх мэт;

б. Газарзүйн эрсдэлүүд - гэмт хэрэгтнүүд ВХ-ийн эсрэг үндэсний арга хэмжээ сул эсхүл байхгүй улс орнуудыг ашиглаж болно;

в. Гүйлгээний хэв маяг – мэдээлэхээс зайлсхийхийн тулд зохион байгуулалттай, эсхүл тогтмол бус, ер бусын эсхүл нийтлэг бус харагдах гүйлгээг багтаасан;

г. Гүйлгээний хэмжээ - хэмжээ, давтамж нь бизнесийн үндэслэлтэй тайлбаргүй бол;

д. Шилжүүлэгч эсхүл хүлээн авагчийн бүртгэл; болон

е. Хөрөнгө, орлогын эх үүсвэр

БҮЛЭГ ТАВ: ВХ БОЛОН ВХҮҮ-ДЭД ЭРСДЭЛД СУУРИЛСАН АРГАЧЛАЛЫГ ХЭРЭГЖҮҮЛСЭН ОЛОН УЛСЫН ЖИШЭЭ

305. Бүлэг 5-д зарим улс орнуудын ВХ-ийн санхүүгийн үйл ажиллагаа болон холбогдох үйлчилгээ үзүүлэгчдийг зохицуулах, хянах эрх зүйн арга барилын талаар багтаасан бөгөөд МУТСТ чиглэлд хүлээсэн үүргээ биелүүлээгүй нөхцөлд ногдуулах шийтгэл, авах албадлагын арга хэмжээ, арга хэрэгсэлийн талаар ерөнхий ойлголтыг тусгаж өгсөнөөр улс орнууд өөрсдийн үндэсний тогтолцоог хөгжүүлэх эсхүл сайжруулахдаа дараах хэсгээс жишээ болгох боломжтой. Эдгээр орнуудын зарим нь ЗТ.15-д заасан шаардлагад нийцэж байгаа эсэхэд хараахан үнэлүүлээгүй байгааг анхааруулж байна.

Бүгд найрамдах Итали улс

306. Итали улсад 2007 оны 231 дугаартай тогтоол, 2017 оны 90 дугаартай тогтоолын нэмэлт өөрчлөлтөөр ВХ, зөвшөөрөгдсөн мөнгөн тэмдэгтүүдийн арилжааны үйлчилгээ үзүүлэгчдийг МУТСТ шаардлагуудтай нийцүүлэх шаардлагатай этгээдүүдийн жагсаалтад оруулсан.

307. ВХ-тэй холбоотой үйлчилгээ үзүүлэгчид нь “Organismo degli Agenti e dei Mediatori”-аас тусгай хэсэгт бүртгэгдсэн байх шаардлагатай. ВХҮҮ-ийн хувьд үйл ажиллагаа явуулахын тулд бүртгэлд хамрагдах нь нэн түрүүний асуудал юм. Бүртгэлжүүлэх ажиллагаа Итали улсад явагдаж байна.

308. ВХҮҮ нь МУТСТ арга хэмжээг бүхлээр нь авч хэрэгжүүлэх этгээдэд хамаарна.

309. 2019 оны 3-р сарын 21-ний өдөр Итали улс нь ҮЭҮ-дээ шинэчлэлт оруулсан бөгөөд МУТС эрсдэлийг үнэлэхдээ ВХ-ийг хамруулахаар болжээ. ҮЭҮ-ний үр дүнд үндэслэж Үндэсний бодлого стратегийг сайжруулах юм. Зохицуулалттай этгээд, санхүүгийн болон санхүүгийн бус байгууллага нь шинэчлэгдсэн ҮЭҮ-ний үр дүнд үндэслэн өөрсдийн эрсдэлийн үнэлгээг шинэчлэнэ.

310. Италийн СМА нь СГТ-нд болон цаашдын дүн шинжилгээнд шаардлагатай дараах мэдээллүүдийг цуглуулах эрхтэй болсон. Үүнд: i) Итали улсад үйл ажиллагаа эрхлэгч ВХҮҮ-ийн бизнесийн үйл ажиллагааны мэдээлэл (үзүүлдэг үйлчилгээний типологи), газарзүйн байршил, эцсийн өмчлөгчийн мэдээлэл болон бусад холбоо бүхий мэдээллүүд; ii) Гүйлгээний дэлгэрэнгүй мэдээлэл (жишээлбэл огноо, дүн, гүйцэтгэгч, холбогдох талууд, болон хэтэвчний данс), холбогдох банкны дансуудын мэдээлэл (жишээлбэл данс эзэмшигч, итгэмжлэл, хөрөнгийн гарал үүсэл / ашиглалт, санхүүгийн урсгалын ерөнхий онцлог); iii) харилцагчийн хувийн болон эдийн засгийн төлөв байдлын дата мэдээлэл эсхүл хэтэвч эзэмшигчийн мэдээлэл, ВХ-ийн эзэмшигчийг таних ВХ-ийн хаягийн талаарх мэдээлэл, хоёрдмол утгатай таних мэдээлэл (санхүүгийн код болон НӨАТ-ын дугаар); iv) хэтэвч эсхүл дансны мэдээлэл (жишээ нь нэг эсхүл түүнээс дээш этгээдэд хамаарах нийт ВХ-ийн хэмжээ, тодорхойлох хугацааны туршид хийгдсэн хоорондоо уялдаа холбоо бүхий ВХ-ийн хөдөлгөөний талаарх мэдээлэл, засч болох форматтай данс/хэтэвчний тодорхойлолт); v) ВХ-ийн төрөл болон гол онцлог.

311. 2015 оноос хойш Италийн банк нь ВХ-ийг эзэмших, худалдан авах нь өндөр эрсдэлтэй талаар харилцагчиддаа болон ВХ-тэй холбогдон үүсч болзошгүй эрсдлийн

талаар санхүүгийн зуучлагчдад анхааруулга өгсөн. Италийн СМА нь хувийн хэвшлийн байгууллагуудтай харилцаа холбоог эрчимжүүлэх зорилгоор 2015 оны 1-р сарын 30-ны өдөр Крипто хөрөнгийг урвуулан ашиглах тухай харилцаа холбооны бичгийг харилцан үүсгэсэн.

312. СМА нь шинээр үүсч буй эрсдэл, тулгарч буй хандлагуудад дүн шинжилгээ хийх ажлыг үргэлжлүүлэн хийж байна. 2019 онд зохицуулалттай этгээдүүдтэй шинэчлэгдсэн харилцаа холбооны бичиг байгуулсан. Ялангуяа СМА нь 2015 оны харицаа холбооны бичгээ шинэчилж крипто хөрөнгийг урвуулан ашиглах тухай давтамжтай элементүүд, үйл ажиллагааны аргачлал, ВХ-ийн СГТ-гийн эрсдэлийн төлөвийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн. Тухайн харилцаа холбооны бичигт СГТ-гийн форматад дата мэдээллийг хэрхэн бөглөх тухай заавар багтсан бөгөөд ВХҮҮ, гүйлгээ, хэрэглэгч/харилцагч, хэтэвч/данс зэргийг хэрхэн бөглөх заавар орсон.
313. 2016 оны 12-р сар, 2018 оны 7-р сард Итали улсын СМА нь ВХ-ийг зүй бусаар ашигласан типологи бүхий МУТС-тэй холбоотой санхүүгийн дүн шинжилгээний кейсүүдийн товхимолыг хэвлүүлсэн.

Финланд

314. ВХҮҮ-ийн тухай хууль (572/2019) 2019 оны 5-р сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон. ВХҮҮ нь Финландын Санхүүгийн Хяналтын Газар (FIN-FSA)-д бүртгүүлэх (зөвшөөрөл) шаардлагатай бөгөөд хууль хүчин төгөлдөр болохоос өмнө үйлчилгээ үзүүлж байсан ВХҮҮ нь 2019 оны 11-р сарын 1-ний өдрөөс өмнө бүртгүүлэх шаардлагатай. Шинэ ВХҮҮ нь үйл ажиллагаагаа эхлэхээс өмнө бүртгүүлэх шаардлагатай болсон. ВХҮҮ-ийн тодорхойлолтод арилжааны бүх хэлбэр (албан ёсны мөнгөн тэмдэгт болон ВХ, ВХ болон алт зэрэг бусад үнэт зүйл хооронд), кастодиан хэтэвчний үйлчилгээ үзүүлэгч болон виртуал валют гаргагчид орно. Бүртгүүлэхэд тавигдах шаардлагууд нь харилцагч нь тохиромжтой этгээд эсэх, харилцагчийн хөрөнгө зохицуулалт, маркетингийн талаархи энгийн дүрэм (жишээ нь, холбогдох бүх мэдээллийг үнэн зөв өгөх) багтана. ВХҮҮ нь Мөнгө угаахтай тэмцэх тухай хуульд (444/2017) тодорхойлсон МҮЭ бөгөөд 2019 оны 12-р сарын 1-нээс эхлэн МУТСТ үүргээ биелүүлэх шаардлагатай болсон. Бүртгэлийн нэг хэсэг болгон ВХҮҮ-ийн МУТС эрсдлийн үнэлгээ, тэдгээрийн журам, зааврыг хянана.
315. Финландын Санхүүгийн Хяналтын Газар (FIN-FSA)-г ВХҮҮ-ийн зарим үйл ажиллагааны хэсэгт дүрэм журам, удирдамж гаргах эрх олгосон. FIN-FSA-ын журам, заавар нь 2019 оны 7-р сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон. Уг журамд харилцагчийн мөнгийг хадгалах, хамгаалах, харилцагчийн мөнгө болон өөрийн хөрөнгийг тусгаарлах зохицуулалтыг тусгасан. Удирдамж нь МУТСТ хууль тогтоомжийг дагаж мөрдөхтэй холбоотой.
316. Хууль гарахаас өмнө FIN-FSA нь үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомж, санхүүгийн хэрэгслийн үүднээс анхдагч койнын санал болгогчидтой хамтран ажилласан. Зорилго нь ВХ нь ямар тохиолдолд санхүүгийн хэрэгсэл (жишээ нь, шилжүүлэх боломжтой үнэт цаас) болохыг тодорхойлох явдал байв. Эдгээр үнэлгээ нь тогтмол шаардлагатай хэвээр байна. Гаргах хөрөнгийн шинж чанарын үнэлгээг

хялбарчлахын тулд FIN-FSA нь анхдагч койн гарагчтай холбоотой бүх лавлагаанд ашигладаг хяналтын хуудсыг боловсруулсан. Асуумж болон ВХ-тэй холбоотой тогтмол асуултуудыг FIN-FSA вэбсайтаас авах боломжтой.

317. FIN-FSA-ын хяналтын туршлагаас харахад ВХҮҮ нь зохицуулалтад хамрагдах хүсэлтэй бөгөөд тэдний үйл ажиллагаанд хянан шалгагч нараас дэмжлэг авахыг хичээж байна. Зөвшөөрөл нь батлахтай тэнцүү биш гэдгийг олон нийтэд мэдээлэх нь тулгамдсан асуудал юм. ВХҮҮ-д банкны данс нээхэд бэрхшээлтэй тулгарсан нь зохицуулалтад хандах хандлага өөрчлөгдсөнийг хэсэгчлэн тайлбарлаж болох юм.

Япон

318. Япон улс 2014 онд томоохон ВХҮҮ дампуурсантай холбогдуулан 2016 онд Төлбөрийн үйлчилгээний тухай хууль болон Гэмт хэргийн орлого шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх тухай хууль (РТСР Акт) болон ФАТФ-ын ВХ-ийн 2015 оны гарын авлагад нэмэлт өөрчлөлт оруулсан. 2017 оны 4-р сард хуулиудыг баталсны дараа Японы санхүүгийн зохицуулах хороо (ЯСЗХ) нь 2017 оны 8-р сард ВХҮҮ-ийн хяналтын багийг МУТСТ болон технологийн мэргэжилтнүүдээс бүрдсэн багаар байгуулсан.

319. ЯСЗХ нь бүртгүүлэх журмынхаа нэг хэсэг болгон, өргөдөл гаргагчийн эрсдэлийн үнэлгээ болон бизнес төлөвлөгөөний хоорондын уялдаа холбоог анхаарч, баримт бичигт суурилсан үнэлгээ, тэдэнтэй газар дээр нь ярилцлага хийх замаар МУТС эрсдлийг үнэлдэг. (2021 оны 7-р сарын байдлаар 31 ВХҮҮ бүртгэгдсэн).

320. Өргөдөл гаргагчийн үүднээс бүртгэлийн үйл явцыг урьдчилан таамаглах, ил тод байлгахын тулд 2018 оны 10-р сард бүртгүүлэхдээ бөглөх шаардлагатай асуулгын маягыг нийтэлсэн. Өнгөрсөн хугацаанд хийсэн хяналт-шинжилгээ, бүртгэлийн шалгалтаар хуримтлуулсан мэдлэг, туршлагадаа үндэслэн санал асуулгын зарим зүйлийг нэгтгэн хасч шинэчилсэн. Дараа нь 2020 оны 4-р сард дахин хэвлэгдсэн бөгөөд энэ нь ЯСЗХ-д МУТСТ дэглэмийг, ялангуяа эрсдэлийн менежментийг илүү эрчимтэй хийх, шаардлагатай зүйлсийг илүү үр дүнтэй шалгах боломжийг олгох зорилготой юм.

321. ЯСЗХ нь бүртгэлийн үйл явцыг дараах байдлаар явуулдаг. Үүнд:

а. ЯСЗХ-ны цахим хуудсанд байршуулсан санал асуулгын хуудсыг өргөдөл гаргагчдад илгээнэ;

б. ЯСЗХ нь өргөдөл гаргагчийн өгсөн хариултад үндэслэн шаардлагатай тохиолдолд нэмж асуулт асууж, нэмэлт баримт бичиг шаардана;

в. Удирдах зөвлөлийн гишүүдтэй эрсдэлийн удирдлага болон бизнес төлөвлөгөөнийх нь талаар ярилцлага хийнэ;

г. Бүртгэлийн хяналтыг өргөдөл гаргагчийн бүрдүүлж өгсөн баримт бичгийг үнэлэх байдлаар үргэлжлүүлэн хийх бөгөөд ингэхдээ дараах зүйлсийг авч үзнэ: 1) ВХ-ийн эрсдэлийн удирдлага; 2) харилцагчийн хөрөнгийг тусгаарлах удирдлага; 3) мэдээллийн технологийн системийн удирдлага; 4) МУТСТ тогтолцоо; 5) аутсорсингийн удирдлага; 6) бизнесийн удирдлага, дотоод аудитын тогтолцоо;

д. Өмнөх үйл явцуудын үр дүнд үндэслэн ЯСЗХ нь дүрэм журам, бодлого, ялангуяа эрсдэлийн удирдлагын тогтолцоо, төлөвлөсөн үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг шалгаж баталгаажуулах зорилгоор өргөдөл гаргагчийн оффис дээр очиж газар дээрх хяналт, шалгалт хийх удирдамж гаргана;

е. ЯСЗХ бүртгэлийн хяналтыг бүрэн хийж, өргөдөл гаргагчийн үйл ажиллагаа хэвийн, ямар нэг асуудалгүй гэдгийг баталгаажуулсны дараа өргөдлийг зөвшөөрч, бүртгэнэ.

322. ЯСЗХ нь зохицуулалттай этгээдийн эрсдэлд өртөх байдлыг үнэлэх зорилгоор жил бүр тэдгээр байгууллагуудаас МУТСТ-тэй холбогдох статистик болон чанарын мэдээлэл цуглуулж, ЯСЗХ-ны боловсруулсан аргачлалын дагуу байгууллага тус бүрийн эрсдэлийн зэрэглэлийг тогтоодог бөгөөд энэ мэдээллийг ашиглан зайнаас хяналт тавих жилийн төлөвлөгөөгөө боловсруулдаг. Тухайлбал, ЯСЗХ нь 22 ВХҮҮ-д газар дээрх хяналт, шалгалт хийж (үүнд, нэмэлт өөрчлөлт орсон хууль батлагдахаас өмнө үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд урьдчилсан нөхцөлөөр үйл ажиллагаа явуулахыг нь зөвшөөрсөн этгээд буюу тухайн үед ВХҮҮ-т тооцогдож байсан 13 ВХҮҮ орсон), захиргааны арга хэмжээ авсан ба 2019 оны 3-р сарын байдлаар, үйл ажиллагааг сайжруулах 21 шийдвэр, бизнесийн үйл ажиллагааг зогсоох 6 шийдвэр, бүртгэхээс татгалзсан 1 шийдвэрийг тус тус гаргасан байна.

323. Зохицуулалттай этгээдээс цуглуулсан мэдээлэл нь ойролцоогоор 60 төрлийн КРІ (гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт) өгөгдлөөс бүрдэх бөгөөд тэдгээрийг салбар бүрийн онцлогт тохируулсан байдаг. ВХҮҮ-ийн салбарын хувьд ЯСЗХ нь дараах мэдээллийг цуглуулдаг бөгөөд эдгээр нь бүх ВХҮҮ-дэд хамаарах төдийгүй жил бүр хянаж сайжруулагдаж байдаг. Үүнд:

а. Блокчэйн дүн шинжилгээний хэрэгслүүдийг гүйлгээний хяналт ба/эсхүл эрсдэлийн шинжилгээний зорилгоор ашиглаж байгаа эсэх;

б. ВХҮҮ-ийн харилцагчдад санал болгож буй ВХ-ийн төрөл;

в. Холигч болон хөрвүүлэгч ашигласан түүхтэй гэж тодорхойлогдсон харилцагчийн тоо;

г. *Hot wallet* болон *cold wallet*-ний хэрэглээний хуваарилалт, хувиар;

д. ВХҮҮ нь байгууллагыг харилцагчаар бүртгэдэг эсэх (дансны тоо, гүйлгээний дүн);

е. ВХҮҮ нь бизнесийн төлбөр тооцооны үйлчилгээг санал болгодог эсэх;

ё. Нөгөө талын ВХҮҮ-ийн талаарх мэдээлэл (газарзүйн тархалт ба гүйлгээний хэмжээ);

ж. ВХҮҮ-ийн эзэмшдэг ВХ-ийн АТМ-ийн тоо, газарзүйн байршил.

324. ЯСЗХ нь ВХҮҮ-тэй холбоотой асуудлуудад шуурхай, уян хатан хариу өгөх үүднээс 2018 оны 10-р сард байгуулагдсан ӨЗБ болох Япон Улсын Виртуал Валютын Биржийн

Холбоо (JVCEA)-тай нягт хамтран ажилладаг. ВВБХ нь гишүүн ВХҮҮ-дийн үйл ажиллагаанд хяналт тавих, сургалт, боловсролын үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлж ажилладаг. Түүнчлэн ВВБХ нь МУТСТ дүрэм журам болон гарын авлага, заавар боловсруулж гаргадаг. ЯСЗХ нь ВВБХ-той, зарим тохиолдолд бусад байгууллагуудтай хамтран соён гэгээрүүлэх ажил зохион байгуулж, ВХҮҮ-тэй мэдээлэл, санаа бодлоо хуваалцаж, тэдний МУТСТ хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулахад хувь нэмрээ оруулсан.

325. Үүнээс гадна ЯСЗХ нь:

- ВХҮҮ-ийн бизнесийн үйл ажиллагаатай холбоотой янз бүрийн асуудлуудыг байгууллагын түвшинд яаж авч үзэж, шийдвэрлэж байгааг судлах зорилгоор 2018 оны 3-р сард “Виртуал валют солилцох бизнесийн судалгааны бүлэг”-ийг байгуулсан. Судалгааны бүлгийн эмхэтгэсэн тайланд гаргасан саналын дагуу ЯСЗХ нь 2019 оны 3-р сард хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг “Diet”-д өргөн барьсан. Нэмэлт өөрчлөлтөөр Төлбөрийн үйлчилгээний тухай хууль болон Гэмт хэргээс олсон хөрөнгө, орлогыг шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх тухай хууль (PTCP Act)-ийг ВХ-ийн кастодиан үйлчилгээ эрхэлдэг үйлчилгээ үзүүлэгчид дагаж мөрдөх, ВХ-ийн нууцлаг байдлыг харгалзан ВХҮҮ-ийн арилжиж байгаа ВХ-ийн төрлийн өөрчлөлт бүрийн талаар урьдчилж мэдэгдэх системийг нэвтрүүлэх зэрэг асуудлуудыг тусгасан байна.
- 2019 оны 4-р сард ВХҮҮ-д тухайлан хамаарах сэжигтэй гүйлгээний шинж тэмдэг, үзүүлэлтүүдийн жишээг бэлтгэж, нийтэд мэдээлэв. Эдгээр шинж тэмдэг, үзүүлэлтүүд нь нэрээ нууцлах технологи ашигласан гүйлгээнүүдтэй холбоотой сэжигтэй гүйлгээний шинж тэмдгүүдийг мөн агуулсан болно.

326. Нэмэлт өөрчлөлт орсон Төлбөрийн үйлчилгээний тухай хууль 2020 оны 5-р сараас хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн (2019 оны 5-р сард батлагдсан). Энэхүү нэмэлт өөрчлөлтөөр крипто хөрөнгийг харилцагчийн нэрийн өмнөөс удирдах (хадгалах/удирдах) болон харилцагчийн зааврын дагуу крипто хөрөнгийг арилжаа хийхгүйгээр заасан хаяг руу шилжүүлэх гэх мэт крипто-хөрөнгийн кастодиан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа нь хуулийн зохицуулалтад хамаарах болсон.

327. Шилжүүлгийн дүрмийн тухайд ВВБХ нь өөрийн зохицуулалтын дүрмээ шинэчлэн, тодорхой хугацаа товлож, шилжүүлгийн дүрмийг нэвтрүүлэхийг зорьж байгаа бөгөөд энэ асуудлаар ЯСЗХ нь ВВБХ-той хамтын ажиллагаагаа эрчимжүүлж байна.

328. 2021 оны 3-р сард ЯСЗХ нь бизнесийн үйл ажиллагааг зохистой, найдвартай явуулах үүднээс шилжүүлгийн дүрмийг зохих ёсоор хэрэгжүүлэх, техникийн болон үйл ажиллагааны асуудлуудыг шийдвэрлэх, шилжүүлгийн дүрмийг хэрэгжүүлэхэд шаардлагатай тогтолцоог бий болгох хүсэлтийг ВВБХ-д хүргүүлсэн.

329. ЯСЗХ нь шилжүүлгийн дүрмийг нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд ВХҮҮ-ийн салбарынхантай өргөн хүрээтэй яриа хэлэлцээр хийсэн. ЯСЗХ нь энэхүү яриа

хэлэлцээрийг үргэлжлүүлэн, шилжүүлгийн дүрэмтэй холбогдох салбарын үйл ажиллагаа, үйл явцыг хянах болно.

Мексик

330. Мексик улс 2018 оны 3-р сард Хууль бус эх үүсвэр бүхий үйл ажиллагааг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх хуулийг шинэчилж, Санхүүгийн технологийн байгууллага, Зээлийн байгууллагаас бусад байгууллагуудын эрхэлж байгаа ВХ-ийн арилжааг өндөр эрсдэлтэй гэж үзсэн.
331. Түүнчлэн Мексик улс 2018 оны 3-р сард Санхүүгийн технологийн байгууллагуудыг зохицуулах хууль баталсан бөгөөд энэ хуулийн дагуу Санхүүгийн технологийн байгууллагууд Мексикийн Төв банкнаас зөвшөөрөл авч, заасан ВХ-тэй холбоотой үйл ажиллагааг явуулж болох юм байна.
332. Үүний дараа 2018 оны 9-р сард ВХ-тэй холбогдуулан авах МУТСТ арга хэмжээ, үйл ажиллагааны хэм хэмжээг тогтоосон стандартуудыг гаргасан.
333. 2019 оны 3-р сард Төв банкнаас шууд болон шууд бусаар ВХ-тэй холбоотой үйл ажиллагаа явуулж байгаа Зээлийн байгууллага болон Санхүүгийн технологийн байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулсан стандартыг гаргасан.
334. Төв банкны зүгээс ВХ нь улс орнуудын хооронд шилжүүлэхэд маш хялбар, түүнчлэн дэлхийн хэмжээнд хяналт тавих, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах нэг ижил стандарт байхгүй байгаагаас шалтгаалан энэ төрлийн хөрөнгө, үйлчилгээ нь МУТС өндөр эрсдэлтэй гэж мэдэгдэв. Гэсэн хэдий ч эдгээр технологиудыг Санхүүгийн технологийн байгууллага болон Зээлийн байгууллагуудын хооронд дотооддоо ашиглах тохиолдолд ашиг тустай байж болох технологийн хэрэглээг дэмжих чиглэл баримталж байгаа юм байна.
335. Эцэст нь, 2019 оны 3-р сарын сүүлээр “Disposiciones de carácter general a que se refiere el 115 de la Ley de Instituciones Crédito” шинэчлэгдэж, зээлийн байгууллагуудын ВХ-тэй холбоотой МУТСТ чиг үүргээ биелүүлэхийн тулд дагаж мөрдвөл зохих арга хэмжээ, үйл ажиллагааг тодорхойлсон.

Норвеги

336. ВХҮҮ-д нь 2018 оны 10-р сарын 15-ны өдрөөс эхлэн Норвеги улсын Мөнгө угаахтай тэмцэх хуулийн дагуу МҮЭ болж, тус хуулийг дагаж мөрдөх үүрэг хүлээсэн. Мөнгө угаахтай тэмцэх журмын холбогдох заалт нь дараах байдалтай байна (хамгийн сүүлд 2021 оны 5-р сард шинэчлэгдсэн – албан бус орчуулга). Үүнд:

Шигтгээ 5. Хэсэг 1-3 Мөнгө угаахтай тэмцэх хуулийг виртуал валютад хэрэглэх – Виртуал валютын арилжаа, кастодианы үйлчилгээ үзүүлэгчдийг бүртгэхэд тавих шаардлага.

(1) Виртуал валют болон албан ёсны мөнгөн тэмдэгтийн хооронд солих үйлчилгээ үзүүлэгчид нь Мөнгө угаахтай тэмцэх хуулийн дагуу дараах тохиолдолд мэдээлэх үүрэг хүлээнэ:

а. Норвеги улсын бизнесийн бүртгэлийн газарт бүртгүүлсэн,

б. Норвеги улсаас үйл ажиллагаа явуулж байгаа,

в. Норвеги улсын зах зээл рүү чиглэсэн.

Энэ нь виртуал валютын кастодиан үйлчилгээнд мөн адил хамаарна.

(2) Виртуал валют гэж төв банк эсхүл засгийн газрын эрх бүхий байгууллагаас гаргаагүй, хууль ёсоор гаргасан мөнгөн тэмдэгтэй заавал холбоогүй, мөнгөн тэмдэгтийн эрх зүйн статусгүй, гэхдээ солилцооны хэрэгсэл болж, цахим хэлбэрээр шилжүүлэх, хадгалах, арилжаалах боломжтой, хүлээн зөвшөөрөгдсөн үнэ цэнийн дижитал илэрхийллийг хэлнэ.

(3) Виртуал валютын кастодиан үйлчилгээ гэж виртуал валют шилжүүлэх, хадгалах, арилжаалах зорилгоор харилцагчдын нэрийн өмнөөс хувийн криптограф түлхүүрийг хадгалахыг хэлнэ.

(4) (1)-д дурдсан үйлчилгээ үзүүлэгч нь зөвхөн Санхүүгийн хяналт шалгалтын байгууллагад бүртгүүлсэн хуулийн этгээд байна. Мөнгө угаахтай тэмцэх хуулийн 42 дугаар зүйлийн 2-4 дэх хэсэгт заасан заалтууд энд мөн хамаарна.

(5) Бүртгүүлэх өргөдөл нь дараах мэдээллийг агуулсан байх ёстой:

а. өргөдөл гаргагчийн нэр

б. аж ахуйн нэгжийн төрөл, байгууллагын дугаар

в. бизнесийн хаяг

г. үзүүлэх үйлчилгээ

д. дараах албан тушаалтны овог нэр, оршин суугаа хаяг, бичиг баримтын дугаар

i. ерөнхий менежер эсхүл холбогдох албан тушаалтан

ii. төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд эсхүл холбогдох албан тушаалтан

2021 оны 10-р сарын байдлаар 9 ВХҮҮ Санхүүгийн хяналт шалгалтын байгууллагад бүртгүүлсэн бөгөөд Норвеги улсын зах зээлд үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөлтэй болсон.

Үүнээс гадна өөр олон этгээд бүртгүүлэх хүсэлт гаргаж байгаа боловч 2020 оноос хойш хүлээн авсан өргөдлийн тоо бага зэрэг буурсан. Өргөдөл гаргагчдын олонх нь мөнгө угаахтай тэмцэх бодлого, журмын дутагдалтай байдлаас болж өмнө нь татгалзсан этгээд байна. Түүнчлэн Санхүүгийн хяналт шалгалтын байгууллага нь дотоод болон гадаад улсад үүсгэн байгуулагдсан, Норвеги улсад зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж буй ВХҮҮ-ийн үйл ажиллагааг зогсоох тогтоол шийдвэр олныг гаргаж байгаа. Тус байгууллага нь бүртгэлгүй ВХҮҮ-ийг илрүүлж, үйл ажиллагааг нь зогсооход СМА-тай нягт хамтран ажиллаж байгаа бөгөөд 2019 оноос хойш хамтарсан урьдчилан сэргийлэх төсөл хэрэгжүүлж ажиллаж байна. Цаашлаад, Санхүүгийн хяналт шалгалтын байгууллага нь 2021 оны 5-р сарын сүүлээр ВХҮҮ-д анхны хяналт шалгалтыг хийсэн бөгөөд салбарын ерөнхий эрсдэл болон үзүүлж буй үйлчилгээний цар хүрээ цаашид ямар байх талаар зураглахын тулд бүх бүртгэлтэй ВХҮҮ-ээс нэмэлт мэдээлэл цуглуулсан. Бүртгүүлэх оролдлогуудын талаарх мэдээлэл болон ерөнхий туршлагаас харахад энэ салбарын оролцогчид болон оролцох сонирхолтой этгээдийн хувьд янз бүрийн хэмжээ, бүтэц, чадавх, мэргэжлийн туршлагатай байхаас гадна мөнгө угаахтай тэмцэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой мэдлэг, туршлагын хувьд өөр өөр этгээдүүд байна.

Швед

337. Швед улсад Санхүүгийн хяналт шалгалтын байгууллагаас нь биткойн болон этериумыг 2013 оноос хойш төлбөрийн хэрэгсэл гэж тооцсон. Үүнтэй холбоотойгоор мэргэжлийн арилжааны үйлчилгээ үзүүлэхэд тусгай зөвшөөрөл⁵³ авах ёстой бөгөөд зөвшөөрөл авсан этгээд нь МУТСТ хяналт шалгалтад хамрагдана. Энэ нь ВХ-ийн арилжааны үйлчилгээний хувьд МУТСТ-тэй холбогдох шууд зохицуулалт биш (өөрөөр хэлбэл, хуульд тухайлан дурдаагүй) хэдий ч шууд бусаар зохицуулна гэж үзсэн. Арилжааны үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл авсан ВХҮҮ-ийн бүх үйл ажиллагаа МУТСТ журмаар зохицуулагдаж, хяналт шалгалтад хамрагдана. МУТСТ зохицуулалт, хяналтад хамаарна. Хяналт тавих эрх бүхий байгууллагаас сэдэвчилсэн хяналт шалгалтыг хийсэн ба тус салбарт үйл ажиллагаа явуулж байсан зарим этгээдийн үйл ажиллагааг зогсоосон. ВХҮҮ нь СМА-нд СГТ мэдээлсэн бөгөөд эрх бүхий байгууллагуудын үзэж байгаагаар гэмт этгээдүүд нь зохицуулалтгүй, өөр газар байрших биржийг сонгож гүйлгээ хийдэг байна.

Швейцар

338. Швейцар улс төвийг сахисан технологийн хандлагыг баримталж, МУТСТ зохицуулалтыг ВХ болон ВХҮҮ-дэд зах зээл дээр ВХ-тэй холбоотой үйл ажиллагааг хөгжүүлэх, бий болгох эхний шатнаас нь хэрэгжүүлсэн. Энэхүү зохицуулалтын дагуу санхүүгийн зуучлал болон ВХ-тэй холбоотой бүх үйл ажиллагаа нь Мөнгө угаахтай тэмцэх хуулийн (AMLA) үйлчлэх хүрээнд хамрагддаг. Үүнд ВХ болон албан ёсны мөнгөн тэмдэгт, эсхүл нэг болон хэд хэдэн төрлийн ВХ-ийг өөр хооронд нь арилжих үйл ажиллагаа, ВХ-ийг шилжүүлэх, хадгалах, эсхүл удирдах аливаа үйл ажиллагаа, ВХ-ийг хянах эсхүл төлбөрийн токен гаргах хэрэгсэл тус тус орно.

⁵³ Энэ нь тусгай зөвшөөрлийн иж бүрэн тогтолцоо биш боловч МУТСТ зорилгоор өмчлөгч болон удирдлагыг зөв, зохистой шалгуур үзүүлэлтээр шалгах, бизнесийн үйл ажиллагааг МУТСТ хууль тогтоомжийн дагуу явуулах эсэхийг үнэлэх тогтолцоо юм.

339. Хөрөнгийг шилжүүлэхэд хэд хэдэн этгээд оролцдог хөрөнгийн шилжүүлгийн төвлөрсөн бус загварууд улам бүр нэмэгдэж байгаа тул виртуал валютаар төлбөрийн гүйлгээ хийхтэй холбоотой үйлчилгээнүүдийг тодорхойлох шинэ шалгуурыг мөнгө угаахтай тэмцэх журамд тусгасан. Тиймээс, санхүүгийн зуучлагч нь харилцагчдад виртуал валютын үйлчилгээ үзүүлэхээс гадна виртуал хөрөнгөөр төлбөрийн гүйлгээ хийхтэй холбоотой үйлчилгээг байнгын бизнесийн харилцаатай харилцагчиддаа үзүүлж байна. Үүнд тухайлбал, харилцагчийн хувийн түлхүүр үгийг эзэмшдэггүй хэдий ч ухаалаг гэрээ эсхүл хэтэвчний үйлчилгээ үзүүлэгч ашиглан шилжүүлэг, гүйлгээ хийдэг төвлөрсөн бус худалдааны платформууд орно. Энэхүү өөрчлөлт нь Швейцар улсын Мөнгө угаахтай тэмцэх хуулийн дагуу ВХ-тэй холбоотой үйл ажиллагааг зохицуулах зохицуулалтад тусгагдсан болно.
340. Швейцар улсад ийм бизнес эрхлэхээс өмнө санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэж байгаа болон Мөнгө угаахтай тэмцэх хуульд хамаарах хувь хүн, хуулийн этгээд нь Швейцар улсын санхүүгийн зах зээлийг зохицуулагч байгууллага (ФИНМА)-аас зөвшөөрөл (жишээлбэл, банкны зөвшөөрөл) авах, эсхүл ФИНМА-аар хянагддаг Хяналт шалгалтын байгууллагын (SO) гишүүн эсхүл ӨЗБ байх ёстой. Мөнгө угаахтай тэмцэх журам (AMLO) нь Швейцар улсад эсхүл тус улсаас үйл ажиллагаа явуулдаг санхүүгийн зуучлагчдыг хамардаг.
341. ФИНМА нь крипто хөрөнгө болон ICO зэрэг крипто хөрөнгөтэй холбоотой бусад үйл ажиллагаатай холбогдох эрсдэлүүдийн талаар хэрэглэгчдэд удаа дараа анхааруулсаар байна. ФИНМА нь хяналт шалгалт хийх явцдаа ВХ-тэй холбоотой асуудлуудад эртнээс анхаарал хандуулж байв. Жишээлбэл, ФИНМА 2019 онд шилжүүлгийн дүрэмтэй холбоотой өөрсдийн хүлээлтийн талаар байр сууриа илэрхийлж байв. Швейцарь улсад санхүүгийн зуучлагчид нь өөрийн байгууллагад байршаагүй хэтэвчнээс эсхүл ийм хэтэвч рүү шилжүүлэг хийдэг бол шилжүүлгийн дүрмийг дагаж мөрдөх ёстой. ФИНМА нь хяналтад байгаа байгууллагууд (тухайлбал, банкууд) ВХ-тэй холбоотой хууль, журмын шаардлагуудыг хэрхэн хэрэгжүүлж ажиллаж байгааг үнэлсэн болно.

АНУ

Иж бүрэн бөгөөд технологийн хувьд төвийг сахисан тогтолцоо

342. Америкийн Нэгдсэн Улс (АНУ) нь МУТСТ зорилгоор "дигитал хөрөнгө"⁵⁴-ийг зохицуулах, хянах иж бүрэн бөгөөд технологийн хувьд төвийг сахисан зохицуулалт, хяналтын тогтолцоог бүрдүүлсэн бөгөөд энэ салбарын үйлчилгээ үзүүлэгч болон үйл ажиллагаа нь дигитал бус хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид СБ-д мөрдөгдөж буй МУТСТ зохицуулалтад хамрагддагтай нэгэн адилаар уг зохицуулалтад хамрагдана. АНУ-ын хувьд дараах эрх бүхий байгууллагууд болон эрх зүйн актаар дамжуулан зохицуулалт, хяналтыг хэрэгжүүлж байна. Үүнд: АНУ-ын СМА болох АНУ-ын Сангийн

⁵⁴ АНУ-ын хувьд "дигитал хөрөнгө" гэсэн нэр томъёо нь дигитал санхүүгийн үйлчилгээний экосистем дэх олон төрлийн хөрөнгийг, тэр дундаа дигитал валют буюу үндэсний дигитал валют, үндэсний засгийн газраас гаргаагүй эсхүл баталгаагүй биткойн гэх мэт хөрвөх виртуал валютууд, түүнчлэн үнэт цаас, бараа бүтээгдэхүүн эсхүл тэдгээрийн дериватив болох дигитал хөрөнгө гэх мэт дигитал валютыг илэрхийлдэг цогц нэр томъёо юм.

яамны Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага (FinCEN), АНУ-ын Мөнгө угаахтай тэмцэх хууль болох Банкны нууцлалын тухай хууль (BSA); АНУ-ын Сангийн яамны Гадаад хөрөнгийн хяналтын алба (OFAC); Татварын алба (IRS); АНУ-ын Үнэт цаас болон биржийн хороо (SEC); АНУ-ын таваарын фьючерс арилжааны комисс (CFTC); АНУ-ын Хууль зүйн яам (DOJ) болон бусад хэлтэс, агентлагууд. FinCEN, IRS, SEC, CFTC болон DOJ нь мөнгө шилжүүлэхтэй холбоотой зарим дижитал хөрөнгийн үйл ажиллагаа; үнэт цаас, бараа бүтээгдэхүүн, дериватив; эсхүл татвартай холбоотой үйл ажиллагааг зохицуулах, хянах, хэрэгжилтийг хангуулах чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд хууль бус санхүүгийн гүйлгээ хийх эсхүл татвараас зайлсхийх зорилгоор дижитал хөрөнгийг буруугаар ашиглахтай тэмцэх эрхтэй.

343. Хэрэв аливаа этгээд (АНУ-ын хууль тогтоомжид тодорхойлсон нэр томъёо нь иргэн болон хуулийн этгээдийг хамруулаад зогсохгүй) дижитал хөрөнгөтэй холбоотой тодорхой санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг бол МУТСТ болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөх үүрэгтэй. Үйл ажиллагааны төрлөөс хамааран тухайн этгээд эсхүл байгууллага нь хяналт тавих эрх бүхий FinCEN, SEC эсхүл CFTC-ийн аль нэгэнд хянагдах бөгөөд тэдгээрийг мөнгө шилжүүлэгч, үндэсний үнэт цаасны бирж, брокер дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх, хөрөнгө оруулалтын компани, шилжүүлэгч агент, холбогдох гэрээ, своп хэлцлийг гүйцэтгэх газар, дериватив клирингийн байгууллага, фьючерс хэлцлийн зуучлагч, түүхий эдийн бөөний үйл ажиллагаа эрхлэгч, түүхий эдийн арилжааны зөвлөх, своп дилер, своп хэлцэлд оролцогч, гадаад валютын арилжааны дилер, эсхүл зуучлагч брокер гэж тооцон зохицуулалтад хамруулна.

344. Хэрэв этгээд нь хууль тогтоомжид заасан "банк" гэсэн тодорхойлолтод хамаарах бол FinCEN болон АНУ-ын холбооны банкны агентлагууд болох Холбооны Нөөцийн Системийн Захирлуудын Зөвлөл, Холбооны Хадгаламжийн Даатгалын Корпорац, Валютын хяналтын алба, Үндэсний Зээлийн Холбооны Захиргаа нь тухайн этгээдийг дижитал хөрөнгөтэй холбоотой санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд зохицуулах, хянах эрх мэдлийг хэрэгжүүлэх бөгөөд зарим тохиолдолд улсын банкны зохицуулагчидтай зэрэгцэн ажилладаг. Түүнчлэн IRS тэдгээрийг өмч гэж ангилдаг тул АНУ-д дижитал хөрөнгөтэй холбоотой гүйлгээнд татварын ерөнхий зарчмууд үйлчилдэг.

Шигтгээ 6. Кэйс судалгаа: АНУ-ын дижитал хөрөнгөтэй холбоотой үйлчилгээ үзүүлэгчдийн зохицуулалт, бүртгэл, зөвшөөрөл, хяналт

Мөнгөн шилжүүлэг. Холбооны түвшинд FinCEN нь мөнгөн тэмдэгтийг орлох бодит эсхүл дижитал үнэ цэнэ (үүнд, виртуал валютаас виртуал валлот руу, виртуал валютаас албан ёсны мөнгөн тэмдэгт рүү, эсхүл виртуал валютаас өөр үнэ цэнэ рүү хөрвөх виртуал валютын аль аль нь орно)-ийг нэг этгээдээс нөгөө этгээд рүү эсхүл байршил руу дамжуулах, хүлээн авах үйл ажиллагаа эрхэлдэг аливаа этгээдийг мөнгө шилжүүлэгч гэж үзэн зохицуулдаг. Банкны нууцлалын тухай хуулийн дагуу мөнгөн шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгч нь FinCEN-д мөнгөн гуйвуулгын үйлчилгээ гэж бүртгүүлэн, мөнгө угаахтай тэмцэх хөтөлбөр баталж хэрэгжүүлэх, баримт бичиг хадгалах, гүйлгээг мэдээлэх, сэжигтэй үйлдлийн тайланг мэдээлэх үүрэг хүлээнэ. Мөнгө угаахтай тэмцэх шаардлагууд нь дотоодод болон гадаад улсад байрладаг мөнгөн шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгчдэд адилхан тавигдах бөгөөд гадаад улсад байрлах этгээдийн хувьд АНУ-д биетээр оршин байдаггүй эсхүл хаана үүсгэн байгуулагдсан, төв оффис нь хаана байдгаас үл хамааран бүрэн хэмжээгээр эсхүл хэсэгчлэн бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг л бол эдгээр шаардлагыг дагаж мөрдөх үүрэгтэй. 2014 оноос хойш IRS болон FinCEN нь администраторууд, хамгийн их арилжаа хийдэг зарим биржүүд, биржийн үйл ажиллагаа эрхлэгч хувь хүмүүс, гадаад улсад үйл ажиллагаа явуулж буй биржүүд, дижитал хөрөнгө/крипто-үнэт металл арилжаалагч, киоск компаниуд, арилжааны платформууд болон бүртгэлтэй, бүртгэлгүй СБ гэх зэрэг төрөл бүрийн дижитал хөрөнгөтэй холбоотой үйлчилгээ үзүүлэгчдэд хяналт шалгалт хийсэн. АНУ-ын ихэнх муж улсын хуулиудаар холбогдох этгээд нь үүсгэн байгуулагдсан эсхүл төв оффис нь байрлах байршил хаана байгаагаас үл хамааран үйл ажиллагаа явуулж байгаа тухайн мужаас мөнгөн гуйвуулга хийх тусгай зөвшөөрөл авахыг шаарддаг. Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгч нь АНУ-ын аль мужид байрладаг эсхүл үйл ажиллагаа явуулдагаас хамаарч аюулгүй байдал, найдвартай байдал, хөрөнгийн нөөцийн шаардлагууд зэрэг бусад зохицуулалт, хуулийн шаардлагуудыг дагаж мөрдөж болно.

Үнэт цаасны үйл ажиллагаа. АНУ-д дижитал хөрөнгө нь үнэт цаас гэж тооцогддог тул SEC нь дижитал хөрөнгийг санал болгох, худалдах, арилжаалах болон дижитал хөрөнгөтэй холбоотой бусад санхүүгийн үйлчилгээ, үйл ажиллагааг зохицуулж, хэрэгжилтийг хангуулах эрх мэдлийг хэрэгжүүлдэг. Дижитал хөрөнгө буюу үнэт цаасыг хоёрдогч зах зээл дээр арилжаалдаг платформууд нь үндэсний үнэт цаасны биржээр бүртгүүлэх эсхүл альтернатив арилжааны системд тавигдах SEC-ийн шаардлагаас чөлөөлөх зохицуулалтын дагуу (жишээ нь, SEC Журам ATS) бүртгүүлэхээс чөлөөлөгдөн үйл ажиллагаа явуулж, өөрсдийн үйл ажиллагаа, арилжааны талаарх мэдээллийг SEC-д тайлагнана.

Хэдийгээр үнэт цаасны бирж, брокер дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх болон үнэт цаастай холбогдох бусад үйл ажиллагаа явуулдаг этгээд нь гадаад улсад байрладаг бөгөөд АНУ-д биетээр оршин байдаггүй ч тухайн этгээд нь АНУ-ын иргэн, хуулийн этгээдэд үнэт цаас (үнэт цаасанд тооцогдох дижитал хөрөнгө гэх мэт) санал болгох, худалдах болон үнэт цаастай холбогдох үйл ажиллагаа явуулдаг эсхүл АНУ-ын үнэт цаасны зах зээлд ямар нэг байдлаар нөлөөлдөг бол SEC-ийн дүрэм журмыг дагаж мөрдөх үүрэгтэй. Аж ахуйн нэгжийн эрхэлж буй үйл ажиллагаа, тухайн үйл ажиллагаа явуулж буй мужаас хамааран мужийн тусгай зөвшөөрөл олгохтой холбогдох нэмэлт шаардлага тавигдаж болно. Дижитал хөрөнгийн зарим арилжаа, түүний дотор платформ дээр арилжаа хийх үйл ажиллагаа нь дээр дурдсанчлан BSA болон муж улсын хууль, журмын дагуу мөнгөн шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгч гэх шалгуурыг хангаж болно. Хэрэв дижитал хөрөнгө нь үнэт цаас бол SEC-ийн харьяалалд хамаарах бөгөөд үнэт цаасны аливаа дериватив нь SEC-ийн харьяалалд хамаарна.

345. АНУ-ын хууль сахиулах байгууллага дижитал хөрөнгөтэй холбоотой хэрэг шалгаж, мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа FinCEN-ийн санхүүгийн мэдээлэл болон бусад мэдээллийг ашигладаг. FinCEN-ийн цуглуулдаг, дүн шинжилгээ хийж, АНУ-ын хууль сахиулах эрх бүхий байгууллагад шилжүүлдэг мэдээлэл нь гэмт хэргийг нотлох баримтыг олж тогтоох, МУТС үйл ажиллагаанд оролцсон байж болзошгүй хүмүүсийг илрүүлэхэд ач холбогдолтой байдаг. FinCEN нь санхүүгийн, захиргааны болон хууль сахиулах ажиллагааны өргөн хүрээний мэдээллийг авах эрхтэй. FinCEN-д байгаа мэдээлэл нь дижитал хөрөнгөтэй холбоотой МУТС сэжиг бүхий хэргийг илрүүлэхэд чухал ач холбогдолтой хоёр үндсэн мэдээллийг агуулдаг: (i) банк эсхүл үнэт цаасны брокер дилер гэх зэрэг мэдээлэх үүрэгтэй этгээдийн мэдээлдэг, дижитал хөрөнгийн бирж эсхүл холбогдох бусад үйлчилгээ үзүүлэгч дээр албан ёсны мөнгөн тэмдэгтийг дижитал хөрөнгө болгон арилжсан, эсхүл дижитал хөрөнгийг албан ёсны мөнгөн тэмдэгт болгон арилжсантай холбогдох Сэжигтэй үйл ажиллагааны тайлан; болон (ii) мөнгө хүлээн авч, тэдгээрийг дижитал хөрөнгө болгон солих эсхүл дижитал хөрөнгийг хадгалах, худалдах, арилжих үйл ажиллагаа эрхэлдэг дижитал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн мэдээлдэг Сэжигтэй үйл ажиллагааны тайлан. FinCEN нь гадаад банкны данс, валют, мөнгөний хэрэгсэл, бэлэн мөнгөний гүйлгээний тайлан гэх мэт бусад мэдээллийг цуглуулдаг бөгөөд эдгээр нь дижитал хөрөнгөтэй холбоотой гэмт хэргийн үйл ажиллагааг таслан зогсоох, мөрдөн шалгахад шаардлагатай мэдээлэл, нотлох баримтуудыг агуулж болно.

346. АНУ-ын хэлтэс, агентлагууд дижитал хөрөнгөтэй холбоотой хууль бус үйл ажиллагаатай тэмцэхийн тулд захиргааны болон холбооны шүүхийн аль алинд нь иргэний болон эрүүгийн хариуцлага хүлээлгэх хүчтэй арга хэмжээ авч байгаа ба тухайлбал, үйл ажиллагааг түр эсхүл бүр зогсоох, хориглох, хохирлыг хүүтэй нь нөхөн төлүүлэх, хууль тогтоомж санаатайгаар зөрчсөн этгээдэд мөнгөн торгууль ногдуулах, хөрөнгө хураах, хорих зэрэг эрүүгийн ял шийтгэл оногдуулах гэх мэт янз бүрийн арга хэмжээ авчээ.⁵⁵ АНУ-ын зохицуулагч болон хяналт тавих эрх бүхий байгууллагууд нь дижитал хөрөнгөтэй холбоотой хэргийг мөрдөн шалгах болон хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилгоор өөр хоорондоо болон муж улсын зохицуулагч, DOJ болоод бусад хууль сахиулах байгууллагуудтай өргөн хүрээнд, нягт хамтран ажиллаж байна.

347. АНУ-ын засгийн газрын агентлагуудад дижитал хөрөнгөтэй холбоотой хууль бус үйл ажиллагааг илрүүлэх, гүйлгээг тодорхой хувь хүн эсхүл байгууллагатай холбоотой эсэхийг тодорхойлох, аюул заналыг бууруулах, холбогдох зохицуулалтын болон эрүүгийн хэрэг мөрдөн шалгах үйл ажиллагаандаа дүн шинжилгээ хийхэд туслах, дэмжлэг үзүүлэх олон төрлийн эрүүгийн болон иргэний байгууллагууд, бодлогын арга хэрэгсэл, хууль эрх зүйн процессууд байдаг. DOJ нь мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэхдээ мөнгөн шилжүүлгийн үйлчилгээг бүртгэх, санхүүгийн байгууллагын баримт бичиг хадгалах, гүйлгээг мэдээлэх шаардлага, мөнгө угаах, залилах, татвараас зайлсхийх, хориотой бодис, бусад хууль бус эд зүйлс, үйлчилгээ борлуулах, компьютерийн гэмт хэрэг, терроризмыг санхүүжүүлэх гэх мэт асуудлуудыг

⁵⁵ АНУ-ын хууль сахиулах, мөрдөн шалгах болон хориг арга хэмжээ авахтай холбогдох зарим жишээ

зохицуулдаг, хуульд заасан эрүүгийн болон иргэний эрх бүхий олон төрлийн байгууллагаар дамжуулан хэрэгжүүлдэг. АНУ нь дижитал хөрөнгөтэй холбоотой бусад хэргийг хянан шийдвэрлэхээс гадна P2P арилжааны үйл ажиллагаа эрхэлсэн иргэдийг Банкны нууцлалын тухай хууль зөрчсөн эсхүл мөнгө угаасан гэх үндэслэлээр, мөн АНУ-ын хууль тогтоомжийг зөрчсөн гадаадад байгаа иргэд, байгууллагуудыг шалгаж, ял шийтгэл оногдуулсан.

348. FinCEN, SEC, CFTC байгууллагуудтай адилаар DOJ нь АНУ-ын хууль тогтоомжийг зөрчсөн дижитал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид болон хувь хүмүүс АНУ-ын нутаг дэвсгэрт биечлэн оршдоггүй байсан ч тэдэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрхтэй байдаг байна. Дижитал хөрөнгийн гүйлгээ нь АНУ-ын санхүүгийн, өгөгдөл хадгалах болон бусад компьютерын системд бүртгэгдсэн тохиолдолд, DOJ нь эдгээр гүйлгээг хийсэн эсхүл удирдан чиглүүлсэн этгээдийг яллах бүрэн эрхтэй болно. Түүнчлэн АНУ руу хууль бус бараа бүтээгдэхүүн импортлох, хууль бусаар бараа бүтээгдэхүүн оруулах зорилгоор дижитал хөрөнгө ашигласан эсхүл АНУ-д байрладаг дижитал хөрөнгийн бизнес, үйлчилгээ үзүүлэгч, санхүүгийн байгууллагыг мөнгө угаах зорилгоор ашигласан гадаад улсад байгаа этгээдийг яллах эрхтэй. Мөн хэрэв гадаад улсад байгаа этгээд АНУ-ын оршин суугчдад хууль бус үйлчилгээ үзүүлсэн, залилан мэхэлсэн, хулгай хийсэн бол түүнийг АНУ-ын хууль тогтоомжийг зөрчсөн хэргээр яллагдаж болно.

349. OFAC нь ихэвчлэн бусад агентлагуудтай зөвшилцсөний үндсэн дээр дижитал хөрөнгө болон бусад ихэнх төрлийн хөрөнгөтэй холбоотой АНУ-ын санхүүгийн хориг арга хэмжээ авах, холбогдох тусгай зөвшөөрлийг олгох, зохицуулах, торгуулийн арга хэмжээг авах үйл ажиллагааг хариуцдаг. Гүйлгээ нь дижитал хөрөнгө (үндэсний дижитал мөнгөн тэмдэгт болон үндэсний бус дижитал валют буюу биткойн гэх мэт хөрвөх виртуал валют) эсхүл уламжлалт албан ёсны мөнгөн тэмдэгт аль алианаар нь ч хийгдсэн байсан АНУ-ын хориг арга хэмжээгээр тавьсан шаардлагуудыг дагаж мөрдөх үүрэгтэй бөгөөд АНУ-ын этгээд болон OFAC-ийн харьяалалд хамаарах этгээд нь OFAC-ийн хориг арга хэмжээгээр хориглосон, зөвшөөрөлгүй гүйлгээнд оролцохгүй байх үүрэгтэй. OFAC-ийн 2020 оны 12-р сард ВХ-ийн үйлчилгээ үзүүлэгчийн гаргасан зөрчилд авсан арга хэмжээ, оногдуулсан торгууль нь үүнийг нотолно.⁵⁶

Олон улсын хамтын ажиллагаа

350. Дижитал хөрөнгийн экосистемийн глобал шинж чанар нь дижитал хөрөнгийн үйл ажиллагааг гэмт хэргийг үндэстэн дамнуулан үйлдэх, зохион байгуулахад онцгой тохиромжтой болгодог. Харилцагчид болон үйлчилгээнүүд нь улсын хил хязгаарыг үл харгалзан гүйлгээ хийж, үйл ажиллагаа явуулан, хууль, эрх зүйн хүрээнд саад бэрхшээл учруулдаг. Ийм учраас дижитал хөрөнгөтэй холбоотой гэмт хэргийн эсрэг үр дүнтэй тэмцэх нь олон улсын нягт хамтын ажиллагааг шаарддаг.

351. АНУ-ын хэлтэс, агентлагууд, ялангуяа АНУ-ын хууль сахиулах байгууллага нь дижитал хөрөнгийн үйл ажиллагаатай холбоотой хэргүүдийг мөрдөн шалгах, баривчлах, гэмт хэргийн замаар олсон хөрөнгө, мөнгийг хураах асуудлаар гадаад улсын эрх бүхий байгууллагатай нягт хамтран ажилладаг. АНУ олон улсын хамтарсан мөрдөн

⁵⁶ https://home.treasury.gov/system/files/126/20201230_bitgo.pdf.

шалгах ажиллагаа явуулах, хянан шийдвэрлэх чиглэлээр, ялангуяа гадаад улсад байрлах этгээд, дижитал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид болон үндэстэн дамнасан гэмт хэргийн байгууллагуудтай холбогдох ажиллагаан дээр гадаад улсын эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлэв. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт нь хамтын ажиллагааг сайжруулах гол механизм хэвээр байна. Учир нь гэмт этгээдүүд дижитал хөрөнгө болон холбогдох нотлох баримтыг хурдан устгах, тараах, нуун дарагдуулах сонирхолтой байдаг тул АНУ нь дижитал хөрөнгө болон холбогдох гүйлгээний мэдээлэл, нотлох баримтыг одоогийн хууль тогтоомж, эрх зүйн гэрээнд тусгаагүй, технологийн арга, үйл явцыг ашиглаж хадгалах эсхүл байршуулах боломжтой гэдгийг хүлээн зөвшөөрч, нотлох баримт олж авах, гадаадад байгаа хөрөнгийн хөдөлгөөнийг хязгаарлах бодлогыг боловсруулсан.

БҮЛЭГ ЗУРГАА: ВХҮҮ-ИЙН ХЯНАН ШАЛГАГЧ НАРЫН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ, ХАМТРАН АЖИЛЛАХ ЗАРЧИМ

352. ФАТФ-ын зөвлөмжүүд нь улс орнуудыг олон улсын хамтын ажиллагааг дээд зэргээр хангаж ажиллахыг зөвлөдөг. ЗТ.15-д улс орнууд 3.37-40-д заасны дагуу ВХ-тэй холбоотой мөнгө угаах, холбогдох суурь гэмт хэрэг болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд олон улсын бүхий л хамтын ажиллагааг түргэн шуурхай, үр дүнтэй үзүүлвэл зохино гэж заасан. Ялангуяа ВХҮҮ-ийг хянан шалгагчид хянан шалгагчдын төрөл, статус болон ВХҮҮ-ийн нэршил, статусын ялгаанаас үл хамааран гадаад улсын хянан шалгагчидтай мэдээллийг шуурхай, цаг алдалгүй солилцох ёстой. 3.37-40-ийг ВХ-д хэрхэн тусгаж хэрэглэх талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Бүлэг 3-т оруулсан болно.

Зорилтууд

353. Улс орон бүр МУТСТ чиглэлээр ВХҮҮ-д хяналт тавих дор хаяж нэг эрх бүхий байгууллагыг томилох шаардлагатай. ФАТФ-ын зөвлөмжид эрх бүхий байгууллага нь өөрийгөө зохицуулах байгууллага байж болохгүй гэж заасан боловч эрх бүхий байгууллага хэн байх ёстойг тухайлан заагаагүй болно. Улс орнууд Санхүүгийн зохицуулах хороо, Төв банк, Үнэт цаасны зохицуулах хороо, Татварын байгууллага, СМА, ВХҮҮ-ийн мэргэшсэн хянан шалгагч гэх мэт олон төрлийн эрх бүхий байгууллагуудыг ВХҮҮ-д хяналт тавих байгууллагаар томилсон байдаг. Зарим улс орнууд нэг хянан шалгагчтай байхад зарим нь олон хянан шалгагчтай байдаг. Зарим улс орнууд ВХҮҮ-ийг амархан тодорхойлогддог, бизнесийн тодорхой ангилал гэж үздэг бол зарим нь ВХҮҮ-ийг өмнө нь байсан бизнесийн ангиллын дэд хэсэг (жишээ нь, мөнгөн гуйвуулгын бизнес гэх мэт) гэж үздэг.

354. ФАТФ-ын зөвлөмжүүд нь хянан шалгагчид хянан шалгагчдын төрөл, статус болон ВХҮҮ-ийн нэршил, статусын ялгаанаас үл хамааран гадаад улсын хянан шалгагчидтай мэдээллийг шуурхай, цаг алдалгүй солилцох ёстой гэж тодорхой заасан байдаг. ВХ-д зохиомол нэр ашиглаж болдог, маш хурдан, хил дамнасан гүйлгээ хийгддэг шинж чанартай байдаг тул ВХҮҮ-ийг хянан шалгагчдын хоорондын олон улсын хамтын ажиллагаа маш чухал юм. Хянан шалгагчдын хамтын ажиллагаа болон мэдээлэл солилцох үйл ажиллагааг дэмжих зорилгоор ФАТФ нь **“ВХҮҮ-ийн хянан шалгагч нарын хооронд мэдээлэл солилцох, хамтран ажиллах зарчмууд”**-ыг боловсруулсан. Эдгээр зарчмууд нь дараах зорилготой:

а. Байгууллагууд бие биетэйгээ хуваалцаж болох хяналт шалгалтын мэдээллийн төрөл болон бусад ерөнхий мэдээллийн талаарх нэгдсэн ойлголт болон эдгээр мэдээллийг хэзээ хуваалцах талаарх мэдээллийг талуудад өгөх;

б. Мэдээлэл солилцох/хүсэлт гаргах шалтгаан, боломжит нөхцөлүүдийг тоймлон харуулах, тухайлбал, гадаад улсын МУТСТ-д нь нөлөөлж болзошгүй кибер аюулгүй байдлын тохиолдол гарсан эсхүл гадаад улсын ВХҮҮ нь тухайн улсад зохицуулалтгүй ВХҮҮ-ийн үйл ажиллагаа явуулж байж болзошгүй тохиолдолд;

в. Тодорхой нөхцөл байдалд хэрэгжүүлэх хяналт шалгалтын туслалцаа/эргэх холбооны төрөл болон эдгээр мэдээллийг хуваалцах, дамжуулах боломжит аргуудыг тодорхойлох (нууцлалын заалтын дагуу);

г. Тодорхой хэрэг, асуудал дээр МУТСТ чиглэлээр олон хянан шалгагчид хамтран ажиллаж байгаа бол тэдний үүрэг, хүлээлтийн хүрээг тодорхойлох;

д. Зохицуулалтын тогтолцоо байхгүй улс оронд ВХҮҮ-тэй холбоотой асуудлыг шийдвэрлэх, эсхүл олон улс оронд үйл ажиллагаа явуулдаг ВХҮҮ-ийг хамтран хянан шалгах гэж байгаа тохиолдолд шаардлагатай заавар, зөвлөмж, удирдамжийг санал болгох;

е. Тус тусын цахим хуудас эсхүл лавлах дээр байршуулах зөвшөөрөлтэй/бүртгүүлсэн ВХҮҮ-тэй холбогдох мэдээллийн төрлүүдтэй холбоотой шилдэг туршлагыг тодорхойлох.

355. Эдгээр зарчмуудыг хянан шалгагчид заавал биелүүлэх үүрэг хүлээхгүй. Эдгээр нь хянан шалгагчдад заавар, чиглэл өгөх зорилготой юм. Хянан шалгагчид эдгээр зарчмуудыг баталж хэрэгжүүлэх үүрэг хүлээхгүй ба хэрэв тэдний дотоодын хууль тогтоомжтой нийцэхгүй бол мэдээлэл хуваалцах, хамтран ажиллах үүрэггүй (хамтран ажиллах, мэдээлэл солилцох нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах зэрэг хууль, эрх зүйн зохицуулалт бий болговол зохино) бөгөөд Зөвлөмж 37-40-д заасан үүрэг хариуцлагатай харшлахгүй.

356. Гэсэн хэдий ч эдгээр зарчмууд нь ВХҮҮ-ийг зөвшөөрсөн эсхүл хориглосон эсэхээс үл хамааран бүх улс оронд хамаарна. ВХҮҮ-ийг хориглодог улс орнууд холбогдох эрх бүхий байгууллагад виртуал хөрөнгө болон ВХҮҮ-тэй холбоотой асуудлаар мэдээлэл солилцохыг зөвшөөрөх эрх зүйн үндэслэлийг бий болгосон байх ёстой. Энэ эрх бүхий байгууллага нь хяналт шалгалтын байгууллага биш, жишээлбэл, хууль сахиулах байгууллага байж болно.

Мэдээлэл солилцох, хамтран ажиллах зарчим

357. Хянан шалгагчдын хооронд олон улсын хамтын ажиллагааг хөхүүлэн дэмждэг, хамтын ажиллагаа нь харилцан итгэлцэлд тулгуурласан байх ёстой. Мэдээлэл солилцох зохицуулалт нь тодорхой асуудлуудыг тохиолдол бүрээр шийдвэрлэх боломжтой байх шаардлагатай.

Хяналт тавих байгууллага болон ВХҮҮ-ийг тодорхойлох

1. Улс орнууд МУТСТ чиглэлээр ВХҮҮ-д хяналт тавих байгууллагыг тодорхойлсон байх ёстой. Тухайн улс олон хяналт тавих байгууллагатай бол тухайн улс хяналт тавих байгууллагуудын зохицуулалтын хамрах хүрээг тодорхой зааж өгөх ёстой.
2. Хянан шалгагчид ВХҮҮ-тэй холбоотой лавлагаа, хүсэлтийг хүлээн авах тодорхой механизмтай байх ёстой. Жишээлбэл, энэ нь ВХҮҮ-тэй холбоотой лавлагаа, хүсэлтийг тодорхой имэйл хаягаар хүлээн авдаг байж болно.

3. Түргэн шуурхай, цаг алдалгүй хамтран ажиллах зорилгоор хянан шалгагчид өөрсдийн эрх мэдлийн хүрээн дэх мэдээлэл буюу зөвшөөрөлтэй эсхүл бүртгэлтэй ВХҮҮ-ийн талаарх мэдээлэлд гадаадын эрх бүхий байгууллага хялбархан хандах боломжийг бүрдүүлсэн байвал зохино. Үүнийг жишээлбэл, мэдээлэх үүрэгтэй этгээдийн бүртгэлийн мэдээллийг нээлттэй байршуулах, тусгай зөвшөөрөлтэй эсхүл бүртгүүлсэн этгээдийн мэдээлэл бүхий мэдээллийн сангаас хаалттай мэдээлэл солилцох сувгаар дамжуулан мэдээлэл хүсдэг байх гэх мэт аргуудаар шийдвэрлэж болно.

Мэдээлэл солилцох

4. Хянан шалгагчид нь гадаад улсын хянан шалгагчидтай статус харгалзахгүйгээр ВХҮҮ-ийн талаарх холбогдох мэдээллийг солилцох шаардлагатай. Үүний тулд хянан шалгагчид МУ, холбогдох суурь гэмт хэрэг, ТС чиглэлээр хамтран ажиллах эрх зүйн хангалттай үндэслэлтэй байх шаардлагатай.
5. Хяналт шалгалтын мэдээлэл солилцох хэд хэдэн арга байдаг. Хамгийн түгээмэл нь нэг талын хянан шалгагч нөгөө талд хүсэлт гаргаснаар хоёр тал харилцан мэдээлэл солилцож болно. ВХҮҮ нь олон талт шинж чанартай бол хянан шалгагчид ВХҮҮ-ийг зохицуулдаг бусад байгууллагуудтай мэдээлэл солилцох шийдвэр гаргаж болно. Эцэст нь, нууцлалын түвшин бага мэдээллийг олон талт шинж чанартай ВХҮҮ-ийг ахлан хянан шалгаж байгаа хянан шалгагчийн удирдлага дор хяналт шалгалтын багийн хүрээнд солилцож болно. ВХҮҮ-ийн хил дамнасан шинж чанарыг харгалзан, томоохон олон талт ВХҮҮ-ийг шалгах хяналт шалгалтын баг байгуулж ажиллах нь эдгээр ВХҮҮ-ийн МУТСТ үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулахад тус дэмтэй болно.
6. Хянан шалгагчдын солилцох мэдээллийн төрлүүд нь мэдээлэл солилцох үндэслэл, шалтгаан, мэдээлэл өгч буй хянан шалгагчийн хуулийн хүрээнд олж авч чадах мэдээлэл, улс орнуудын дотоодын хууль, эрх зүйн орчин зэрэг олон хүчин зүйлээс хамаарна. Боломжтой бөгөөд хуулиар зөвшөөрөгдсөн тохиолдолд хянан шалгагчид ВХҮҮ-ийн зохицуулалтын талаарх мэдээлэл, түүний хувьцаа эзэмшигчид болон захирлуудын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, гүйлгээтэй холбоотой мэдээлэл, хэрэглэгчийн мэдээлэл (зөвшөөрөл авахад бүрүүлж өгсөн болон хяналт шалгалтын үед цуглуулсан мэдээлэл, блокчэйн тандалт, дүн шинжилгээний хэрэгсэл ашиглаж олж авсан мэдээлэл г.м) зэрэг мэдээллийг солилцвол зохино. Хянан шалгагчид шаардлагатай тохиолдолд өөрсдийн хяналт шалгалтын эрх мэдлийг хэрэгжүүлж, ВХҮҮ-ээс нэмэлт мэдээлэл авдаг байх шаардлагатай.
7. Мэдээлэл хүсэж буй хянан шалгагч нь хүсэлтийг хүлээн авч буй хянан шалгагчид хүсэлт хүргүүлэх болсон үндэслэл, шалтгаан, мэдээллийг ямар зорилгоор ашиглах талаарх мэдээллийг өгч, хүсэлтийг хүлээн авч буй хянан шалгагч хууль ёсны дагуу мэдээлэл өгөхөд шаардлагатай, аль болох дэлгэрэнгүй, хангалттай мэдээлэл өгөх нь зүйтэй.

8. Хянан шалгагчид хүсэлтийг хүлээн авсан талаар хариу мэдэгдэж, мэдээлэл авах хүсэлтэд цаг тухайд нь хариу өгнө.
9. Хянан шалгагчид нь мэдээлэл солилцох, туслалцаа үзүүлэхийг хориглох болон үндэслэлгүйгээр хязгаарлах нөхцөл тавих ёсгүй. Ялангуяа хянан шалгагчид нь дараах үндэслэлээр туслалцаа хүсэхээс татгалзах ёсгүй. Үүнд:
 - а. хууль тогтоомжоор СБ, СББМҮҮ болон ВХҮҮ-д нууцлал, нууцлалыг хадгалахтай холбоотой шаардлага тавигддаг (мэдээлэл нь хууль ёсны давуу эрх эсхүл хууль ёсны мэргэжлийн нууцад хамаарах нөхцөл байдалд байхаас бусад тохиолдолд);
 - б. хүсэлтийг хүлээн авч байгаа улсад хэрэг бүртгэл, мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа ба хүсэж буй туслалцаа нь хэрэг бүртгэл, мөрдөн байцаалт, байцаан шийтгэх ажиллагаанд саад учруулахгүй бол;
 - в. хүсэлт гаргагч байгууллагын мөн чанар, статус нь хүсэлт хүлээн авагч гадаад улсын хяналт тавих байгууллагынхнаас ялгаатай.
10. Хүсэлт гаргасан хянан шалгагчдын ирүүлсэн, боловсруулсан, эзэмшсэн, шилжүүлсэн мэдээллийг зөвхөн тохиролцсон эрх зүйн акт, журам, бодлого, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд найдвартай хамгаалж, солилцож, ашиглана.
11. Солилцсон мэдээллийг зөвхөн тухайн мэдээллийг хүссэн эсхүл өгсөн зорилгоор ашиглана. Мэдээллийг бусад эрх бүхий байгууллага эсхүл гуравдагч этгээдэд дамжуулах, эсхүл мэдээллийг захиргааны, мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх болон шүүхийн зорилгоор буюу анх зөвшөөрснөөс бусад зорилгоор ашиглах бол хүсэлтэд хариулж, мэдээлэл өгсөн хянан шалгагчаас урьдчилан зөвшөөрөл авсан байх ёстой. Хүсэлт гаргасан санхүүгийн хянан шалгагч нь тухайн мэдээллийг гуравдагч этгээдэд задруулах, мэдээлэхтэй холбогдуулан хуулиар ямар үүрэг, хариуцлага хүлээдэг талаараа хүсэлт хүлээн авагч хянан шалгагчид нэн даруй мэдэгдэх ёстой.
12. Хянан шалгагчид нь ирүүлсэн хүсэлт, баримт бичиг шаардлага хангаагүй тохиолдолд энэ талаар хүсэлт гаргасан хянан шалгагчид тэр даруй мэдэгдэж, цаг алдалгүй мэдээлэл солилцохыг эрмэлзвэл зохино.
13. Хянан шалгагчид хяналт шалгалтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийг өөрийн хүсэлтээр болон хүсэлтийн дагуу солилцох нь зүйтэй. Ийм хүсэлтийг дараах тохиолдолд гаргана:
 - а. тухайн улсын ВХҮҮ-д кибер аюулгүй байдалтай холбоотой хэрэг, зөрчил гарсан бөгөөд энэ нь гадаад улсын МУТСТ асуудалд сөргөөр нөлөөлж болзошгүй;
 - б. тухайн улсын нутаг дэвсгэрт гадаад улсын ВХҮҮ нь зохицуулалтгүй үйл ажиллагаа явуулж байж болзошгүй;

в. тухайн улсын ВХҮҮ нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа явуулж байж болзошгүй гэж сэжиглэгдэж байгаа бөгөөд уг ВХҮҮ нь гадаад улсад үйл ажиллагаа явуулдаг.

14. Хянан шалгагчдын хүсэлтийн дагуу болон боломжтой үедээ хянан шалгагчид нь хүлээн авсан мэдээллийн ашиглалт болон авсан мэдээллийг ашиглан хийсэн дүн шинжилгээний үр дүнгийн талаар мэдээлэл ирүүлсэн гадаад улсын хянан шалгагчдад эргэх хариу мэдээлэл өгнө.
15. Хянан шалгагчид нь шинээр үүссэн асуудал, мэдээллийн боловсруулалт болон үүсч болзошгүй сөрөг нөхцөл байдлын талаарх мэдээллийг болон хянан шалгагчийн авсан арга хэмжээний талаарх мэдээллийг нөгөө талын хянан шалгагчтай цаг алдалгүй солилцоно.
16. Хянан шалгагчид нь хяналт шалгалтын үйл ажиллагаанд өөрөөр заагаагүй, ердийн бус нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд хянан шалгагчийн авсан арга хэмжээ гэх мэт мэдээлэх үүрэгтэй этгээдэд хамаарах мэдээллийг ВХҮҮ-д хяналт тавих нөгөө талын хянан шалгагчидтай хуваалцах шаардлагатай.

Хамтын ажиллагаа

17. Зарим тохиолдолд, хэрэв ВХҮҮ нь нэг улсын нутаг дэвсгэрт бизнесийн үйл ажиллагааныхаа нэлээдгүй хэсгийг явуулдаг бол “үндсэн” Хяналт тавих байгууллагыг томилж болно. Энэ тохиолдолд улс орнуудын хяналт тавих эрх бүхий байгууллагууд нь мэдээлэл солилцох, хамтын ажиллагааг уялдуулан зохион байгуулах “үндсэн” хяналт тавих байгууллагыг томилоход хамтран ажиллавал зохих ч энэ нь заавал биелүүлэх шинжгүй бөгөөд хянан шалгагчдыг өөр өөрсдийн нутаг дэвсгэр дээр ВХҮҮ-д хяналт тавих үүрэг хариуцлагаас чөлөөлөхгүй.
18. Хянан шалгагчид хамтран ажиллах хамгийн үр дүнтэй арга, хэрэгслийг ашиглах ёстой. Хэрэв харилцан ойлголцлын санамж бичиг гэх мэт хоёр болон олон талт гэрээ, хэлэлцээр байгуулах шаардлагатай бол мөнгө угаах, холбогдох суурь гэмт хэрэг, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын хамтын ажиллагааны хүрээнд гадаад улсын хяналт тавих эрх бүхий байгууллагуудтай аль болох өргөн хүрээнд яриа хэлэлцээ хийж, санамж бичиг байгуулах шаардлагатай.
19. Хянан шалгагчид гадаад улсын хянан шалгагчдын нэрийн өмнөөс мэдээлэл, лавлагаа авах эрхтэй байх ба хэрэв дотоодын эрх бүхий байгууллагаас авсан мэдээлэл, лавлагаа авсан бол эдгээр мэдээллийг гадаад улсын хянан шалгагчидтай солилцоно.
20. Хамтран ажиллах хүсэлт гаргахдаа хянан шалгагчид нь аль болох бүрэн, бодитой бөгөөд холбогдох хэргийн тайлбар бүхий хууль, эрх зүйн үндэслэлтэй мэдээллийг нөгөө талд өгөхийг эрмэлзэх шаардлагатай. Хэрэв хүсэлтэд яаралтай хариу авах шаардлагатай бол хамтын ажиллагааны хүсэлтийг цаг алдалгүй, үр дүнтэй гүйцэтгэх боломжийг бүрдүүлэхийн тулд энэ талаар тодорхой дурдах шаардлагатай.